| Бодит үнэ цэнийн ашиг алдагдлаар хэмжигдэх өмчийн үнэт цаасны худалдан авалт | - | - | (831,597) | (612,893) |
| Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаасны худалдан авалт | - | (1,571,913) | (623,986) | (754,367) |
| Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаасыг эргүүлэн авснаас олсон орлого | - | - | 1,000,000 | 955,436 |
| Бусад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа | 8,425,367 | - | (622,331) | 671,370 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 7,521,550 | (1,868,433) | (1,674,142) | 152,896 |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ: | | | | |
| Гаргасан хувьцаа | 500,001 | - | - | - |
| Эзний татан авалт | (1,000,000) | - | - | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Гаргасан бонд | - | 5,433,678 | 1,196,557 | 5,120,051 |
| Бондын эргэн төлөлт | - | (8,113,988) | (1,544,582) | (2,015,618) |
| Төлсөн ногдол ашиг | (1,465,173) | (1,963,690) | (1,823,040) | (1,956,140) |
| Авсан зээл болон өр төлбөр | 101,808,031 | 55,681,506 | 42,870,426 | 35,868,605 |
| Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт | (92,177,980) | (58,249,464) | (36,218,740) | (34,422,055) |
| Харилцагчаас татсан итгэлцэл | 2,836,909 | 2,115,569 | 6,492,271 | 14,604,734 |
| Харилцагчдад төлсөн итгэлцэл | (1,162,208) | (687,841) | (2,186,418) | (13,125,507) |
| Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөрт төлсөн хүү | - | (847,545) | (206,591) | (2,219,478) |
| Зээлийн өр төлбөрт төлсөн хүү | - | (771,653) | (543,468) | (1,070,316) |
| Бондын өр төлбөрт төлсөн хүү | - | (924,911) | (201,890) | (486,056) |
| Түрээсийн үндсэн төлбөр ба хүүгийн төлөлт | (72,418) | (126,302) | (123,960) | (69,579) |
| Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | 9,267,162 | (8,454,641) | 7,710,565 | 228,641 |
| Тайлант жилд бий болсон (зарцуулсан) нийт цэвэр мөнгөн гүйлгээ | 2,567,634 | (2,685,959) | 3,003,769 | 2,469,349 |
| Мөнгө бө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 2,969,688 | 5,518,099 | 2,917,449 | 5,919,649 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө | (19,223) | 85,309 | (1,569) | (5,793) |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 5,518,099 | 2,917,449 | 5,919,649 | 8,383,205 |

*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

## 2.3. НИЙТ АКТИВ БА ОРЛОГО, АШИГТ АЖИЛЛАГАА

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө 2022 онд 69.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 11.4 тэрбум төгрөг буюу 19.5 хувиар өссөн байна. Сүүлийн 4 жилд БИД ББСБ-ын нийт актив жилд дунджаар 15.6 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа юм. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгөд эзэлж буй нийт зээлийн багц 54.2 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 77.5 хувийг бүрдүүлж байна.

2022 онд нийт зээлийн багцын хэмжээ өнгөрсөн оноос 24.8 хувиар өссөн нь компани 2021 онд цахим зээлийн аппликэйшн болох БИД апп-ыг зах зээлд нэвтрүүлсэн нь нөлөөлжээ. Мөн 2022 онд итгэлцлийн үйлчилгээний өглөг 16.7 тэрбум төгрөгийн эх үүсвэртэй байгаа, банк, санхүүгийн байгууллагаас татах зээлийн эх үүсвэр 14.8 хувиар нэмэгдсэн зэрэг нь зээлийн багц өсөхөд нөлөөлсөн.

Компанийн нийт хөрөнгө болон зээлийн багцын дүн 2020 онд өмнөх оноос тус бүр харгалзан 3.6 хувь болон 6.6 хувиар буурсан нь Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын нөлөөгөөр дотоодын хөл хорио, иргэдийн ажил эрхлэлт буурч, зээлийн эргэн төлөлт саарсан зэрэг нь хамгийн их нөлөөлсөн байна.

*График 11. Нийт хөрөнгө (тэрбум төгрөг) ба жилийн өсөлт (хувиар)*




*График 10. Нийт хөрөнгө ба нийт зээлийн багцын харьцуулалт, ( тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл 2022 онд нийт хөрөнгийн 54.0 хувь буюу 37.8 тэрбум төгрөгийг өр төлбөрийн эх үүсвэр, 46.0 хувийг буюу 32.1 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. Нийт активт эзлэх өр төлбөрийн хэмжээ 2019 оноос хойш жилд дунджаар 15.7 хувиар өссөн.

*График 13. Нийт активын бүтэц, (тэрбум төгрөг)*




*График 12. Нийт цэвэр орлого (тэрбум төгрөг), цэвэр ашиг (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

2022 онд өр төлбөрийн санхүүжилт 20.1 хувиар нэмэгдэхэд итгэлцлийн үйлчилгээгээр татсан эх үүсвэр 5.7 хувиар өсөж 16.6 тэрбум төгрөгт хүрсэн, банк, санхүүгийн байгууллагаас татсан зээлийн санхүүжилт 14.8 хувиар өсөж 12.9 тэрбум төгрөгт хүрсэн нь тус тус нөлөөлсөн байна.

2019-2022 оны хооронд нийт өр төлбөрийн дүн жилд дунджаар 15.7 хувиар буюу өөрийн хөрөнгийн жилийн дундаж өсөлт 15.4 хувиас өндөр хурдтай өсөж байна. Цэвэр ашиг 2022 онд 7.0 тэрбумт төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 36.4 хувиар өссөн байна.

2022 онд нийт цэвэр орлогыг бүрдүүлж буй хүүгийн цэвэр орлого 14.8 тэрбум төгрөг, үйлчилгээний хураамжийн орлого 12.9 сая төгрөг, санхүүгийн хэрэглүүрийн

үнэ цэнийн бууралтын гарз 19.1 тэрбум төгрөг байна. Үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлого буурч байгаа нь уламжлалт хэлбэрээр зээлийн гэрээ байгуулах тохиолдол буурсан нь нөлөөлсөн.

*График 15. Зээлийн багцын чанар, зээлийн ангиллаар, (хувиар)*




*График 14. Зээлийн эрсдэлийн сан (тэрбум төгрөг) ба эрсдэлийн сангийн хүрэлцээ*




*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

Компанийн нийт зээлийн багцын 93.3 хувь буюу 50.6 тэрбум төгрөгийг хэвийн зээл, 2.1 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 4.5 хувь буюу 2.4 тэрбум төгрөгийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. 2022 онд байгуулсан эрсдэлийн сангийн хэмжээ 2.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ 83.7 хувь байна.

## 2.4. БИЗНЕСИЙН ҮР АШИГ, ӨГӨӨЖИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн өгөөж 2022 онд 10.1 хувь байгаа бол өөрийн хөрөнгийн өгөөж 21.9 хувьд хүрсэн байна. Ийнхүү бизнесийн үр ашгийн үзүүлэлт 2021 оноос хойш бага зэрэг өсөх хандлага үзүүлж байгаа нь компанийн эх үүсвэрийн бүтцэд өөрийн хөрөнгийн эх үүсвэрийн чадамж нэмэгдэж байгаа нь нөлөөлж байна.

*График 17. Нийт хөрөнгийн өгөөж ба өөрийн хөрөнгийн өгөөж, (хувиар)*




*График 16. Цэвэр хүүгийн орлогын маржин ба хүүгийн цэвэр орлого (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

Цэвэр ашгийн маржин 2019-2022 оны хооронд дунджаар 41.2 хувийн түвшинд байна. Харин нийт ашгийн маржин 75.1 хувийн орчимд байгаа нь хүүгээс бусад

үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны зардал нийт орлогод харьцангуй бага хувийг эзэлдэг болохыг харуулж байна.

*График 19. Нийт ашгийн маржин, (хувиар)*




*График 18. Цэвэр ашгийн маржин, (хувиар)*




*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

2022 онд цэвэр ашгийн маржин 5.0 орчим пунктээр буурахад ерөнхий ба удирлагын зардал 31.7 хувиар өссөн, хүү болон түүнтэй адилтгах эх үүсвэрийн зардал 35.0 хувиар нэмэгдсэн, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний гарз 0.5 тэрбум төгрөгөөр өссөн нь тус тус нөлөөлжээ.

## 2.5. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР БА КАПИТАЛЫН БҮТЭЦ

2022 оны жилийн эцсийн байдлаар БИД ББСБ-ын өөрийн хөрөнгийн 82.9 хувь буюу 26.7 тэрбум төгрөгийг хуримтлагдсан ашиг эзэлж байгаа бол 5.0 тэрбум төгрөг буюу 15.6 хувийг хувьцаат капиталын дүн тус тус эзэлж байна.

*График 21. Өөрийн хөрөнгийн бүтэц, (тэрбум төгрөг)*




*График 20. Нийт өр төлбөрийн санхүүжилтийн бүтэц, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

Харин нийт өр төлбөрийн бүтцэд итгэлцлийн үйлчилгээгээр татсан эх үүсвэр давамгайлж байгаа бөгөөд нийт өр төлбөрийн эх үүсвэрийн 44.1 хувь буюу 16.7 тэрбум төгрөг, банк санхүүгийн байгууллагаас авсан зээл 34.1 хувь буюу 12.9 тэрбум төгрөг, бондын санхүүжилтээр татсан эх үүсвэр 6.8 тэрбум төгрөг тус тус бүрдүүлж байна.

## 2.6. МӨНГӨН УРСГАЛ БА ХӨРВӨХ ЧАДВАР

Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангаас мөнгөн хөрөнгийн эргэлт, мөнгөн урсгалыг мөнгөн эх үүсвэрийн төрлөөр задалбал зээл гаргалтын өсөлтөөс шалтгаалан үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний үлдэгдлийг буурахад нөлөөлж байна. Тухайлбал, 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас бий болсон цэвэр мөнгөн гүйлгээ 14.2 тэрбум төгрөгийн дутагдалтай харагдаж байгаа нь зээл олголтоо 10.9 тэрбум төгрөгөөр өсгөсөн нь голчлон нөлөөлсөн.

*График 23. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл ба тухайн оны цэвэр мөнгөн гүйлгээ, (тэрбум төгрөг)*




*График 22. Цэвэр мөнгөн гүйлгээний задаргаа, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

2020 оны цар тахлын үед зээлийн гарах урсгал хумигдаж, зээлийн эргэн төлөлтүүд үргэлжилснээр харилцагчид олгосон зээл өмнөх онтой харьцуулахад ердөө 239.9 сая төгрөгөөр нэмэгджээ. Цар тахлын дараах үед өрийн болон өмчийн үнэт цаасанд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр жилийн дундаж хөрөнгө оруулалтын гарах мөнгөн урсгал 1.4 тэрбум төгрөг орчим байна.

*Хүснэгт 17. Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд*

| Харьцаа үзүүлэлтүүд | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|
| Эргэлтийн харьцаа (current ratio) | 166.9% | 196.4% | 169.0% | 173.6% |
| Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа (quick ratio) | 166.6% | 195.8% | 168.7% | 172.0% |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн харьцаа (cash ratio) | 23.0% | 37.8% | 37.3% | 32.0% |
| Өр зээл ба бэлэн мөнгөний харьцаа (Total loan to total deposit ratio) | 431.4% | 349.9% | 335.6% | 351.3% |

*Эх сурвалж: Аудитлагдсан санхүүгийн тайлан*

Компанийн хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтүүд зохимжтой түвшинд хадгалагдаж байгаа бөгөөд санхүүгийн бизнесийн онцлогоос шалтгаалан түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа болон бусад эргэлтийн харьцаанууд харилцагчдаас авах зээлийн авлагын нөлөөгөөр өндөр харьцаа үзүүлэлт харуулж байна. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө, богино хугацаатай үнэт цаасны хөрөнгийг богино хугацаат өр төлбөрт харьцуулсан харьцаа 32.0 хувь байна.

## 2.7. САНХҮҮГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Хүснэгт 18. Санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд*

| Зохистой үзүүлэлт | Байвал зохих | Тайлангаар | Биелсэн эсэх |
|---|---|---|---|
| **Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт** | | | |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 44.3% | Тийм |
| Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-аас доошгүй | 44.9% | Тийм |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 45.3% | Тийм |
| **Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа** | | | |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-аас дээш | 38.4% | Тийм |
| **Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт** | | | |
| Хөрөнгө (актив)-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу ) | 1,782,329.9 | 1,810,251.5 | Тийм |
| Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 30%-аас хэтрэхгүй | 1.2% | Тийм |
| ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 70%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа | 25%-аас хэтрэхгүй | 1.7% | Тийм |
| ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 1.0% | Тийм |
| Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 3.5% | Тийм |
| Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Монголын хөрөнгийн биржийн "I", "II" ангилалын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 3.8% | Тийм |
| Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.0% | Тийм |
| **Гадаад валютын ханшийн эрсдэл** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | ±40% | -18.2% | Тийм |
| **Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд** | | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-аас хэтрэхгүй | 48.5% | Тийм |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 20.6% | Тийм |
| **Үндсэн хөрөнгийн үзүүлэлт** | | | |
| Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 15%-аас хэтрэхгүй | 6.0% | Тийм |
| **Өгөөж** | | | |
| Хөрөнгө (актив)-ийн өгөөж | | | 9.9% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | | | 21.4% |

*Эх сурвалж: СЗХ-нд тайлагнасан 2022 оны 4 дүгээр улирлын урьдчилсан тайлан*

Банк бус, санхүүгийн байгууллагын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг БИД ББСБ нь 2022 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хангаж ажиллаж байна. Эдгээр шалгуур үзүүлэлтийг тухайн банк бус, санхүүгийн байгууллага хангаж ажилласнаар өөрийн компанид ирээдүйд учирч болох төлбөрийн чадварын эрсдэл, хөрвөх чадварын эрсдэлийг бууруулах, цаашлаад урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл болгож ашиглах гол үзүүлэлт болдог билээ.

- **Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт**

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт нь банк бус, санхүүгийн байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлдог үзүүлэлт бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар БИД ББСБ тус үзүүлэлтийг хангаж ажиллаж байна.

- **Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа**

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харцаа үзүүлэлт нь бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар буцаан олгох чадварыг илэрхийлдэг. 2022 оны эцсийн санхүүгийн тайлан дээр үндэслэхэд Үнэт цаас гаргагч нь ямар нэг төлбөрийн чадварын эрсдэлд ороогүй байна.

- **Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт**

Актив хөрөнгийн төвлөрлийн эрсдэл нь нэг этгээд эсвэл холбоотой этгээдүүдэд их хэмжээгээр төвлөрүүлсэн зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг илэрхийлдэг. Тус үзүүлэлтийг Үнэт цаас гаргагч нь зохистой түвшинд хадгалж, эрсдэлийг доогуур түвшинд барьж байна.

- **Гадаад валютын ханшийн эрсдэл**

Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа үзүүлэлтийг хангаж ажиллах ач холбогдол нь тухайн санхүүгийн байгууллагын ханшийн савалгаанд өртөмтгий байдлыг хянах, эрсдэлийг хязгаарлах боломжийг олгодог. Компанийн хувьд гадаад валютын ханшийн эрсдэл бага түвшинд байна.

- **Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлт**

Үнэт цаас гаргагч нь итгэлцлийн үйлчилгээгээр эх үүсвэр татах дээд хязгаар 80 хувьтай харьцуулахад 48.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Өрийн бичгээр хөрөнгө татан төвлөрүүлэх зохистой харьцааны шалгуурыг мөн хангаж ажиллаж байна.

- **Үндсэн хөрөнгийн үзүүлэлт**

Банк бус, санхүүгийн байгууллагын хувьд үндсэн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь хэмжээг зохистой түвшинд хадгалж ажилласнаар түргэн хөрвөх чадвар, төлбөрийн чадварын эрсдэлээ хангаж ажиллах хөшүүрэг болдог. Компанийн хувьд үндсэн хөрөнгийн зохистой харьцаа нь зохих түвшинд байна.

- **Өгөөж**

Нэгж хөрөнгөөс олж буй цэвэр ашгийн үзүүлэлтийг харуулдаг хөрөнгийн өгөөж БИД ББСБ-ын хувьд 9.9 хувь байна. Харин эздийн өмчийг хэр үр ашигтай захиран зарцуулж, үр өгөөж олж буйг илтгэдэг өөрийн хөрөнгийн өгөөж 21.4 хувийн түвшинд байна.



# ГУРАВ. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

2023 -03- 28
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

## 3.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

### 3.1.1. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

**Эдийн засгийн бодит өсөлт, үйлдвэрлэл**

Монгол Улсын эдийн засаг 2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4.8 хувийн бодит өсөлттэй гарсан бөгөөд 2020 оны цар тахлын хямралын дараах (Post-Covid) жилүүд дэх хамгийн өндөр өсөлтийг үзүүллээ. Эдийн засгийн бодит өсөлт нэмэгдэхэд дотоодын хөл хорио цуцлагдаж үйлчилгээ, худалдааны салбар сэргэсэн, мөн хилийн боомт дээрх нөхцөл байдал сайжирч байгаа нь нөлөөлж байна.

*График 25. Бодит ДНБ-ийн өсөлт, (хувиар)*




*Эх сурвалж: Монголбанк*

*График 24. 2023 оны эдийн засгийн өсөлтийн таамаглал*




*Эх сурвалж: Олон улсын санхүүгийн байгууллагуудын тайлан*

Монголбанкнаас 2023 оны эдийн засгийн өсөлтийг 3.2 хувь байхаар төсөөлсөн бол Олон Улсын санхүүгийн байгууллагууд 4.9-5.8 хувийн өсөлттэй (Дэлхийн банкны таамаглал нь 2022 оны 04 дүгээр сарын байдлаарх мэдээлэл) байна гэж таамаглажээ.

*Хүснэгт 19. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, (их наяд төгрөг)*

| Салбарууд | 2019 | 2020 | 2021 | 2022 | Өсөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2022/2021 | 2022/2019 |
| Уул уурхай, олборлолт | 15.2 | 14.5 | 17.9 | 22.5 | +25.6% | +48.0% |
| Боловсруулах үйлдвэрлэл | 4.0 | 4.0 | 5.3 | 6.1 | +15.1% | +52.5% |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 1.1 | 1.2 | 1.3 | 1.4 | +7.7% | +27.3% |
| Ус хангамж, сувагжилтын систем, бусад холбогдох үйл ажиллагаа | 0.1 | 0.1 | 0.2 | 0.2 | +0.1% | +100.0% |
| Нийт борлуулалт | 20.4 | 19.8 | 24.7 | 30.2 | +22.3% | +48.0% |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

2023 онд дотоодын эдийн засгийн өсөлт үргэлжлэх эерэг төсөөлөлтэй байгаа хэдий ч коронавирусийн эрсдэл, БНХАУ-ын хөл хорио, эрчим хүчний тасалдал, тээвэр шатахууны үнийн өсөлт нь хүлээгдэж буй эрсдэлүүд хэвээр байгаа юм.

2022 оны урьдчилсан гүйцэтгэлээр аж үйлдвэрийн голлох салбарын борлуулсан бүтээгдэхүүн цар тахлын өмнөх үетэй харьцуулахад 48.0 хувиар, 2021 онтой харьцуулахад 22.3 хувиар тус тус нэмэгджээ. Энэхүү өсөлтөөс харахад манай улсын аж үйлдвэрийн салбарын борлуулалт 2022 онд цар тахлын өмнөх үеэс ч өндөр борлуулалттай байжээ.

## Инфляц, хүү ба Мөнгөний бодлого

Инфляцын түвшин 2022 оны 12 дугаар сарын эцэст улсын хэмжээнд 13.2 хувь, Улаанбаатар хотод 12.9 хувь тус тус гарсан ба хэрэглээний үнийн өсөлтийн тал орчим хувийг импортын барааны үнийн өсөлт эзэлж байна. Төв банкнаас 2022 онд мөнгөний хатуу бодлого баримталж, бодлогын хүүг эрчимтэй өсгөсөн ба өнгөрсөн оны эхэнд 6.0 хувь байсан бодлогын хүүг 13.0 хувь хүртэл нэмэгдүүлсэн.

*График 27. Инфляцын түвшин ба Бодлогын хүү, (хувиар)*




*Эх сурвалж: Монголбанк*

*График 26. Монгол Улсын 2023 оны инфляцын төсөөлөл*




*Эх сурвалж: Олон улсын санхүүгийн байгууллагуудын тайлан*

Олон Улсын санхүүгийн байгууллагууд Монгол Улсын 2023 оны инфляцын түвшинг 7.5-12.2 хувийн хооронд байхаар төсөөлж байна. Харин Монголбанкны хувьд 2023 онд дотоодын инфляц Төв банкны зорилтот түвшинд (6%±2%) ойртож 9.1 хувьд хүрнэ гэж үзжээ.

*График 29. Мөнгөний нийлүүлэлт, М2 мөнгө, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: ҮСХ*

*График 28. Мөнгөний нийлүүлэлт, эх үүсвэр талаас, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: ҮСХ*

MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

Мөнгөний нийлүүлэлт 2021 оны жилийн эцэст 27.8 их наяд төгрөгт хүрч байсан бол 2022 оны 01 дүгээр сард 26.8 их наяд төгрөг болж Монголбанкны мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр 3.8 хувиар буурсан. Харин 2022 оны 04 дүгээр сараас эхлэн M2 мөнгөний хэмжээ сард дунджаар 27.3 их наяд төгрөг байсан бөгөөд 2022 оны төгсгөлд 29.6 их наяд төгрөгт хүрч оны эхнээс 10.6 хувиар өсжээ.

*График 31. Шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү, валютаар, (хувиар)*




*Эх сурвалж: Монголбанк*

*График 30. Бодлогын хүү ба хадгаламжийн хүүний хоорондын хамаарал*




*Эх сурвалж: Монголбанк*

Мөнгөний нийлүүлэлт ийнхүү өсөхөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хэрэгжиж байсан харилцах, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй байх хуулийн хэрэгжилт дуусаж байгаатай холбоотойгоор иргэдийн харилцах, хадгаламжийн үлдэгдэл нэмэгдсэн нь нөлөөлсөн.

*График 33. Аж ахуй нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: ҮСХ*

*График 32. Чанаргүй зээл, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: ҮСХ*

Банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 онд 22.2 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 6.5 хувиар өсжээ. Харин нөгөө талд чанаргүй зээлийн хэмжээ 2021 оны цар тахлын оргил түвшнээс аажмаар буурч 2.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Дотоодын эдийн засгийн суурь нөхцөл байдал тогтворжихын хэрээр зээл олголт нэмэгдэх, эргэн төлөлт сайжрах төлөв харуулж байна.

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү Төв банкны бодлогын хүүгийн өсөлттэй шууд хамааралтай нэмэгдэж, 2022 оны 12 дугаар сарын статистик мэдээллээр 15.7 хувьд хүрчээ. Энэ нь оны эхнээс 1.3 пунктээр өссөн үзүүлэлт юм.

*График 35. Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү, (хувиар)*




*Эх сурвалж: ҮСХ*

*График 34. Иргэдийн ипотекийн зээлийн үлдэгдэл ба зээлдэгчийн тоо*




*Эх сурвалж: ҮСХ*

Иргэдэд олгосон ипотекийн зээлийн үлдэгдэл 2022 оны эхний 12 сарын байдлаар 6.4 их наяд төгрөгт хүрсэн ба зээлдэгчдийн тоо 108.6 мянгад хүрч өмнөх оноос 4.0 хувиар өсжээ. Ипотекийн зээлийн эргэн төлөлтөө хойшлуулсан иргэд 2023 оны 01 дүгээр сараас эхлэн зээлээ үргэлжлүүлэн төлж эхлэх учраас ипотекийн зээл гаргалт нэмэгдэх хүлээлттэй байна.

## Гадаад худалдаа ба экспорт

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2020 оны 02 дугаар улирлаас хойш ашигтай гарч байгаа бөгөөд өсөн нэмэгдэх дүнгээр 2022 онд 12.5 тэрбум ам.долларын экспорт, 8.7 тэрбум ам.долларын бараа, үйлчилгээ импортолсон байна. Манай улсын экспортын хэмжээ 2022 онд 2019, 2021 онуудаас тус бүр харгалзан 64.6 болон 35.6 хувиар өндөр байна.

*График 37. Гадаад худалдааны тэнцэл ба экспорт, (сая ам.доллар)*




*Эх сурвалж: ҮСХ*

*График 36. Урсгал дансны тэнцэл, (сая ам.доллар)*




*Эх сурвалж: ҮСХ*

Монгол Улсын 2022 оны экспортын борлуулалтын орлого 10,997.7 сая ам.долларт хүрсэн ба өмнөх оны өссөн дүнгээс 3,088.2 сая ам.доллар буюу 39.0 хувиар нэмэгдсэн байна. Экспортын орлого өсөхөд нүүрсний экспортын биет хэмжээ 97.5 хувиар, зэсийн баяжмал болон алтны биет экспорт харгалзан 13.3 ба 14.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

*Хүснэгт 20. Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, жилээр*

| Барааны нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | | Өсөлт | Борлуулалт, сая ам.доллар | | Өсөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | | 2021 | 2022 | |
| Зэсийн баяжмал | мян.т | 1,282.5 | 1,453.3 | +13.3% | 2,899.9 | 2,734.8 | -5.7% |
| Нүүрс | сая.т | 16.1 | 31.8 | +97.5% | 2,779.5 | 6,502.7 | +134.0% |
| Алт | т | 17.2 | 19.7 | +14.5% | 1,004.5 | 1,127.4 | +12.2% |
| Төмрийн хүдэр | мян.т | 7,106.2 | 4,732.2 | -33.4% | 952.2 | 391.0 | -58.9% |
| Боловсруулаагүй газрын тос | мян.бар | 4,348.9 | 2,605.7 | -40.1% | 273.4 | 241.8 | -11.6% |
| Нийт | | | | | 7,909.5 | 10,997.7 | +39.0% |

*Эх сурвалж: ҮСХ*

Монгол Улсын гадаад худалдааны гол түнш орнууд болох БНХАУ, ОХУ-ын дотоодын нөхцөл байдал, эдийн засгийн идэвхжил нь манай улсын экспортын орлого, уул уурхайн гаралтай түүхий эдийн эрэлтийг шууд тодорхойлж байна.

*График 39. Экспорт, гол түнш улсаар, 2022 он*




*График 38. Импорт, гол түнш улсаар, 2022 он*




*Эх сурвалж: ҮСХ*

Манай улсын БНХАУ руу экспортолсон нийт бараа, бүтээгдэхүүний 56.8 хувийг чулуун нүүрс, 25.9 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар Улсад экспортолсон барааны 99.7 хувийг алт эзэлж байна. Харин импортын худалдааны хувьд ОХУ-аас импортолсон барааны 60.6 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон барааны 67.3 хувийг суудлын автомашин тус тус эзэлж байна.

### Валютын ханш ба Гадаад валютын нөөц

Төгрөгийн голлох валютуудтай харьцах өдрийн ханшийн графикийг 2019 оноос хойших Монголбанкнаас зарласан ханшаар харвал ам.долларын ханш 2022 оны эцэст 3443.4 төгрөг, ОХУ-ын рубль 48.9, БНХАУ-ын юань 494.1 байгаа бол БНСУ-ын вон 2.7 төгрөгтэй тэнцэж байна.

*График 40. Голлох валютуудын ханшийн хөдөлгөөн*




*Эх сурвалж: Монголбанк*

Ам.долларын ханш АНУ-ын Холбооны нөөцийн сангийн бодлогын хүүгийн 2022 оны огцом өсөлттэй холбоотой бусад валютын эсрэг чангараад байна. Юань болон воны ханш харьцангуй тогтвортой байгаа бол рублийн ханш 2022 оны Украины дайн эхэлсэн үед огцом суларч, эргэн чангарсан нь дээрх графикаас харагдаж байна.

*График 42. Гадаад валютын албан нөөц, (сая ам.доллар)*




*Эх сурвалж: ҮСХ*

*График 41. Урсгал дансны алдагдал, ам.долларын ханш ба Гадаад валютын нөөц*




*Эх сурвалж: ҮСХ*

Гадаад валютын албан нөөц 2022 оны 01 дүгээр улирлаас эхлэн 3 улирал дараалан буурсан ба 2022 оны 9 дүгээр сарын байдлаар 2.7 тэрбум ам.долларт хүрч

сүүлийн 4 жилийн хамгийн доод түвшинд хүрчээ. Өнгөрсөн оны 4 дүгээр улиралд ГВАН дахин сэргэж 3.4 тэрбум ам.долларт хүрсэн хэдий ч цар тахлын өмнөх үеэс 27.9 хувиар бага байна.

2022 онд гадаад валютын албан нөөц ба ам.долларын хооронд эсрэг хамаарал бүхий хөдөлгөөн ажиглагдаж эхэлсэн бөгөөд урсгал дансны тэнцлийн алдагдал төгрөгийн ханшид дарамт үзүүлсэн хэвээр байна.

## Сангийн бодлого ба засгийн газрын өр

Монгол Улсын Засгийн газрын нийт өр 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 30.1 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 11.1 хувь өссөн байна. 2020 онд Монгол Улсын засгийн газрын нийт өр өмнөх оноос 4.0 орчим их наяд төгрөг буюу 16.7 хувиар өссөн нь Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын хүндрэлийг даван туулахын тулд халамж болон татаасыг (тог, усны төлбөрийг хөнгөлөх, татварыг бууруулах гэх мэт) иргэд, аж ахуй нэгжүүдэд олгосноос бий болжээ.

*График 44. Төсвийн нийт орлого, зарлага ба тэнцвэржүүлсэн тэнцэл, (их наяд төгрөг)*




*Эх сурвалж: ҮСХ*

*График 43. Засгийн газрын нийт өр ба эргэн төлөлт, (их наяд төгрөг)*




*Эх сурвалж: ҮСХ*

Засгийн газраас өрийн эргэн төлөлтийн ахиц маш удаан байгаа бөгөөд 2019-2022 оны 3 дугаар улирал хүртэл нийт 8.5 их наяд төгрөгийн үндсэн төлбөр ба хүүгийн төлбөр төлөлт хийсэн нь 30.1 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдлийн дөнгөж 28.2 хувийг эзэлж байна.

## Хөдөлмөрийн зах зээл

Монгол Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 2022 оны 4 дүгээр улиралд 5.3 хувьд хүрч, өмнөх улирлаас 0.1 пунктээр буурсан эерэг үзүүлэлттэй байсан. Харин хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувь нь идэвхтэй хөдөлмөр эрхэлж буй харуулдаг хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.9 нэгжид хүрч, өмнөх сараас 1.1 нэгжээр муудсан байна.

*График 46. Ажилгүйдлийн түвшин, (хувиар)*




*Эх сурвалж: ҮСХ*

*График 45. Ажиллах хүчний оролцооны түвшин ба хөдөлмөр эрхлэлтийн түвшин*




*Эх сурвалж: ҮСХ*

Монгол Улсад 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар ажил эрхэлж буй нийт иргэдийг насны бүлгээр ангилбал 35-39 насныхан хамгийн их буюу 15.8 хувь, 20 хүртэлх насныхан хамгийн бага буюу 1.3 хувийг тус тус эзэлж байна.

Харин манай улсаас гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр БНСУ руу 211, Япон Улс руу 69, нийт 280 хүн 2022 оны 4 дүгээр улиралд зуучлагдсан нь өмнөх улирлаас 52 хүнээр өссөн байна.

## 3.1.2. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### Хөрөнгийн зах зээлийн үндсэн үзүүлэлтүүд

Монгол Улсын ТОП-20 индекс 2022 онд 36,177.8 хүрч өнгөрсөн оноос 13.2 хувиар буурсан хэдий ч, цар тахлын өмнөх 2019 оны түвшнээс 1 дахин өссөн үзүүлэлттэй байна. Хөрөнгийн зах зээл дотоодод ийнхүү идэвхжихэд коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын нөлөөгөөр ухаалаг гар утсанд зориулсан брокерын аппликэйшний хялбар шийдлүүд олноор гарч, хөл хорионд байсан иргэд сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөө хөрөнгийн зах зээл рүү оруулах сонирхол өссөн нь нөлөөлжээ.

*График 48. Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс*




*Эх сурвалж: ҮСХ*

*График 47. Үнэт цаасны гүйлгээний дүн (сая төгрөг) ба ТОП-20 индекс дундаж*




*Эх сурвалж: ҮСХ*

Үнэт цаасны гүйлгээний дүн 2022 онд 170.4 тэрбум төгрөгт хүрч, 2021 оноос 4 дахин өссөн түүхэн өсөлтийг үзүүлэв. Энэхүү өсөлтөд системийн нөлөө бүхий банкнуудын хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгох үйл ажиллагаа эхэлсэн нь шууд нөлөөлөв.

2022 оны 10 дугаар сард Төрийн банк олон нийтээс 25.4 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн бол мөн оны 11 дүгээр сард Голомт банк 118.7 тэрбум төгрөгийг амжилттай татсан юм. Энэ хоёр банкны IPO үйл ажиллагааны нөлөөгөөр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 1.5 их наяд орчим төгрөгөөр нэмэгдэв.

*График 50. Зах зээлийн үнэлгээ, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: ҮСХ*

*График 49. Зах зээлийн үнэлгээ ба ДНБ-ий харьцаа*




*Эх сурвалж: ҮСХ*

Сүүлийн байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 оны нэрлэсэн ДНБ-тэй харьцуулахад 15.8 хувьтай тэнцэж байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн идэвхжил сүүлийн 3 жилд ийнхүү өндөр байсан нь компаниуд нээлттэй байдлаар олон нийтээс санхүүжилт татах сонирхол, эрэлт хэрэгцээ нэмэгдсэн нь нөлөөлсөн байх талтай юм.

Тухайлбал, Монголын хөрөнгийн бирж дээр 2022 онд нийт 6 компани анхдагч зах зээл дээр 175.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцаагаа олон нийтэд арилжаалж хөрөнгө оруулалт татсан бол 5 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаар 85 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна.

Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

### 3.1.3. ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ХУРААНГУЙ

*Хүснэгт 21. Макро эдийн засгийн төлөв байдалд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс*

| | Эрсдэл | Боломж |
|---|---|---|
| **Инфляц** | • ОХУ-аас экспортлох шатахуун, эрчим хүчний үнийн өсөлт нь үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлэх эрсдэлтэй<br>• Улаан буудайн үрийн хомсдол, махны үнийн өсөлт нь хэрэглээний үнийн өсөлтийг өдөөж өрхийн хэрэглээг бууруулах эрсдэлтэй<br>• Экспортын түүхий эд, материалын үнийн өсөлт нь үйлдвэрлэлийн зардлыг өсгөж, улмаар эцсийн бүтээгдэхүүний үнийг өсгөх эрсдэлтэй | • Цаг агаарын тогтуун нөхцөл байдал нь ургац хураалт, малын хоргодолд эерэгээр нөлөөлж мах, гурил, сүү, хүнсний ногоо гэх мэт өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт саарах<br>• БНХАУ-ын хилийн хориг суларснаар гадаад худалдааны эргэлт сайжирч, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдэх, үнэ буурах нөхцөл бүрдэх<br>• Коронавирусийн хөл хорио суларч, энгийн түвшин рүү шилжсэн нь бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулах нөлөө үзүүлэх төлөвтэй |
| **Эдийн засгийн өсөлт** | • Үнийн өсөлтөөс шалтгаалж эрэлт буурах, өрхийн эцсийн хэрэглээ хумигдах эрсдэлтэй<br>• Төв банкны мөнгөний хатуу бодлого 2023 онд үргэлжилбэл зээл гаргалт саарах, хөрөнгө оруулалт буурах эрсдэлтэй<br>• Хилийн саад, тээврийн зардлын өсөлт нь экспортын хэмжээнд сөргөөр нөлөөлөх, эргэцийг удаашруулах эрсдэлтэй | • Нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдэж, гадаад худалдааны борлуулалт өсөх<br>• Оюутолгойн гүний уурхайн олборлолт 2023 оноос эхлэж гадаа худалдааны орлого өсөх, татварын орлого нэмэгдэх боломжтой<br>• Коронавирусийн хөл хорио суларсантай холбоотой худалдаа, үйлчилгээний салбар өсөх боломжтой |
| **Мөнгөний бодлого** | • Мөнгөний бодлогын хүү нэмэгдэх, зээл хумигдах эрсдэлтэй байх<br>• Монгол Улсын саарал жагсаалт руу орох эсвэл олон улсын байгууллагын зохицуулалтад орох эрсдэл үүсэж болзошгүй | • Эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор бодлогын хүү аажмаар буурах нөхцөл бүрдэх боломжтой.<br>• Сангийн бодлоготой уялдаж, инфляцын түвшин Төв банкны зорилтот түвшинд хүрэх |
| **Сангийн бодлого** | • Төсвийн орлогыг бүрдүүлэх зорилгоор татвар нэмэх, иргэд, аж ахуй нэгжийн татварын ачаалал нэмэгдэх эрсдэлтэй<br>• Засгийн газрын гадаад өрийн дарамт нэмэгдэх, зээлжих зэрэглэл буурах | • Засгийн газраас дэд бүтцэд зориулсан хөрөнгө оруулалтыг хийснээр эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжтой<br>• Төсвийн урсгал зардлыг бууруулж, урт хугацааны хөрөнгө оруулалтыг хийх, төсвийг үр ашигтай зарцуулж Мөнгөний бодлогыг дэмжих |

*Эх сурвалж: Андеррайтерийн шинжилгээ*

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9011031195 СТС2420

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12 өдөр

Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

## 3.2. БАНК БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ

### Банк бус санхүүгийн салбарын үзүүлэлтүүд

Монгол Улсын банк бус санхүүгийн салбарт 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 513 ББСБ үйл ажиллагаа идэвхтэй эрхэлж байна. Тусгай зөвшөөрлийн хувьд Хорооноос зээлийн үйл ажиллагааг дагнан эрхэлдэг 307 ББСБ байгаа бол факторинг 45, итгэлцлийн үйлчилгээг эрхлэх 64, цахим төлбөр тооцоо мөнгөн гүйвуулгын 37 ББСБ тус тус байна.

*График 52. ББСБ-ын тоо ба харилцагчдын тоо (сая хүнээр)*




*Эх сурвалж: СЗХ*

*График 51. ББСБ-ын салбарын харилцагчдын тоо, зээлдэгчдийн тоо*




*Эх сурвалж: СЗХ*

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2022 оны 4 дүгээр улиралд 3.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд банкны салбарын нийт хөрөнгийн 7.7 хувьтай тэнцэж байна. Чанаргүй зээлийн хувь ББСБ-ын салбарт 7.6 хувьтай байгаа нь өнгөрсөн оноос 0.6 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт болжээ.

*График 54. ББСБ-ын салбарын нийт хөрөнгө ба зээл, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: СЗХ*

*График 53. ББСБ-ын салбарын нийт хөрөнгийн бүтэц, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: СЗХ*

Нийт хөрөнгийн бүтцийг авч үзвэл цар тахлын өмнө буюу 2019 онд нийт хөрөнгөө өр төлбөрөөр санхүүжүүлсэн хувь 27.1 хувийг эзэлж байсан бол 2022 оны 4 дүгээр улирал гэхэд 37.8 хувийг өр төлбөр эзэлж байна. Өөрийн хөрөнгийн дүн 2022 оны 4 дүгээр улиралд 2.2 их наяд төгрөгт хүрсэн нь ашигт ажиллагаа сайжирсантай холбоотой юм.

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
2021031195 СТС2420

Банк бус санхүүгийн салбарын нийт өр төлбөрийн хэмжээ нэмэгдэж буй нь шинээр Биржийн бус зах зээл дээр хаалттай өрийн хэрэгсэл гаргах, богино хугацаатай репо санхүүжилт татах боломж нээгдсэн нь нөлөөлсөн.

*График 56. Банк бус санхүүгийн салбарын нийт орлого ба ашгийн маржин*




*Эх сурвалж: СЗХ*

*График 55. Банк ба банк бус санхүүгийн салбарын зээлийн хүүгийн харьцуулалт*




*Эх сурвалж: СЗХ*

Банк бус санхүүгийн салбарт нийт харилцагчдын тоо давхардсан тоогоор уламжлалт зээлийн үйлчилгээнд 266.5 мянган хүн байгаа бол гар утсаар дамжуулан хялбар зээл авах боломжтой финтек үйлчилгээний харилцагчдын тоо даруй 16 дахин өндөр буюу 4.3 сая хүрчээ. Зээлдэгчдийн тоо мөн уламжлалт болон финтек зах зээлд 1:4 байна.

*График 58. Банк бус санхүүгийн салбарын чанаргүй зээлийн хувь*




*Эх сурвалж: СЗХ*

*График 57. Банк бус санхүүгийн салбарын банкны салбартай харьцуулсан үзүүлэлт*




*Эх сурвалж: СЗХ*

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын чанаргүй зээлийн хувь 2020 онд цар тахлын хөл хорионы улмаас эргэн төлөлт муудаж 10.3 хувьд хүрч өссөн. 2022 оны 4 дүгээр улиралд ББСБ-ын салбарын чанаргүй зээлийн хувь 7.6 хувьд байна. ББСБ-ын салбарын компаниудын хувь нийлүүлсэн хөрөнгө нь банкны салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 78.8 хувьтай тэнцэж байна.

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 оны 05, 12 өдөр
БҮРТГЭВ

Үнэт цаасны танилцуулга
2023-03-2
БҮРТГЭВ-02

### ББСБ-ын балансын нэгдсэн үзүүлэлтийн шинжилгээ

Монгол Улсын ББСБ-ын салбарын нийт хөрөнгийн эх үүсвэр талыг авч үзвэл банк бус санхүүгийн байгууллагууд нь өр төлбөрийн санхүүжилтийнхээ 28.5 хувийг итгэлцэл татсанаар, 17.1 хувийг өрийн хэрэгслээр, 29.7 хувийг бусад банк, санхүүгийн байгууллагаас татсан зээлийн өглөгөөр бүрдүүлж байна.

*График 60. ББСБ-ын салбарын өр төлбөрийн санхүүжилтийн бүтэц, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: СЗХ*

*График 59. ББСБ-ын салбарын өөрийн хөрөнгийн бүтэц, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: СЗХ*

Тухайн ББСБ-ын Эрсдэл даах чадамжийг харуулдаг гол үзүүлэлт болох өөрийн хөрөнгийн дүн 2022 оны 4 дүгээр улиралд 2,191.6 тэрбум төгрөг буюу 21.8 хувиар өсжээ. Тайлант хугацаанд ББСБ-ын салбарын өөрийн хөрөнгийн 35.4 хувийг эдгээр компаниудын хуримтлагдсан ашиг эзэлж байна.

*График 62. ББСБ-ын салбарын өр төлбөрийн бүтэц, үйлчилгээний төрлөөр (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: СЗХ*

*График 61. Нийт зээл (тэрбум төгрөг) ба чанаргүй зээлийн хувь*




*Эх сурвалж: СЗХ*

ББСБ-ын өр төлбөрөөр санхүүжилтээ бүрдүүлж буй эх үүсвэрүүдийг задалбал уламжлалт зээл дээр төвлөрсөн ББСБ-ууд нь бусад банк, санхүүгийн байгууллагаас зээллэг хэлбэрээр эх үүсвэр татаж санхүүжилтээ бүрдүүлдэг.

Харин финтект суурилсан ББСБ-ууд өрийн бичиг гаргах байдлаар хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг идэвхтэй ашигладаг байна. ББСБ-ын салбарын нийт зээлийн үлдэгдлийн 53.8 хувийг уламжлалт зээл, 46.2 хувийг финтек зээлүүд эзэлж байна.

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023.05.12

Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02

Нийт зээлийн үлдэгдлээр нь харьцуулбал нэг зээлдэгчид олгож буй зээлийн хэмжээнээс хамаарч финтек үйлчилгээний багц харьцангуй бага байгаа хэдий ч зээлийн чанар уламжлалт зээлээс сайн байгаа нь хамгийн сонирхолтой үзүүлэлт бөгөөд олон жижиг зээлээр зээлийн багцын эрсдэлээ тархаан байршуулж чадаж байгааг илтгэж байна.

*График 64. ББСБ-ын салбарын иргэдийн зээлийн бүтэц, зориулалтаар*




*Эх сурвалж: СЗХ*

*График 63. Аж ахуй нэгжид олгосон зээлийн бүтэц, зориулалтаар*




*Эх сурвалж: СЗХ*

ББСБ-ын салбарын иргэдийн зээлийн 38 орчим хувь нь хэрэглээний зээлд төвлөрсөн бол, дараагийн хамгийн эрэлттэй зээлийн бүтээгдэхүүн нь автомашины зээл болон хувиараа бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн бүтээгдэхүүнүүд байна.

*График 66. ББСБ-ын салбарын "Ногоон зээл"-ийн үлдэгдэл, (сая төгрөг)*




*Эх сурвалж: СЗХ*

*График 65. Зээлийн хүүгийн харьцуулалт*




*Эх сурвалж: СЗХ*

Бизнесийн санхүүжилтэд хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах чиглэлээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тогтвортой, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх зорилгоор "Ногоон хөгжлийн сэргэлтийн бодлого"-ыг хэлэлцэн, зөвлөмж гаргасан байдаг.

Энэхүү зөвлөмжид "Ногоон зээлийг банкны салбарт 10 хувь, ББСБ-д 5 хувьд хүргэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх..." талаар тусгаж, Монгол Улсын ББСБ-ын салбарт "Ногоон зээл"-ийн тайланг авч эхлээд байна.

Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02

## ББСБ-ын салбарын хураангуй тойм

*Хүснэгт 22. ББСБ-ын салбарын хураангуй тойм*

| | Эрсдэл | Боломж |
|---|---|---|
| **Эх үүсвэр татах чадамж** | • Төв банкны бодлогын хүүгийн өсөлттэй холбоотой эх үүсвэрийн зардал нэмэгдэх;<br>• Үнэт цаас гаргагчийн эргэн төлөлтийн чадамж буурах, төлбөрийн чадварын эрсдэл учрах;<br>• Зохицуулагч байгууллагын өрийн хэрэгсэл татах журам өөрчлөгдөх, шалгуур нэмэгдэх;<br>• Хөрөнгийн зах зээлийн савалгаа нь хөрөнгө оруулагчдын эрсдэлийн мэдрэмжийг өсгөх; | • Богино хугацаат мөнгөний зах дээрээс репо санхүүжилт татах боломж, багтаамж нэмэгдсэн;<br>• Биржийн бус зах зээл дээр компанийн өрийн хэрэгсэл гаргах боломжтой болсон;<br>• Макро эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдал нь тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгслийн эрэлтийг өсгөх;<br>• Биржийн нээлттэй зах зээл дээр бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэх мэт санхүүжилт татах хэрэгсэл нэмэгдсэн; |
| **Активын чанарыг хангах** | • Эдийн засгийн эрсдэлтэй орчинд барьцаагүй, гар утсаар олгодог хялбар зээл гаргалт нэмэгдсэнээр зээлийн активын чанар буурах;<br>• Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг тогтмол хянах компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо доголдох;<br>• Зээлийг анхан шатнаас эхлэн судлах, олгох, эргэн төлүүлэхэд мэргэжлийн, туршлагатай хүний нөөцийн хомсдол учрах; | • Ковидын дараах эдийн засгийн сэргэлт нь зээлийн эргэн төлөлтийг сайжруулах суурь нөхцөл болох;<br>• Бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ нь ковидын дараах сэргэлтийн мөчлөг дээр явж байгаа;<br>• Зээлдэгчийн талаар мэдээлэл цуглуулалт, мэдээллийн чанар сайжирч байгаа нь кредит скоринг тогтооход эерэгээр нөлөөлөх; |
| **Финтек үйлчилгээний өрсөлдөөн** | • Зээлийн аппликэйшн хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой тогтмол зардал өсөх;<br>• Барьцаагүй, гар утсаар олгодог зээлийн эргэн төлөлт эрсдэх:<br>• Финтек үйлчилгээтэй холбоотой брендинг, олонд таниулах зар сурталчилгааны өрсөлдөөн ширүүсэх; | • Хүний оролцоотой шийдвэр гаргалт, алдааг бууруулж автоматжуулснаар зардал хэмнэх;<br>• Харилцагчдын тоогоо богино хугацаанд өсгөж, сайн зээлдэгчдийн мэдээллийн сан бүрдүүлэх;<br>• Зээл олголтоо гар утасны аппликейшнээр шийдсэнээр, санхүүжилтээ хурдан хугацаанд зээл рүү хувиргаж өгөөж хүртэх боломжтой; |
| **Ногоон зээл, тогтвортой санхүүжилт** | • Дэлхийн дахинд эдийн засгийн өсөлт удааширч байгаа учраас ногоон зээлд байршуулах эх үүсвэр буурах;<br>• Ногоон зээлийн ашгийн бага маржин нь компаниудад бусад зээл гаргалтаа нэмэх хөшүүрэг болох; | • Хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжсэнээр зээлийн эрсдэл буурах, хүү буурах үндэс болох;<br>• Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, тогтвортой зээлийн эх үүсвэрийг олон улсын байгууллагуудаас татах; |

*Эх сурвалж: Андеррайтерийн шинжилгээ*

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9021031195 СТС2420

Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

### 3.3. ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөлтэй 37 ББСБ финтек зээлийн үйлчилгээг үзүүлж байна. Зах зээл дээр хэрэглэгч нарт хамгийн өргөн тархсан топ 4 ББСБ нь салбарын нийт хөрөнгийн 24.6 хувийг эзэлж байгаа ба салбарын нийт харилцагчдын 4.3 хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэж байна.

*Схем 15. ББСБ-ын хөрөнгийн төвлөрөл ба зах зээлд эзлэх байр суурь*




**25%:** хамгийн их хөрөнгөтэй 4 ББСБ салбарын нийт хөрөнгийн 24.6%-ийг эзэлж байна.

**50%:** хамгийн их хөрөнгөтэй 19 ББСБ салбарын нийт хөрөнгийн 50%-ийг, харилцагчдын 87%-ийг хамарч байна.

**75%:** хамгийн их хөрөнгөтэй 102 ББСБ нь салбарын нийт хөрөнгийн 75%, харилцагчдын 97%-д хүрч чадсан.

*Эх сурвалж: СЗХ*

Хорооноос тусгай зөвшөөрөлтэй 513 ББСБ-аас ердөө 19 ББСБ нь салбарын нийт хөрөнгийн 50 хувийг эзэлж байна. Эндээс харахад салбарын нийт хөрөнгө цөөн банк бус, санхүүгийн байгууллагад төвлөрсөн байгааг харуулахын зэрэгцээ өрсөлдөөн ширүүсэж байгааг илтгэж байна.

*Хүснэгт 23. Цахим зээл олгож байгаа аппликэйшнуудын таталт, (PlayStore)*

| 10-50 мянга хүртэл | 50-100 мянга хүртэл | 100-500 мянга хүртэл | 500 мянгаас дээш |
|---|---|---|---|
| Tugrug App | Nsf.mn | Tus Fintech | Monpay |
| PayOn | Opay | Simple | Toki |
| Sendly | Green Fintech | Numur | Pocket |
| Cashone | Naizly | HiPay | LendMN |
| Entcreditmn | Nano Capital | MoniDigital | Sono |
| GSB | MyCredit | **БИД апп** | Ard |
| Gate | | Zeely | |
| Хасхаан | | Net app | |
| Ufinance | | Zeel.mn | |
| | | Qmoni | |
| | | Most Money | |
| | | 100k.mn | |

*Эх сурвалж: СЗХ*

Зах зээл дээр хэрэглэгчдийн дунд хамгийн их хандалттай буюу плэйстор (PlayStore) дээрээс хамгийн өндөр таталттай аппликэйшнүүдээс сонгон авч харьцуулсан судалгаа хийхэд БИД, Симпл, Покет, Соно, Нөмөр гэх мэт зээлийн аппликэйшнүүд нь харилцан адилгүй нөхцөлтэй байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын гаргасан доорх 10 финтек аппликэйшнээс хамгийн урт хугацаатай зээл олгодог аппликэйшнууд нь Симпл, ТусАпп, Соно апп байна. БИД аппликейшний хувьд зээл олгох дээд хугацаа нь харьцангуй богино буюу 6 сар байдаг. Хүүгийн түвшний хувьд дундаж буюу 3.0 хүртэлх хувиар зээл олголтоо гаргадаг байна.

*Хүснэгт 24. Финтек зээлийн аппликэйшнүүдын бүтээгдэхүүний нөхцөлийн харьцуулалт*

| № | Апп | Харьяалагдах ББСБ нэр | Хувааж төлөх нөхцөлтэй эсэх | Хүү, Шимтгэл | Зээлийн доод хэмжээ, төгрөг | Зээлийн дээд хэмжээ | Зээлийн дээд хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | **Бид Апп** | **"Бизнес-Инвест девелопмент" ББСБ** | **Тийм** | **0.5%-3.0%** | **50,000** | **1,000,000** | **6 сар** |
| 2 | Симпл | "Ашид капитал ББСБ" ХХК | Тийм | 2.3%-3.0% | 100,000 | 20,000,000 | 24 сар |
| 3 | pocket Покет | "Инвескор хэтэвч ББСБ" ХХК | Тийм | 1.0-4.5% | 20,000 | 10,000,000 | 60 хоног |
| 4 | ЛэндМН | "ЛэндМН ББСБ" ХК | Үгүй | 3.0%-4.0% | 50,000 | 50,000,000 | 30 хоног |
| 5 | АрдАпп | "Ард Кредит ББСБ" ХК | Тийм | 4.0-6.0% | 50,000 | 10,000,000 | 6 сар |
| 6 | numur Нөмөр | "Нөмөр Кредит ББСБ" ХХК | Тийм | 4.5-5.9% | 50,000 | 2,000,000 | 9 сар |
| 7 | Zeely Зээлий | "Хатан суудал инвест ББСБ" ХХК | Тийм | 3.0%-6.0% | 50,000 | 500,000 | 90 хоног |
| 8 | ТусАПП | "Тус финтек ББСБ" ХХК | Тийм | 3.0% | 50,000 | 1,500,000 | 24 сар |
| 9 | sono СоноАпп | "Соно финтек ББСБ" ХХК | Тийм | 6.2-8.1% | 100,000 | 2,500,000 | 12 сар |
| 10 | Нэт Пэй | "Нэткапитал финанс корпораци ББСБ" | Тийм | 3.3%-8.0% | 50,000 | 2,000,000 | 30 хоног |

*Эх сурвалж: Андеррайтерийн түүвэр судалгаа*

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани хэлбэртэй 4 ББСБ-тай харьцуулах байдлаар БИД ББСБ-ын зах зээлд эзлэх хувийг тодорхойлбол 11.7 хувьтай дүйцэж байна. Зах зээлд эзлэх хувийг тооцохдоо тухайн ББСБ-ын нийт хөрөнгийн дүнг 2022 оны жилийн эцсийн байдлаар МХБ дээрх нээлттэй эх сурвалжаас авч тооцов.

*Схем 16. Нээлттэй ХК ББСБ-уудтай харьцуулсан зах зээлд эзлэх хэмжээ*




*Эх сурвалж: МХБ*

Нээлттэй ББСБ-ын зээлийн чанаргүйдлийг 2022 оны жилийн эцсийн байдлаар БИД ББСБ-тай харьцуулахад Ард Кредит ББСБ, болон Сэндли ББСБ-аас зээлийн чанар өндөр байна. Мөн өөрийн хөрөнгийн өгөөжийн хувьд Ард Кредит ББСБ, Сэндли ББСБ-аас өндөр үр ашигтайгаар өөрийн хөрөнгөө ашиглаж байна.

*График 68. Нээлттэй ББСБ-тай харьцуулсан өөрийн хөрөнгийн өгөөйн харьцуулалт*




*График 67. Нээлттэй ББСБ-тай харьцуулсан чанаргүй зээлийн хувь*




*Эх сурвалж: МХБ*

Зах зээлд танигдсан зээлийн аппликэйшнүүдийг нэмэлт олгож буй үйлчилгээгээр харьцуулбал Ард болон Покет аппликэйшн нь хөгжүүлэлт, олон төрлийн санхүүгийн үйлчилгээгээр ялгарч байна. БИД аппликэйшний хувьд мерчант, лизингийн зээл олгодог ба ногоон, эко зээлийг аппаар дамжуулан олгодгоороо бусад аппликэйшнүүдээс ялгарч байна.

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12 өдөр

Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ 02

*Хүснэгт 25. Финтех аппликэйшнүүдийн нэмэлт үйлчилгээний харьцуулалт*

| № | Апп | Харьяалагдах ББСБ нэр | Мерчант зээл олгодог эсэх | Лизинг зээл олгодог эсэх | Нэмэлт үйлчилгээ, боломж |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Бид Апп** | **“Бизнес-Инвест девелопмент” ББСБ** | + | + | Бүх банкны шилжүүлэг хийх, Qpay дамжуулан төлбөр тооцоо хийх |
| 2 | Симпл | “Ашид капитал ББСБ” ХХК | + | + | Автомашин, Бизнесийн зээл |
| 3 | Покет | “Инвескор хэтэвч ББСБ” ХХК | + | + | Автомашин, Барьцаат, Цалингийн, Бизнесийн зээл |
| 4 | ЛэндМН | “ЛэндМН ББСБ” ХК | + | + | Автомашин, Хэрэглээний, Бизнесийн зээл |
| 5 | АрдАпп | “Ард Кредит ББСБ” ХК | + | + | Мөнгөн шилжүүлэг, Үнэт цаас, даатгал, хадгаламж |
| 6 | Нөмөр | “Нөмөр Кредит ББСБ” ХХК | - | + | Оюутны зээл, Эмэгтэйчүүдийн зээл |
| 7 | Зээлий | “Хатан суудал инвест ББСБ” ХХК | - | - | Өрхийн СӨХ төлөх, Санхүүгийн сургалт |
| 8 | ТусАПП | “Тус финтек ББСБ” ХХК | - | - | - |
| 9 | СоноАпп | “Соно финтек ББСБ” ХХК | + | + | - |
| 10 | Нэт Пэй | “Нэткапитал финанс корпораци ББСБ” | + | + | - |

*Эх сурвалж: Андеррайтерийн түүвэр судалгаа*

“БИД апп”-ийн бусад зээлийн аппликэйшнүүдээс ялгарах онцлог нь харилцагч анх удаа цахим зээлийн гэрээ байгуулахдаа заавал салбар дээр биечлэн ирэх шаардлагагүй байдаг. Мөн БИД аппликэйшнийг хэтэвч байдлаар буюу бүх банкны шилжүүлэг хийх, Qpay үйлчилгээгээр дамжуулан төлбөр тооцоо хийх боломжтой байдаг.

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023.05.12 БҮРТГЭВ
Үнэт цаасны танилцуулга 2023-03-28

БИД апп нь харилцагчийг өрийн дарамтад орохоос сэргийлэхийн тулд бусад зээлийн аппликэйшнүүд дээр давхар 3 ба түүнээс дээш онлайн зээлтэй бол зээл олгохгүй байх шийдэлтэй. БИД ББСБ-ын итгэлцлийн харилцагч нар аппаасаа итгэлцийн тооцооллоо харах, мөн түүнд тохирсон зээлийн эрхийг олгодог.

## 3.4. SWOT ШИНЖИЛГЭЭ

*Хүснэгт 26. SWOT шинжилгээ*

| Давуу тал | Сул тал |
| --- | --- |
| • Компанийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн хараат бус гишүүд нь ББСБ-ын салбарт туршлагатай, нэр хүндтэй удирдлагын тогтолцоотой;<br>• Олон жил тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, ББСБ-ын салбарыг манлайлж ирсэн ба шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж байгаа;<br>• Найдвартай харилцагчдын олон жилийн бааз суурь, зах зээлд эзэлсэн нэр хүндээр тэргүүлэгч;<br>• Гар утасны хялбар зээлийн аппликйешнийг нэвтрүүлж, финтек зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж байгаа;<br>• Систем хөгжүүлэлтийн баг бүрдүүлж финтек хөгжлийг дотооддоо шийдвэрлэх боломжтой болсон; | • Компанийн брэндинг, харилцагчдын идэвхжүүлэлт бага;<br>• Финтек аппликэйшний нэвтрүүлэлт бусад зах зээлийн гол тоглогчдоос танигдалт бага;<br>• Орон нутаг дахь салбар, нэгжийн тэлэлт бага;<br>• Эх үүсвэрийн зардал нэмэгдэж буй нь ашигт ажиллагаанд нөлөөлж байна;<br>• Хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл өндөр, цөөн тооны хувьцаа эзэмшигчдээс хамааралтай;<br>• Банк бус, санхүүгийн байгууллагын салбар дахь технологийн шинэчлэлтэд хариу үйлдэл удаан; |
| **Боломж** | **Аюул** |
| • Банкны салбарын зээлийн бодлого чангарч буй үед зах зээл дээрх зээлийн эрэлтийг хангах;<br>• Төв банкны бодлогын хүүгийн өсөлттэй холбоотой хүүгийн орлого нэмэгдэх;<br>• Финтек шийдлүүд болох хэтэвч, цахим төлбөр тооцоо гэх мэт шинэ үйлчилгээг аппликэйшндээ шингээж, хэрэглэгчдийн тоогоо нэмэгдүүлэх;<br>• Биржийн болон биржийн бус зах зээлээс өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэх мэт хэрэгслээр эх үүсвэрээ тэлэх; | • Төв банкны мөнгөний хатуу бодлого, эдийн засгийн сэргэлтийн удаашралаас хамаарч зээлийн эрэлт багасах;<br>• Эдийн засгийн тодорхой бус байдал болон инфляцын өндөр орчинд эх үүсвэрийн зардал нэмэгдэх;<br>• Санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагуудын гэнэтийн шийдвэр, журмын өөрчлөлтүүд;<br>• Коронавирусийн хөл хорио, улс төрийн хурцадмал байдлаас шалтгаалж нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал үүсэх; |

*Эх сурвалж: Андеррайтерийн шинжилгээ*

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 9011031195 СТС2420



# ДӨРӨВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮ, БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 4.1. ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

БИД ББСБ нь дунд хугацаанд **фокуслах** (төвлөрөх) стратегийг баримтлан зээлийн үйлчилгээг хамгийн өндөр түвшинд шуурхай олгох үндсэн бизнесийн зорилгоо ирээдүйд хэрэгжүүлэн ажиллах юм. Ингэхдээ хүн амын төвлөрөл ихтэй төв суурин газрыг сонгон бизнесийн зээлийг олгохоос гадна, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг барин захын дүүргүүдэд салбар нээн үйлчилгээгээ сурталчлан тэлэх үндсэн төлөвлөгөөтэй байна.

### Харилцагч төвтэй бизнесийн стратеги

Үнэт цаас гаргагчийн хувьд харилцагчийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар цахим боловсролыг олгож, ирээдүйн хэрэглэгч нараа бэлдэх, урамшууллын системээр харилцагч нараа тогтоон барих стратеги барьж байна.

*График 69. Харилцагчдын тоо, төсөөлөл (2023-2027 он)*




*Эх сурвалж: БИД ББСБ*

Мөн үйлчилгээний онцгой нөхцөл, түргэн шуурхай байдлаар найдвартай харилцагчид татах зорилготой байна. Нийт харилцагчдын жилийн дундаж өсөлт 18.5 хувь байхаар төсөөлж байгаа бөгөөд онлайн зээлийн харилцагчдын өсөлт нь компанийн харилцагчдын өсөлтийг бий болгох гол бүлэг болж байна.

*График 70. Нийт зээлийн багцын өсөлт, төсөөлөл, тэрбум төгрөг, (2023-2027 он)*




*Эх сурвалж: БИД ББСБ*

БИД ББСБ-ын "БИД эх орондоо санхүүгийн хүртээмжтэй үйлчилгээгээр тэргүүлэн, салбартаа хөгжлийг тодорхойлогч нь байна" гэсэн алсын хараны дагуу жил бүр 2-3 аймагт бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нэвтрүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

*Схем 17. Хөдөө орон нутаг дахь салбарын тэлэлт*




*Эх сурвалж: БИД ББСБ*

Мөн ойрын жилүүдэд Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан шуурхай зээлийг аппликэйшнээр дамжуулан олгох хууль, эрх зүйн зохицуулалт хэрэгжих төлөвтэй байна. Энэхүү хууль, эрх зүйн таатай нөхцөл нь бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжилтөд эерэг нөлөө үзүүлэх хүлээлттэй байгаа юм.

*График 71. Зээлийн багцын орон нутаг дахь шилжилт*




*Эх сурвалж: БИД ББСБ*

Үнэт цаас гаргагч нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зээлийн багцын байршлыг орон нутагт 2022 оны байдлаарх 9.5 хувиас 20.0 хувьд хүргэж, уламжлалт зээлийн бүтээгдэхүүнийг онлайнаар олгодог болох дунд хугацааны зорилтыг дэвшүүлэн "Дунд хугацааны бизнес стратеги"-даа тусгаад байна.

*Схем 18. Орон нутаг дахь салбарын тэлэлтийн хүрээ*




*Эх сурвалж: БИД ББСБ*

## Уламжлалт зээлийн бүтээгдэхүүний стратеги

Компани нь уламжлалт бүтээгдэхүүний стратегиа тодорхойлохдоо нийт 20 зээлийн бүтээгдэхүүнээс дараах голлох бүтээгдэхүүнүүд дээр баримтлах хөгжүүлэлтийн бодлогоо тодорхойлсон байна.

*Хүснэгт 27. Уламжлалт зээлийн бүтээгдэхүүний стратеги*

| № | Зээлийн бүтээгдэхүүн | Бүтээгдэхүүний одоогийн онцлог | Стратеги |
|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн түргэн тусламжийн зээл | Ямар нэгэн бизнес төсөл, төлөвлөгөө шаардахгүйгээр, барьцаа хөрөнгө дээр нь тулгуурлан Санхүүгийн түргэн тусламжийн бүтээгдэхүүний хэмжээнд олгоно | Шинэ харилцагч татах |
| 2 | Сайн харилцагч түншлэлийн зээл | Тус ББСБ-д сайн харилцсан түүхтэй, Барьцаа хөрөнгийн түргэн борлогдох үнэлгээ өндөр, Шуурхай олгох зээлийн хэмжээ өндөр. | Харилцагчаа тогтоон барих |
| 3 | Бизнес эхлэлтийн зээл | Ямар нэгэн бизнес эрхлэх гэж байгаа, түүнийгээ нотолсон зөвшөөрөл, гэрээнд (түрээсийн гэрээ, захиалгын гэрээ гэх мэт) үндэслэн барьцаа хөрөнгө дээр нь тулгуурлан Санхүүгийн түргэн тусламжийн бүтээгдэхүүний хэмжээнд шуурхай олгодог. | Банк бус санхүүгийн байгууллагаас банк руу шилжих харилцагчдыг тогтоон барих |
| 4 | Бизнесийн эргэлтийн хөрөнгийн зээл | Нэг жилээс дээш тогтвортой бизнес эрхэлсэн, тогтмол орлоготой, Барьцаа хөрөнгийн түргэн борлогдох үнэлгээний 50 хувь, 150 сая хүртэлх хэмжээнд олгох зээл | Банк бус санхүүгийн байгууллагын салбараас шинэ харилцагч татах |
| 5 | Бизнес хөгжлийн зээл | Нэг жилээс дээш тогтвортой бизнес эрхэлсэн, тогтмол орлоготой, Барьцаа хөрөнгийн түргэн борлогдох үнэлгээний 60 хувь, 300 сая хүртэлх хэмжээнд | Банкны салбараас шинэ харилцагчдыг татах |
| 6 | Онлайн зээл | Зээлийн түүх болон орлогод тулгуурлан ухаалаг үнэлгээний аргачлал ашиглан олгодог барьцаагүй зээл | Бүтээгдэхүүнийг сайжруулж, харилцагчийн бааз суурь нэмэгдүүлэх |
| 7 | Төслийн зээл | Ажлын байр нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зээл | Нэр хүндийг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, ядуурлыг бууруулах |
| 8 | Ногоон болон эко зээл | Байгаль орчинд ээлтэй амины сууц, шалны халаалт, газар тариалан эрхлэлт, хүлэмж барих, хүнсний ногоо тариалах, цахилгаан хөдөлгүүртэй автомашинд олгох зээл | Агаарын болон хөрсний бохирдлыг багасгах зориулалт бүхий нийгмийн хариуцлагын хүрээнд идэвхтэй хэрэгжүүлэх |

*Эх сурвалж: БИД ББСБ*

2023.05.12 өдөр

Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

## Финтек бүтээгдэхүүн, үйлчилгээний стратеги

*Схем 19. Финтек бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн зураглал*

### 2023 он




- Мэдээллийн аюулгүй байдлын стандарт ISO27001 Стандарт, MNS 27001 нэвтрүүлэлт, баталгаажуулалт хийх ;
- Скорингийн модель;
- Дижитал кредит карт модуль;
- Итгэлцлийн модуль;
- Хөрөнгө оруулалтын модуль;
- Хэтэвч, төлбөр тооцооны модуль;

### 2024 он




- Барьцаатай зээлийн модуль 50% цахимжилт;
- BID кредит картыг хэдийд ч, хаана ч хэрэглэх боломжтой үйлчилгээ;
- Үнэнч харилцагчаа урамшуулах BID Point урамшууллын модуль хөгжүүлэх;

### 2025 он




- Метаверс салбарын үйл ажиллагааны цахимжуулалт ;
- Онлайн худалдааны модель;
- Лизингийн зээлийн модуль;
- Барьцаатай зээлийн модуль 100% цахимжилт;

### 2026 он




- Хэрэглэгч өөрийн үнэт цаасны дансаа холбож арилжаанд оролцох боломжтой модуль;
- Валют арилжаа, валютын шилжүүлэг хийх модуль;
- Дуудлага худалдааны модуль;

### 2027 он




- Мөнгөн гүйвуулгыг богино хугацаанд, хамгийн хямдаар хийх боломжтой үйлчилгээний модуль ;
- Цаг үеийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, технологитой уялдсан модуль хөгжүүлэлтүүд;

*Эх сурвалж: БИД ББСБ*

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

## 4.2. САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

*Хүснэгт 28. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл*

| (мянган төгрөг) | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Мөнгө түүнтэй адилгах | 6,161,185 | 10,301,441 | 11,109,471 | 10,000,508 | 16,802,838 |
| Зээлийн багц | 64,479,660 | 80,107,660 | 98,732,660 | 111,482,660 | 121,382,660 |
| Эрсдэлийн сан | (2,114,390) | (2,314,000) | (2,853,374) | (3,221,849) | (3,681,359) |
| Бусад эргэлтийн хөрөнгө (хүү авлага, бусад) | 5,234,584 | 7,768,115 | 9,726,823 | 11,599,732 | 13,711,790 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 4,560,260 | 6,452,000 | 8,653,800 | 10,112,000 | 11,487,000 |
| Нийт хөрөнгө | 78,321,299 | 102,315,216 | 125,369,381 | 139,973,051 | 159,702,929 |
| Итгэлцэл | 13,681,500 | 18,261,500 | 22,998,990 | 25,684,480 | 28,369,970 |
| Бонд | 12,752,650 | 19,905,650 | 27,405,650 | 24,905,650 | 22,405,650 |
| Дотоод зээл | 3,400,000 | 3,400,000 | 3,400,000 | 4,000,000 | 4,400,000 |
| Гадаад зээл | 5,551,500 | 7,978,500 | 7,978,500 | 9,978,500 | 13,478,500 |
| Бусад (хүү, татварын өглөг) | 2,359,500 | 3,882,114 | 5,770,658 | 6,936,140 | 10,318,860 |
| Нийт өр төлбөр | 37,745,150 | 53,427,764 | 67,553,798 | 71,504,770 | 78,972,980 |
| Хувьцаат капитал | 5,000,001 | 5,000,001 | 5,000,001 | 5,000,001 | 5,000,001 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 526,648 | 526,648 | 526,648 | 526,648 | 526,648 |
| Хуримтлагдсан ашиг | 27,048,500 | 33,249,500 | 41,360,803 | 50,088,934 | 60,441,632 |
| Тайлант оны цэвэр ашиг | 8,001,000 | 10,111,303 | 10,928,131 | 12,852,698 | 14,761,668 |
| Нийт эздийн өмч | 40,576,149 | 48,887,452 | 57,815,583 | 68,468,281 | 80,729,949 |
| Нийт эздийн өмч ба өр төлбөр | 78,321,299 | 102,315,216 | 125,369,381 | 139,973,051 | 159,702,929 |

*Эх сурвалж: БИД ББСБ*

2023-2027 оны хооронд БИД ББСБ нь нийт активаа жилд дунджаар 19.5 хувиар өсөхөөр төсөөлжээ. Энэхүү өсөлтийн төсөөлөл нь тус компанийн нийт активын 2019-2022 оны хооронд өссөн 18.2 хувьтай ойролцоо байгаа нь санхүүгийн төсөөллөө түүхэн хугацааны өсөлт дээр суурилж гаргасан бодитой төсөөлөл гэдгийг илтгэж байна. Мөн 2027 он гэхэд нийт зээлийн багцын хэмжээ 121.4 тэрбум төгрөгт хүрэх юм.

*График 73. Нийт хөрөнгө ба нийт зээл, (тэрбум төгрөг)*




*График 72. Нийт хөрөнгийн санхүүжилтийн бүтэц, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: БИД ББСБ*

Энэхүү нийт хөрөнгийн өсөлтийг 2027 он хүртэл тогтвортой барихын тулд итгэлцлийн үйлчилгээгээр татах эх үүсвэрийг жилд дунджаар 20.0 хувиар өсгөж, 2027 он гэхэд 28.3 тэрбум төгрөгт хүргэх шаардлагатай байна. Өөрийн хэрэгслээр бий болгох санхүүжилтийг 2025 онд 27.4 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлж, дараагийн жилүүдэд аажмаар 9.6 хувиар бууруулан 22.4 тэрбум төгрөгт хүргэх төлөвлөгөөтэй байна.

Гадаад болон дотоодын банк, санхүүгийн байгууллагаас татах зээлийн санхүүжилт 2023 онд 8.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байх бол 2027 онд Олон Улсын хамтын ажиллагааны үр дүнд 17.9 тэрбум төгрөгт хүрэх төсөөллийг гаргажээ.

*График 75. Өр төлбөрийн эх үүсвэрийн бүтэц, (тэрбум төгрөг)*




*График 74. Өөрийн хөрөнгийн бүтэц, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: БИД ББСБ*

Компанийн өөрийн хөрөнгийн бүтцийг авч үзвэл хувьцаат капиталын дүн 5.0 тэрбум төгрөгт хэвээр хадгалагдана. Харин нийт хуримтлагдсан ашиг жилд дунджаар 22.3 хувиар өсөж 60.4 тэрбум төгрөг, нийт эздийн өмч 80.7 тэрбум төгрөгт хүрэх хүлээлттэй байна.

*Хүснэгт 29. Орлогын хураангуй тайлангийн төсөөлөл*

| (мянган төгрөг) | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 22,054,300 | 28,670,612 | 33,174,174 | 37,458,174 | 42,241,166 |
| Хүүгийн бус орлого | 831,700 | 1,037,054 | 1,140,759 | 1,311,873 | 1,508,654 |
| Хүүгийн зардал | 5,724,300 | 8,251,347 | 10,328,356 | 10,846,500 | 11,571,413 |
| Хүүгийн бус зардал | 7,427,550 | 9,174,589 | 10,615,736 | 11,986,616 | 13,696,184 |
| Нийт ашиг | 9,734,150 | 12,281,730 | 13,370,842 | 15,936,931 | 18,482,224 |
| Татвар | 1,732,460 | 2,170,427 | 2,442,710 | 3,084,233 | 3,720,556 |
| Цэвэр ашиг | 8,001,690 | 10,111,303 | 10,928,131 | 12,852,698 | 14,761,668 |

*Эх сурвалж: БИД ББСБ*

2023 онд БИД ББСБ нь нийт хүүгийн орлогыг 22.0 тэрбум төгрөгт хүрч, цэвэр ашиг 8.0 тэрбум төгрөг байх төсөөллийг гаргасан. Хүүгийн бус орлогын дүн 2023 онд 0.8 тэрбум төгрөг байх бол 2027 онд орон нутаг дахь салбарын тоогоо нэмэгдүүлснээр үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлого 1.5 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн орлого 2023-2027 онд жилд дунджаар 17.6 хувийн дундаж өсөлттэй байх бол үйл ажиллагааны зардал 16.5 хувийн өсөлттэй буюу үйл ажиллагааны үр ашиг хадгалагдах төлөвтэй байна.

*График 77. Хүүгийн ба хүүгийн бус орлогын төсөөлөл, (тэрбум төгрөг)*




*График 76. Нийт орлого ба цэвэр ашиг, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: БИД ББСБ*

Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөллөөр үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ 2023 онд 6.3 тэрбум төгрөгийн дутагдалтай байна. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн хөрөнгө ийнхүү багасахад зээл олголтоо 2023 онд өнгөрсөн оноос 12.7 хувиар нэмэгдүүлж 115.6 тэрбум төгрөгт хүргэх нь нөлөөлөх төсөөлөлтэй байна.

*Хүснэгт 30. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл*

| (мянган төгрөг) | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | | | |
| **Орох урсгал** | **125,615,866** | **165,774,135** | **232,031,224** | **276,147,138** | **328,737,761** |
| Зээлийн үндсэн төлөлт | 103,675,687 | 137,500,000 | 199,375,000 | 239,250,000 | 287,100,000 |
| Зээлийн хүүгийн төлөлт | 20,951,611 | 27,237,081 | 31,515,465 | 35,585,265 | 40,129,107 |
| Бусад орлого (үйлчилгээний хураамж, хадгаламж) | 988,569 | 1,037,054 | 1,140,759 | 1,311,873 | 1,508,654 |
| **Гарах урсгал** | **131,896,730** | **167,965,146** | **234,720,872** | **270,360,573** | **317,832,229** |
| Зээл олголт | 115,675,687 | 153,128,000 | 218,000,000 | 252,000,000 | 297,000,000 |
| Үйл ажиллагааны зардал | 12,950,894 | 8,974,979 | 10,076,362 | 11,618,141 | 13,236,674 |
| Капитал зарцуулалт | 103,893 | 1,891,740 | 2,201,800 | 1,458,200 | 1,375,000 |
| Ногдол ашиг | 1,433,791 | 1,800,000 | 2,000,000 | 2,200,000 | 2,500,000 |
| Татвар | 1,732,465 | 2,170,427 | 2,442,710 | 3,084,233 | 3,720,556 |
| **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(6,280,864)** | **(2,191,011)** | **(2,689,648)** | **5,786,565** | **10,905,532** |
| Санхүүжилтийн мөнгөн гүйлгээ | | | | | |
| **Орох урсгал** | **24,820,575** | **40,771,740** | **38,095,800** | **36,900,200** | **35,917,000** |
| Гадаад | | 8,500,000 | 2,000,000 | 6,000,000 | 6,000,000 |
| Дотоод | 1,500,000 | 1,900,000 | | 2,100,000 | 400,000 |
| Бонд | 10,000,000 | 15,000,000 | 20,000,000 | 15,000,000 | 15,000,000 |
| Итгэлцэл | 13,320,575 | 15,371,740 | 16,095,800 | 13,800,200 | 14,517,000 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Гарах урсгал** | **24,145,276** | **33,340,473** | **34,298,122** | **43,795,728** | **40,020,202** |
| Гадаад | 7,150,000 | 6,988,798 | 3,210,338 | 5,271,018 | 4,119,928 |
| Дотоод | 623,000 | 2,532,400 | 632,400 | 2,154,720 | 758,880 |
| Бонд | 4,731,162 | 10,399,985 | 15,639,454 | 21,018,784 | 18,590,000 |
| Итгэлцэл | 11,641,114 | 13,419,290 | 14,815,930 | 15,351,206 | 16,551,394 |
| **Санхүүжилтийн цэвэр мөнгөн урсгал** | **675,299** | **7,431,267** | **3,797,678** | **(6,895,528)** | **(4,103,202)** |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ | | | | | |
| Орох урсгал | 5,646,851 | 500,000 | 200,000 | 200,000 | 200,000 |
| Гарах урсгал | 3,587,660 | 1,600,000 | 500,000 | 200,000 | 200,000 |
| **Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал** | **2,059,191** | **(1,100,000)** | **(300,000)** | **-** | **-** |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | (3,546,374) | 4,140,256 | 808,030 | (1,108,963) | 6,802,330 |
| Эхний үлдэгдэл | 9,707,559 | 6,161,185 | 10,301,441 | 11,109,471 | 10,000,508 |
| **Эцсийн үлдэгдэл** | **6,161,185** | **10,301,441** | **11,109,471** | **10,000,508** | **16,802,838** |

*Эх сурвалж: БИД ББСБ*

Мөнгөн гүйлгээг төрлөөр нь ялгахад 2024, 2025 онуудад нийт 11.2 тэрбум төгрөгийн цэвэр санхүүжилт татах бол 2026, 2027 онд 11.0 орчим тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлт хийгдэж, үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн үлдэгдэл 10.9 тэрбум төгрөгт хүрснээр эцсийн мөнгөн үлдэгдлийн төсөөлөл 2027 онд 16.8 тэрбум төгрөг байх хүлээлттэй байна.

*График 79. Мөнгөн гүйлгээний төсөөлөл, төрлөөр, (тэрбум төгрөг)*




*График 78. Нийт цэвэр мөнгөн гүйлгээ ба эцсийн мөнгөн үлдэгдлийн төсөөлөл, (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: БИД ББСБ*

Нийт хөрөнгийн өгөөж 2023 онд 10.2 хувь байх бол өөрийн хөрөнгийн өгөөж 19.7 хувь байх төсөөлөлтэй байна. Нийт эх үүсвэрт эзлэх өр төлбөрийн эргэн төлөлт, хүүгийн төлбөрийн улмаас цэвэр ашиг багасаж, нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгийн үр өгөөж ялимгүй доогуур түвшингээс сэргэж тогтворжих хандлагатай байна.

Компанийн ирэх 5 жилийн дундаж нийт хөрөнгийн өгөөж 9.4 хувь байх бол өөрийн хөрөнгийн өгөөж дунджаар 19.3 хувьд хадгалагдах төлөвтэй байна. Цэвэр ашгийн маржин 2025 онд зээл болон өрийн хэрэгслийн эргэн төлөлтийн нөлөөгөөр хүүгийн зардал өсөж, цэвэр ашиг буурах бөгөөд 2026 оноос эхлэн аажмаар сэргэх хүлээлттэй байна.

*График 81. Нийт хөрөнгийн өгөөж ба өөрийн хөрөнгийн өгөөж, (хувиар)*




*График 80. Цэвэр ашиг, (тэрбум төгрөг) ба цэвэр ашгийн маржин*




*Эх сурвалж: БИД ББСБ*

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс эх үүсвэр татахтай холбоотой харьцаа үзүүлэлтүүдийг авч үзвэл итгэлцлийн үйлчилгээний харьцаа 80 хувиас доош байвал зохих түвшинг тогтмол хангаж, ирэх онуудад өөрийн хөрөнгийн 33.7 хувиас 39.8 хувьтай тэнцэх дүнгээр итгэлцлийн үйлчилгээгээр санхүүжилт татах хүлээлттэй байна.

*Хүснэгт 31. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд*

| (мянган төгрөг) | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 19.1% | 22.7% | 18.6% | 16.3% | 25.7% |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 33.7% | 37.4% | 39.8% | 37.5% | 35.1% |
| Өрийн бичгийн зохистой харьцаа | 31.4% | 40.7% | 47.4% | 36.4% | 27.8% |

*Эх сурвалж: БИД ББСБ*

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 8 хувиас доошгүй байх шалгуурыг давах төлөвтэй байгаа бол өрийн бичгийн зохистой харьцаа өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй байх гэсэн шалгуурыг бүрэн хангаж ажиллахаар санхүүгийн төсөөлөлдөө тусгаж өгсөн.

# ТАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ



## 5.1. НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 5.1.1. БОНДЫН НЭРЛЭСЭН ҮНЭ, ХУГАЦАА, НӨХЦӨЛ

Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Компанийн Дүрмийн 10.4.5 дахь заалтад үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хурлын №02/09 дугаартай тогтоол болон 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн №03/22 тоот нэмэлт өөрчлөлтийн дагуу Бондын нэрлэсэн үнэ, хугацаа, нөхцөлийг доорх хүснэгтэд оруулснаар тогтоосон байна. Үнэт цаас гаргагчийн энэхүү шийдвэр нь дээрх хууль, дүрмийн заалтаас гадна Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.1-4 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.5.15 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 16.4 дэх хэсэгт нийцэж байгаа болно.

*Хүснэгт 32. Бондын нэрлэсэн үнэ, хугацаа, нөхцөл*

| | |
|---|---|
| **Үнэт цаас гаргагч** | “Бизнес-Инвест девелопмент ББСБ” ХХК |
| **Үнэт цаасны төрөл** | Өрийн бичиг |
| **Бондын арилжаа** | Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд |
| **Өрийн бичгийн төрөл** | Тогтмол хүүтэй энгийн бонд |
| **Нэгж бондын нэрлэсэн үнэ** | 100,000.0 (нэг зуун мянга) төгрөг |
| **Бондын нийт тоо, ширхэг** | 80,000.0 (наян мянга) ширхэг |
| **Бондын нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн** | 8,000,000,000.0 (найман тэрбум) төгрөг |
| **Бондын хугацаа** | 18 (арван найм) сар |
| **Бондын жилийн хүүгийн түвшин** | 18.5 (арван найм аравны тав) хувь |
| **Хүү төлөгдөх давтамж** | Хагас жил тутамд (Бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 6, 12, 18 сарын дараах мөн өдрүүдэд хүүг төлөх бөгөөд хүү төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө.) |
| **Үндсэн төлбөр төлөх** | Хугацааны эцэст (Хоёрдогч арилжаа эхэлсэн өдрөөс хойш 18 дахь сарын мөн өдөр төлнө. Хэрэв амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө.) |
| **Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт** | Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх |
| **Бондын барьцаа** | Компанийн өөрийн хөрөнгө |
| **Бондын батлан даалт** | "Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгох 8,000,000,000.00 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн бичгийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хувьцаа эзэмшигчид нь батлан даалт гаргасан болно. |
| **Бондын хадгалалт, төлбөр тооцоо** | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |

## 5.2. ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийн хүүгийн түвшинг тогтоохдоо зах зээлийн нөхцөл байдал, ижил төстэй өрийн хэрэгслийн хүү, бодлогын хүү ба инфляц, эдийн засгийн тодорхой бус байдал, хөрөнгө оруулагчдын хүлээлтэд үндэслэн жилийн 18.5 хувийн хүүг санал болгож байна.

### Бодлогын хүү ба инфляц

2022 оны эцэст Монгол Улсын инфляцын түвшин өнгөрсөн сараас 1.3 пунктээр буурч 13.2 хувьд хүрсэн эерэг мэдээлэлтэй байна. Өнгөрсөн онд Монголбанкны зүгээс нийт 5 удаа бодлогын хүүг өсгөж 13.0 нэгжид хүргэсэн. Энэхүү мөнгөний хатуу бодлого нь эрэлтийн гаралтай инфляцын өдөөлтийг сааруулж, нийт эрэлтэд нөлөөлснөөр инфляцын түвшин буурах хандлага харуулаад байна.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл”-ийн хүрээнд “Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ” гэжээ.

Иймд зах зээл дээр дунд хугацааны инфляц нэг оронтой тоо орчимд очих, дунд хугацаанд энэ түвшиндээ тогтворжих хүлээлтийг бий болгож байна. Мөн 2022 оны 12 дугаар сарын Монголбанкны инфляцын тайланд дурдсанаар 2023 оны инфляцын түвшинг (7.2-11.0) хувийн хооронд буюу дунджаар 9.1 хувь гэж төсөөлсөн ба 2024 онд (4.9-8.0) хувийн хооронд буюу 6.4 хувьд хүргэх зорилготой байна.

Инфляцын дээрх төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдлын улмаас бодит байдал, төсөөллийн хооронд зөрүү гарч болох хэдий ч Төв банкны зүгээс дунд хугацааны стратегиа инфляцыг 1 оронтой тоонд буулгах зорилтыг мөнгөний бодлогоор дамжуулан хэрэгжүүлэх төлөвтэй байна.

### Банкны хадгаламжийн хүү

Монголбанкны нээлттэй тайлан, мэдээлэлд дурдсанаар шинээр татсан төгрөгийн хугацаатай хадгаламжийн дундаж хүү 2022 оны 12 дугаар сард 11.1 хувь буюу 10 дугаар сартай харьцуулахад 0.4 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Ийнхүү төгрөгийн хугацаатай хадгаламжийн дундаж хүү сүүлийн 3 сар дараалан аажмаар буурч байна.

Монгол Улсын системийн нөлөө бүхий 5 банкны 12 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн зарласан хүүг харьцуулж харвал дунджаар 12.2 хувь байна. Тухайлбал, Худалдаа хөгжлийн банкны төгрөгийн энгийн нөхцөлтэй, 12 сарын хугацаатай хадгаламжийн зарласан хүүгийн түвшин хамгийн өндөр буюу 12.5 хувь байгаа бол Хас банкны хүүгийн түвшин үл ялиг бага буюу 11.6 хувь орчим байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-04-27
БҮРТГЭВ-02

*График 82. Системийн нөлөө бүхий банкуудын 12 сарын хугацаатай, төгрөгийн хадгаламжийн хүү*




*Эх сурвалж: Банкуудын вэб хуудас*

### Нээлттэй бонд, ХБҮЦ-ны хүүгийн харьцуулалт

Зах зээл дээр нээлттэй арилжаалагдаж байгаа, хамгийн сүүлд гарсан нээлттэй бондуудын хүүгийн түвшинг харьцуулбал инфляцын өсөлт, бодлогын хүүгийн түвшин, банкны хадгаламжийн хүү болон ижил төстэй өрийн хэрэгслийн хүүтэй өрсөлдөхүйц түвшинд тогтоож байна.

*Хүснэгт 33. Нээлттэй бонд, ХБҮЦ-ны хүү*

| | Бонд, ХБҮЦ-ны нэр | Бүртгэсэн огноо | Хүү (жилийн) |
|---|---|---|---|
| 1 | Сэндли бонд | 2023.01.10 | 19.20% |
| 2 | Бичил Глобус ХБҮЦ | 2022.11.15 | 17.50% |
| 3 | Инвескор бонд | 2022.10.21 | 18.00% |
| 4 | ЛэндМН актив ХБҮЦ | 2022.10.07 | 17.00% |
| 5 | Нөмөр кредит ассет ХБҮЦ | 2022.09.29 | 17.50% |
| 6 | Бэрс ХБҮЦ | 2022.08.15 | 16.80% |
| 7 | Симпл ассет ХБҮЦ | 2022.06.16 | 15.00% |
| 8 | Омни актив ХБҮЦ | 2022.01.28 | 14.50% |

*Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж*

Дотоодын эдийн засагт гарч буй гэнэтийн өөрчлөлтүүд нь үнэт цаас гаргагч нар хүүгийн түвшнээ тогтоох, санхүүжилтийн зардлаа төлөвлөхөд шууд нөлөөлдөг. Тухайлбал, дээрх хүснэгтээс харахад хүүгийн түвшинг хамгийн сүүлд нээлттэй гарсан гурван бонд, ХБҮЦ дээр ихээхэн ялгаатай тогтоосон байна.

## 5.3. БОНДЫН БАРЬЦАА, БАТЛАН ДААЛТ

"БИД ББСБ" ХХК -ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хурлын №02/24 тоот тогтоол, 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн №03/22 тоот тогтоол (энэхүү танилцуулгын хавсралтаас үзнэ үү)-д үндэслэн Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай 2023 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр №БГ-23/03 тоот Барьцааны гэрээ байгуулж Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө (цаашид "Барьцааны зүйл" гэх)-ийг өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэл хугацаатайгаар барьцаалсан.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-04-27
БҮРТГЭВ-02

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 оны 05 сар 12 өдөр

Энэхүү Барьцааны гэрээгээр төлбөр тасалдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Барьцааны гэрээнд заасны дагуу төлбөрийг барагдуулах үүрэгтэй талаар тусгасан. Компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хөндлөнгийн хараат бус үнэлгээний "Итгэлт эстимэйт" ХХК-иар хийлгүүлсэн ба энэхүү үнэлгээ болон "Компанийн тухай хууль" -ийн 30.2 дахь хэсгийг үндэслэн Андеррайтер болон Үнэт цаас гаргагч нь харилцан зөвшилцөж Барьцааны зүйлийн үнэлгээг цэвэр активын үнэлгээ болох 32.8 тэрбум төгрөгөөр тогтоосон болно. (Бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний дэлгэрэнгүй тайлан, аудитын тайлангийн дэлгэрэнгүйг тус тус энэхүү үнэт цаасны танилцуулгын хавсралтаас үзнэ үү.)

Үнэт цаас гаргагч, түүний хувьцаа эзэмшигчид болон Андеррайтерийн хооронд 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн №БД-23/03 дугаартай батлан даалтын гэрээний дагуу Үнэт цаас гаргагчийн нийт хувьцааны 51.0 хувийг эзэмшигч, ХА72121475 регистрийн дугаартай Аварзэдийн Алтансүх, 49.0 хувийг эзэмшигч, ХН73030266 регистрийн дугаартай Хөхөөгийн Одонтуяа нар нь өрийн хэрэгслийн хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд хувийн батлан даалт гаргасан. Хувьцаа эзэмшигч А.Алтансүх нь 2010 оноос 2019 оны хооронд Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооны ерөнхийлөгчөөр ажилласан бөгөөд тус салбартаа мэдлэг боловсрол, туршлагаараа тэргүүлэгч нэгэн юм. Харин Хувьцаа эзэмшигч Х.Одонтуяа нь 2012 оноос одоог хүртэл Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа 10 гаруй жилийн банк бус, санхүүгийн байгууллагад ажилласан туршлагатай юм. Батлан даалтын гэрээгээр Үнэт цаас гаргагч нь Бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд Андеррайтерийн мэдэгдлийг үндэслэн Батлан даагч нь бондын үндсэн болон хуваарьт төлбөрийг бонд эзэмшигчдийн дансанд үл маргах журмаар шилжүүлнэ. Батлан даалтын гэрээ нь Үнэт цаас гаргагч бонд эзэмшигчийн өмнө хүлээсэн аливаа төлбөрийн үүргээ бүрэн биелүүлснээр эсхүл бонд эзэмшигчийн өмнө хүлээсэн аливаа төлбөрийн үүргээ бүрэн биелүүлэх боломжгүй болсон нөхцөлд тухайн үүргийг Батлан даагч бүрэн биелүүлж холбогдох төлбөрийг төлж барагдуулснаар дуусгавар болохоор заасан.

## 5.4. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь 80,000 (наян мянга) ширхэг, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, тогтмол хүүтэй, энгийн бондыг олон нийтэд санал болгож нийт 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа билээ. Энэхүү олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаас гаргагч нь бизнесийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд зарцуулна.

*Хүснэгт 34. Эх үүсвэрийн зарцуулалт*

| № | Эх үүсвэрийн зарцуулалтын төлөвлөгөө | Мөнгөн дүн |
|---|---|---|
| 1 | Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх | 8,000,000,000 (найман тэрбум) төгрөг |

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

Өрийн хэрэгслээр татан төвлөрүүлэх санхүүжилтийг зөвхөн зээлийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд тус санхүүжилтийн зардлыг татан төвлөрүүлэх хөрөнгөөс гаргахгүй болно.

## 5.5. ӨРИЙН БИЧГЭЭР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

### Өрийн бичиг нь түүний эзэмшигчийн дараах эрхийг гэрчилнэ:

- Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь компанийн санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгыг хөрөнгө оруулалтын зорилгоор судлан үзэж, бүрэн танилцсаны үндсэн дээр өрийн бичгийг худалдан авч, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах эрхтэй;
- Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь өрийн бичгийн хоёрдогч зах зээлийн үнийн мэдээлэлтэй танилцах эрхтэй;
- Өрийн бичгийг бирж дээрээс үнэт цаасны компаниараа дамжуулан чөлөөтэй худалдан авах, хоёрдогч зах зээл дээр худалдах эрхтэй;
- Өрийн бичиг эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь хугацааны эцэст өрийн бичгийг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, хуримтлагдсан хүүг төлөхийг шаардах эрхтэй;
- Үнэт цаас гаргах тухай шийдвэрт зааснаар үнэт цаасны хүүгийн төлбөрийг хагас жил тутамд төлөхийг шаардах эрхтэй;
- Хэрэв Үнэт цаас гаргагч нь дээр дурдсан хүүгийн болон үндсэн төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол Андеррайтераар дамжуулан барьцаалуулагч-хувьцаа эзэмшигчдээс үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авахыг шаардах эрхтэй;
- Өрийн бичиг гаргагч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол өрийн бичиг эзэмшигч нь тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах (Иргэний хуулийн 208.6) эрхтэй;
- Барьцаалуулагч, батлан даалт гаргагчийн талаарх мэдээлэлтэй танилцах (Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам) эрхтэй;

### Өрийн бичиг нь түүний эзэмшигчийн дараах үүргийг гэрчилнэ:

- Мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулах нөхцөлөөр өөрийн захиалсан өрийн бичгийн төлбөрийг төлөх, тийнхүү төлөөгүй бол захиалсан өрийн бичгийг ҮЦК худалдах эрхтэйг хүлээн зөвшөөрөх;
- Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн өрийн бичгийн төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй мөнгөн хөрөнгө болохыг бүрэн баталж, эрсдэл болон өгөөжийг бүрэн тооцоолж хөрөнгө оруулалтын шийдвэрийг бие даан гаргасан талаар баталгаа гаргаж ҮЦК-аас гаргасан анхан шатны маягтыг үнэн зөв мэдээлэх болон түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

## Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг

- Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй;
- Өөрийн бичгийн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд Хувьцааны барьцааны гэрээний дагуу зохих арга хэмжээг авч үнэт цаас эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах;
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу үр ашигтай захиран зарцуулах;
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу хагас жил тутамд хүүгийн төлбөрийг төлөх, хугацааны эцэст үндсэн төлбөрийг төлөх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах;
- Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээнүүд дээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах үүрэгтэй;
- Үнэт цаас гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр хийгдэх өдрөөс ажлын 3 хоногийн өмнө ҮЦТХТ-д байрших өөрийн дансанд шилжүүлнэ. Шилжүүлсэн дүнг ҮЦТХТ нь хөрөнгө оруулагчийн үнэт цаасны данс руу үндсэн болон хүүгийн төлбөр хийгдэх өдөр татна;
- Холбогдох хууль тогтоомж болон журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;
- Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар хүргэх;
- Үнэт цаас гаргагч нь бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын мэдээллийг нэн даруй олон нийт, Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх;
- Андеррайтер, бонд эзэмшигчээс хууль тогтоомж болон энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй;

## Бондын гэрээний тухай

Андеррайтер нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг төлөөлөн Үнэт цаас гаргагчтай бондын нөхцөл, талуудын эрх, үүргийг тусгасан №БОГ 23/02 дугаартай "Бондын гэрээ"-г 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан ба тус гэрээнд 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр №БОГН 23/02 дугаартай тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. Бондын үндсэн нөхцөл нь олон нийтээс татан төвлөрүүлэх үнийн дүн нь 8,000,000,000.0 (найман тэрбум) төгрөг, жилийн 18.5 (арван найм аравны тав) хувийн тогтмол хүүтэй, энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлгүй, 18 (арван найм) сарын хугацаатай, Бондын 18 сарын үндсэн хугацаа дуусахаас өмнө эргүүлэн худалдаж авах нөхцөлгүй, хагас жил тутам хүү төлөгдөх давтамжтай, үндсэн төлбөрийг Бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 18 дахь сарын мөн өдөр төлнө (хэрэв амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлнө). Хүүгийн төлбөрийг тооцохдоо жилийн хүүг 365 хоногоор тооцох бөгөөд Бонд гаргагч нь нийт төлбөл зохих хүүгийн дүнгээс татварыг 5 хувиар суутган авч бонд эзэмшигч тус бүрийн өмнөөс төсөвт төлнө.

Үнэт цаас гаргагчийн Бонд нь барьцаа, батлан даалттай ба энэхүү үнэт цаасны танилцуулгын 5.3-д тодорхой тусгаж оруулсан. Үнэт цаас гаргагч нь Бондын хүү болон үндсэн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх боломжгүй нөхцөл үүсэх, эсхүл 2 болон түүнээс дээш удаа дараалан Бондын хүүгийн төлбөрийг гүйцэтгээгүй тохиолдолд төлбөрийн тасалдал (дефолт) болсонд тооцно. Энэ тохиолдолд Андеррайтер нь барьцааны эрх хэрэгжүүлж БИД ББСБ-аас төлбөл зохих төлбөрийг барагдуулахыг шаардах ба Бондын гэрээний дагуу бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Төлбөрийн чадваргүй болох тохиолдлыг Монгол Улсын Дампуурлын тухай хуульд заасны дагуу өөрийн хөрөнгийн 10-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үүргээ хууль буюу гэрээнд заасан хугацаанд биелүүлэхгүй бол төлбөрийн чадваргүйд тооцно. Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд Монгол Улсын Дампуурлын тухай хуулийн хүрээнд шаардлагатай холбогдох арга хэмжээг авна.

- Бонд гаргагчид Бондын гэрээний дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон ББСБ-ын санхүүгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй тохиолдолд нэмж зээл авах, их хэмжээний өр төлбөр гаргах, Бондын үндсэн ба хүүгийн төлбөрийг бүрэн төлж барагдуулахаас өмнө БИД ББСБ-ын хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахыг хориглосон байна.
- Бонд гаргагчид Бондын гэрээний дагуу хэрэгжүүлж болох зүйлд барьцааны зүйлийн үнэлгээг бууруулахгүй байх үүднээс үнэт цаасны танилцуулгад тусгасан бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөллийг хангаж ажиллах шаардлагатай хэмээн тусгасан.
- Бонд гаргагч нь санхүүгийн чадавхиа сайжруулахтай холбоотой СЗХ-ноос тогтоосон ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах, татан төвлөрүүлсэн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагатай холбоотой бодлого, журам, хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах ёстой.
- Бонд эзэмшигч буюу хөрөнгө оруулагч, Үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг, хариуцлагыг энэхүү үнэт цаасны танилцуулгын 5.5 дахь хэсгийн Өрийн бичгээр гэрчлэгдэх эрх, үүрэг хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

СЗХ-ны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг дараах хугацаанд Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

- Бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны чиглэл, төсөл болон төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орох, бусад санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчаас зээл авсан, тэдний өмнө хүлээсэн нэмэлт үүрэг үүссэн, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт орсон, Эрх бүхий байгууллагын шийдвэрээр бонд гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан, Бонд гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, хугацааг сунгуулсан, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, Бонд гаргагч нь гуравдагч этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргасан бол тухай үйл явдал болсноос хойш ажлын 3 өдрийн дотор;
- Улирлын тайланг дараа сарын 10-ны дотор, жилийн тайланг 2 дугаар сарын 10-ны дотор, аудитын тайланг 3 дугаар сарын 10-ны дотор;

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга 2023-04-27
БҮРТГЭВ-02

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023.05.12

## 5.6. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл болон хөрөнгийн биржийн бүртгэл аль алинд нь бүртгэгдсэн үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдана. Тус хуулийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг арилжих зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо олгох бөгөөд СЗХ нь уг зөвшөөрлийг Хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэсэн болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай хөрөнгийн биржээс гаргасан тодорхойлолт, үнэт цаас гаргагчийн хүсэлтэд үндэслэн олгох бөгөөд Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн №15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д заасны дагуу Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах дэлгэрэнгүй төлөвлөгөөг танилцуулна.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй бондын худалдан авах захиалгын хугацааг Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрөл олгосны дараа Үнэт цаас гаргагч болон Андеррайтер харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

### 5.6.1. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны оны 02 дугаар сарын 09-ний өдрийн №02/09 дугаартай тогтоол, 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн №03/22 дугаартай нэмэлт өөрчлөлтийн дагуу нийт 80,000 (наян мянга) ширхэг, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий компанийн өрийн хэрэгслийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон арилжаална. Анхдагч зах зээлийн арилжааг Биржийн холбогдох журмын дагуу тогтоосон үнийн аргыг ашиглан олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн болно. Олон нийтэд танилцуулах, сурталчлах болон өрийн хэрэгслийн захиалгыг эхлүүлэх хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс 5-аас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэнэ. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөөг доорх схемээр дүрслэн харуулав.

*Схем 20. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах тухай*




### 5.6.2. ӨРИЙН ХЭРЭГСЭЛ ХУДАЛДАН АВАХ ЗААВАР

- **Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга**

Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн №15 дугаартай тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-04-27
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

журам"-д заасны дагуу үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр цаг хугацааны ахлах дараалаар санал болгон арилжих арга юм.

- **Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа**

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан анхдагч зах зээлийн арилжааны тайланг Санхүүгийн зохциуулах хороонд хүргүүлнэ. Санхүүгийн зохицуулах хороо нь уг тайланг хүлээн авч аливаа зөрчил гараагүй, амжилттай болсон гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх, арилжаа эрхлэх байгууллагад хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Энэ өдрөөс эхэлж бондын хүү тооцогдож эхэлнэ.

- **Бонд худалдан авах заавар**

Хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгийг дараах 2 аргаас сонгон дансандаа байршуулах боломжтой. Хэрэв үнэт цаасны дансгүй бол МХБ-д бүртгэлтэй аль нэг үнэт цаасны компаниас сонгон данс нээлгэнэ. Данс бүрэн баталгаажихад 1-2 хоног шаардлагатай байдгийг та тооцно уу.

1. *Дурын банкнаас бонд авах мөнгөн дүнг дараах зааврын дагуу байршуулаад өөрийн үйлчлүүлдэг брокерийн компанийн аппликэйшнийг ашиглан захиалгаа оруулах эсхүл брокертоо мэдэгдэж захиалгаа баталгаажуулна.*

   Банкны нэр: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
   Дансны нэр: Таны өөрийн нэр
   Дансны дугаар: **** **** **** (өөрийн брокероос лавлах)
   Гүйлгээний утга: регистрийн дугаар, нэр, утасны дугаар

2. *Дурын данснаас өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанийн номинал дансанд байршуулаад цахимаар болон утсаар захиалгаа баталгаажуулах боломжтой.*

   Банкны нэр: ҮЦК-ийн номинал данс байршиж буй банкны нэр
   Дансны нэр: Үнэт цаасны компанийн нэр
   Дансны дугаар: Үнэт цаасны компанийн номинал дансны дугаар
   Гүйлгээний утга: регистрийн дугаар

- **Арилжааны шимтгэл**

Хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанийн тогтоосон арилжааны шимтгэлийг үнэт цаас авах мөнгөн дүн дээр нэмж байршуулна. Уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын шимтгэл багтсан байна.

- **Албан татвар**

Хөрөнгө оруулагч нь хувь хүн бол ХХОАТ-ын хуулийн 16.1.4-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 17.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнийн дүнг хассан зөрүүнээс тус хуулийн 21.5-т заасан 5.0 хувийн татвар төлнө. Хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол ААНОАТ-ын хуулийн 18.6.3-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 18.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнийн дүнг хассан зөрүүнээс тус хуулийн 20.2.5-д заасан 5.0 хувийн татвар төлнө.

# ЗУРГАА. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД



## 6.1. ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК |
| Үйл ажиллагааны чиглэл | Брокер, дилер, андеррайтер, номинал дансны үйл ажиллагаа |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2007.12.06 |
| Регистрийн дугаар | 5183855 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити Тауэр, 25 давхар, 2506 |
| Утас | +976 7777-6377 |
| Цахим шуудан | info@ucc.mn |

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан билээ. Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн биржийн арилжаанд онлайнаар оролцох боломжийг харилцагч нарт олгож, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилладаг ба дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Хонгконг, Лондон, Австрали, Нью-Йоркийн хөрөнгийн биржийн арилжаанд бодит цагийн горимоор хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдах, худалдан авахад зуучилдаг ба энэхүү үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн.

Хөгжлийн цоо шинэ шатандаа гарч байгаа Монголын компаниудад хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татаж бизнесээ өргөжүүлэх боломжийг таниулан, бизнес болон санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Мөн түүнчлэн салбартаа тэргүүлэгч томоохон компаниудын үнэт цаас гаргах үйл ажиллагаанд андеррайтерийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлж байна.

| | |
|---|---|
| **2008 он** | Брокер дилер андеррайтерийн тусгай зөвшөөрөл авсан. |
| **2009 он** | Лондонгийн хөрөнгийн бирж болон АНУ-н банк Bank New York Mellon-той хөрөнгө босгох боломжтийн талаарх форумыг анх удаа зохион байгуулсан. |
| **2010 он** | Монголд анх удаа HKEX, LSE, ASX, NYSE зэрэг биржүүдийн гадаадын арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлсэн. |
| **2010 он** | Bank of China International-тай түншлэв. |
| **2011 он** | Шилдэг брокерын компани |
| **2011 он** | Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн |
| **2013 он** | Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards "Шинийг санаачлагч байгууллага" |
| **2015-2018 он** | Япон улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх |
| **2016 он** | Австралийн CPS Capital ҮЦК-ийн Монгол дахь төлөөлөгч |
| **2018 он** | МҮОНТ-ийн "Ногоон сум" реалити шоуны ялагч |

| | |
|---|---|
| **2018 он** | Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards “Шилдэг Мэргэжилтэн” |
| **2019-2020 он** | Үнэт цаасны арилжаанд голлох байр суурьтай оролцож, МХБ-ийн ТОП-5 ҮЦК-д багтсан. |
| **2019 он** | “Ард Кредит ББСБ” ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглан, эрэлтэд үндэслэн хувьцааны үнийг тогтоов. |
| **2020 он** | “ЛэндМН” ББСБ ХК-ийн нээлттэй бондын Үндсэн андеррайтер |
| **2020 он** | Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн шууд гишүүн |
| **2020 он** | МҮОНТ-н “Цагийн хүрдийн баатар” |
| **2020 он** | Европын сэргээн босголт хөгжлийн банкны брокер |
| **2021 он** | Биржийн бус зах зээл (OTC)-ийн анхны гишүүн байгууллага |
| **2021 он** | Монголбанк, СЗХ, Сангийн яамны хамтарсан тушаалаар баталсан “Sandbox” төслийн анхны бүтээгдэхүүн болох “Монпэй” бондын андеррайтер |
| **2021 он** | Биржийн бус зах зээлийн (OTC)-ийн анхны “БИД” бондын андеррайтер |
| **2022 он** | Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан “Ашид капитал ББСБ” ХХК хаалттай бондын Үндсэн андеррайтер |
| **2022 он** | Симпл ассет ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр нээлттэй гаргах үйл ажиллагаанд Үндсэн андеррайтер |
| **2022 он** | МҮОНТ-ийн орон даяарх “Ногоон сум” аянд хамтрагч компани |
| **2022 он** | “Төрийн банк “ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж, системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат болох эхлэлийг тавьсан. |
| **2022 он** | “Сэндли ББСБ” ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтер |
| **2022 он** | “ЛэндМН” ХБҮЦ-д хамтрагч андеррайтер |
| **2023 он** | “Сэндли нээлттэй бонд”-д Үндсэн андеррайтер |
| **2023 он** | Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан “Үйзэн-Ивээлт ББСБ” ХХК хаалттай бондын Үндсэн андеррайтер |

Өнөөгийн байдлаар **“ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК”** нь:

“Мобифинанс ББСБ”, “М-Си-Эс Инвестмент” ХХК, “Капитрон банк”, “Ай Си Ти групп”, “Сүү ХК”, “Төрийн банк”, “БИД ББСБ” , “Ашид капитал ББСБ”, “Монголчех Метал”, “ОНДО”, “Монголын финтек групп”, “Эрхэт Монгол групп”, “Бичил глобус финанс ББСБ” гэх зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 200.0 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлээд байна.

## Андеррайтерийн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:

Энэхүү гэрээгээр "Өлзий энд Ко капитал ҮЦК" (цаашид "Андеррайтер" гэх) нь Үнэт цаас гаргагчийн Монголын хөрөнгийн биржид нээлттэй бонд гаргах ажлыг зохион байгуулах, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасны дагуу үнэт цаасны танилцуулга, холбогдох материалыг бэлтгэх, хөрөнгө оруулагчдад санал болгох, арилжааг зохион байгуулах, эрх бүхий байгууллагуудтай харилцах гэх мэт талуудын хоорондын харилцааг зохицуулна.

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ болон МХБ "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулна.
- Андеррайтер нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх бөгөөд үр дүнтэй арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг хангаж ажиллана.
- Үнэт цаас гаргагч нь андеррайтер ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн тогтоол шийдвэр, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг андеррайтераас тогтоосон хугацаанд түргэн шуурхай, бүрэн гүйцэд гаргаж өгөх бөгөөд андеррайтерийг гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч нь андеррайтертай харилцах үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахтай холбоотой ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтан, мэргэжилтэнг томилон ажиллуулах ба тэдгээр ажилтнууд нь удирдамжийн дагуу холбогдох ажил үүргийг зохих ёсоор гүйцэтгэж чадаагүй тохиолдолд түүнийг солих шаардлагыг андеррайтерийн зүгээс тавьж болох бөгөөд Үнэт цаас гаргагч энэхүү шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчаас бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд Үнэт цаас гаргагчийн нууц мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд ямар нэгэн хэлбэрээр задруулахгүй байх үүрэгтэй.
- Үнэт цаас гаргагч нь андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай анхан шатны баримт бичиг, мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх явцад шаардсан бусад баримт бичиг, мэдээллийг андеррайтерийн санал болгосон хугацаанд, хугацаа заагаагүй бол 10 хоногийн дотор гаргаж өгөх үүрэгтэй.

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ 02

## 6.2. АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | "ЖЭЙ ПИ ЭЙ ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ" ХХК |
| Үйл ажиллагааны чиглэл | Аудит, нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх үйлчилгээ |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2021.09.24 |
| Регистрийн дугаар | 6761267 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25-р хороо, ЮүБи тауэр плас оффис, Тауэр, 6 давхар, 609 |
| Утас | +976 7740-4848 |
| Цахим шуудан | bulgan@jpamongolia.com |

"Жэй Пи Эй Глобал Монголиа" ХХК нь үйл ажиллагаагаа 2021 оноос эхлэн явуулж эхэлсэн бөгөөд 2022 оноос эхлэн "Жэй Пи Эй интернэшнл"-ийн Монгол Улс дахь албан ёсны хараат бус гишүүн байгууллагаар ажиллаж эхэлсэн. Аудит, татвар, нягтлан бодох бүртгэл болон бизнесийн зөвлөх үйлчилгээний цогц үйлчилгээг Монгол улсын зах зээлд хүргэх зорилгоор Олон Улсын болон дотоодын туршлага бүхий чадварлаг багийг бүрдүүлэн, үйл ажиллагаагаа явуулж байна.

"Жэй Пи Эй Глобал Монголиа Аудит" ХХК нь санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх, санхүүгийн болон удирдлагын нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг, татвар, ERP, бизнес болон менежментийн цогц зөвлөх үйлчилгээг харилцагчийнхаа онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж байна. Найдвартай, мэргэжлийн үйл ажиллагааг Монголын мэргэшсэн нягтлан бодогчид, Татварын мэргэшсэн зөвлөхүүд, ACCA цолтой мэргэжилтнүүд хүргэж байна.

### Үүсгэн байгуулагчдын туршлага


Б.БАЯРМАА
Партнер
CPA, MBA, Докторант
25 жилийн туршлагатай


Э.БУЛГАН
Гүйцэтгэх захирал
ACCA, CPA, MSc
13 жилийн туршлагатай


CHRISTINE MULLIN
Зөвлөх
ACCA, ICAEW-н гишүүн
25 жилийн туршлагатай


М.ЭНХМЭНД
Партнер, Татварын зөвлөх
CPTA, CPA, MBA
15 жилийн туршлагатай


У.ҮҮРДМӨНХ
Партнер, Аудитор
US CPA
17 жилийн туршлагатай

### 2022 онд ажилласан төслүүд:

2022 онд нийтдээ 73 компанид санхүүгийн тайлангийн аудитын үйлчилгээг үзүүлэн хамтран ажилласан. Эдгээрээс томоохон компаниудыг дурдвал "Ай Си Ти групп" ХХК, "Монгол Базальт" ХК , "Нарантээг" ХХК, "Солар повер интернейшнл" ХХК , "Пипл ин Нийд (ПИН) ОУБ" (People In Need NGO), "Тэлмэн Ресурс" ХХК , "БИД ББСБ" ХХК, "Дижитал эксченж монголиа" (Digital Exchange Mongolia), "И Клиник" ХХК, "Урбан Бизнес Групп" ХХК, "Эн Би Си" ХХК , "Ганброс" ХХК, "Герман Стандарт" ХХК , "Май Мон Соорс" ХХК зэрэг компаниудад санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлсэн.

### Аудитын үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
2021031195 CTC2420

Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын "Иргэний хууль", "Нягтлан бодох бүртгэл", "Аудитын тухай хууль" болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, Олон Улсын хэмжээнд дагаж мөрддөг санхүүгийн тайлагналын болон аудит стандартын дагуу Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар үеийн санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргахад оршино.

- Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэсэн 2022 оны санхүүгийн байдлын тайлан (жилийн эцсийн), дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй зэргийг багтаасан Санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийнэ.
- Аудитын үйлчилгээг санхүүгийн үйл ажиллагаанд мэргэжлийн стандартын дагуу хийнэ.
- Санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргахдаа Аудитын Олон Улсын стандартыг мөрдөнө.
- Аудитор нь өөрийн үйл ажиллагааны бүх үр дагаврыг хариуцах бөгөөд өөрийн ажилтны аливаа үйлдлийн үр дагаврыг мөн хариуцна.
- Аудитор дүгнэлт алдаатай, дутуу, зохих шаардлага, стандартыг хангаагүйгээс үүссэн хохирол, түүнийг олгохтой холбоотой гарсан зардлыг бүрэн хариуцна.
- Үнэт цаас гаргагчийн (цаашид "Үйлчлүүлэгч гэх" ХХК), түүний гүйцэтгэх удирдлага, нягтлан бодох бүртгэлийн удирдах ажилтан, аудитын хорооны дарга, дотоод аудитын нэгжийн ажилтан, санхүү, бүртгэлийн болон бусад ажилтнаас аудитын үйл ажиллагааны гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгэхтэй холбогдсон баримт, мэдээллийг гаргуулж авах, ажиглалт, асуулга, ярилцлага, тулган баталгаажуулалт хийх эрхтэй.
- Аудитын үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой баримт, мэдээллийг харилцагч банк, санхүүгийн байгууллага болон бусад холбогдох аж ахуйн нэгж, байгууллагаас шаардах авч танилцах эрхтэй.
- Аудит хийх явцад олж авсан аливаа мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад мэдээлэхээс татгалзах үүрэгтэй.
- Хүсэлт, шаардлагаа ойлгомжтой байдлаар үйлчлүүлэгчид илэрхийлнэ. Нэмэлт тайлбар тодруулгыг ямар ч үед түргэн шуурхай өгнө. Аудитын дүгнэлтэд үндэслэл бүхий, шаардлагатай засвар өөрчлөлтийг үйлчлүүлэгчийн хүсэлтээр оруулна.
- Аудитын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг үйлчлүүлэгч шаардсан тухай бүр нь үйлчлүүлэгчид мэдээлнэ.

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ 02

## 6.3. ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | "ИТГЭЛТ ЭСТИМЭЙТ" ХХК |
| Үйл ажиллагааны чиглэл | Хөрөнгийн үнэлгээ, бизнес үнэлгээ, хохирлын үнэлгээ, төслийн үнэлгээ, гүйцэтгэлийн үнэлгээ |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2007.03.21 |
| Регистрийн дугаар | 2866641 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Хүннү гудамж, Олимп плаза, 4 давхар, 401 |
| Утас | +976 9999-5638 |
| Цахим шуудан | itgelt_estimate@itgeltgroup.mn |

"Итгэлт Эстимэйт" ХХК нь хөрөнгийн үнэлгээний чиглэлээр анх 1998 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын анхны хөрөнгө үнэлгээний компани юм. Тус компани нь 24 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж, 200,000 гаруй үнэлгээний ажлыг гүйцэтгэсэн ба үнэлгээний шилдэг аргачлал боловсруулан хэрэглээндээ ашигладаг.

Эрдмийн цол зэрэгтэй, туршлагатай, мэргэжлийн үнэлгээчдийн баг хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, даатгалын тохиолдлын эд хөрөнгийн хохирлын үнэлгээ, бизнес үнэлгээ, төслийн гүйцэтгэлийн болон хэрэгжилтийн үнэлгээ, санхүүгийн тайлангийн зориулалттай үнэлгээ зэрэг олон төрлийн үнэлгээ хийж гүйцэтгэн ажиллаж байна.

### Хөрөнгийн үнэлгээний онцлох төслүүд:

Уул уурхай, эрчим хүч, барилга, үйлдвэр, үйлчилгээ, хүнс, хөдөө аж ахуй, авто зам, агаарын тээвэр, төмөр зам зэрэг улс орны бүхий л салбарын олон зуун томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын хөрөнгийн үнэлгээг хийсэн. Үүнээс ДЦС-2, ДЦС-4 зэрэг эрчим хүчний 10 гаруй томоохон аж ахуйн хөрөнгийн үнэлгээг хийсэн нь эрчим хүчний салбарын үнэ бүрдэлтийг бодитой тогтоох үндэс болж, энэ салбар өрийн сүлжээнээс гарч, улмаар нөхөн үйлдвэрлэл жам ёсоороо явах нөхцөл боломж бүрдсэн юм.

2019, 2020, 2021 онд "Жаст Ойл" ХХК, "Эрдэнэт Булганы Цахилгаан Түгээх Сүлжээ" ТӨХК, "АПУ" ХК, "Эрдмин" ХХК, Хуримын ордон төв, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, "Фронтейр Ланд" ХК, "Оюу Толгой" ХХК, "Номин Констракшн Девелопмент Групп", "Эрэл" ХХК, "Степ Голд" ХХК, "Түмэн Шувуут" ХК, "Монос Хүнс" ХК, "ЛэндМн ББСБ" ХК, "Ард Санхүүгийн нэгдэл" ХК зэрэг 20 орчим томоохон аж ахуй нэгжийн хөрөнгийн үнэлгээ, Голомт банк, Хөгжлийн банк, Чингис хаан банк, Төрийн банкны зээлийн барьцаанд байгаа үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламжийн үнэлгээг Монгол улсын хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Үнэлгээний Олон Улсын Стандартын Консулаас гаргасан "Үнэлгээний Олон Улсын Стандарт" болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу чанарын өндөр түвшинд, хараат бусаар хийж гүйцэтгээд байна.

- 2022 оны 5 дугаар сард "Таван Богд групп" ХХК-ийн охин компани "Улаанбаатар гурил" ХХК, "Мон-Бийф" ХХК-ийн бизнесийн үнэлгээг хийж

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

гүйцэтгэсэн бөгөөд "Мон-Бийф" ХХК нь олон нийтэд хувьцаа гаргаж нээлттэй компани болоод байна.

- 2022 оны 6 дугаар сард Номин группын 8 компанийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.
- 2022 оны 9 дүгээр сард "Боса" ХХК-ийн хөрөнгийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.
- 2022 онд нийт 51 аж ахуй нэгж байгууллага, 450 орчим иргэдийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгээд байна.

### Бизнесийн үнэлгээний компанийн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:

Гэрээний зорилго нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг Үнэлгээний Олон Улсын стандарт, "Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэх хийх юм.

- Захиалагчийн үнэлгээ хийлгэж буй хөрөнгөтэй танилцаж, шинж байдлыг нь тодорхойлж, үнэлгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээт хугацаанд хийж гүйцэтгэнэ.
- Үнэлгээ хийж гүйцэтгэх, хөрөнгийн өнөөгийн байдалд үзлэг хэмжилт судалгаа хийх, ажлын төлөвлөгөө зохиох, мэдээлэл цуглуулах, түүнийг шалгах, үнэлгээ хийх, тайлан бичих, хүлээлгэн өгөх графикийг захиалагчтай хамтран боловсруулж мөрдөнө.
- Захиалагчийн ирүүлсэн мэдээ материалын нууцыг хадгалж, захиалагчийн зүгээс бичгээр албан ёсны зөвшөөрөл ирүүлээгүй тохиолдолд энэ тухай лавлагаа мэдээллийг бусдад гаргаж өгөхгүй болно. Бизнесийн үнэлгээний тайлан болон үнэлгээ хийхтэй холбоотой ирүүлсэн баримт бичгийг архивын нэгж бүрдүүлэн 5-аас доошгүй жил хадгална.
- Үнэлгээний ажлын гэрээт хугацаанд үнэн зөв хийж үнэлгээний тайланг Үнэлгээний Олон Улсын стандартын дагуу бичиж хүлээлгэн өгнө.
- Гаргасан үнэлгээний тайлантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс талбар, тодруулга авах тухай бүр түргэн шуурхай хариу өгөх үүрэгтэй.
- Бизнесийн үнэлгээ хийхэд шаардлагатай үнэн зөв баримт, мэдээллээр хангахыг захиалагчаас шаардах эрхтэй.
- Үйлчлүүлэгч хөрөнгийн үнэлгээний зүйлийн тухай шаардлагатай мэдээллээр хангаагүй, гэрээнд заасан ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй бол хөрөнгийн үнэлгээ хийхээс татгалзах эрхтэй.

## 6.4. ХУУЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | ӨМГӨӨЛЛИЙН "БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС" ХХН |
| Үйл ажиллагааны чиглэл | Хууль зүйн зөвлөгөө өгөх |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2013.06.18 |
| Регистрийн дугаар | 5722292 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-8, Монгол ТВ цамхаг, 10-р давхар |
| Утас | +976 7711-9008 |
| Цахим шуудан | contact@bnp.mn |

Өмгөөллийн "Батбаяр энд Партнэрс" ХХН ("Хуулийн фирм") нь 2013 оны 06 дугаар сарын 18-ны өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн мэргэшсэн бизнесийн хуулийн фирм бөгөөд үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны №72 тоот тогтоолын дагуу авсан. Тус хуулийн фирм нь уул уурхай, барилга, ашигт малтмал, санхүүгийн салбарт мэргэшин хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Өмгөөллийн "Батбаяр энд Партнэрс" ХХН нь үнэт цаасны зах зээлийн оролцогчдод хууль зүйн туслалцаа, хөндлөнгийн дүгнэлт гаргаж өгөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй, гадаад, дотоодын хөрөнгийн биржид хувьцаа, өрийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад үнэт цаасны зах зээлийн бүхий л үе шатанд ажиллаж байсан бөгөөд концесс, төр хувийн хэвшлийн түншлэл (дэд бүтэц - төмөр зам, авто зам, угаах үйлдвэр, барилга, эрчим хүчний салбар), бизнес, компанийн хууль, эрх зүйн түгээмэл тохиолддог асуудлуудаар аж ахуй нэгж, бизнес эрхлэгч, компаниудад хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.

**Амжилттай ажилласан төслүүд:**

- "Төрийн Банк" ХК-ийг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох ажилд хуулийн зөвлөх, хуулийн дүн шинжилгээ, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн;
- "Симпл ассет ТЗК" ХХК-ийн нийтэд санал болгон гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах ажилд хуулийн зөвлөх, хуулийн дүн шинжилгээ, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн;
- "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХХК-ийн олон нийтэд анх удаа үнэт цаас гаргах ажилд хуулийн дүн шинжилгээ;
- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх, 2 их наяд төгрөг хүртэлх өрийн хэрэгсэл/бондыг гаргах ажилд хуулийн зөвлөхөөр ажиллаж, хууль зүйн зөвлөх үйлчилгээ;
- "Монголын Ипотекийн Корпораци ОССК" ХХК-ийн Олон Улсын хөрөнгийн зах зээл 250 сая ам.долларын өрийн хэрэгслийг 3 жилийн хугацаатай, жилийн 8.85%-ийн хүүтэйгээр гаргах ажилд дотоодын хуулийн зөвлөхөөр ажиллаж, хууль зүйн зөвлөх үйлчилгээ;

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023.05.12
Үнэт цаасны танилцуулга
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-03-28
БҮРТГЭВ-02
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
6183855
СТС2420

- “Эрдэнэс сольюшинс ХК”-ийн хувьцааг хуваасантай холбогдуулан үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах ажилд хуулийн дүн шинжилгээ (Due diligence) хийж, хууль зүйн зөвлөгөө;
- “Хар хорум пропертийс ХК”-ийг “Эрдэнэс сольюшинс ХК”-д нэгтгэх (Merger & Acquisition), нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах ажилд хуулийн дүн шинжилгээ (Due diligence) хийж, хууль зүйн зөвлөгөө;
- Үндэсний шингэн хүнсний бүтээгдэхүүн, архи пиво үйлдвэрлэгч ХК-д тусгай зориулалтын компани нэгтгэх, нэмж хувьцаа гаргах ажилд хуулийн дүн шинжилгээ;
- Монголын даатгалын салбарын анхдагч IPO хийж байгаа даатгалын компанийн үнэт цаас гаргах ажилд хуулийн дүн шинжилгээ;
- “Мандал даатгал” ХК-ийн хувьцааг хуваасантай холбогдуулан үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах ажилд хуулийн дүн шинжилгээ (Due diligence), хууль зүйн зөвлөгөө;
- “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргах, тусгай зориулалтын компаниар дамжуулан үнэт цаас гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ.

**Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг:**

Үнэт цаас гаргагч (цаашид “А” тал гэх) болон “Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН” (цаашид “Б” тал гэх) нар нь 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр №02/06/01 дугаартай Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ (цаашид “Гэрээ” гэх) -г байгуулсан бөгөөд энэхүү Гэрээнд Б талын дараах эрх, үүргийг тусгасан. Үүнд:

- Гэрээний дагуу Б тал нь А талын нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах хөндлөнгийн дүн шинжилгээг А талаас гаргаж өгсөн баримт материал, шийдвэрт үндэслэн шалгаж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн холбогдох журамд заасан асуудлыг хамруулсан хуулийн дүгнэлт бэлтгэх ажлыг Гэрээнд заасан нөхцөлөөр хийж гүйцэтгэх;
- Энэхүү Гэрээний дагуу Б талаас үзүүлэх үйлчилгээ нь А талаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт материал, шийдвэрт үндэслэх бөгөөд А тал нь Гэрээний дагуу гүйцэтгэх ажил, үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээлэл, баримт материал, шийдвэрийг үнэн зөв, бүрэн гүйцэт, шаардлагатай цаг хугацаанд нь гаргаж өгөх үүрэг хүлээнэ. Ийнхүү гаргаж өгөөгүй, алдаатай, буруу эсвэл дутуу мэдээлэл, баримт өгсний улмаас үүсэх аливаа хуль зүйн болон санхүүгийн үр дагаврыг Б тал хариуцахгүй байх;
- Урьдчилан гаргаж өгсөн баримтууд дээр үндэслэн дараагийн шаардлагатай дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагаас шаардсан нөхцөлийг тодруулахад ач холбогдолтой баримтуудыг Хуулийн фирмээс тодорхойлох бөгөөд А тал нь тухай бүр шуурхай гаргаж өгч ажиллах;
- Б тал нь Гэрээний дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой олж авсан А талаас гаргаж өгсөн, нийтэд ил болсноос бусад талуудын хооронд солилцсон бүхий л мэдээллийн нууцлалыг чанд хадгалах үүрэг хүлээнэ.

## 6.5. АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

“Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК (цаашид “Үндсэн андеррайтер” гэх) нь Үнэт цаас гаргагч “Бизнес-Инвест девелопмент” ХХК (РД: 5013348) -тай 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн №АГ-23/03 дугаартай “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”, 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн №АГН-23/3 дугаартай нэмэлт өөрчлөлтийн дагуу Үнэт цаас гаргагчийн нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн үнэтэй, 80,000 (наян мянга) ширхэг бондыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгож нийт 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд хамтран ажиллаж байгаа билээ.

Үндсэн андеррайтер нь үнэт цаасны танилцуулгыг бэлтгэхдээ Санхүүгийн зохицуулах хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”, Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн тухай журам”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”, “Компанийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журамд нийцүүлэн хараат бус андеррайтерийн дүгнэлтийг гаргасан болно.

Андеррайтерийн мэргэжлийн дүгнэлтийг дараах дэд хэсгүүдийн хүрээнд танилцуулж байна.

- Үнэт цаас гаргагчийн тухай
- Макро эдийн засаг, салбарын төлөв байдал
- Бизнесийн төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө
- Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт
- Эрсдэлийн бодлого
- Өрийн хэрэгслийн хүү тогтоосон үндэслэл
- Хөрөнгө оруулалтын боломж
- Хөрөнгө оруулагч нарт зөвлөх нь

### 1. Үнэт цаас гаргагчийн тухай

БИД ББСБ нь 2005 оны 08 дугаар сарын 19-ний өдөр үүсгэн байгуулагдсан, 19 жилийн түүхтэй Монгол Улсын ууган банк бус санхүүгийн байгууллагуудын нэг юм. 2022 оны эцсийн байдлаар БИД ББСБ-ын нийт активын хэмжээ 69.9 тэрбум төгрөг, нийт зээлийн багц 54.2 тэрбум төгрөгт хүрсэн ба тус онд 102.5 тэрбум төгрөгийн зээл олголтыг хувь хүмүүс, бизнес, өрхүүдэд олгосон өндөр амжилттай байсан юм. Нийт харилцагчдын тоо 24,224-д хүрч, үүнээс онлайн харилцагчдын тоо 18,468-ыг давжээ.

БИД ББСБ нь 2020 онд бүтцийн шинэчлэлт хийж “БИД ББСБ” болон “БИД Финанс ББСБ” нэгдэн “Бизнес-Инвест девелопмент ББСБ” ХХК дор үйл ажиллагаагаа явуулах болсон. Компани нь 2021 онд финтек зээлийн үйлчилгээний “БИД апп”-ыг зах зээлд гаргаж, шинэлэг технологийг бизнестээ нэвтрүүлсэн бөгөөд 2022 оны эцсийн байдлаар тус аппликэйшний таталт 100,000-аас дээш тоог давaад байна. Мөн 2022 онд БИД ББСБ нь ребрэндинг хийж компанийн өнгө төрхөө шинэчлэн, бизнесийн дараагийн шинэ шат руу гарах алхмаа хийсэн юм.

Үнэт цаас гаргагч нь Улаанбаатар хотын хүн ам олноор төвлөрсөн бүсүүдэд нийт 14 салбар нэгжтэй бөгөөд Мөрөн хот, Эрдэнэт хот, Дархан хот дахь салбараар дамжуулан орон нутгийн иргэд, аж ахуй нэгжүүдэд зээл, санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэж байна. Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ-аас шалгаруулдаг "ТОП ББСБ"-аар 2006-2013 онуудад тасралтгүй шалгарсан ба 2022 онд Монголын маркетинг менежментийн хүрээлэнгээс БИД ББСБ-ыг "2022 оны Банк бус санхүүгийн салбарын шилдэг ББСБ"-аар шалгаруулаад байна.

Компани нь анх үүсгэн байгуулагдсан цагаас хойш 19 жилийн хугацаанд нийт 700.0 гаруй тэрбум төгрөгийг 140,000 гаруй үйлчлүүлэгчдэд олгож 20,000 гаруй ажлын байр шинээр бий болгоод байна. БИД ББСБ нь жил бүр 15-40 хувийн нийт хөрөнгийн өсөлтийг тогтмол үзүүлж, Монгол Улсын төсвийн орлогод жил бүр 1.0 тэрбум гаруй төгрөг төлдөг хариуцлагатай, шилдэг аж ахуй нэгж юм.

Нийгмийн хариуцлагын хүрээнд 2007, 2012 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-ийн "Ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах" төслийг 2 удаа амжилттай хэрэгжүүлж 290.0 сая төгрөгийн зээлийн санхүүжилтийг ажлын байрыг дэмжих, хадгалах зорилгоор хувь хүмүүс, өрхүүдэд олгосон байна. Мөн Монгол Улсын Засгийн газраас Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлсэн "Тогтвортой амьжиргаа-II" (ТАТ-II) төсөлд нийт 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зорилтот бүлэгт хүргэжээ. Улаанбаатар хотын агаарын бохирдол, орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх "Грийнспот" төслийн дэмжигчээр оролцож Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 5 дугаар хороонд байрлах 3,200 м.кв талбайд хийх орчны ногоон тохижилтын ажилд 200.0 сая төгрөгийг хандивлахаар болсон.

Санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлэхэд БИД ББСБ нь олон талын санхүүжилтийн арга хэрэгслийг ашигладаг ба 2021 онд Монгол Улсын Биржийн бус зах зээлийн анхны бондыг гаргаж 1.0 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж байсан туршлагатай юм. Мөн Үнэт цаас гаргагч нь Олон Улсын банк, санхүүгийн байгууллагуудтай идэвхтэй хамтын ажиллагаатай ба тогтвортой хөгжил, хүртээмжтэй санхүүгийн чиглэлээр санхүүжилт олгодог "Ойко кредит" компаниас 500.0 мянган ам.долларын санхүүжилт, 2019 онд "Инкофин" санхүүгийн байгууллагаас 1.0 сая ам.долларын санхүүжилт, "Франкфуртын Санхүү, менежментийн сургуулийн сан"-аас 2019 онд 750.0 мянган ам.доллар, 2022 онд 1.0 сая ам.долларын санхүүжилтийг тус тус амжилттай татан төвлөрүүлээд байна.

БИД ББСБ нь хүртээмжтэй, бичил санхүүжилтийн үйлчилгээг цаашид улам бүр нэмэгдүүлж, шинэлэг шийдлийг цаг алдахгүй харилцагч нартаа хүргэхээр компанийн дотоод бүтэц зохион байгуулалтдаа 2022 онд "Бизнес хөгжлийн газар"-ыг шинээр үүсгэн байгуулж, цаашид финтект суурилсан дараагийн дижитал шилжилтийг хийх томоохон өөрчлөлтөд бэлэн болоод байна.

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК

УЛААНБААТАР ХОТ

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

## 2. Макро эдийн засаг, салбарын төлөв байдал

Монгол Улсын эдийн засаг 2022 онд 4.8 хувийн бодит өсөлттэй гарсан бөгөөд 2020 оны цар тахлын хямралын дараах (Post-Covid) жилүүд дэх хамгийн өндөр өсөлтийг үзүүллээ. Монгол Улсын цар тахлын дараах сэргэлт нь U-хэлбэрийн сэргэлтийг харуулж байгаа ба Монголбанкнаас 2023 оны эдийн засгийн өсөлтийг 3.2 хувь байхаар төсөөлсөн бол Олон Улсын санхүүгийн байгууллагууд 4.9-5.8 хувийн өсөлттэй байна гэж таамаглаж байна.

Инфляцын түвшин 2022 онд улсын хэмжээнд 13.2 хувь гарсан бөгөөд хэрэглээний үнийн өсөлтийн тал орчим хувийг импортын барааны үнийн өсөлт, дотоодын үйлдвэрлэлийн зардал нэмэгдсэн нь нөлөөлж байна. 2023 онд Төв банкнаас дотоодын инфляцын түвшин зорилтот түвшинд (6%±2%) ойртож, 9.1 хувьд хүрнэ гэж үзэж байна. Өнгөрсөн онд Монголбанкнаас мөнгөний хатуу бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж, бодлогын хүүг нэг дахин буюу 6.0 нэгжээс 13.0 нэгж хүртэл өсгөсөн нь үнийн өсөлтийг сааруулах нөлөө үзүүлж эхэллээ.

Монгол Улсын банк бус санхүүгийн салбарын хувьд 2022 оны эцсийн байдлаар 513 ББСБ үйл ажиллагаа идэвхтэй эрхэлж байна. Тусгай зөвшөөрлийн хувьд Хорооноос зээлийн үйл ажиллагааг дагнан эрхэлдэг 307 ББСБ байгаа бол факторинг 45, итгэлцлийн үйлчилгээг эрхлэх 64, цахим төлбөр тооцоо мөнгөн гүйвуулгын 37 ББСБ тус тус байна. Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2022 оны 4 дүгээр улиралд 3.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд банкны салбарын нийт хөрөнгийн 7.7 хувьтай тэнцэж байна. Чанаргүй зээлийн хувь ББСБ-ын салбарт 7.6 хувьтай байгаа нь өнгөрсөн оноос 0.6 пунктээр нэмэгдсэн үзүүлэлт болжээ.

Цар тахлаас хойших сүүлийн 3 жилд банк бус, санхүүгийн салбарт гарч буй томоохон шинэчлэлт нь финтек технологид суурилсан гар утасны аппликэйшнээр хялбар зээл авах үйлчилгээ хурдацтай тэлж байгаа үзэгдэл юм. Монгол Улсын банк бус, санхүүгийн байгууллагаар үйлчлүүлж буй, давхардсан тоогоор 4.6 сая харилцагчдын 94.2 хувийг зөвхөн финтек харилцагчид эзэлж байгаа бол финтек зээлийн багц нь тус салбарын нийт зээлийн үлдэгдлийн 1,257.6 тэрбум төгрөг буюу 46.2 хувийг бүрдүүлж байна.

Мөнгөний хатуу бодлогоос үүдэлтэй мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн удаашрал нь банкны харилцагчдын шалгуур, журамд хатуу зохицуулалтууд орох, зээл олголтоо хумих үйл хөдлөл рүү хөтөлж байгаа хэдий ч энэхүү мөнгөний зах зээлийн төлөв байдал нь банк бус, санхүүгийн байгууллагад зах зээлээ тэлэх шинэ орон зайг олгож байна.

## 3. Бизнесийн төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл

2023-2027 оны хооронд БИД ББСБ нь нийт активаа жилд дунджаар 19.5 хувиар өсөхөөр төсөөлжээ. Энэхүү өсөлтийн төсөөлөл нь тус компанийн нийт активын 2019-2022 оны хооронд өссөн 18.2 хувьтай ойролцоо байгаа нь санхүүгийн төсөөллөө түүхэн хугацааны өсөлт дээр суурилж гаргасан бодитой төсөөлөл гэдгийг илтгэж байна. Мөн 2027 он гэхэд нийт зээлийн багцын хэмжээ 121.4 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байгаа юм.

*Хүснэгт 35. Санхүү байдлын тайлангийн төсөөлөл, 2023-2027*

| (мянган төгрөг) | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Мөнгө түүнтэй адилгах | 6,161,185 | 10,301,441 | 11,109,471 | 10,000,508 | 16,802,838 |
| Зээлийн багц | 64,479,660 | 80,107,660 | 98,732,660 | 111,482,660 | 121,382,660 |
| Эрсдэлийн сан | (2,114,390) | (2,314,000) | (2,853,374) | (3,221,849) | (3,681,359) |
| Бусад эргэлтийн хөрөнгө (хүү авлага, бусад) | 5,234,584 | 7,768,115 | 9,726,823 | 11,599,732 | 13,711,790 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 4,560,260 | 6,452,000 | 8,653,800 | 10,112,000 | 11,487,000 |
| Нийт хөрөнгө | 78,321,299 | 102,315,216 | 125,369,381 | 139,973,051 | 159,702,929 |
| Итгэлцэл | 13,681,500 | 18,261,500 | 22,998,990 | 25,684,480 | 28,369,970 |
| Бонд | 12,752,650 | 19,905,650 | 27,405,650 | 24,905,650 | 22,405,650 |
| Дотоод зээл | 3,400,000 | 3,400,000 | 3,400,000 | 4,000,000 | 4,400,000 |
| Гадаад зээл | 5,551,500 | 7,978,500 | 7,978,500 | 9,978,500 | 13,478,500 |
| Бусад (хүү, татварын өглөг) | 2,359,500 | 3,882,114 | 5,770,658 | 6,936,140 | 10,318,860 |
| Нийт өр төлбөр | 37,745,150 | 53,427,764 | 67,553,798 | 71,504,770 | 78,972,980 |
| Хувьцаат капитал | 5,000,001 | 5,000,001 | 5,000,001 | 5,000,001 | 5,000,001 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 526,648 | 526,648 | 526,648 | 526,648 | 526,648 |
| Хуримтлагдсан ашиг | 27,048,500 | 33,249,500 | 41,360,803 | 50,088,934 | 60,441,632 |
| Тайлант оны цэвэр ашиг | 8,001,000 | 10,111,303 | 10,928,131 | 12,852,698 | 14,761,668 |
| Нийт эздийн өмч | 40,576,149 | 48,887,452 | 57,815,583 | 68,468,281 | 80,729,949 |
| Нийт эздийн өмч ба өр төлбөр | 78,321,299 | 102,315,216 | 125,369,381 | 139,973,051 | 159,702,929 |

Өрийн хэрэгслээр бий болгох санхүүжилтийг 2025 онд 27.4 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлж, дараагийн жилүүдэд аажмаар 9.6 хувиар бууруулан 22.4 тэрбум төгрөгт хүргэх төлөвлөгөөтэй байна. Гадаад болон дотоодын банк, санхүүгийн байгууллагаас татах зээлийн санхүүжилт 2023 онд 8.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байх бол 2027 онд Олон Улсын хамтын ажиллагааны үр дүнд 17.9 тэрбум төгрөгт хүрэх төсөөллийг гаргажээ.

*Хүснэгт 36. Орлогын хураангуй тайлангийн төсөөлөл, 2023-2027*

| (мянган төгрөг) | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Хүүгийн орлого | 22,054,300 | 28,670,612 | 33,174,174 | 37,458,174 | 42,241,166 |
| Хүүгийн бус орлого | 831,700 | 1,037,054 | 1,140,759 | 1,311,873 | 1,508,654 |
| Хүүгийн зардал | 5,724,300 | 8,251,347 | 10,328,356 | 10,846,500 | 11,571,413 |
| Хүүгийн бус зардал | 7,427,550 | 9,174,589 | 10,615,736 | 11,986,616 | 13,696,184 |
| Нийт ашиг | 9,734,150 | 12,281,730 | 13,370,842 | 15,936,931 | 18,482,224 |
| Татвар | 1,732,460 | 2,170,427 | 2,442,710 | 3,084,233 | 3,720,556 |
| Цэвэр ашиг | 8,001,690 | 10,111,303 | 10,928,131 | 12,852,698 | 14,761,668 |

2023 онд БИД ББСБ нь нийт хүүгийн орлогыг 22.0 тэрбум төгрөгт хүрч, цэвэр ашиг 8.0 тэрбум төгрөг байх төсөөллийг гаргасан. Хүүгийн бус орлогын дүн 2023 онд 0.8 тэрбум төгрөг байх бол 2027 онд орон нутаг дахь салбарын тоогоо нэмэгдүүлснээр үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлого 1.5 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна.

2023.05.12
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

*Хүснэгт 37. Мөнгөн гүйлгээний тайлан, 2023-2027 он*

| (мянган төгрөг) | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| | | Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | | |
| **Орох урсгал** | **125,615,866** | **165,774,135** | **232,031,224** | **276,147,138** | 328,737,761 |
| Зээлийн үндсэн төлөлт | 103,675,687 | 137,500,000 | 199,375,000 | 239,250,000 | 287,100,000 |
| Зээлийн хүүгийн төлөлт | 20,951,611 | 27,237,081 | 31,515,465 | 35,585,265 | 40,129,107 |
| Бусад орлого (үйлчилгээний хураамж, хадгаламж) | 988,569 | 1,037,054 | 1,140,759 | 1,311,873 | 1,508,654 |
| **Гарах урсгал** | **131,896,730** | **167,965,146** | **234,720,872** | **270,360,573** | **317,832,229** |
| Зээл олголт | 115,675,687 | 153,128,000 | 218,000,000 | 252,000,000 | 297,000,000 |
| Үйл ажиллагааны зардал | 12,950,894 | 8,974,979 | 10,076,362 | 11,618,141 | 13,236,674 |
| Капитал зарцуулалт | 103,893 | 1,891,740 | 2,201,800 | 1,458,200 | 1,375,000 |
| Ногдол ашиг | 1,433,791 | 1,800,000 | 2,000,000 | 2,200,000 | 2,500,000 |
| Татвар | 1,732,465 | 2,170,427 | 2,442,710 | 3,084,233 | 3,720,556 |
| **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(6,280,864)** | **(2,191,011)** | **(2,689,648)** | **5,786,565** | **10,905,532** |
| | | Санхүүжилтийн мөнгөн гүйлгээ | | | |
| **Орох урсгал** | **24,820,575** | **40,771,740** | **38,095,800** | **36,900,200** | **35,917,000** |
| Гадаад | - | 8,500,000 | 2,000,000 | 6,000,000 | 6,000,000 |
| Дотоод | 1,500,000 | 1,900,000 | - | 2,100,000 | 400,000 |
| Бонд | 10,000,000 | 15,000,000 | 20,000,000 | 15,000,000 | 15,000,000 |
| Итгэлцэл | 13,320,575 | 15,371,740 | 16,095,800 | 13,800,200 | 14,517,000 |
| **Гарах урсгал** | **24,145,276** | **33,340,473** | **34,298,122** | **43,795,728** | **40,020,202** |
| Гадаад | 7,150,000 | 6,988,798 | 3,210,338 | 5,271,018 | 4,119,928 |
| Дотоод | 623,000 | 2,532,400 | 632,400 | 2,154,720 | 758,880 |
| Бонд | 4,731,162 | 10,399,985 | 15,639,454 | 21,018,784 | 18,590,000 |
| Итгэлцэл | 11,641,114 | 13,419,290 | 14,815,930 | 15,351,206 | 16,551,394 |
| **Санхүүжилтийн цэвэр мөнгөн урсгал** | **675,299** | **7,431,267** | **3,797,678** | **(6,895,528)** | **(4,103,202)** |
| | | Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ | | | |
| Орох урсгал | 5,646,851 | 500,000 | 200,000 | 200,000 | 200,000 |
| Гарах урсгал | 3,587,660 | 1,600,000 | 500,000 | 200,000 | 200,000 |
| **Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн урсгал** | **2,059,191** | **(1,100,000)** | **(300,000)** | **-** | **-** |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | (3,546,374) | 4,140,256 | 808,030 | (1,108,963) | 6,802,330 |
| Эхний үлдэгдэл | 9,707,559 | 6,161,185 | 10,301,441 | 11,109,471 | 10,000,508 |
| **Эцсийн үлдэгдэл** | **6,161,185** | **10,301,441** | **11,109,471** | **10,000,508** | **16,802,838** |

Мөнгөн гүйлгээг төрлөөр нь ялгахад 2024, 2025 онуудад нийт 11.2 тэрбум төгрөгийн цэвэр санхүүжилт татах бол 2026, 2027 онд 11.0 орчим тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлт хийгдэж, үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн

БИЗНЕС ИНВЕСТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ... ХХК

2023 .05. 12

Үнэт цаасны танилцуулга
2023 -03- 28
БҮРТГЭВ-02

үлдэгдэл 10.9 тэрбум төгрөгт хүрснээр эцсийн мөнгөн үлдэгдлийн төсөөлөл 2027 онд 16.8 тэрбум төгрөг байх хүлээлттэй байна.

Нийт хөрөнгийн өгөөж 2023 онд 10.2 хувь байх бол өөрийн хөрөнгийн өгөөж 19.7 хувь байх төсөөлөлтэй байна. Нийт эх үүсвэрт эзлэх өр төлбөрийн эргэн төлөлт, хүүгийн төлбөрийн улмаас цэвэр ашиг багасаж, нийт хөрөнгө болон өөрийн хөрөнгийн үр өгөөж ялимгүй доогуур түвшингээс сэргэж тогтворжих хандлагатай байна.

## 4. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь 80,000 (наян мянга) ширхэг, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, тогтмол хүүтэй, энгийн бондыг олон нийтэд санал болгож нийт 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа билээ. Энэхүү олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаас гаргагч нь бизнесийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд зарцуулна.

*Хүснэгт 38. Эх үүсвэрийн зарцуулалтын төлөвлөгөө*

| № | Эх үүсвэрийн зарцуулалтын төлөвлөгөө | Мөнгөн дүн |
|---|---|---|
| 1 | Зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх | 8,000,000,000 (найман тэрбум) төгрөг |

*(Тайлбар: Өрийн хэрэгслээр татан төвлөрүүлэх санхүүжилтийг зөвхөн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд тус санхүүжилтийн зардлыг татан төвлөрүүлэх хөрөнгөөс гаргахгүй болно.)*

## 5. Эрсдэлийн бодлого

Компани нь “Эрсдэлийн удирдлагын бодлого”-доо эрсдэлийн удирдлагын тодорхойлолт, зорилт, үндсэн зарчим, төрөл, ангилал, хэрэгжүүлэх үе шат, тайлагнал, хяналт хариуцлагын талаар тусган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

* ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо нь байгууллагын үйл ажиллагааны бүхий л чиглэлийн эрсдэлийг тооцож, дотооддоо мөрдөх заавар байгууллагын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн батална.
* Заавраар байгууллагын зорилго, зорилтот нөлөөлөх эрсдэл, ирээдүйд тохиолдох магадлал ба нөлөөллийг үнэлснээр эрсдэлд хариу арга хэмжээ, түүнийг үнэлэх үйл авцад мониторинг хийх зэрэг эрсдэлийн удирдлагын хүрээг тодорхойлно.
* ТУЗ-ийн Эрсдэлийн хороо нь зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд байгууллагын эрсдэлийн удирдлага, түүний хэрэгжилтэд хяналт тавина.
* Эрсдэлийн удирдлагын баримт бичгийг цаг үедээ тохируулан тухай бүр шинэчлэн батална.

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг удирдах, хяналт гэсэн 4 үе шатыг дамжина. Тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэх болон бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, гуравдагч талын харилцаа, зах зээлээс хамаарсан, эсхүл зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт зэргээс үүсэх магадлалтай эрсдэлийг байгууллагын бүхий л түвшинд тодорхойлно. Үүнд дараах хүчин зүйлсийг харгалзаж үзнэ. Үүнд:

* Эрсдэлийн шинж чанар (nature of the risk) - хаана, хэзээ, ямар үйл явдал;
* Эрсдэлийн эх үүсвэр (source of the risk) - ямар хүчин зүйлс, хүн, үйл ажиллагаа;
* Эрсдэлийн шалтгаан (cause of the risk) - шууд болон шууд бус шалтгаан;
* Эрсдэлийн нөлөө (effect of the risk)- үүсэх үр дагавар, хамгийн сөрөг нөлөө;

## 7. Өрийн хэрэгслийн хүү тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийн хүүгийн түвшинг тогтоохдоо зах зээлийн нөхцөл байдал, ижил төстэй өрийн хэрэгслийн хүү, бодлогын хүү ба инфляц, эдийн засгийн тодорхой бус байдал, хөрөнгө оруулагчдын хүлээлтэд үндэслэн жилийн 18.5 хувийн хүүг санал болгож байна.

Монгол Улсын системийн нөлөө бүхий 5 банкны 12 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн зарласан хүүг харьцуулж харвал дунджаар 12.2 хувь байна. Харин Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалагдаж буй нээлттэй бонд, ХБҮЦ-ны харьцуулалтыг хийхэд хамгийн сүүлд гарсан Сэндли Бонд 19.2 хувь байгаа бол Инвескор 2.0 бондын хүү 18.0 хувь байсан юм.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл”-ийн хүрээнд “Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ” гэжээ. Иймд зах зээл дээр дунд хугацааны инфляц нэг оронтой тоо орчимд очих, дунд хугацаанд энэ түвшиндээ тогтворжих хүлээлтийг бий болгож байна.

## 8. Хөрөнгө оруулалтын боломж

### * Өндөр өгөөж

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад 18.5 хувийн хүүг санал болгож байгаа нь 2022 онд Монгол хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдсан бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)-ны дундаж хүү 16.61 хувийн хүүтэй харьцуулахад харьцангуй өндөр хүүтэй байна. Мөн хөрөнгийн зах зээл дээр 2022 онд хамгийн сүүлд нээлттэй арилжаалагдсан “Инвескор Бонд 2.0” нь жилийн 18.0 хувийн хүүтэй гарсан ба тус бондын өгөөжөөс 0.5 пунктээр өндөр байгаа нь хөрөнгө оруулагч нарт хөрөнгөө илүү өндөр өгөөжтэй удирдах боломжийг олгож байгаа юм.

### * Арилжааны боломж

Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгсэл нь Монгол хөрөнгийн биржийн систем дээр нээлттэй байршиж, олон нийтэд арилжаалагдах учраас бонд эзэмшигч нь хэрэгцээтэй үедээ худалдан авсан бондоо хоёрдогч зах зээл дээр борлуулах, худалдан авах бүрэн боломжтой байна. Бондыг эзэмшиж буй хөрөнгө оруулагч нь

зах зээл дээр хадгаламжийн хүү буурах эсвэл бондын эргэн төлөлтийн хугацаа дөхөх тусам бондын үнэ өссөнөөр (the pull to par effect) ханшийн зөрүүнээс ашиг хүртэх боломжтой.

* **Эргэн төлөгдөх барьцаа, батлан даалттай бонд**

"БИД ББСБ" ХХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтээс санхүүжилт татах зорилгоор гаргаж буй 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй бондын үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийн эрсдэлийг бууруулж, хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах зорилгоор Үнэт цаас гаргагч ба Андеррайтер нь харилцан тохиролцсоны үндсэн дээр тус компанийн өөрийн хөрөнгийг холбогдох журмын дагуу барьцаална. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.5-д заасны дагуу тус компанийн хувьцаа эзэмшигч А.Алтансүх болон Х.Одонтуяа нар нь хувийн батлан даалт гаргасан болно.

## 9. Хөрөнгө оруулагч нарт зөвлөх нь

Хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчийн танилцуулгын бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөллүүд нь ирээдүйн макро эдийн засгийн орчин, хөрөнгийн зах зээлийн төлөв байдлын судалгаанд үндэслэсэн таамаглалууд дээр суурилж байгаа учраас нийгэм, эдийн засгийн урьдчилан таамаглах боломжгүй гэнэтийн шокуудын улмаас өөрчлөгдөж болно гэдгийг анхаарах нь зүйтэй.

Иймд хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан "Эрсдэлийн удирдлага", "Бизнес төлөвлөгөө", "Зах зээлийн судалгаа" хэсгүүдтэй сайтар уншиж, танилцсаны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл санал болгох үйл ажиллагаанд оролцогч мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь хоорондоо болон Үнэт цаас гаргагчтай аливаа сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдэж байна.

Үнэт цаасны танилцуулга 2023-05-28

БҮРТГЭВ-02

**Бизнес Инвест Девелопмент ББСБ ХХК**

**Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Дагуу бэлтгэгдсэн Санхүүгийн Тайлан болон Хараат бус Аудиторын Тайлан**

**2022 оны 12 дугаар сарын 31**

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ХХК
5183855
9021031195 СТС2420

BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ

Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

АГУУЛГА

Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл ..... 3
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН ..... 4

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН ..... 7
САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН ..... 8
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН ..... 9
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН ..... 10

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ТЭМДЭГЛЭЛ

1. Компанийн ерөнхий мэдээлэл ..... 12
2. Компанийн үйл ажиллагааны орчин ..... 13
3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд ..... 13
4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо ..... 18
5. Хүү болон адилтгах орлого ..... 28
6. Хүү болон адилтгах зарлага ..... 28
7. Санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийн бууралт ..... 28
8. Шимтгэл, хураамжийн орлого ..... 28
9. Ерөнхий ба удирдлагын зардал ..... 28
10. Бусад олз/(гарз) ..... 29
11. Бусад орлого ..... 29
12. Бусад зардал ..... 30
13. Орлогын албан татвар ..... 30
14. Ногдол ашиг ..... 30
15. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө ..... 30
16. Хугацаат хадгаламж ..... 31
17. Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт ..... 31
18. Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт ..... 31
19. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа ..... 32
20. Бусад санхүүгийн хөрөнгө ..... 35
21. Бусад санхүүгийн бус хөрөнгө ..... 35
22. Үндсэн хөрөнгө ..... 36
23. Түрээс ..... 37
24. Хөрөнгө оруулалтын зориулалттай үндсэн хөрөнгө ..... 38
25. Биет бус хөрөнгө ..... 39
26. Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр ..... 40
27. Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл ..... 40
28. Бондын өр төлбөр ..... 42
29. Бусад санхүүгийн өр төлбөр ..... 42
30. Бусад санхүүгийн бус өр төлбөр ..... 42
31. Эрсдэлийн удирдлага ..... 42
32. Мөнгөн гүйлгээний тайланг дэмжих тэмдэглэл ..... 52
33. Холбоотой талууд ..... 53
34. Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага ..... 55
35. Тайлагналын өдрийн дараах үйл явдал ..... 55
36. Тайлангийн оруулга ..... 55

BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
9023010137

УЛААНБААТАР ХОТ
ХХК

БҮРТГЭВ №01

Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02

## Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Энэхүү тайлангийн 3-5 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй уншигдах дараах мэдэгдэл нь Бизнест Инвест Девелопмент ББСБ Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн (цаашид 'Компани' гэх) 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь ялгаруулах үүднээс хийгдсэн болно.

Компани-ийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагнагч Олон Улсын Стандарт ('СТОУС')-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлага ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ('СТОУС'), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг шалгахыг зөвшөөрч байна.

*Ц. Бат-Эрдэнэ*
Гүйцэтгэх захирал

*А. Баяржаргал*
Ерөнхий нягтлан бодогч

Монгол Улс, Улаанбаатар хот
2023 оны 3 сарын 1



БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 .03. 12 өдөр
БҮРТГЭВ

Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02



# ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**Бизнес Инвест Девелопмент ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

---

**Аудиторын дүгнэлт**

Бизнес Инвест Девелопмент ХХК (цаашид "Компани" гэх)–ийн 2022 оны 12 дугаар сарын 31–ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31–ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд ("СТОУС")–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")–уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм"–ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

**Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага**

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

**Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг**

Залилан эсвэл алдаанаас үүсэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ХХК УЛААНБААТАР ХОТ
JPA АУДИТ Хуудас №: 4
УЛААНБААТАР ХОТ ХХК

JPA GLOBAL MONGOLIA

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

### Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.

- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын өрөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын эхлэн төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Хуудас № 5

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 сар 03. 12 өдөр
БҮРТГЭВ
№

Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

JPA GLOBAL MONGOLIA

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

**Бусад зүйл**

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно

**ЖЭЙ ПИ ЭЙ ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид:

Гарын үсэг

**У. Нарандэлгэр**
Аудитор

Батлагсан

**Э. Булган**
Партнер

**Улаанбаатар хот, Монгол улс**
**2023 оны 3 дугаар сарын 2**

БИД БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

Хуудас № 6

## 2022 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ДУУССАН ТАЙЛАНТ ЖИЛИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

| Мянган төгрөгөөр | Тэм | 2022-12-31 | 2021-12-31 |
|---|---|---|---|
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 5 | 18,952,857 | 13,338,418 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | 6 | (4,176,352) | (3,093,470) |
| Санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийн бууралт | 7 | (19,058) | (1,087,181) |
| **Нийт ашиг** | | **14,757,247** | **9,157,767** |
| | | | |
| Үйлчилгээний хураамжийн орлого | 8 | 12,980 | 3,114 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 9 | (4,845,464) | (3,680,328) |
| Хэрэгжээ оруулалтын зориулалттай хөрөнгийн дахин үнэлгээний олз / (гарз) | 24 | (59,675) | 2,704 |
| Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз | 18 | - | 52,895 |
| Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний гарз | 25 | (580,080) | (53,581) |
| Бусад олз/ (гарз) | 10 | (955,110) | (5,178) |
| Бусад орлого | 11 | 274,729 | 469,784 |
| Бусад зардал | 12 | (268,107) | (129,722) |
| **Татварын өмнөх ашиг** | | **8,336,520** | **5,817,457** |
| | | | |
| Татварын зардал | 13 | (1,299,113) | (657,540) |
| **Тайлант жилийн ашиг** | | **7,037,407** | **5,159,917** |
| | | | |
| **Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого:** | | | |
| Дахин үнэлгээний олз | | 80,723 | 26,868 |
| Дахин үнэлгээний нөөцийн ашиг/(алдагдал) | | (62,466) | (6,717) |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг** | | **7,055,664** | **5,180,068** |

2023.05.12

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх

## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

| Мянган төгрөгөөр | Тэм | 2022-12-31 | 2021-12-31 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 15 | 8,383,205 | 5,919,649 |
| Хугацаат хадгаламж | 16 | 1,975,838 | 3,241,925 |
| Өрийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт | 17 | 677,347 | 1,203,391 |
| Өмчийн хэлбэрээрх хөрөнгө оруулалт | 18 | 448,666 | 884,492 |
| Харилцагчдад олгосон зээл | 19 | 52,139,655 | 41,028,093 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 20 | 417,016 | 386,751 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 21 | 615,881 | 112,441 |
| **Нийт эргэлтийн хөрөнгө** | | **64,657,608** | **52,776,742** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | |
| Үндсэн хөрөнгө | 22 | 3,441,355 | 3,684,377 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | 23 | 716,793 | 501,489 |
| Хөрөнгө оруулалтын хөрөнгө | 24 | 752,601 | 812,277 |
| Биет бус хөрөнгө | 25 | 75,820 | 701,243 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | | 286,296 | 21,925 |
| **Нийт эргэлтийн бус хөрөнгө** | | **5,272,865** | **5,721,311** |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **69,930,473** | **58,498,053** |
| **Өр төлбөр** | | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | |
| Иттэлцлийн үйлчилгээний өр төлбөр | 26 | 16,658,632 | 15,756,513 |
| Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл | 27 | 12,902,177 | 11,236,319 |
| Бонд | 28 | 6,836,363 | 3,756,992 |
| Орлогын татварын өглөг | | 489,715 | 210,208 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 29 | 331,814 | 256,085 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 30 | 26,540 | 8,144 |
| **Нийт богино хугацаат өр төлбөр** | | **37,243,241** | **31,224,261** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | | |
| Түрээсийн өр төлбөр | 23 | 424,053 | 215,743 |
| Хойшлогдсон татварын өглөг | | 125,548 | 19,941 |
| **Нийт урт хугацаат өр төлбөр** | | **549,601** | **235,684** |
| **Нийт өр төлбөр** | | **37,792,842** | **31,459,945** |
| **Эздийн өмч** | | | |
| Хувьцаат капитал | | 5,000,001 | 5,000,001 |
| Дахин үнэлгээний нөөц | | 484,333 | 546,799 |
| Хуримтлагдсан ашиг | | 26,653,297 | 21,491,308 |
| **Нийт эздийн өмч** | | **32,137,631** | **27,038,108** |
| **Нийт өр төлбөр болон эздийн өмч** | | **69,930,473** | **58,498,053** |

JMA АУДИТ Хуудас №: 8

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КАПИТАЛ УДК ХХК
5183855
9021031198 СТС2420

## 2022 ОНЫ 12 САРЫН 31-НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Мянган төгрөгөөр | Хувьцаат капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан ашиг | Нийт өмч |
|---|---|---|---|---|
| **2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | **5,000,001** | **526,648** | **18,154,431** | **23,681,080** |
| Тайлант жилийн ашиг | - | - | 5,159,916 | 5,159,916 |
| Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого | - | 20,151 | - | 20,151 |
| Төлсөн ногдол ашиг | - | - | (1,823,040) | (1,823,040) |
| **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **5,000,001** | **546,799** | **21,491,307** | **27,038,197** |
| | | | | |
| **2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл** | **5,000,001** | **546,799** | **21,491,307** | **27,038,107** |
| Тайлант жилийн ашиг | - | - | 7,037,407 | 7,037,407 |
| Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого | - | (62,466) | 80,723 | 18,257 |
| Төлсөн ногдол ашиг | - | - | (1,958,140) | (1,958,140) |
| **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **5,000,001** | **484,333** | **26,653,297** | **32,137,831** |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

BID BUSINESS INVEST DEVELOPMENT

СЭХ 2023 .03. 12 өдөр БҮРТГЭВ № 01

Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02

## 2022 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| *Мянган төгрөгөөр* | Тэм | 2022-12-31 | 2021-12-31 |
|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| **Тайлант жилийн ашиг/(алдагдал)** | | **8,336,520** | **5,817,457** |
| *Тохируулга:* | | | |
| Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэлийн сангийн зардал | 7 | 19,058 | 1,087,181 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 9 | 276,149 | 274,005 |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга | 9 | 149,358 | 111,441 |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга | 9 | 58,825 | 29,692 |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны (олз)/ гарз | | - | - |
| Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний гарз | | 580,060 | 53,581 |
| Койн арилжаанаас үүссэн олз | | - | (1,015) |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийн (олз)/ гарз | 24 | 59,675 | (2,704) |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны (олз)/ гарз | 22 | 751 | 3,602 |
| Гадаад валютын ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй гарз | 10 | 982,663 | 2,589 |
| Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх өмчийн хөрөнгө оруулалтаас үүссэн (олз)/ гарз | 18 | (1,920) | (52,895) |
| Ногдол ашгийн орлого | 14 | (14,627) | (701) |
| Түрээсийн хөрөнгө данснаас хассанаас үүсэх орлого | | - | (3,145) |
| Хүүгийн болон түүнтэй адилтгах орлого | 5 | (18,952,657) | (13,338,418) |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | 6 | 4,176,352 | 3,093,470 |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны ашиг/(алдагдал)** | | **(4,329,773)** | **(2,926,860)** |
| Харилцагчдад олгосон зээлийн (өсөлт)/ бууралт | | (11,796,987) | (10,578,279) |
| Бусад банк санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламжийн (өсөлт)/ бууралт | | 1,154,169 | (635,058) |
| Бусад санхүүгийн хөрөнгийн (өсөлт)/ бууралт | | (30,265) | (138,094) |
| Бусад санхүүгийн бус (өсөлт)/ бууралт | | (503,440) | 7,164 |
| Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт/(бууралт) | | (299,566) | (1,006,702) |
| Бусад санхүүгийн бус өр төлбөрийн (өсөлт)/бууралт | | (18,396) | (117,145) |
| Санхүүгийн хэрэглүүрээс хүлээж авсан хүү | | 18,952,657 | 12,945,591 |
| **Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон/үйл ажиллагаанд зарцуулсан мөнгө** | | **3,128,419** | **(2,448,383)** |
| Төлсөн орлогын албан татвар | 13 | (1,040,607) | (584,271) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **2,087,812** | **(3,032,654)** |

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348

Хуудас № 10

BiD BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-20
БҮРТГЭВ-02

Бизнес Инвест Девелопмент ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ны байдлаар

## 2022 ОНЫ 12 САРЫН 31-НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

| *Мянган төгрөгөөр* | Тэм | 2022-12-31 | 2021-12-31 |
|---|---|---|---|
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Худалдан авсан эмч, барилга, тоног төхөөрөмж | 22 | (190,897) | (714,131) |
| Борлуулсан үндсэн хөрөнгө | 22 | 114,972 | 217,083 |
| Худалдан авсан биет бус хөрөнгө | 25 | (30,725) | (99,180) |
| Худалдан авсан койн | 25 | (704,862) | (651,354) |
| Борлуулсан койн | 25 | 1,361,605 | 28,322 |
| БҮЦ ашиг алдагдлаар хэмжигдэх өмчийн үнэт цаасны худалдан авалт | 18 | (612,893) | (831,597) |
| Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаасны худалдан авалт | 17 | (754,367) | (623,986) |
| Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн үнэт цаасыг эргүүлэн авснаас олсон орлого | | 955,436 | 1,000,000 |
| Хүлээн авсан ногдол ашиг | | 14,627 | 701 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **152,896** | **(1,674,142)** |

| | Тэм | 2022-12-31 | 2021-12-31 |
|---|---|---|---|
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | |
| Гаргасан бонд | 32 | 5,120,051 | 1,196,557 |
| Бондын эргэн төлөлт | 32 | (2,015,618) | (1,544,582) |
| Төлсөн ногдол ашиг | 14 | (1,956,140) | (1,823,040) |
| Авсан зээл болон өр төлбөр | 32 | 35,868,605 | 42,870,426 |
| Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт | 32 | (34,422,055) | (36,218,740) |
| Харилцагчаас татсан итгэлцэл | 32 | 14,604,734 | 6,492,271 |
| Харилцагчдад төлсөн итгэлцэл | 32 | (13,125,507) | (2,186,418) |
| Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөрт төлсөн хүү | 32 | (2,219,478) | (206,591) |
| Зээлийн өр төлбөрт төлсөн хүү | 32 | (1,070,318) | (543,468) |
| Бондын өр төлбөрт төлсөн хүү | 32 | (486,056) | (201,890) |
| Түрээсийн өр төлбөрийн төлсөн үндсэн төлбөр | 23 | (118,096) | (79,911) |
| Түрээсийн өр төлбөрийн төлсөн хүүгийн төлбөр | 23 | 48,517 | (44,049) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | | **228,641** | **7,710,565** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ (бууралт)** | | **2,469,349** | **3,003,769** |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **5,919,649** | **2,917,449** |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө | | (5,793) | (1,569) |
| **Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **8,383,205** | **5,919,649** |

BiD БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

ИА АУДИТ Хуудас №: 11

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮНК ХХК

"Бизнес Инвест Девелопмент" ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ны байдлаар

1. Компанийн ерөнхий мэдээлэл

Бизнес Инвест Девелопмент ББСБ ХХК (цаашид "Компани" гэх) нь 2005 оны 05-р сарын 15-ны өдрийн үүсгэн байгуулагчийн №01/01 тоот шийдвэрээр Монгол улсын хууль тогтоомжийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. 2005 оны 08-р сарын 19-ний өдөр Монгол улсын Улсын Бүртгэлийн Албанд бүртгүүлж 5013348 тоот регистр бүхий 9015001006 тоот Улсын Бүртгэлийн Гэрчилгээг авсан.
Компанийн үндсэн үйл ажиллагаа нь Зээлийн үйл ажиллагаа, Итгэлцлийн үйлчилгээ, Санхүүгийн түрээс, Гадаад валют арилжаа, Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга зэрэг болно.

Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2007 оны 09-р сарын 28-ний өдрийн 130 тоот дугаар бүхий тогтоолоор "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрлийн 1/18 тоот гэрчилгээ авсан.

Компани нь дээрх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах үйл ажиллагаануудыг эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг нэмж авсан. Үүнд:

- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 09 сарын 18-ны өдрийн 307 тоот тогтоолоор Зээлийн үйлчилгээ үзүүлэх,
- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 09 сарын 18-ны өдрийн 307 тоот тогтоолоор Санхүүгийн түрээс;
- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 09 сарын 18-ны өдрийн 307 тоот тогтоолоор Итгэлцлийн үйлчилгээ;
- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны 12 сарын 10-ны өдрийн 445 тоот тогтоолоор
- Гадаад валютын арилжаа;
- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 04 сарын 04-ний өдрийн 147 тоот тогтоолоор цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга;
- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 03 сарын 10-ны өдрийн 83 тоот тогтоолоор Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх;
- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 232 тоот тогтоолоор Хаалттай өрийн бичиг бүртгэх;

2021 оны 12-р сарын 31-ний байдлаар хүчин төгөлдөр Компанийн дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон хувьцаат капитал нь дараах байдалтай байна. Үүнд:

| Хувьцаа эзэмшигчийн нэр | Эзэмшлийн хувь | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ (мян.төг) | Нийт (мян.төг) |
|---|---|---|---|---|
| А.Алтансүх | 51% | 2,550,001 | 1,000 | 2,550,001 |
| Х.Одонтуяа | 49% | 2,450,000 | 1,000 | 2,450,000 |
| **Нийт** | **100%** | **5,000,001** | | **5,000,001** |

Компанид толгой компани болон дээд хяналт байхгүй болно.

2023 .05. 12
Үнэт цаасны танилцуулга
2023 -03- 28
БҮРТГЭВ-02



## 2. Компанийн үйл ажиллагааны орчин

Монгол улс хөгжиж буй зах зээлийн олон шинж чанарыг агуулдаг бөгөөд тэр дундаа харьцангуй өндөр инфляци, зээлийн хүүгийн түвшинтэй. 2017-2020 онуудад эдийн засаг жилд 6 орчим хувиар өссөний дараа, КОВИД-19 цар тахлын улмаас Монголын эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлж 2021 онд эдийн засаг 4.6%-иар өссөн.

Мүүдис үнэлгээний агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B3-"аас "B3" болгон өөрчилсөн ба Монгол улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ Стандарт энд Пүүр'с кредит рейтинг тогтоох байгууллагын 2018 оны 11 сарын 9-ний өдрийн үнэлгээгээр тогтвортой төлөвтэй "B" түвшинд байна. Фитч'с үнэлгээний агентлаг 2021 оны 5 сарын эцсийн үнэлгээгээр тогтвортой төлөвтэй "B" түвшинд байна гэж тус тус үзсэн байна.

2020 оны 3-р сард ДЭМБ-аас COVID-19-ийн дэгдэлтийг дэлхийн цар тахал гэж зарласан. Цар тахлын хариуд Монголын эрх баригчид COVID-19-ийн тархалт, нөлөөллийг бууруулах зорилгоор зорчихыг хориглох, хязгаарлах, хорио цээрийн дэглэм тогтоох, хамгаалах байрны захиалга, бизнесийн үйл ажиллагааг хязгаарлах, тэр дундаа хаах зэрэг олон арга хэмжээг хэрэгжүүлсэн. Дараа нь дээрх арга хэмжээний заримыг зөөлрүүлсэн боловч эдгээр арга хэмжээ нь Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагааг эрс хязгаарлаж, сөргөөр нөлөөлсөн бөгөөд цаашид ч тодорхойгүй хугацаанд бизнес эрхлэгчид, зах зээлд оролцогчид, Компанийн үйлчлүүлэгчид, түүнчлэн Монголын болон дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлсөөр байх болно гэж үзэж байна.

Удирдлага нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ажилчдаа дэмжих нөхцөлд шаардлагатай арга хэмжээг авч байна.

## 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд

### 3.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд ашигласан нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуйг нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын гол тэмдэглэлд тусгасан. Өөрөөр тусгайлан заагаагүй бусад тохиолдолд уг бодлогуудыг толилуулж буй бүх тайлант үеүдэд тууштай баримталж мөрдөх болно.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн болон тайлагнагч валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт болох Төгрөг юм.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь төгрөгөөр илэрхийлэгдэж, мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) болон тайлбарууд (хамтад нь СТОУС гэх)-ын дагуу бэлтгэсэн.

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. Санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол болон түүний нөлөөллийн талаар нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэлд нэмж тодруулсан.

Хуудас №: 13

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
... ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5103855 9021031185 СТС2430

"Бизнес Инвест Девелопмент" ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-нн байдлаар

## 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

### 3.2 Хэмжилтийн суурь

Эдгээр санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харна уу) бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн

- Санхүүгийн хэрэглүүр - бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөх
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
- Дахин үнэлэгдсэн өмч, барилга, тоног төхөөрөмж
- Крипто валютаарх хөрөнгө

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт

(а) 2021 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандартууд, тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд

2021 оны 12-р сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланд мөрдөгдөх, Компанид нөлөө үзүүлэх дараах стандартын шинэ шаардлага нь Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо өөрчлөлт оруулахад хүргэсэн:

- 2021 оны 06-р сарын 30-аас хойших КОВИД-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт (СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт)
- Хүүгийн түвшний суурийн шинэчлэл - БХХ 'Үе шат 2' (СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 ба СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт

*КОВИД-19-тэй холбоотой Түрээсийн Хөнгөлөлт (СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт.)*

КОВИД-19 цар тахлын шууд нөлөөгөөр бий болсон бөгөөд дараах шалгуурыудыг хангасан түрээсийн хөнгөлөлтөд зориулж түрээслэгчийн нягтлан бодох бүртгэлд практик чөлөөлөлт олгох нэмэлт өөрчлөлтийг 2020 оны 06-р сарын 01-ээс хүчин төгөлдөр үйлчлэхээр СТОУС 16-д оруулсан:

- Түрээсийн шинэчилсэн төлбөрт тусгагдсан түрээсийн төлбөрийн өөрчлөлт нь өөрчлөлт орохын өмнөх түрээсийн төлбөртэй бараг ижил эсвэл түүнээс бага дүнтэй байх;
- Үр бууралт нь 2021 оны 06-р сарын 30 болон түүнээс өмнө төлөх байсан түрээсийн төлбөрт нөлөөлсөн байх;
- Түрээсийн бусад болзол ба нөхцөлд бодитой өөрчлөлт ороогүй байх.

Эдгээр шаардлагыг хангасан түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлтийн тодорхойлолтыг хангаж байгаа эсэхийг түрээслэгч үнэлэхгүйгээр практик чөлөөлөлтийн дагуу бүртгэж болно. Түрээслэгч энэхүү хөнгөлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ СТОУС 16-ын бусад шаардлагыг мөрдөнө. 2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланд Компани дээрх шалгуурыг хангасан бүх түрээсийн хөнгөлөлтөд практик чөлөөлөлтийг ашигласан.

Түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлтөөр бүртгэх нь Компанийг шинэчилсэн хөнгөлөлтийн хувийг ашиглан шинэчилсэн төлбөрийг тусгахдаа түрээсийн өр төлбөр дэх өөрчлөлтийн нөлөөг хөрөнгө ашиглах эрхээр бүртгэж түрээсийн өр төлбөрийг дахин хэмжихэд хүргэж болох юм.



BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ ... ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

BID BUSINESS INVEST DEVELOPMENT

СЗХ
Он 2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-03-28
БҮРТГЭВ-02



## 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн [illegible]

Практик чөлөөлөлтийг хэрэглэснээр Компаниас шинэчилсэн хөнгөлөлтийн хувь тодорхойлохыг шаардахгүй бөгөөд түрээсийн өр төлбөр дэх өөрчлөлтийн нөлөөг түрээсийн хөнгөлөлт үүсэхэд нөлөөлсөн үйл явдал эсвэл нөхцөл байдал гарсан тухайн тайлант үеийн ашиг, алдагдлаар тусгана.

2021 оны 03-р сарын 31-ний өдөр НББОУСЗ-өөс 2022 оны 06-р сарын 30 буюу түүнээс өмнө төлөгдөх байсан түрээсийн төлбөрийн бууралтад дээрх практик чөлөөлөлтийн хугацааг сунгасан СТОУС 16: 2021 оны 06-р сарын 30-аас хойших Ковидтой холбоотой түрээсийн хөнгөлөлтийн дахин нэг нэмэлт өөрчлөлтийг гаргасан. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2021 оны 04-р сарын 01-ээс эхлэх буюу түүнээс хойших жилүүдэд хүчин төгөлдөр мөрдөнө. Ковид 19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг мөрдөхөөр сонгосон аж ахуйн нэгжүүд энэхүү нэмэлт өөрчлөлтийг заавал мөрдөнө. Энэ шаардлагын дагуу Компани 2021 оны 06-р сарын 30-аас хойших Ковидтой холбоотой түрээсийн хөнгөлөлтийг хэрэглэсэн.

<u>Хүүгийн түвшний суурийн шинэчлэл - БХХ 'Үе шат 2' (СТОУС 9, НББОУС 39, СТОУС 7, СТОУС 4 ба СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт).</u>

Хэд хэдэн СТОУС-д орсон эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь 2021 оны 01-р сарын 01 болон түүнээс хойших санхүүгийн үеүдэд хүчин төгөлдөр мөрдөгдсөн. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь хүүгийн шинэчлэлээр гэрээний нөхцөл өөрчлөгдсөн зээлийн хувьд компанид хөнгөлөлт үзүүлдэг.

(б) Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Компани хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхээр шийдээгүй буюу ирээдүйн нягтлан бодох бүртгэлийн үеүдэд хэрэглэх НББОУСЗ-өөс батлан гаргасан хэд хэдэн стандартууд болон тайлбарууд байна.

2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх гол нөлөө бүхий стандартууд:

- Алдагдалтай гэрээ — Гэрээг биелүүлэх өртөг (НББОУС 37-д орсон нэмэлт өөрчлөлт);
- Үндсэн хөрөнгө: Зориулалтаас өмнөх орлого (НББОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт);
- СТОУС 2018-2020 дахь жилийн сайжруулалт (СТОУС 1, СТОУС 9, СТОУС 16 болон НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлтүүд); ба
- Үзэл баримтлалын хүрээний лавлагаа (СТОУС 3-д орсон нэмэлт өөрчлөлт).

2023 оны 01-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх гол нөлөө бүхий стандартууд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга (НББОУС 1 болон СТОУС-ын Практикийн тайлан 2-т орсон нэмэлт өөрчлөлт);
- Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт (НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлт);
- Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал (НББОУС 1-д орсон нэмэлт өөрчлөлт); ба
- Нэг удаагийн ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрт хамаарах хойшлогдсон татвар (НББОУС 12-т орсон нэмэлт өөрчлөлт)

Хуудас №: 15

BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ
ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

## 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт (үргэлжлэл)

Компани Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан болов ч хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа дараах стандартууд нь компанид материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Үүнд:

- СТОУС 17 Даатгалын гэрээ (2023 оны 01-р сарын 01-нээс мөрдөнө) - 2020 оны 06-р сард Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс СТОУС 17-г 2023 оны 01-р сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөх нэмэлт өөрчлөлтийг баталсан.

### 3.4 Бодит үнэ цэнийн хэмжилт

Компани нь хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тухайн зах зээл дээрх хамгийн сайн ажиглагдахуйц мэдээллийг ашиглахыг зорьдог. Бодит үнэ цэнийг үнэлгээний арга барилд ашиглагдах өгөгдлүүдэд үндэслэн бодит үнэ цэний шатлалаар дараах түвшинд ангилдаг:

- Түвшин 1: Хөрөнгө, өр төлбөрийн хувьд хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхтэй зах зээл дээрх үнэ.
- Түвшин 2: Түвшин 1 дэх бүртгэсэн бодит үнэ цэнд томоохон нөлөө үзүүлэх бүх өгөгдлүүдийг нь шууд (жишээлбэл: үнэ) болон шууд бусаар (жишээлбэл: үнээс хамааралтай) ажиглах боломжтой бусад техникүүд;
- Түвшин 3: бүртгэсэн бодит үнэ цэнд томоохон нөлөө үзүүлэх, ажиглаж үл болохуйц зах зээлийн өгөгдөл дээр суурилсан өгөгдлүүдийг ашигладаг техникүүд.

Хэрэв бодит үнэ цэний шатлалын түвшин хооронд шилжсэн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд олон төрлийн өгөгдөл ашигласан бол Компани хөрөнгө, өр төлбөрийг бүх хэмжсэн үнэ цэнд нөлөөлөхүйц бодит үнэ цэний шатлалын дундах өгөгдлийн хамгийн бага түвшинд ангилах ба түвшин хоорондын шилжилтийг тухайн шилжилт хийгдсэн тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрнө.

### 3.5 Таамаглал, тооцоолол ба үнэлгээ хэрэглэх нь

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой таамаглал болон төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Ирээдүйд бодит үр дүн нь тооцоолол ба таамаглалаас ялгаатай байж болно. Дараагийн санхүүгийн жилүүдэд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг нөлөө үзүүлж болохуйц нөлөө бүхий эрсдэлтэй тооцоолол ба төсөөллийг доор дурдлаа.

***Тооцоолол ба таамаглал***

- **Зээлийн авлагын хүлээгдэж буй алдагдлын хэмжилт** - Зээлийн ХБЗА-ын тооцоолол нь загвар, аргачлал, түүхэн өгөгдлийн орц зэргийг агуулсан чухал тооцоолол юм. (Тооцооллын аргачлалын дэлгэрэнгүй Тэмдэглэл 19-ийг үзнэ үү). Дараах хүчин зүйлүүд нь зээлийн хүлээгдэж буй алдагдлын нөөцөд өөрчлөлт оруулахад гол нөлөө үзүүлдэг.
    - ХБЗА-г тооцоолох санхүүгийн хөрөнгийн шатлал тус бүрээрх ангилал
    - Зээлийн авлагын эрсдэл нэмэгдсэн эсэхийг үнэлэх шалгуур
    - Компанийн тодорхойлсон дефолтын тодорхойлолт
    - Компанийн эрсдэлийн зэрэглэлийг хуваарилах шалгуур /Exposure at default/ - PD
    - Зээлийн эрган төлөлт хийгдээгүйгээс хүлээх алдагдал /Loss given default/ - LGD
    - Дефолт болох үеийн үлдэгдлийг үнэлэх арга аргачлал /Exposure a default/ - EAD
    - Эдийн засаг ба/эсвэл зах зээлийн ерөнхий нөхцөл байдал болон ирээдүйн таамаглал
    - Барьцаа хөрөнгийн зээлийн алдагдлыг нөхөх үнэлгээ

2023.05.12

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-03-28
БҮРТГЭВ-02

Бизнес Инвест Девелопмент ББСБ ХХК
**2022** оны **12** сарын **31**-ний байдлаар

**3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогууд (үргэлжлэл)**

3.5 [illegible]

- **Барилга байгууламж болон хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн дахин үнэлгээ.** Компани нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дараа үеийн хэмжилтийг бодит үнэ цэнийн загвараар хэмждэг. Үнэлгээг ижил төстэй хөрөнгийн үнэлгээг хийж байсан туршлагатай хараат бус мэргэшсэн үнэлгээчнийг ашиглан үнэлгээ хийлгэсэн (Бодит үнэ цэнийн тооцооллыг гаргахад ашигласан таамаглал, үнэлгээний аргыг Тэмдэглэл 24-ийг үзнэ үү)

- **Түрээсийн хөрөнгийн хугацаа тодорхойлох** - Компани нь өөрийн салбар оффисуудад түрээсийн хөрөнгө ашигладаг. Түрээсийн хөрөнгийн гэрээг компани нь жил бүр хянадаг ба талууд түрээсийн хугацаа дууссанаас хойш 30 хоногт гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол автоматаар 1 жилээр сунгалт хийдэг. Компанийн удирдлага нь 2023 оныг дуустал өөрийн салбар оффисуудыг түрээсийн хөрөнгөд бүртгэхээр төлөвлөж байгаа. (Түрээсийн хөрөнгийн хугацаа болон хүүгийн түвшний талаарх шийдлийг Тэмдэглэл 23-аас үзнэ үү)

- **Компани түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд ашиглах нэмэгдэл хүүгийн түвшин** - Компани нь түрээсийн өр төлбөрийн тооцоололд ашиглах хүүгийн түвшинг жил бүр хянаж үздэг. Ингэхдээ ББСБ-ийн эх үүсвэрийн зээлийн хүүгийн түвшин болон арилжааны банкуудын дундаж зээлийн хүүгийн түвшинг харьцуулдаг.

- **Өрийн болон өмчийн үнэт цаас дахь хөрөнгө оруулалт** - Компани нь тайлант жилд өөрийн сул чөлөөтэй хөрөнгийг нээлттэй болон хаалттай зах зээлээр арилжаалагдаж буй өрийн болон өмчийн үнэт цааснуудад хөрөнгө оруулалт хийсэн. Удирдлага нь оруулсан хөрөнгө оруулалтын бизнес загвар болон мөнгөн урсгалын цуглуулалтын талаарх шийдвэрийг тайлант үе бүрийн эцэст хянадаг. ( Тэмдэглэл 17 болон 18-г үзнэ үү)

- **Санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ** - Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн 1 жилээс дээш хугацаатай санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнийг идэвхтэй зах зээл дээрх ижил төстэй хөрөнгийн хүүгийн түвшинг ашиглан үнэ цэнийг тодорхойлсон. Удирдлага нь 12 сараас бага хугацаатай болон хөвөгч хүүтэй санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг дансны үнэтэйгээ ойролцоо гэж авч үздэг. ( Тэмдэглэл 32-г үзнэ үү)

- **Биет бус хөрөнгийн бүртгэл** - Крипто валют нь биет бус хөрөнгийн тодорхойлолтод нийцэж байгаа тул анх худалдан авсан өртгөөр (төлсөн эсвэл өгсөн үнэ) бүртгэнэ. Биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг шалгадаг. Хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараа үеүдэд нь буцаах боломжгүй. Зөвхөн идэвхтэй зах зээл дээр үндэслэн бодит үнэ цэнийг тодорхойлох боломжтой тохиолдолд л крипто валютыг дараа үеийн хорогдол, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасаж дахин үнэлсэн үнээр (бодит үнэ цэнээр) бүртгэнэ. Компани худалдаж авсан крипто валютын үнэ цэнийг идэвхтэй зах зээлээс тодорхойлдог.

БИД БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

Хуудас №: 17

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5103855 9021031155 СТС2420

## 4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд (үргэлжлэл)

### 4.1 Хүү болон түүнтэй адилтгах орлого

Хүү болон түүнтэй адилтгах орлогыг ашиг, алдагдлаар бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд бүх санхүүгийн хэрэглүүр бүрийн хувьд үр ашигт хүүгийн түвшин ашиглан ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд аккруэл сууриар бүртгэж тайлагнадаг. Үр ашигт хүүгийн түвшин гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны турш хүлээн авах мөнгөн орлогын төлбөрийг санхүүгийн хөрөнгийн дансны цэвэр дүн хүртэл хөнгөлөх түвшин юм.

Үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авахад шууд холбоотойгоор нэмэгдэн гардаг, жишээлбэл төлбөрийн чадварыг үнэлэх, зээлийн баталгаа эсвэл барьцааг үнэлэх болон бүртгэх, гэрээний нөхцөлүүдийг хэлэлцэх болон холбогдох баримт бичиг боловсруулах зэрэг гэрээ байгуулахтай холбоотой эливаа хураамжууд орно.

Компани нь төв болон бусад 16 салбаруудаар дамжуулан хүүгийн болон түүнтэй адилтгах орлого олж байна. Харилцагчтай байгуулж буй зээлийн гэрээний дундаж хугацаа 24 сар бөгөөд зээлийн гэрээнд заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу системтэй төлөлт хийгддэг.

Харилцагчийн зээлийн хүүгийн түвшинг тодорхойлохдоо тухайлсан гэрээний нөхцөл болон өөрийн бизнесийн тогтсон практикийг харгалзан үздэг. Харилцагчтай байгуулсан гэрээнээс олох хүү болон түүнтэй адилтгах орлогын дүн нь зээлдэгчийн эргэн төлөлтөөс хамаарах үндсэн болон нэмэгдүүлсэн хүү байна.

Компани нь үнэ цэнийн бууралтад орсон хөрөнгөөс бусад хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцдог. Энэ нь "Шатлал 1" болон "Шатлал 2"-д хамаарах санхүүгийн хөрөнгийн дансны үнээс гэрээнд заасан хүүгийн хувиар хүүгийн орлогыг аккруэл сууриар бүртгэл орлогын тайланд тусгадаг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурч "Шатлал 3"-д орсон тохиолдолд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр нь тооцож, хүлээгдэж буй зээлийн алдагдлын санг хассан дүнгээр буюу цэвэр дүнгээс хүүгийн орлогын тооцоолол хийдэг.

Шатлал 3-д ангилагдсан санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтгүй болж эрсдэл нь сайжирсан тохиолдолд хүүгийн орлогыг дансны үнээс үр ашигт хүүгийн аргаар тооцно. Өмнө нь санхүүгийн хөрөнгө Шатлал 3-д байсны улмаас ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан нэмэлт хүүгийн орлого нь ангилал сайжирснаар үнэ цэнэ бууралтын буцаалт гэж хүлээн зөвшөөрөгдөнө.

### 4.2 Үйлчилгээ хураамж шимтгэлийн орлого

Энэхүү дүн нь зээл олгох жил гүйлгээ гарсны дараагаар зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдон гарч буй хураамжийн орлогын дүнг илэрхийлнэ. Энэхүү хураамжийн орлогыг компани болон харилцагч нар өгөөжийг нэгэн зэрэг хүлээн авч байгаа тул үйлчилгээг үзүүлсэн үед нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

### 4.3 Гадаад валютын ажил гүйлгээ

Компанийн үйл ажиллагаа эрхэлдэг үндсэн эдийн засгийн орчны валютаас ("бүртгэлийн валют") бусад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлсэн. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг бүртгэлийн тайлангийн өдрийн албан ханшаар хөрвүүлсэн. Мөнгөөрх төлөгдөөгүй хөрөнгө, өр төлбөрийг дахин хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүг ашиг, алдагдалд шууд тусгасан.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02



### 4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### 4.3 Гадаад валютын ханш [illegible]

Борлуулахад бэлэн мөнгөөрх санхүүгийн хөрөнгийг дахин хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн тусдаа бүрэлдэхүүн хэсэг гэж үзсэн бөгөөд ашиг, алдагдалд тусгасан. Харин борлуулахад бэлэн мөнгөн бус санхүүгийн хөрөнгийн ханшийн зөрүүний олз, гарзыг тухайн санхүүгийн хэрэглүүртэй хамаатай гэж үзэж нийт олз, гарзтай нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

Тайлант жилийн явцад хэрэглэж байсан ханш дараах байдалтай байна:

| Валют | 2022-12-31 (төгрөгөөр) | 2021-12-31 (төгрөгөөр) | Зөрүү /+-/ |
|---|---|---|---|
| Ам доллар | 3,444.60 | 2,848.80 | +595.8 |

#### 4.4 Санхүүгийн хөрөнгө

Хөрөнгө худалдан авсан зорилгоос хамаарч компани санхүүгийн хөрөнгийг доор дурдсан төрлүүдийн нэгээр нь ангилдаг.

*4.4.1 Санхүүгийн хөрөнгө - Бизнес загвар*

Компани нь мөнгөн урсгалыг бий болгохын тулд хөрөнгийг хэрхэн удирддаг болохыг бизнесийн загвар харуулдаг. Компанийн нь бизнес загварын дараах зорилгуудаас сонголт хийж ашигладаг.

- Зөвхөн хөрөнгийн гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах
- Хөрөнгийг борлуулснаас үүсэх мөнгөн гүйлгээ эсвэл гэрээнд заасан мөнгөн гүйлгээг цуглуулах
- Эсвэл дээрх 2 ангиллын аль нэгд ч багтахгүй бусад загвар

*4.4.2 Санхүүгийн хөрөнгө - Мөнгө урсгалын онцлог*

Бизнес загвар нь хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших авах эсвэл хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг авах зорилготой үед мөнгөн урсгал нь зөвхөн хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй эсэхэд үнэлгээ өгнө. Энэ үнэлгээг хийхдээ гэрээний мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоонд нийцтэй эсэх, ялангуяа хүү нь зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг авч үздэг.

Хөйжийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийг компани дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

*4.4.2.1 Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх*

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөд мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүр болон цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (өр төлбөрөөр ангилагдсан мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүрийн тухай "Санхүүгийн өр төлбөр" хэсгээс харна уу).

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК

"Бизнес Инвест Девелопмент ББСБ" ХХК
2022 оны 12 сарын 31-ны байдлаар

## 4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

*4.4 Санхүүгийн хэрэгсэл (үргэлжлэл)*

*4.4.2 Санхүүгийн хөрөнгө – Мөнгөн урсгалын шинжүүр (үргэлжлэл)*

*4.4.2.1 Бодит үнэ цэнээр ашиг алдагдлаар хэмжигдэх (үргэлжлэл)*

Энэхүү ангилалд багтсан санхүүгийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн орлого эсвэл зардлын мөрөнд тусгана. Хөйжийн хэрэглүүрийн зориулалттүй үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусдаар компанид арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө байхгүй бөгөөд компани санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг сайн дураараа ашиг, алдагдлаар хэмжигдэх ангилалд оруулдаггүй байна.

*4.4.2.2 Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх*

Эдгээр хөрөнгө нь харилцагчид хүргэх бараа болон үйлчилгээний нөөцөөс (харилцагчдад олгосон зээл гэх мэт) ихэвчлэн үүсдэг. Гэхдээ мөн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд гэрээний мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрддэг бусад төрлийн санхүүгийн хөрөнгөөс үүсдэг. Эдгээрийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнэ дээр тэдгээрийг олж авах эсвэл гаргахтай холбоотой шууд хамааралтай гарсан ажил гүйлгээний зардлыг нэмж бүртгэх ба дараа үед үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон үнэ цэнийн бууралтыг хассан хорогдуулсан өртгөөр бүртгэнэ.

Санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн дүнгийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүд анх хүлээн зөвшөөрөх үед хойшлогдсон гүйлгээний зардлын хорогдуулалт, хийж үр ашигт хүүгийн түвшингээр тооцно.

Хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардал, мөн хуримтлагдсан купон болон үнийн дискаунтчилсан нэмэгдэл буюу хөнгөлөлтийг (мөн аливаа хойшлогдсон шимтгэлийн хамт) тусад нь толилуулаагүй ба тэдгээрийг санхүүгийн байдлын тайлан дахь тэнцэлд хамаарах хэсэгт дансны үнээр тусгасан болно.

Компани богино болон урт хугацаат санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг СТОУС 9-д заасан хялбаршуулсан аргад үндэслэн нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тодорхойлох замаар хасагдуулгын матрицыг байгуулдаг. Хүлээгдэж буй алдагдлын хэмжилт нь

(i) олон янзын боломжит үр дүнг үнэлсний үр дүнд тодорхойлсон зохистой, магадлалаар жинлэсэн дүн

(ii) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; болон

(iii) өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээллүүд дээр үндэслэнэ.

Ингэхдээ худалдааны авлагын төлөгдөхгүй байх магадлалыг үнэлдэг. Худалдааны авлагын нийт хугацааны туршид авлага төлөгдөхгүй байхаас үүсэх хүлээгдэж буй алдагдлыг тодорхойлж үт хүлээгдэж буй алдагдлыг энэхүү магадлалаар үржүүлж тооцно. Худалдааны авлагын хувьд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн гарзын тусдаа бүртгэгдсэн хасагдуулгын данстай цэвэр дүнгээр тайлагнана. Худалдааны авлагыг цуглуулж чадахгүй гэдгийг баталгаажуулснаар хөрөнгийн нийт дансны үнийг холбогдох нөөцтэй нь цэвэрлэж данснаас хасна.

Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэглүүрийг санхүүгийн байдлын тайланд ХБЗА-ын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр тайлагнана. Зээл болон санхүүгийн баталгааны хувьд ХБЗА-ын санг санхүүгийн байдлын тайланд өр төлбөр гэж тусад нь хүлээн зөвшөөрдөг. БДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн хувьд ХЗА-ын хасагдуулгыг хассан хорогдуулсан өртгийн өөрчлөлтийн дүн нь ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд дансны үнийн бусад өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод БДОБҮЦ-ээрх өрийн хэрэглүүрийн гарзыг хассан дүнгээр олз гэж тайлагнагдана.

Хуудас № 20

он 2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02



**4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)**

4.4 Санхүүгийн хэрэгсэл (үргэлжлэл)

4.4.2 Санхүүгийн хөрөнгө – Үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

4.4.2.2 Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх (үргэлжлэл)

Холбоотой талуудаас авах авлага болон холбоотой талуудад олгосон зээлд байгуулсан үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвараар урьдчилан таамагласны үндсэн дээр тооцоолно. Хасагдуулгын дүнг тодорхойлохдоо ашигласан аргачлал нь санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нэлээд бүхий өсөлт гарсан эсэхэд үндэслэнэ. Санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэлд нэлээд бүхий өсөлт гараагүй бол 12 сарын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Зээлийн эрсдэлд нэлээд бүхий өсөлт гарсан бол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг нийт хүүгийн орлоготой нь хамт хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үнэ цэнийн бууралт үүссэн гэж тогтоогдвол нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүүгийн орлоготой нь хамт цэвэр сууриар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Компани нь харилцагчдад олгосон зээлийг СТОУС 9-ийн дагуу ерөнхий арга болон хялбаршуулсан арга ашиглан хүлээгдэж буй алдагдлын дүнг тодорхойлдог. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх эсэх үнэлгээ нь тухайн тайлант үеийн эцсээр санхүүгийн хөрөнгийн зээлийн үнэлэмж буурч байгаа эсвэл, үл биелүүлэлт бодитоор гарч тохиолдсон талаарх нотолгоонд биш, харин анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш гэрээний үл биелүүлэлт гарч тохиолдох магадлал буюу эрсдэлийн мэдэгдэхүйц нэмэгдэлтэд үндэслэн тооцоолол хийдэг. Ингэхдээ нийт санхүүгийн хэрэглүүрийг 3 шатлалд хувааж авч үздэг.

***Шатлал 1*** - Анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн алдагдалд томоохон өсөлт гараагүй буюу эргэн төлөлтийн хугацаа хэтрээгүй зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийг хамааруулдаг. Энэхүү ангилал дах санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед 12 сарын зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаар сан бүртгэхээс гадна шатлал 2-оос эрсдэл нь буурч буй зээлүүд дахин ангилагдана.

***Шатлал 2*** - Анх хүлээн зөвшөөрснөөс зээлийн алдагдалд томоохон өсөлт гарсан буюу 31-90 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийн хамааруулдаг. Энэхүү ангилал дах санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойших үүсэж болох эрсдэл ихэссэн үед нийт хугацааны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаар сан бүртгэхээс гадна шатлал 3-аас эрсдэл буурч буй зээлүүд дахин ангилагдана.

***Шатлал 3*** - Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан буюу 91-ээс дээш хоног хугацаа хэтэрч алдагдал бий болсон зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийн хамааруулдаг. Энэхүү ангилал дах санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойших үүсэж болох эрсдэл ихэссэн үед нийт хугацааны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаар сан байгуулан бүртгэнэ.

Компани нь дээрх гурван шатлалыг үр ашигт хүүгээр хорогдуулсан хүлээгдэж буй мөнгөн урсгалаар зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)-г тооцоолдог. Мөнгөний урсгал нь гэрээний дагуух мөнгөн гүйлгээ болон эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний зөрүү юм. ЗҮЦХА тооцооллын гол нөлөөлөгч хүчин зүйлийг тайлбарлан харуулбал:

*4.4.3 Зээл эргэн төлөгдөхгүй байх магадлал*

Зээл төлөгдөхгүй байх эрсдэл тус бүрд үндэслэн тооцоолсон зээлийн алдагдлын жигнэсэн дунджийг илэрхийлнэ. Зээл эргэн төлөгдөхгүй байх магадлал нь үнэ цэнийн бууралтыг тооцох санхүүгийн хэрэгслийн нийт дансны үнийг илэрхийлж, зээлдэгчийн хувьд анхдагч болон боломжит эрт төлбөрт ойртох тусам өртөх чадварaa нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл өгөгдсөн цаг хугацаанд төлбөрийн чадваргүй болох магадлалаар тооцоолно. Хэрвээ хэрэгсэл нь өмнө нь үл хүлээн зөвшөөрч байгаагүй мөн хэрэглэх бөгөөд үргэлжлүүлэн байгаа бол үнэлсэн хугацааны тодорхой хугацаанд нэг удаа алдагдал үүсэх боломжтой

АУДИТ Хуудас №: 21

BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 ch 0123010637

УЛААНБААТАР ХОТ
... КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9023031105 СТС2420

### 4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### *4.4 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)*

#### *4.4.4 Зээлийн [illegible] алдагдал*

Зээл нь тайлагналын дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлт, гэрээний дагуух үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт, зээлийн үүргийн хүрээнд нэмж олгосон дүн болон төлбөр хоцорсноор үүссэн хуримтлагдсан хүүг хасч тооцсон, ирээдүйн эргэн төлөлт хийгдээгүйгээс хүлээх алдагдлыг тооцоолдог. Энэ нь гэрээний дагуу мөнгөн урсгал болон зээлдэгч хүлээн авахаар тооцоолсон дүн, барьцаа хөрөнгө борлуулсан дүнгийн нийлбэрийн зөрүүгээс тооцно.

#### *4.4.5 Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх*

Компани нь охин компани, хараат компани эсвэл хамтын хяналттай аж ахуйн нэгжид багтаагүй, арилжаалах зорилгоор эзэмшдэггүй, хувьцаат болон хувьцаат бус аж ахуйн нэгж дэх стратегийн зорилго бүхий хөрөнгө оруулалт эзэмшиж байгаа тохиолдолд бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх хөрөнгө оруулалтаар ангилна. Эдгээрийг бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч бүртгэх ба бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцөд хуримтлуулна. Бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцийн үлдэгдлийг данснаас хасах замаар ашиг, алдагдал руу ангилахгүй ба харин шууд хуримтлагдсан ашиг руу ангилна.

Хөрөнгө оруулалтын өртгийн хэсгийг илэрхий нөхөх ногдол ашгаас бусад ногдол ашгийн хувьд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Харин уг тохиолдолд ногдол ашгийг бүхэлд нь эсвэл зарим хэсэг нь холбогдох хөрөнгө оруулалтын дансны үнээс хасаж бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн худалдан авалт болон борлуулалтыг бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх бодит үнэ цэнээр нь тохиролцоо хийсэн өдрөөр хэмжих ба арилжааны өдөр болон тохиролцоо хийсэн өдөр хоорондын бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг бодит үнэ цэнэ нь бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжигдэх нөөцөд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

#### 4.5 Санхүүгийн өр төлбөр

Өр төлбөрийг олж авсан зорилгоос хамаарч компани санхүүгийн өр төлбөрийг доор дурдсан хоёр төрлийн аль нэгээр нь ангилдаг. Хөйжийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн өр төлбөрөөс бусад санхүүгийн өр төлбөрийг компани дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу ангилна:

*Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх*

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болоогүй мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр багтана (цаг хугацааны үнэ цэнийн нөлөөгөөр цэвэрлэгдэж сөрөг болсон мөнгөөр төлөх үүсмэл хэрэглүүр болон мөнгөөр төлөгдөх үүсмэл хэрэглүүрийн тухай "Санхүүгийн хөрөнгө" хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Компани ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах (хейж) зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж, гаргадаг.
Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусдаар компанид арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана:

- Банкны зээл болон компанийн буцаан дуудах давуу эрхтэй хувьцааг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашиг хүүгийн түвшин ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмждэг.

"Бизнес Инвест Девелопмент" ББСБ ХХК
2022 оны 12 сарын 31-ны байдлаар

## 4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

### 4.5 Санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)

Ингэснээр санхүүгийн байдлын тайлангаарх өр төлбөрийн үлдэгдэлд хүүгийн зардлыг эргэн төлөлтийн хугацааны туршид тогтмол хувиар тооцоолох боломжийг олгодог. Санхүүгийн өр төлбөр бүрийн зорилгын хувьд хүүгийн зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү эсвэл купоны өглөг багтаадаг.

- Хөрвөх зээлийн өрийн хэсгийг доор тайлбарласны дагуу хэмжинэ.
- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн худалдааны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

### 4.6 Хувьцаат капитал

Компанийн гаргасан санхүүгийн хэрэгслүүд санхүүгийн өр төлбөр, хөрөнгийн шалгуурыг хангахгүй байх тохиолдолд л тэдгээрийг өмчөөр ангилна.

Компани энгийн хувьцаагаа өмчийн хэрэглүүр гэж ангилсан.

### 4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн чухал хэсгүүд тодорхой хугацаанд солигдох шаардлагатай болсон үед компани тэдгээр хэсгүүдийг өөрийн гэсэн ашиглалтын хугацаа болон элэгдэлтэй тусдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Үүнтэй адил, үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан бол үндсэн хяналт хийх үед түүний өртгийг үндсэн хөрөнгийн бүртгэлийн дунд оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгө нь хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг. Бусад үндсэн хөрөнгийг дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулна:

| Үндсэн хөрөнгө | Ашиглалтын хугацаа |
|---|---|
| Барилга | 25 жил |
| Тоног төхөөрөмж | 10 жил |
| Компьютер дагалдах хэрэгсэл | 2 жил |
| Тээврийн хэрэгсэл | 10 жил |
| Тавилга, эд хогшил | 10 жил |

Үндсэн хөрөнгө зарагдсаны дараа эсвэл цаашид ашиглах, захиран зарцуулах нь эдийн засгийн үр өгөөжгүй байх үед данснаас хасна. Данснаас хассаны цэвэр орлого ба дансны цэвэр үнийн зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Баригдаж буй хөрөнгийг үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь бүртгэж, элэгдэл тооцохгүй. Баригдаж буй хөрөнгийг ашиглалтад оруулахад бэлэн болсны дараа зохих ангилалд шилжүүлдэг.

### 4.8 Худалдан авсан биет бус хөрөнгө

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд түүний өртгөөс хуримтлагдсан хорогдуулга ба үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэж эдийн засгийн ашиглалтын хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулна. Биет бус хөрөнгийг худалдан авсан аж ахуйн нэгжээс нь салгаж болохуйц эсвэл бусад гэрээгээр хүлээлт үүсгэж байгаа тохиолдолд бизнесийн нэгдлийн үед хүлээн зөвшөөрнө. Ийм төрлийн биет бус хөрөнгийн үнийн дүнг тохирох үнэлгээний арга техникийг ашиглан тооцоолно.

JPA Аудит Хуудас № 23

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023.05.12 өдөр ХҮЛЭЭН АВАВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02



## 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын товчоо (үргэлжлэл)

### 4.8 Хугацаатай [illegible]

Компанийн хүлээн зөвшөөрсөн нэгжийн бүхий биет бус хөрөнгө, тэдгээрийн эдийн засгийн ашиглалтын хугацааг доор харуулав:

| Биет бус хөрөнгө | Ашиглалтын хугацаа |
|---|---|
| Программ хангамжууд | 2 жил |
| Домайн нэр | 10 жил |
| Крипто валют | Ашиг алдагдлаарх БҮЦ |

### 4.9 Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо гэрээний агуулга дээр үндэслэх ба гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх ба гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай.

#### *4.9.1 Компани түрээслэгч үед*

Компани богино хугацаат түрээс болон бага үнэ цэнэ бүхий хөрөнгийн түрээсээс бусад бүх түрээсийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийн нэг аргыг хэрэглэнэ. Компани түрээсийн төлбөрийг төлөөлж "түрээсийн өр төлбөр"-ийг хүлээн зөвшөөрч, тодорхойлсон хөрөнгийг түрээслэн ашиглах эрхийг төлөөлж "ашиглах эрхтэй хөрөнгө"-ийг хүлээн зөвшөөрнө.

#### *4.9.2 Ашиглах эрхтэй хөрөнгө*

Компани ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн эхлэх өдөр (хөрөнгийг ашиглаж эхлэх боломжтой болсон өдөр) эхлэн хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхтэй хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, аливаа үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасаж өртгөөр нь хэмжих бөгөөд түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөг нь хүлээн зөвшөөрөгдсөн түрээсийн өр төлбөр, анхны шууд өртөг, түрээсийн урамшууллыг хүлээн авахаас өмнө буюу өмнөх өдрөөс эхлэн хийсэн түрээсийн төлбөрүүд багтана. Ашиглах эрхтэй хөрөнгө нь оффисын түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдэх юм.

#### *4.9.3 Түрээсийн өр төлбөр*

Компани түрээсийн хугацааны туршид төлөх төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өр төлбөрийг түрээс эхлэх өдөр хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөр гадагт аливаа урамшуулал хөнгөлөлтийг хассан түрээсийн тогтмол төлбөрөөс гадна хувь хэмжээнээс хамаарах хувьсах шинжтэй төлбөр, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөхөөр хүлээгдэж буй төлбөрүүдийг хамруулан авч үзнэ. Хувьсах шинжтэй түрээсийн төлбөр нь ямар нэг индекс, хувь хэмжээнээс хамааралгүй (бараа материал үйлдвэрлэхэд зориулж гаргаагүй бол) бол түүнийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

### 4.10 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэдэг нь удирдлагын зорилгоор эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор ашигладаг, бизнесийн хэвийн үйл явцад зарагдах бус, түрээсийн орлого ба капиталын өсөлт хүртэх зорилготой эсвэл тус 2 зорилгыг хоёуланг нь хэрэгжүүлэхээр эзэмшиж буй эмч хөрөнгө юм. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анх бодит өртгөөр нь бүртгэж дараагийн үеүдэд нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тухайн тайлант хугацааны зах зээлийн нөхцөл байдалд үндэслэн бодит үнэ цэнээр хэмждэг.

JPA АУДИТ Хуудас №: 24

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ ... АУДИТ ХХК

## 4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

### 4.10 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (үргэлжлэл)

Тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг үг үл хөдлөх хөрөнгийг борлуулснаас олсон үнэ гэж үзнэ. Үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотой олз гарзыг тухайн олз гарз нь бүртгэгдсэн жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгийг данснаас хасах эсвэл ашиглалтаас бүр мөсөн хасах үед болон хөрөнгийн ашиглалтаас ирээдүйд өгөөж өгөхгүй бол үл хүлээн зөвшөөрнө.

### 4.11 Биет бус хөрөнгө

Крипто валютыг биет бус хөрөнгө гэж ангилдаг бөгөөд олж авсан хөрөнгийг өртгөөр нь хүлээн зөвшөөрч, дараа үед нь бодит үнэ цэнээр нь үнэлдэг. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэж, дахин үнэлгээний нөөцийн үлдэгдлээс давсан үнэ цэнийн бууралт эсвэл ийм хэлцлийг буцаах нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөгдөхөөс бусад тохиолдолд дахин үнэлгээний нөөцөд хуримтлагдана.

### 4.12 Нэгдэл ашиг

Нэгдэл ашиг нь хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан хөрөнгө оруулалтын өгөөжийн татан авалт юм. Нэгдэл ашиг олгох эсэх болон нэгж хувьцаанд хадэн төгрөгийн нэгдэл ашиг олгохыг компанийн хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр тогтоох бөгөөд түүний зарласан тайлант хугацаанд нь өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

### 4.13 Татвар

#### *4.13.1 Тайлант хугацааны орлогын албан татвар*

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Удирдлага НББ-ийг хэрхэн хөтлөхийг холбогдох татварын хууль, журмуудад тодорхой заагаагүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай тийм шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахын тулд тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

#### *4.13.2 Хойшлогдсон орлогын албан татвар*

Хойшлогдсон орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хөрөнгийн дүнг бууруулна.

Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

## 4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын тойм (үргэлжлэл)

### 4.13 Татвар (үргэлжлэл)

#### 4.13.2 Хойшлогдсон орлогын албан татвар (үргэлжлэл)

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

#### 4.13.3 Нэмэгдсэн өртгийн албан татвар

Орлого, зардал болон хөрөнгүүд нь доорхоос бусад тохиолдолд Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ) –гүй цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгддөг:

- Хөрөнгө эсвэл үйлчилгээг худалдан авахад төлсөн НӨАТ–ыг татварын байгууллагаас буцаан авах боломжгүй үед уг НӨАТ–ыг хөрөнгө худалдан авалтын өртгийн нэг хэсгээр эсвэл зардлын нэг хэсгээр (аль тохиромжтойгоор) хүлээн зөвшөөрнө.
- НӨАТ–ын дүн орсон дүнгээр илэрхийлэгдэх авлага ба өглөг. Татварын байгууллагаас авах эсвэл татварын байгууллагад өгөх өглөгийн цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд авлага эсвэл өглөгийн нэг хэсэг болгон толилуулна.

### 4.14 Бараа материал

Хуулийн фирм нь Гэрээгээр хүлээсэн ажлын даалгаварт тусгагдсанаас бусдаар Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт, БИД Финанс ББСБ ХХК-ийн эрх, үүрэг, хариуцлагыг БИД ББСБ ХХК д шилжүүлж нэгтгэх замаар өөрчлөн байгуулсантай холбоотой эмнэх асуудлаар тусгайлан дүн шинжилгээ хийгээгүй болохыг анхаарна уу

Хуулийн дүгнэлтийг зөвхөн энд дурдагдсан зорилгоор хийж гүйцэтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагч нь өөр бусад зорилгоор ашиглах, хэсэгчлэн болон бүхлээр нь нийтэд дэлгэх, түгээх болон Хуулийн фирмийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

Хуулийн дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд Хуулийн дүгнэлт гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон бол Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ
5183855
9021031105 СТС2420

BUSINESS INVEST DEVELOPMENT

Нууц баримт
Эх хувь

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

Хуулийн фирм нь илэрхий үг үсэг, утга найруулгын зөрүүнээс бусдаар Үнэт цаас гаргагчийн шилжүүлж өгсөн баримт бичгийн материалд агуулагдаж байгаа дараах асуудлыг үнэн зөв гэж үзэж дүгнэлт гаргасан болно. Үүнд:

- *Баримт бичигт агуулагдсан хүсэл зориг, гол санаа, дурдсан/дурдагдсан асуудал нь үндэслэлтэй, үнэн зөв, хууль ёсны дагуу илэрхийлэгдсэн, хүчин төгөлдөр;*
- *Баримт бичгүүд нь цаг хугацаандаа үйлдэгдсэн, үнэн, зөв, бүрэн, зарим үсэг зурсан этгээд нь хуулийн дагуу албан ёсоор төлөөлөх эрхтэй;*
- *Хуулийн дүгнэлт гаргах үндэслэл болсон баримт материалд дурдагдсан нөхцөл байдал нь Хуулийн дүгнэлт гаргаснаас хойш эсхүл тухайн баримт бичгийг үйлдсэн огноо, хугацаанаас хойш өөрчлөгдөөгүй бөгөөд аливаа байдлаар талуудын эрх ашгийг зөрчсөн нөлөөлөх үйл ажиллагаа;*
- *Аливаа даргадсан тэмдэг (тамга) нь үнэн, зөв, жинхэнэ, эрх бүхий ашиглах эрхтэй этгээдийн зөвшөөрлөөр дарагдсан.*

**Энэхүү Хуулийн дүгнэлт нь Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй өрийн бичигт гаргасан аливаа төрлийн амлалт, баталгаанд тооцогдохгүй болохыг анхаарна уу.**

Үнэт цаас гаргагчийн бичгээр тавьсан хүсэлтийг үндэслэн Хуулийн фирм нь шаардлагатай гэж үзвэл Хуулийн дүгнэлтийн талаар гуравдагч этгээдэд нэмэлт тайлбар, тодруулга өгөх боломжтой болохыг дурдаж байна. Хуулийн фирмийн зүгээс өгөх нэмэлт тайлбар, тодруулга нь Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргасан ажлын даалгаварт тусгагдсанаас бусад асуудлаар нэмэлт дүн шинжилгээ хийх, тайлбар өгөх үүрэг үүсгэхгүй болно.

Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийхэд ашиглагдсан лавлагаа, тодорхойлолт, Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн аливаа баримт, материалд дурдагдсан үйл баримт, нөхцөл байдал Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөн аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн бөгөөд гадаад улсын хууль тогтоомж, хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх, ашиглахтай холбоотой асуудал байхгүй болохыг илэрхийлж байна.

**Хууль тогтоомж, хэм хэмжээний акт**

Хуулийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэж өгөх өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, түүнийг дагалдаж батлагдсан холбогдох хэм хэмжээний актуудыг үндэслэл болгон бэлтгэсэн

**Дүн шинжилгээ, дүгнэлт**

Үнэт цаас гаргагч Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн эрх зүйн байдал, хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн талаар тодруулж авч үзлээ.

БИД ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 01 сарын 18-ны өдрийн №01/01 тоот шийдвэрээр ББСБ-ын одоогийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй дүрмийг баталсан бөгөөд хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2021 оны 03 сарын 31-ний өдөр бүртгэгдсэн байна.

БИД ББСБ ХХК-ийн Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "Бизнес-Инвест Девелопмент оносон нэр бүхий ББСБ нь ... Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийг үндэслэн энэхүү Дүрмийн хүрээнд ашгийн төлөө ББСБ-ын үйл ажиллагаа явуулах хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай[4] (ХХК) байна" гэж ББСБ өөрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байна.

[4] Компанийн тухай хууль (2021).
3 дугаар зүйл Компани, түүний хэлбэр



БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9011031195 СТС2420

252

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12
БҮРТГЭВ
№31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьд Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт "ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 5,000,001,000 (таван тэрбум нэг мянган) төгрөг ба нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,000,001 (таван сая нэг) ширхэг энгийн хувьцаа байна", 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт БИД ББСБ ХХК нь 2 (хоёр) хувьцаа эзэмшигчтэй байна гэж тусгасан байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2023 оны 03 сарын 07-ны өдрийн лавлагаанаас үзвэл БИД ББСБ ХХК нь нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,000,001 (таван сая нэг) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 5,000,001,000 (таван тэрбум нэг мянган) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд 2 (хоёр) хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани болохыг тодорхойлсон байна.

Хуулийн фирм нь энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар БИД ББСБ ХХК-ийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Дүрэм болон хөндлөнгийн гуравдагч этгээдээс олгосон лавлагаа, тодорхойлолтод үндэслэн Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн баримт материал, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэж дараах байдлаар дүгнэлээ.

**Нэг. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх болон үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлаар:**

Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулж буй хуулийн зохицуулалтын дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль[5] болон Зөвшөөрлийн тухай хуульд[6] заасан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авч хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлснээр хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар үүсэх хуулийн зохицуулалттай байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зохицуулалтын дагуу компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд нь улсын бүртгэлийн байгууллагад мэдээллээ бүртгүүлэх бөгөөд хуулийн этгээд бүхэн хувийн хэрэгтэй байхаар зохицуулсан[7]. Тус

3.1.Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагдах, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.
3.2.Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд тухайн компанийн эд хөрөнгөд тусгайлсан өмчлөх эрхийг нотлохгүй.
3.3.Хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоох бөгөөд хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг хуваарилахаас өөрийн хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ.
3.4.Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компанийн хэлбэртэй байна.
3.5.Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг эзэмшигчийн хариуцлах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагдсан компанийг хэлнэ.
[5] Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002).
9 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
9.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрийн салбар, төлөөлөгчийн газар, нэгжийг Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэйгээр нээнэ.
[6] Зөвшөөрлийн тухай хууль (2022).
8.1 дүгээр зүйл Тусгай зөвшөөрлийн жагсаалт
2 Банк, банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:
[7] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2018)
4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
4.1.4."хуулийн этгээдийн хувийн хэрэг" гэж улсын бүртгэлийн мэдээллийн санд цаасан болон цахим хэлбэрээр байгаа, энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээллийн бүрдлийг;
4.1.6."хуулийн этгээдийн мэдээлэл" гэж хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа энэ хуулийн 10.1-д заасан болон бусад мэдээллийг;
10 дугаар зүйл. Хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулга
10.1.Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна:
10.1.1.хуулийн этгээдийн нэр, регистрийн болон хувийн хэргийн дугаар;
10.1.2.хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл;



БИД
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
5183855
CTC2420

зохицуулалтыг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан дахь БИД ББСБ ХХК-ийн хувийн хэргээс лавлагаа гаргуулан авч дүн шинжилгээ хийлээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн хүүлбар лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагчдын 2005 оны 05 сарын 15-ны өдрийн №01 шийдвэрээр Бизнес-Инвест Девелопмент оноосон нэртэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдаж, хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ 2005 оны 08 сарын 19-ний өдөр бүртгэгдсэн байна. БИД ББСБ ХХК-ийг үүсгэн байгуулагдах үед хүчин төгөлдөр хэрэгжиж байсан хуулийн зохицуулалтын дагуу Монголбанкнаас банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог зохицуулалттай байсан бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005 оны 07 сарын 25-ны өдрийн №340 тоот тушаалаар банк бус санхүүгийн байгууллага байгуулж, зээл, гадаад валютын арилжаа, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Үнэт цаас гаргагч Бизнес-Инвест Девелопмент ХХК-д олгосон байна.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль 2005 оны 11 сарын 17-ны өдөр батлагдсанаар Санхүүгийн зохицуулах хороо нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилсан. Үүнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 09 сарын 28-ны өдрийн №130 тоот тогтоолоор БИД ББСБ ХХК-д банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл[3] олгосон бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 09 сарын 23-ны өдрийн №248 тоот тогтоолоор БИД ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 09 сарын 28-ны өдрөөс эхлэн 3 (гурван) жилийн хугацаагаар сунгасан байна. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 сарын 18-ны өдрийн №533 тоот Банк бус санхүүгийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийг хугацаагүй болгох тухай тогтоолоор хавсралтад дурдсан нэр бүхий 258 (хоёр зуун тавин найман) банк бус санхүүгийн байгууллагын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй болгож шийдвэрлэсэн байна. Тус тогтоолын хавсралтын №112 дугаарт Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК байх тул Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-д банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүйгээр олгосон нь холбогдох хуулийн заалтад нийцэж байна гэж үзлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 02 сарын 15-ны өдрийн №9/711 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл БИД ББСБ ХХК-д Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны №130 тоот тогтоолоор банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг

---

10.1.3.хуулийн этгээдийн ерөнхий захирлын оршин байгаа газрын албан ёсны хаяг, харин байнгын ажиллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн оршин байгаа газрын хаяг;
10.1.4.хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах тухай;
10.1.5.үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл;
10.1.6.үүсгэн байгуулах баримт бичиг;
10.1.7.өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлагчийн талаарх;
10.1.8.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тухай мэдээлэл, түүнийг бүртгэсэн он, сар, өдөр;
10.1.9.компанийн нэвчд үүсгэн байгуулах баримт бичигт заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;
10.1.10.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн дугаар, гадаадын иргэн бол паспортын дугаар;
10.1.11.хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын албан ёсны хаяг, эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхийн дугаар;
10.1.12.хуулийн этгээдийн эрх бариц этгээдийн гишүүдийг сонгосон, өөрчилсөн тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр, хурлын тэмдэглэл;
10.1.13.төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавьсан, цуцалсан тухай баримт бичиг, хянан шалгах улсын байцаагчийн дүгнэлт, шийдвэрийн хуулбар;
10.1.14.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний нэвшил, хувь эзэмшил, санхүүгийн эрхийн талаарх мэдээлэл

[3] Санхүүгийн зохицуулах хороо
Банк бус санхүүгийн байгууллага, Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК байгууллага болон тусгай зөвшөөрлийн талаарх нээлттэй мэдээлэл
http://www.frc.mn/...



БИД
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
5183855

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023.05.12 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02

олгосон бөгөөд (i) Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны №233 тоот тогтоолоор итгэлцлийн үйлчилгээ, (ii) Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны №445 тоот тогтоолоор гадаад валютын арилжаа, (iii) Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны №147 тоот тогтоолоор цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, болон (iv) Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №83 тоот тогтоолоор богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх нэмэлт тусгай зөвшөөрлийг олгосон бөгөөд лавлагаа гаргах өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэр гараагүй, ББСБ-ын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хууль зүйн зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан болохыг тодорхойлсон байна.

Иймд дээр дурдсан хуулийн зохицуулалт, баримт материалын хүрээнд Хуулийн фирм нь БИД ББСБ ХХК-ийг хуульд тогтоомжид нийцүүлэн үүсгэн байгуулж, бүртгүүлсэн бөгөөд хуулиар зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэрэгжүүлэгчээс зааж эрх бүхий этгээдээс олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр банк бус санхүүгийн үйл ажиллагааг эрхэлж байна гэж дүгнэлээ.

БИД ББСБ ХХК Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 12 сарын 09-ний өдрийн №12/09 тоот тогтоолоор БИД Финанс ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагааны чиглэлийг БИД ББСБ ХХК-д нэгтгэх хэлбэрээр өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 сарын 27-ны өдрийн №415 тоот тогтоолоор[3] БИД Финанс ББСБ ХХК-ийг банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, БИД Финанс ББСБ ХХК-ийг Бизнес Инвест Девелопмент ББСБ ХХК-тай нэгтгэхийг зөвшөөрсөн бөгөөд тус өөрчлөн байгуулагдсан бүртгэлийг 2020 оны 01 сарын 22-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн болохыг дурдаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 сарын 27-ны өдрийн №441 тоот Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хугацааг шинэчлэн батлах тухай тогтоолоор ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг банк бус санхүүгийн гадаад валютын үйл ажиллагааг дагнан эрхлэхээс бусад банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Улаанбаатар хотод 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун сая төгрөг)-өөр тогтоосон бөгөөд 2023 оны 02 сарын 10-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотод 2,500,000,000 (хоёр тэрбум таван зуун) төгрөгөөр нэмэгдүүлж 5,000,000,000 (таван тэрбум) байхаар тогтоож шийдвэрлэсэн.

БИД ББСБ ХХК-ийн Дүрэмд тусгагдсанаар ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 5,000,001,000 (таван тэрбум нэг мянган) төгрөг ба нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,000,001 (таван сая нэг) ширхэг энгийн хувьцаатай байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2023 оны 03 сарын 07-ны өдрийн лавлагаанаас үзэхэд Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК нь нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,000,001 (таван сая нэг) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 5,000,001,000 (таван тэрбум нэг мянган) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд дараах 2 (хоёр) хувьцаа эзэмшигчийн эзэмшилд байна. Үүнд:

*Хүснэгт №01. БИД ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц.*

| № | Хувьцаа эзэмшигчид | Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр) | Хувьцааны тоо (ширхэгээр) | Нийт дүн (төгрөгөөр) | Хувь хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | А.Алтансүх | 1,000 | 2,550,001 | 2,550,001,000 | 51.00% |
| 2 | Х.Одонтуяа | 1,000 | 2,450,000 | 2,450,000,000 | 49.00% |
| | НИЙТ | 1,000 | 5,000,001 | 5,000,001,000 | 100.00% |

[3] Санхүү зохицуулах хорооны цахим хуудас
Бид Финанс ББСБ ХХК-ийг Бизнес Инвест Девелопмент ББСБ ХХК-тай нэгтгэхийг зөвшөөрөх, Бид Финанс ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай №415 тогтоол
http://www.frc.mn/...8a81907a94009afbc4aa3cb58148832be15320.pdf

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК 9023010137



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 9021031105

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023.03 сар 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК нь тайлан мэдээг хугацаанд нь ирүүлдэг бөгөөд 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хангаж ажиллавал зохих зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж байгааг Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 02 сарын 15-ны өдрийн №9/711 тоот албан бичгээр тодорхойлсон болно.

ББСБ-ын оршин байгаа газрын хувьд Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт[10] заасны дагуу түүний өөрөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлогдох бөгөөд ББСБ-ын хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагад бүртгүүлэх хуулийн зохицуулалттай. Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн одоогийн оршин байгаа газар буюу үйл ажиллагаа эрхлэн явуулах албан ёсны хаягийн хувьд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, 5-р хороолол, Сөүлийн гудамж, 1/11 -р барилга, 6 давхар хаягаар хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн байна.

Үнэт цаас гаргагчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд буюу Гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Ц.Бат-Эрдэнэ бүртгэлтэй байна. Хувьцаа эзэмшигчдийн 2005 оны 08 сарын 28-ны өдрийн №08/28 тоот шийдвэрээр Цагаачийн Бат-Эрдэнийг Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон байна.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн бөгөөд ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон шалгуурыг хангаж байна гэж дүгнэлээ.**

**Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлын тухайд**

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 сарын 09-ний өдрийн №02/09 тоот нээлттэй өрийн хэрэгсэл гаргах тухай тогтоолоор нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 100,000 (нэг зуун мянган) ширхэг нийт 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий, 18 (арван найман) сарын хугацаатай, жилийн 18.5 (арван найм арвны таван) хувь хүртэлх хүүтэй, хагас жил тутамд хүү төлөгдөх давтамжтай өрийн бичиг гарган Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон нээлттэй арилжих, хөрөнгө татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлын хувьд Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, БИД ББСБ ХХК-ийн Дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.5 дахь хэсэг болон ББСБ-ын 2023 оны төлөвлөгөөг тус тус үндэслэн Компани нь 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичиг ("Бонд")-ийг гаргаж Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан 2023 онд нийтэд нээлттэй санал болгон арилжаалахаар шийдвэрлэж өрийн бичгийн нөхцөлийг тогтоож, татан төвлөрүүлсэн хөрөнгийг зээлийн үйл ажиллагаанд санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Компанийн тухай хуулийн зохицуулалтын дагуу[11] компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгээр

---

[10] Компанийн тухай хууль (2011).
10 дугаар зүйл Компанийн оноосон нэр, оршин байгаа газар
10.4 Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний өөрөнхий захиргаа байрлаж байгаа газраар тодорхойлно.
10.5 Компанийн хаягийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлнэ
[11] Компанийн тухай хууль (2011)
41 дүгээр зүйл Компанийн өрийн бичиг
41.1 Компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгээр өрийн бичиг гаргаж болно.
41.2 Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 41.1-д заасны дагуу өрийн бичиг гаргах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргана.
41.3 Энэ хуулийн 41.2-т заасан шийдвэрт өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн худалдан авах үнэ, бусад нөхцөлийг заана.
41.4 Компани нь нэг удаа буюу төлөгдөх, эсхүл хэсэгчлэн төлөгдөх өрийн бичиг гаргаж болно.
41.5 Компанийн өрийн бичиг нь өөр компаниас тусгайлан гаргасан баталгаатай байж болно.
41.6 Өрийн бичиг гаргах шийдвэрт заасан бол компани гаргасан өрийн бичгээ төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдан авч

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 5183855 CTC2420

256

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-05-28
БҮРТГЭВ-02

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
он сар өдөр
2023 05 17
БҮРТГЭВ
№ 01

өрийн бичиг гаргаж болохоор зохицуулсан байдаг бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар[14] Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржээс тогтоосон шалгуурыг хангасан компани нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргаж болохыг зөвшөөрсөн байна. Иймээс Үнэт цаас гаргагч нь хууль тогтоомжид нийцүүлэн өрийн бичиг гаргах боломжтой бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн нөхцөлд үнэт цаасны анхдагч зах зээл дээр олон нийтэд нээлттэй санал болгож хөрөнгө татан төвлөрүүлэх боломжтой байна.

Компанийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын дагуу компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргах[15] зохицуулалттай байна. Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн дүрмийн холбогдох зохицуулалтаас харвал тус дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.5 дахь заалтад "Компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах" асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэрлэхээр зохицуулжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын үндэслэлийг дүгнэж үзвэл Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал) гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана", 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалтад "төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах бүрэн эрхтэй", Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэгт компанийн өрийн хэрэгсэл нь тус хуулийн зохицуулалтад хамрагдах үнэт цаасанд хамаарна, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Үнэт цаасыг нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргаж болно", Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.5 дахь заалтад "Компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах" асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэрлэхээр тусгасан нь компанийн өрийн бичиг гаргах эрх нь төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд БИД ББСБ ХХК-ийг өрийн бичиг гаргах, биржээр дамжуулан нийтэд санал болгох шийдвэрийг холбогдох хуулийн дагуу гарсан байна гэж дүгнэлээ.

---

41.7.Энэ хуулийн 41.6-д заасны дагуу өрийн бичгийг эргүүлэн худалдан авах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргана.

[14] Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013).

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.9."өрийн хэрэгсэл" гэж үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаа дуусмагц үндсэн төлбөр болон хүүг мөнгөн хэлбэрээр, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр тухайн үнэт цаасыг эзэмшигчид эргүүлэн төлөх нөхцөлтэй гаргасан болон түүнтэй адилтгах бусад үнэт цаасыг;

16 дугаар зүйл.Компанийн өрийн хэрэгсэл

16.1.Хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон шалгуурыг хангасан компани нийтэд санал болгон өрийн хэрэгсэл гаргаж болно.

16.2.Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгэх журмыг Хороо тогтооно.

16.3.Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгсэл нь үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаатай байж болно.

16.4.Компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн нийт дүн нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байх ба гуравдагч этгээдийн баталгаатай гаргаж байгаа нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн нийт дүн нь тухайн компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон гуравдагч этгээдийн гаргасан баталгааны нийлбэр дүнгээс илүүгүй байна.

[15] Компанийн тухай хууль (2011).

42 дугаар зүйл.Үнэт цаас гаргах тухай шийдвэр

42.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана.

42.2.Компани зарласан энгийн хувьцааг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь гаргах үүрэгтэй.

42.3.Компани давуу эрхийн хувьцааг зарласан хэмжээгээр нь, эсхүл зарим хэсгийг нь гаргаж болохоос гадна тодорхой хугацаанд гаргахгүй байж болно.

42.4.Компани нийтэд худалдахаар гаргаж байгаа үнэт цаас болон хувьцаат компанийн нэмж гаргаж байгаа хувьцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.

БИД БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
5183855
CTC2420



257

Мөн тус тогтоолын хавсралтаар өрийн бичиг гаргах нөхцөлийг баталсан бөгөөд тус нөхцөлд өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, нэрлэсэн үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, давтамж, татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, батлан даалт зэргийг тусгасан нь Компанийн тухай хуульд заасан өрийн бичиг гаргах шийдвэрт тусгавал зохих зүйлийг тусгасан, компанийн эрх барих байгууллага бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр байна гэж үзлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №226 тоот тогтоолоор батлагдсан Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэгт Үнэт цаас гаргагч нь өрийн бичгийн үүргийн гүйцэтгэлийг хангах гуравдагч этгээдээс тусгайлан гаргасан баталгаа, батлан даалттай байж болох бөгөөд барьцаа хөрөнгө нь бонд гаргагчийн гаргасан энгийн хувьцаа эсхүл түүнд хөрвөх нөхцөлтэй үнэт цааснаас бусад төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хэлбэртэй[14] байхаар журамласан байна.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 02 сарын 24-ний өдрийн №02/24-01 тоот Батлан даалт гаргах тухай тогтоолоор БИД ББСБ ХХК-ийн Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгох 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичгийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн байна. Мөн тус тогтоолоос үзвэл хувьцаа эзэмшигч А.Алтансүх болон хувьцаа эзэмшигч Х.Отгонтуяа нар нь хувийн батлан даалт гаргаж, андеррайтер Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-тай Батлан даалтын гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн байна. Мөн Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч А.Алтансүх болон хувьцаа эзэмшигч Х.Отгонтуяа нар нь хувийн батлан даалт гаргах Батламж бичиг үйлдсэн байгааг дурдаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №226 тоот тогтоолоор батлагдсан Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтад[15] Үнэт цаас гаргагч нь хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэй бол гурваас доошгүй жилийн өмнө үүсгэн байгуулагдсан, Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн гурван жилд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх бөгөөд хүсэлт гаргах үед зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх, хөрөнгө оруулагчдын өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэг байх шаардлагыг хангасан байхыг журамласан. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материал болон төрийн эрх бүхий байгууллагын лавлагаанд үндэслэн Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК нь Өрийн хэрэгслийн бүртгэлийн журамд тусгасан нийтэд санал болгон өрийн бичиг гаргагчид тавигдсан шаардлагыг хангаж байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Нэгтгэн дүгнэж үзвэл БИД ББСБ ХХК-ийн нээлттэй өрийн бичиг гаргах шийдвэр нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох журмын дагуу**

---

[14] **Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам СЗХ (2021)**
**Хоёр. Нийтэд санал болгон бонд гаргагчид тавигдах шаардлага**
2.5 Бонд гаргагч нь бондын үүргийн гүйцэтгэлийг хангах гуравдагч этгээдээс тусгайлан гаргасан баталгаа, батлан даалттай байж болох бөгөөд бонд бонд гаргагч компанийн тухайд энэ журмын 2.6 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд барьцаа хөрөнгө нь бонд гаргагчийн гаргасан энгийн хувьцаа эсхүл түүнд хөрвөх нөхцөлтэй үнэт цааснаас бусад төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хэлбэртэй байна.
2.6 Бонд гаргагч нь нээлттэй хувьцаат компани бол тухайн компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан даагч болох бөгөөд батлан даах хувьцаа нь бонд гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны 50 хувиас доошгүй байна.
[15] **Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам СЗХ (2021).**
**Хоёр. Нийтэд санал болгон бонд гаргагчид тавигдах шаардлага**
2.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга бонд гаргахад Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг, бусад бонд гаргагч нь дараах шаардлагыг тус тус бүрэн хангасан байна:
/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан/
2.1.1 нээлттэй хувьцаат компани, эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэй бол гурваас доошгүй жилийн өмнө үүсгэн байгуулагдсан, Хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн гурван жилд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
2.1.2 Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргах үед зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;
2.1.3 Хөрөнгө оруулагчдын өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэг байх.

гарсан бөгөөд Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгон өрийн бичиг гаргагчид тавьсан шалгуур, шаардлагыг хангаж байна гэж дүгнэлээ.

Хоёр. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангаж байгаа эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал болон эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлага хангаж байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлага болон тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлага хангаж буй эсэхэд БИД ББСБ ХХК-аас ирүүлсэн баримт материал болон Санхүүгийн зохицуулах хорооны лавлагаанд үндэслэн дүн шинжилгээ хийлээ.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2013 оны 11 сарын 22-ны өдрийн хурлын №11 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр А.Алтансүх, Х.Одонтуяа, С.Отгонбат, Ц.Бат-Эрдэнэ нарыг хугацаагүйгээр сонгосон бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 11 сарын 22-ны өдрийн №1 тоот тушаалаар А.Алтансүхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгосон байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 09 сарын 11-ний өдрийн №09/11/1 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Б.Анхилууныг, 2019 оны 10 сарын 18-ны өдрийн №10/18/01 тоот тогтоолоор Б.Отгондоржийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр тус тус хугацаагүйгээр сонгосон байна

Төлөөлөн удирдах зөвлөл

Хуулийн дүгнэлт үйлдэх өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын хүрээнд үзвэл хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл[16] байх бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно[17]. Компанийн дүрэмд заасан бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөл хараат бус гишүүнтэй байж болно[18], Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно[19], Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно[20] гэж нарийвчлан зохицуулсан

---

[16] Компанийн тухай хууль (2011)
75 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл
75.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.
[17] Компанийн тухай хууль (2011).
75 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл
75.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно
[18] Компанийн тухай хууль (2011)
75 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл
75.5.Компанийн дүрэмд заасан бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөл хараат бус гишүүнтэй байж болно
[19] Компанийн тухай хууль (2011)
77 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох
77.2.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно.
[20] Компанийн тухай хууль (2011)
78 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12
БҮРТГЭВ
Үнэт цаасны танилцуулга
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-03-28
БҮРТГЭВ-02

Хуулийн зохицуулалтын дагуу авч үзвэл Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт "Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна", 10.2 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь 6 (зургаан) гишүүнтэй байна. Уг гишүүдэд хоёр хувьцаа эзэмшигч өөрөө болон өөрийн нэг, нэг гишүүнийг нэрж оруулах ба Гүйцэтгэх захирал, хараат бус гишүүн гэсэн 6 (зургаан) гишүүний бүрэлдэхүүнтэй байна", 10.3 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь хамгийн багадаа нэг хараат бус гишүүнтэй байна" 10.8 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно" гэж заасан бөгөөд дүрмийн зохицуулалт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний хувьд авч үзвэл энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

*Хүснэгт №32. БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд*

| № | Овог, нэр | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн төлөв | Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийн дугаар | ХЭХ-ын тогтоолын дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | А.Алтансүх | Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга | №7/4813 | №11/22 |
| 2 | Х.Одонтуяа | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | №7/4813 | №11/22 |
| 3 | С.Отгонбат | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | №7/4813 | №11/22 |
| 4 | Ц.Бат-Эрдэнэ | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | №7/4813 | №11/22 |
| 5 | Б.Анхилуун | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн | №7/4342 | №09/11/1 |
| 6 | Б.Отгондорж | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн | №7/3748 | №10/18/01 |

### Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

**А.Алтансүх** нь Хувьцаа эзэмшигчдийн 2013 оны 11 сарын 22-ны өдрийн №11/22 тоот тогтоолоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон. Улмаар БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 11 сарын 22-ны өдрийн хурлын №1 тоот тогтоолоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар сонгогдсон байна. Тэрээр 1998 онд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль ("ШУТИС")-ийг Санхүүгийн менежмент мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, 2000 онд ШУТИС-ийг Бизнесийн удирдлагын магистр, 2009 онд Шихихутаг хуулийн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй тус тус төгссөн, 2017 оноос хойш ШУТИС-ийн Бизнесийн удирдлагын докторантаар суралцаж байгаа. А.Алтансүх нь 1998-2000 онд УПА Трейд ХХК-ийн Санхүүгийн албаны дарга, 2000-2003 онд Шим Импорт ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 2004-2005 онд Бизнес Инвест ХЗХ-ны Дарга, 2010-2019 онд Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбооны Ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байсан бөгөөд 2005 оноос хойш БИД ББСБ ХХК-д өнөөг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Алтансүх нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2012 оны 12 сард хамрагдаж №0720001 дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 12 сарын 18-ны өдрийн №7/4813 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

### Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд

**Х.Одонтуяа** нь Хувьцаа эзэмшигчдийн 2013 оны 11 сарын 22-ны өдрийн №11/22 тоот тогтоолоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон байна. Тэрээр 2001 онд Өлзий их сургуулийг Аялал жуулчлалын чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. Х.Одонтуяа нь 2003-2010 онд Блу Скай Трэвэл ХХК-ийн Ерөнхий менежерээр ажиллаж байгаад 2010 оноос

[illegible] бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос [illegible] сонгоно

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК

хойш Аваргас Трейд ХХК-ийн Ерөнхий захирлаар, 2012 оноос хойш БИД ББСБ ХХК-д өнөөг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Х.Одонтуяа нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2016 оны 12 сард хамрагдаж №0520510 дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 12 сарын 18-ны өдрийн №7/4813 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

**С.Отгонбат** нь Хувьцаа эзэмшигчдийн 2013 оны 11 сарын 22-ны өдрийн №11/22 тоот тогтоолоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон байна. Тэрээр 1996 онд Цог дээд сургуулийг Багш, орчуулагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, 1998 онд Нидерланд Улсын Маастрихтын Менежментийн Сургуулийг Бизнесийн удирдлагын магистр, Америкийн Нэгдсэн Улсын Харвардын Бизнесийн Их Сургуулийг Боловсон хүчний менежмент мэргэжлээр тус тус төгссөн. С.Отгонбат нь 2001-2007 онд Гадаад Худалдаа Хөрөнгө Оруулалтын Агентлагийн Дэд дарга, 2004-2008 онд Улаанбаатар Хотын Захиргааны Тэргүүлэх гишүүн, 2007-2008 онд Худалдаа Аж Үйлдвэрийн яамны Зөвлөх, 2008-2011 онд Эрдэс Баялаг Эрчим Хүчний яамны Зөвлөх, 2012-2014 онд Оюу Толгой ХХК-ийн Дэд ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байсан бөгөөд 2014 оноос хойш Өтгөн Холдинг ХХК-ийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байгаад 2012 оноос хойш БИД ББСБ ХХК-д өнөөг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн С.Отгонбат нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2016 оны 12 сард хамрагдаж №0520509 дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 12 сарын 18-ны өдрийн №7/4813 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

**Ц.Бат-Эрдэнэ** нь Хувьцаа эзэмшигчдийн 2013 оны 11 сарын 22-ны өдрийн №11/22 тоот тогтоолоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон байна. Тэрээр 1998 онд ШУТИС-ийн Компьютерын Техник, Менежментийн Сургууль ("КТМС")-ийг Бизнесийн удирдлагын бакалавр, 2001 онд ШУТИС-ийн КТМС-ийг Бизнесийн удирдлагын магистраар тус тус төгссөн. Ц.Бат-Эрдэнэ нь 1998 онд УПА Трэйд ХХК-д Төслийн менежер, 1999-2004 онд Гуна хайрхан ХХК-д Ерөнхий менежер, 2004-2005 онд Бизнес Инвест ХЗХ-ны Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байгаад 2005 оноос хойш БИД ББСБ ХХК-д өнөөг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц.Бат-Эрдэнэ нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2016 оны 04 сард хамрагдаж №0520293 дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 12 сарын 18-ны өдрийн №7/4813 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

**Б.Анхилуун** нь Хувьцаа эзэмшигчдийн 2014 оны 09 сарын 11-ний өдрийн №09/11/1 тоот тогтоолоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдсон байна. Тэрээр 1998 онд Оюу их сургуулийг Орос хэлний багш мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, 2002 онд Санхүү эдийн засгийн их сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй тус тус төгссөн. Б.Анхилуун нь 2004-2005 онд Бизнес Инвест ХЗХ-ийн Нягтлан бодогч, БИД ББСБ ХХК-д 2005-2007 онд Нягтлан бодогч, 2008-2011 онд Зээлийн мэргэжилтэн, 2012-2017 онд Дотоод аудитор, 2017-2018 онд Маша Миша ХХК-д Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байсан бөгөөд 2014 оноос хойш БИД ББСБ ХХК-д өнөөг хүртэл ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Анхилуун нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2016 оны 04 сард хамрагдаж №0520294 дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2014 оны 10 сарын 03-ны өдрийн №7/4342 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

[illegible] нь Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 10 сарын 18-ны өдрийн №01/18/01 тоот тогтоолоор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгогдсон [illegible]

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
он сар өдөр
2023 г. 05 сар 13
№ 01
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

Тэрээр МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Эдийн засгийн кибернетик мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, 2000 онд Англи Улсын Манчестерийн их сургуулийг Мөнгөний эдийн засаг, эконометрик багш мэргэжлээр Магистрын зэрэгтэй тус тус төгссөн Б.Отгондорж нь 1995-1996 онд Монголбанкинд Дотоод аудитын газрын хянагч, 1996-1997 онд Хяналтын хэлтсийн хянагч, 1997-2005 онд Мөнгөний бодлого, судалгааны газрын ахлах эдийн засагчаар тус тус ажиллаж байсан бөгөөд 2005 оноос хойш Монгол-Оросын хамтарсан "ИЕК-Монгол" ХХК-ийн Ерөнхий захирлаар, 2019 оноос хойш БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр өнөөг хүртэл тус тус ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Отгондорж нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад 2023 оны 01 сард хамрагдаж №0521332 дугаартай гэрчилгээ авсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 10 сарын 25-ны өдрийн №7/3748 тоот тушаалаар Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнаар бүртгэгдсэн байна.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод**

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно", 81.2 дахь хэсэгт "Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ" гэж заасан байна. Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 30-ны өдрийн №01/30-04 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх (i) Цалин, урамшууллын хороо; (ii) Нэр дэвшүүлэх хороо; (iii) Аудитын хороо болон (iv) Эрсдэлийн хороог тус тус байгуулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 30-ны өдрийн №01/30-04 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Отгондорж, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Алтансүх болон Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Б.Анхилуун нарыг тус тус сонгосон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 30-ны өдрийн №01/30-04 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Отгондорж, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга А.Алтансүх болон Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн С.Отгонбат нарыг тус тус сонгосон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 30-ны өдрийн №01/30-04 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Б.Анхилуун, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Б.Отгондорж болон Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Х.Одонтуяа нарыг тус тус сонгосон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 30-ны өдрийн №01/30-04 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн С.Отгонбат, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Х.Одонтуяа, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Ц.Бат-Эрдэнэ нарыг тус тус сонгосон байна.

**Эрх бүхий албан тушаалтан**

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд

БИД ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
6183855
СТС2420

болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж хуульчилсан байдаг бөгөөд хуулийн этгээд өөрийн үүсгэн байгуулах баримт бичиг буюу дүрмээрээ илүү нарийвчлан тодорхойлох эсхүл албан тушаалаар нэр заан тодорхойлох боломжийг олгосон байдаг.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн дүрмээс үзвэл эрх бүхий албан тушаалтны талаар тодорхойлж тусгаагүй байна. Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Хуулийн фирмд ирүүлсэн баримт материал болон эрх бүхий албан тушаалтны мэдээлэлд үндэслэн дараах эрх бүхий албан тушаал буюу ажлын байр, орон тоо БИД ББСБ ХХК-ийн бүтцэд байна гэж үзлээ. Үүнд:

Хүснэгт №03. Эрх бүхий албан тушаалын ажлын байрны мэдээлэл

| № | Овог, нэр | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|---|
| 1 | Ц.Бат-Эрдэнэ | Гүйцэтгэх захирал | 1 |
| 2 | А.Баяржаргал | Ерөнхий нягтлан бодогч | 1 |
| 3 | Д.Ганзул | Зээлийн газрын захирал | 1 |
| 4 | А.Бямбажав | Үйл ажиллагаа хариуцсан захирал | 1 |
| 5 | Ө.Туул | Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга | 1 |

## Гүйцэтгэх удирдлага

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэгт "Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд нь гүйцэтгэх захирал байна". Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5[11] дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал дараах (i) зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх; (ii) ял шийтгэлгүй байх; (iii) ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банк бус санхүүгийн байгууллагыг удирдахад харшлахгүй байх; (iv) банк, санхүүгийн мэргэжилтэй, тухайн салбарт ажилласан туршлагатай байх; болон (v) Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагыг тус тус хангаж байхаар хуульчилсан.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт "ББСБ-ийн гүйцэтгэх удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр томилогдсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ", 11.3 дахь хэсэгт "ББСБ-ын өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал хууль тогтоомж, ББСБ-ын дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд удирдана", 11.4 дэх хэсэгт "Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигч байж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалахгүй" гэж тус тус тусгасан байна.

БИД ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2005 оны 08 сарын 28-ны өдрийн №08/28 тоот шийдвэрээр Цагаачийн Бат-Эрдэнийг БИД ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилсон байна.

Иймд Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, БИД ББСБ ХХК-ийн Дүрэм болон тэдгээрт холбогдох баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал Ц.Бат-Эрдэнэ хэрэгжүүлж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

[11] Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай (2002)
13 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага
13.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал дараах шаардлагыг хангасан байна:
13.5.1. зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
13.5.2. ял шийтгэлгүй;
13.5.3. ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банк бус санхүүгийн байгууллагыг удирдахад харшлахгүй байх;
13.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн гүйцэтгэх удирдлага нь банк, санхүүгийн мэргэжилтэй, тухайн салбарт ажилласан туршлагатай байна.

СЗХ
BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 05 12

Үнэт цаасны танилцуулга
2023 -03- 28
БҮРТГЭВ-02



Бусад эрх бүхий албан тушаалтан

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Дүрмээс үзвэл эрх бүхий албан тушаалтны талаар тодорхойлж тусгаагүй байна. Үнэт цаас гаргагч Хуулийн фирмд 2023 оны 01 сарын 30-ны өдрийн №01/30-2 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичиг болон Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Хуулийн фирмд ирүүлсэн баримт материал, эрх бүхий албан тушаалтны мэдээлэлд үндэслэн дараах эрх бүхий албан тушаал буюу ажлын байр, орон тоо БИД ББСБ ХХК-ийн бүтцэд байна гэж үзлээ. Үүнд:

§ А.Баяржаргал — БИД ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 11 сарын 23-ны өдрийн №11/23/01 тоот тушаалаар БИД ББСБ ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч албан тушаалд томилогдон ажиллаж байна.

§ Д.Ганхуяг — БИД ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2013 оны 01 сарын 04-ний өдрийн №01/04/04 тоот тушаалаар БИД ББСБ ХХК-ийн Зээлийн газрын захирал албан тушаалд томилогдон ажиллаж байна.

§ А.Баясгалан — БИД ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 сарын 23-ны өдрийн №01/23/02 тоот тушаалаар БИД ББСБ ХХК-ийн Үйл ажиллагаа эрхэлсэн захирал албан тушаалд томилогдон ажиллаж байна.

§ Ө.Туул — БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 сарын 21-ний өдрийн №12/28 тоот тушаалаар БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдон ажиллаж байна.

Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн зохицуулалт болон Компанийн засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд тавигддаг шаардлагын хүрээнд Хуулийн фирм нь Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл, анкет, тэдгээрийн мэдлэг чадварыг тодорхойлох баримт материалыг гаргаж өгөхийг хүссэн. Хуулийн фирм нь Компаниас ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг дараах хүснэгтээр дэлгэрүүлэн авч үзлээ.

*Хүснэгт №04. БИД ББСБ ХХК-ийн эрх бүхий албан т ушаалт ан Компанийн т ухай хууль, Компанийн засаглалын кодекст т авигдсан шаардлагыг хангасан эсэх мэдээлэл.*

| № | Эрх бүхий албан тушаал | Эрх бүхий албан тушаалтны нэрс | Компанийн тухай хууль (КТХ) | | | | Компанийн засаглалын кодекс (КЗК) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Компанийн засаглалын чиглэлээр суралцаж хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (Тийм/Үгүй/N/A* | Төрийн болон нутгийн захиргааны байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх Тийм/Үгүй | Ял шийтгэл эдэлж байгаа болон эдэлж байсан эсэх Тийм/Үгүй | ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагыг хуульд заасан хүн хэрэгжүүлдэг эсэх Тийм/ Үгүй/ N/A | ТУЗ-ийн гишүүд нь КЗК 1.2-ийн Тайлбар 1 хэсэгт заасан мэдээллийг шалгасан эсэх Тийм/Үгүй/ N/A |
| Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд | | | | | | | |
| 1. | ТУЗ-ийн дарга | А.Алтансүх | Тийм | Тийм | Үгүй | Тийм | Тийм |
| 2. | ТУЗ-ийн гишүүн | Х.Одонтуяа | Тийм | Тийм | Үгүй | Тийм | Тийм |
| 3. | ТУЗ-ийн гишүүн | С.Отгонбат | Тийм | Тийм | Үгүй | Тийм | Тийм |
| 4. | ТУЗ-ийн гишүүн | Ц.Бат-Эрдэнэ | Тийм | Тийм | Үгүй | Тийм | Тийм |
| 5. | ТУЗ-ийн гишүүн | Б.Анхилуун | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ ХХК

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Б.Отгондорж | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| Хоёр. Бусад эрх бүхий албан тушаалтан | | | | | | | |
| 7. | Гүйцэтгэх захирал | Ц.Бат-Эрдэнэ | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 8. | Ерөнхий нягтлан бодогч | А.Баяржаргал | N/A | Үгүй | Үгүй | N/A | N/A |
| 9. | Зээлийн газрын захирал | Д.Ганхуяг | N/A | Үгүй | Үгүй | N/A | N/A |
| 10. | Үйл ажиллагаа хариуцсан захирал | А.Баясгалан | N/A | Үгүй | Үгүй | N/A | N/A |
| 11. | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | Ө.Түвл | Тийм | Үгүй | Үгүй | N/A | N/A |

*N/A: Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтанд тусгайлан тавигдсан шаардлагад үндэслэн шалгах шаардлагагүй гэж үзсэн этгээдийн харгалзах нүдэнд тус тэмдэглэгээг оруулсан болно. Хуулийн фирм.

*Хүснэгт №05. БИД ББСБ ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу тавигдах шаардлага, Тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын шалгуурыг хангасан эсэх мэдээлэл.*

| № | Эрх бүхий албан тушаал | Эрх бүхий албан тушаалтны нэрс | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн алдагдалтай өртэй эсэх Тийм/Үгүй/N/A* | Ял шийтгэлтэй эсэх Тийм/Үгүй/NA* | Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банк бус санхүүгийн байгууллагыг удирдахад харшлах эсэх Тийм/Үгүй/NA* |
| Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд | | | | | |
| 1. | ТУЗ-ийн дарга | А.Алтансүх | Үгүй | Үгүй | Үгүй |
| 2. | ТУЗ-ийн гишүүн | Х.Одонтуяа | Үгүй | Үгүй | Үгүй |
| 3. | ТУЗ-ийн гишүүн | С.Оггонбат | Үгүй | Үгүй | Үгүй |
| 4. | ТУЗ-ийн гишүүн | Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | Үгүй | Үгүй |
| 5. | ТУЗ-ийн гишүүн | Б.Анхилуун | Үгүй | Үгүй | Үгүй |
| 6. | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Б.Отгондорж | Үгүй | Үгүй | Үгүй |
| 7. | Гүйцэтгэх захирал | Ц.Бат-Эрдэнэ | N/A** | N/A** | N/A** |
| 8. | Ерөнхий нягтлан бодогч | А.Баяржаргал | N/A** | N/A** | N/A** |
| 9. | Зээлийн газрын захирал | Д.Ганхуяг | N/A** | N/A** | N/A** |
| 10. | Үйл ажиллагаа хариуцсан захирал | А.Баясгалан | N/A** | N/A** | N/A** |
| 11. | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | Ө.Түвл | N/A** | N/A** | N/A*8 |

**N/A: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтанд тусгайлан тавигдсан шаардлагад үндэслэн шалгах шаардлагагүй гэж үзсэн этгээдийн харгалзах нүдэнд тус тэмдэглэгээг оруулсан болно. Хуулийн фирм.

Дээр дурдсан хүснэгт дэх мэдээлэл болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, журам болон Компанийн засаглалын кодекс, тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуурыг хангасан эсэх асуудлыг дэлгэрүүлэн авч үзлээ.

**Төлөөлөн** удирдах **зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн** дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, **гэрчилгээ авсан байх шаардлагыг**



265

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023.05.12 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

Компанийн тухай хуулийн 75.8 дахь хэсэгт[22] заасан бөгөөд Компаниас Хуулийн фирмд ирүүлсэн компанийн засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээнд үндэслэн БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Төлөөлөн удирдах гишүүд болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх тул холбогдох хууль, журмын шаардлагыг хангаж байна гэж үзлээ. Компанийн засаглалын кодексийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийн Тайлбар №1 дэх хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгасны үндсэн дээр томилно[23] гэж заасан. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл болон Батламжид үндэслэн Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь Компанийн засаглалын кодекст заасан шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

Эрх бүхий албан тушаалтны хувьд Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт[24] (i) хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг; болон (ii) ял шийтгэл эдэлж байгаа этгээдийг Компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглохоор хуульчилсан, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт Банк бус санхүүгийн байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал нь (i) зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн, хугацаа хэтэрсэн аливаа өргүй; (ii) ял шийтгэлгүй; болон (iii) ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банк бус санхүүгийн байгууллагыг удирдахад харшлахгүй байх шаардлагыг хангаж байх бөгөөд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтны эрхэлж байгаа ажил, албан тушаал, анкет, баримт бичигт тусгагдсан мэдээлэл, эрх бүхий албан тушаалтнуудын гаргаж өгсөн дээрх хуулийн шаардлагыг хангаж байгаа тухай Баталгаанд үндэслэн Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнууд нь холбогдох хуульд заасан шаардлагыг хангаж байна гэж үзлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 04 сарын 08-ны өдрийн №179 тоот тогтоолоор батлагдсан Тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын дагуу банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан[25], тохиромжтой этгээдийн

---

[22] Компанийн тухай хууль (2011).
75 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл
75.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

[23] Компанийн засаглалын кодекс (2022).
1.2 Тайлбар 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгана.

[24] Компанийн тухай хууль (2011).
84 дүгээр зүйл.Компанийн эрх бүхий албан тушаалтан
84.3.Дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглоно:
84.3.1.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг;
84.3.2.ял шийтгэл эдэлж байгаа;

[25] Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам. СЗХ (2020)
Нэг. Нийтлэг үндэслэл
1.2. Санхүүгийн зохицуулах хороо доор дурдсан хувь хүн, хуулийн этгээдэд энэхүү журмын дагуу тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байгаа эсэхэд үнэлгээ хийнэ. Үүнд:
1.2.2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч, бүртгүүлэгч, үнэт цаас гаргагч болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, бүртгэлтэй этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигч;
Дөрөв. Тохиромжтой этгээдийн шалгуур хангасан эсэхийг тодорхойлох баримт бичгийг бүрдүүлэх
4.1.Энэхүү журмын 1.2-т заасан этгээд өөрийн тохиромжтой этгээд болохыг нотлох баримтыг бүрдүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлнэ[illegible].



BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК 5183855 9011031195 CTC2420

266

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 он 05 сар 17 өдөр
БҮРТГЭВ
Нууц баримт
Эх хувь

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

шалгуурыг[20] хангасан нотлох баримтыг бүрдүүлж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж ажиллах үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн баримт материал, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмын дагуу бүртгэсэн тухай албан бичигт үндэслэн Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн зохицуулах хороонд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээллийг холбогдох журмын дагуу хүргүүлж, бүртгүүлсэн байх тул тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байна гэж Хуулийн фирмээс үзлээ. Харин Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтнуудын хувьд мөн Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд ирүүлсэн баримт материал, Баталгаанд үндэслэн тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байна гэж үзэх үндэслэлтэй байна. Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох баримт материалыг хүргүүлэн, бүртгүүлээгүй эрх бүхий албан тушаалтан Ерөнхий нягтлан бодогч, Зээлийн газрын захирал, Үйл ажиллагаа хариуцсан захирал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг гүс журамд нарийвчлан тусгасан шалгуурыг хангаж байгаа талаарх нотлох баримтыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, бүртгүүлэхийг Хуулийн фирмээс зөвлөж байна.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн баримт материал болон Тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын дагуу тохиромжтой этгээд нь мэдлэг, боловсрол,

---

[20] Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам. СЗХ (2020).
Хоёр. Тохиромжтой этгээдийн шалгуур
2.1. Санхүүгийн зохицуулах хороо дараах шалгууруудыг хангасан этгээдийг тохиромжтой этгээд гэж үзнэ. Үүнд:
2.1.2. Хувь хүнд дараах шалгуур тавигдана. Үүнд:
2.1.2.1. мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх;
2.1.2.2. гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх;
2.1.2.3. ес зүйн нэр хүндтэй байх;
2.1.2.4. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
2.1.2.5. журамд заасан бусад.
Гурав. Тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлох
3.2. Энэхүү журмын 2.1.2-т заасан хувь хүнд тавигдах шалгуурууд нь дараах байдалтай байна:
3.2.1. энэхүү журмын 2.1.2.1-д заасан "Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх" шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд: банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хувьд:
3.2.1.1. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, салбарын удирдлага, эрх бүхий албан тушаалтан, комплайнсын ажилтан зэрэг эрх бүхий албан тушаалд томилогдох этгээдүүд нь:
(Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан.)
а) Банк, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, хууль, эрх зүйн болон Хорооноос хүлээн зөвшөөрсөн бусад мэргэжлийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн байх;
б) Тухайн албан тушаалд дүйцэхүйц албан тушаалд 1-ээс доошгүй жил ажилласан туршлагатай байх;
в) Санхүүгийн салбарт 2-оос доошгүй жил ажилласан байх.
3.2.2. энэхүү журмын 2.1.2.2-т заасан "Гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх" шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:
3.2.2.1. Эрүүгийн хуульд заасан бусдын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээж байгаагүй байх;
3.2.2.2. Эрүүгийн хуульд заасан бусдын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбогдон шалгагдаж байгаа болон шүүх хуралд шилжүүлсэн, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр татагдан байгаа эсэх.
3.2.3. энэхүү журмын 2.1.2.3-т заасан "Ес зүйн нэр хүндтэй байх" шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:
3.2.3.1. сүүлийн 3 жилийн хугацаанд өөрийн буруутай үйлдлээс, салбарын ес зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс үүдэн ажлаас халагдах арга хэмжээ авагдаагүй байх;
3.2.3.2. санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой [illegible] буруутан байсан эсэх;
3.2.3.3. сүүлийн 1 жилийн хугацаанд салбарын ес зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх;
3.2.3.4. Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт хууль, журам, бизнесийн ес зүй, дүрмийн зөрчил [illegible], бусдад энэхүү үйлдлийг хийхэд туслалцаа үзүүлсэн хэрэгт холбогдоогүй байх;
3.2.3.5. Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын [illegible] шаардлагыг хангаагүй, [illegible] мэргэжлийн болон ес зүйн [illegible] стандартыг дагаж мөрдөхөд [illegible] байх.
3.2.4. энэхүү журмын 2.1.2.4-д заасан "Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх" шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:
3.2.4.1. нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйлд харшлахгүй байх;
3.2.4.2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг зохицуулсан тус хамаарах хууль, журамд харшлахгүй байх.
(Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 307 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан.)



БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
9021031195 СТС2420
267

ажлын туршлагатай байх шаардлагын дагуу Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл, анкет, Батламжид үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр мэргэшсэн бөгөөд эдгээр албан тушаалтан нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд шаардагдах мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн туршлагатай байна гэж Хуулийн фирмээс үзэж болохоор дүгнэж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь тухайлан дурдсанаас бусдаар холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангаж байна гэж үзлээ. Цаашид эрх бүхий албан тушаалтныг тохиромжтой этгээд болохыг нотлох баримтыг тухай бүр бүрдүүлж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж холбогдох журамд заасан шаардлагыг хангаж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

Гурав. Үнэт цаас гаргагчийн дүрэм, бусад дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд БИД ББСБ ХХК-ийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа дүрэм, журамд дүн шинжилгээ хийлээ. БИД ББСБ ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн баримт материалаас үзэхэд нийт 53 (тавин гурав) дүрэм, журам хүчин төгөлдөр хэрэгжиж байна. БИД ББСБ ХХК-ийн дүрэм, журмын жагсаалтыг **Хавсралт №01. "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын жагсаалт"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

*Хүснэгт №26. БИД ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын ангиллын тоон үзүүлэлт*

| № | Дүрэм, журмын нэр, төрөл | Нийт |
|---|---|---|
| 1 | Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам | 8 |
| 2 | Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журам | 9 |
| 3 | Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам | 28 |
| 4 | Санхүү, нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журам | 1 |
| 5 | Мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журам | 1 |
| 6 | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам | 1 |
| 7 | Бусад дүрэм, журам | 5 |
| | НИЙТ | 53 |

Хуулийн фирм нь БИД ББСБ ХХК-аас тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэж ирүүлсэн нийт дүрэм, журмын хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө дүрэм, журмаар зохицуулж байгаа харилцаанд үндэслэн хамааруулан дараах шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

(i) Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Компанийн засаглалын кодекст харшлаагүй эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;

(ii) Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журам нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Компанийн хөдөлмөрийн дотоод журам, БИД ББСБ ХХК-ийн хүний нөөцийн талаар баримтлах бодлогод тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль, журамд харшлаагүй эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;

(iii) Банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаа буюу Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан зээл, факторингийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валют арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, үл хөдлөх хөрөнгө барьцаалалттай холбоотой санхүүгийн зуучлалын үйлчилгээний журам нь банк, эрх бүхий

хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн гүйлгээний шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх,

(iv) Санхүү нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журам нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын Стандартад тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж мөрдүүлсэн эсэх,

(v) Эрсдэлийн удирдлага болон мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн засаглалын кодекст тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх,

(vi) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нийцсэн эсэх, агуулга нь хууль болоод Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх,

(vii) Бусад ангилалд хамаарах дүрэм, журам нь холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэх, агуулга нь хууль, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх.

БИД ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөж буй 53 (тавин гурав) дүрэм, журмаас үзвэл 48 (дөчин найман) дүрэм, журам нь Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдсан, 4 (дөрвөн) журмыг Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан байна.

(i) <u>Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам</u>

БИД ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 01 сарын 18-ны өдрийн хурлаар ББСБ-ын Дүрмийг баталсан байна. Хуулийн фирмээс БИД ББСБ ХХК-ийн дүрэм нь Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тогтоолоор шинэчлэн баталсан "Компанийн засаглалын кодекс"-т тус тус нийцэж байгаа эсэхэд дараах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "ББСБ-ын эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна" гэж заасан байхаас гадна 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 59-74 дүгээр зүйлийг шууд удирдлага болгохоор заасан байна. Иймд БИД ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах түүнд оролцох, шийдвэр гаргах, шийдвэр хүчин төгөлдөр болох, ээлжит бус хурал зарлах, хурлын тэмдэглэлийг хөтлөх зэрэг бүхий л үе шат нь Компанийн тухай хуулийн дагуу явагдахаар байна. Иймд дүрэмд заасан хувьцаа эзэмшигчдийн эрх, шийдвэр гаргалт зэрэг нь Компанийн тухай хуулийг зөрчөөгүй байна гэж үзлээ.

Дүрмийн 10 дугаар зүйлд Төлөөлөн удирдах зөвлөлийн зохицуулалт орсон ба Төлөөлөн удирдах зөвлөл нь 6 (зургаан) гишүүнтэй үүнээс хамгийн багадаа 1 (нэг) хараат бус гишүүнтэй байхаар заасан байна. Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсэгт[27] зааснаар хязгаарлагдмал хариуцлагатай компани нь дүрэмдээ тусгаснаар Төлөөлөн удирдах зөвлөлтэй байж болохоор байна. Мөн тус хуулийн 75 дугаар зүйлийн 75.3 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно", 75 дугаар зүйлийн 75.5 дахь хэсэгт "компанийн дүрэмд заасан бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөл хараат бус гишүүнтэй байж болно" гэж заасан байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан "Компанийн

[27] Компанийн тухай хууль (2011).

[illegible] 75 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл
[illegible] удирдах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно.

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.03.12
БҮРТГЭВ

Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

засаглалын кодекс"-т компанийн засаглалын үндсэн зарчмын нэг болох компани Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх шаардлагыг тус тус хангаж байна. Дүрмийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг болон 10.6 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгох ба Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь бүрэн эрхийн хугацаагүй байхаар тогтоосон байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 77 дугаар 77.1 болон 77.2 дахь хэсгийг[24] бүрэн хангаж байна. Дүрэмд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхын саналаар сонгохоор заасан байна. Харин Гүйцэтгэх захирлын хувьд түүнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж эрх, үүрэг, хариуцлагын хэмжээг тогтоосон гэрээг байгуулахаар заасан байна.

БИД ББСБ ХХК-ийн Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан дүрэмд тусгавал зохих зүйлийг тусгасан, агуулгын хувьд Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн байна гэж Хуулийн фирмийн зүгээс үзлээ.

Хуулийн фирм нь БИД ББСБ ХХК-аас ирүүлсэн компанийн засаглалд хамаарах бусад дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

БИД ББСБ ХХК-ийн засаглалд хамаарах дүрэм, журмаас онцгойлон дурдвал Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 сарын 10-ны өдрийн №10/10 тоот тогтоолоор "Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам"-ыг баталсан байна. Тус журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргын нэрийг нэг бүрчлэн зааж оруулсан байна. Энэ нь холбогдох хууль, дүрэм журмыг зөрчихгүй боловч Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, дарга, нарийн бичгийн дарга өөрчлөгдөх болгонд журамд өөрчлөлт оруулж дахин батлах шаардлагыг үүсгэх юм. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох зарчмыг БИД ББСБ ХХК-ийн дүрэмд нарийвчлан тусгасан. Өөрөөр хэлбэл БИД ББСБ ХХК-ийн 2 (хоёр) хувьцаа эзэмшигч болон компанийн Гүйцэтгэх захирал Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байхаар заасан байна.

БИД ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-т заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд (i) Нэр дэвшүүлэх хороо; (ii) Цалин, урамшууллын хороо; (iii) Эрсдэлийн хороо, болон (iii) Актив, пассивын хороог байгуулсан байна. Эдгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод нь зорилго, эрх үүргээ тодорхойлсон дүрэмтэй байх ба дүрмийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс батлахаар тусгасан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 30-ны өдрийн №01/30-01 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар "Залгамж халааны бодлого", 2 дугаар хавсралтаар "Цалин, урамшууллын бодлого", 5 дугаар хавсралтаар "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг, 2020 оны 09 сарын 17-ны өдрийн №09/17/01 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар "Актив пассивын хорооны журам"-ыг тус тус баталсан байна.

БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь "Залгамж халааны бодлого"-ыг удирдлага болгох ба ББСБ-ын эрх бүхий албан тушаалд нэр

[24] Компанийн тухай хууль (2011).
77 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох
77.1.Энэ хууль болон компанийн дүрэмд тогтоосон журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоно.
77.2.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно.



БИД ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
5183855 9021031195 СТС2420

2023.03.12 өдөр БҮРТГЭВ №11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02

дэвшигчдийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах, эрх бүхий албан тушаалтнуудын мэдлэг, ур чадвар, туршлага нь тухайн ажлын байрны шаардлагыг хангах эсэх, сонирхлын зөрчил үүссэн эсэх, эрх бүхий албан тушаалтны мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зэрэгт анхаарал хандуулан ажиллах зохицуулалттай байна. Мөн тус хороо нь эрх бүхий ажилтны ажлын байр тур болон урт хугацаагаар эзэнгүй байх, орон тоо гэнэт өөрчлөгдсөнөөс үүдэн гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг байна.

Цалин, урамшууллын хороо нь "Цалин, урамшууллын бодлого"-ын хүрээнд ББСБ-ын хэмжээнд цалин болон урамшууллын зарчмыг тодорхойлж жил бүр батлуулан мөрдүүлэх чиглэлээр ажилладаг байна. Мөн тухайн ажилтны мэргэжлийн ур чадвар, гүйцэтгэл зэрэгт үндэслэн урамшуулах олгох зарчим, салбарын ажилтнуудын цалингийн дундаж хэмжээ, тухайн жилийн инфляцийн түвшинтэй уялдуулж бодит цалингийн хэмжээг тогтоож Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх үүрэгтэй байдаг байна.

Эрсдэлийн удирдлагын хороо нь "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ын хүрээнд ББСБ-ын хэмжээнд үүсэж болох эрсдэлийг олж тодорхойлох түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг тогтоон Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж шаардлагатай тохиолдолд компанийн хэмжээнд мөрдөж буй дүрэм, журамд өөрчлөлт оруулах байдлаар ажлаа зохион байгуулдаг байна. Хороо нь эрсдэлийг үйл ажиллагааны, зээлийн, санхүүгийн, гадаад орчны, хүний нөөцийн, мэдээллийн аюулгүй байдлын гэж ангилан тус бүрт нь тохирсон хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Актив, пассивын хороо нь "Актив пассивын хорооны журам"-ын хүрээнд ажлаа зохион байгуулна. Энэ хорооны үндсэн ажил нь төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ББСБ хангаж буй эсэх, бэлэн мөнгөний үлдэгдлийг хангалтгүй эрсдэлээс урьдчилан хамгаалах, компанийн зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд активыг зөв байршуулах, ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж Төлөөлөн удирдах зөвлөлд мэдээлэл өгөх үндсэн үүрэгтэй тусгай нэгж юм. Актив, пассивын хороо нь 6 (зургаан) гишүүнтэй байх ба Гүйцэтгэх захирал, зээлийн газрын захирал, ерөнхий нягтлан бодогч, дотоод аудитор зэрэг албан тушаалтнууд байхаар заасан байна.

**Нэгтгэн дүгнэж үзвэл БИД ББСБ ХХК-ийн Дүрэм болон засаглалд хамаарах дүрэм, журам нь Компанийн тухай хууль болон бусад дүрэм, журамд нийцсэн байна.**

(ii) <u>Хөдөлмөрийн харилцаа хүний нөөцөд хамаарах журам</u>

Үнэт цаас гаргагч нь тасралтгүй болгосон өдрийн байдлаар ББСБ-ын дотоод үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журмыг Хуулийн фирмд ирүүлсэн байх бөгөөд эдгээр журмаас онцгойлон дурдвал Үнэт цаас гаргагч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт[24] заасан ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны №03/18 тоот тогтоолоор "Хүний нөөцийн бодлого"-ыг шинэчлэн баталсан байна. Энэхүү журмаар ажилтныг сонгон шалгаруулах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, ажлын цаг, ээлжийн амралт, ажилтанд олгох цалин хөлс, урамшуулал, тэтгэмж, нөхөн олговор, эд хөрөнгийн хариуцлага, ажилтанд нөлөөллийн арга хэмжээ авах, сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох, ажилтны гомдлыг шийдвэрлэх асуудлыг тус тус тодорхойлон тусгасан байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт "Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах орон тооны бус байнгын ажиллагаатай комиссыг 20 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад байгуулна" гэж заасан байдаг. БИД ББСБ ХХК-ийн хөдөлмөрийн

[24] Хөдөлмөрийн тухай хууль (2021)
122 дугаар зүйл.Хөдөлмөрийн дотоод журам
122.1.Ажил олгогч ажилтны төлөөллийн байгууллагатай зөвшилцөн хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлнэ.

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК



УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО ХУУЛЬ ХАЙ ХХК

дотоод журамд энэ тухай заагаагүй байх тул Хуулийн фирмийн зүгээс нэмж оруулахыг зөвлөж байна.

БИД ББСБ ХХК-аас ирүүлсэн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журмууд нь Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн байна гэж үзлээ.

(iii) Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгосон өдрийн байдлаар компанийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй, тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах нийт 28 (хорин найман) дүрэм, журмыг Хуулийн фирмд ирүүлсэн байна.

Хүснэгт №07. БИД ББСБ ХХК-ийн тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмын тоон үзүүлэлт

| № | Дүрэм, журмын нэр, төрөл | Нийт |
|---|---|---|
| 1. | Итгэлцэл, үнэт цаастай холбоотой дүрэм, журам | 2 |
| 2. | Зээлийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам | 26 |
| | **НИЙТ** | **28** |

Эдгээр дүрэм, журмаас онцолбол дурдвал БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №09/17/01 тоот тогтоолоор "Итгэлцлийн үйлчилгээний журам"-ыг баталсан байна. Тус журмаар БИД ББСБ ХХК нь иргэн болон аж ахуйн нэгжийн бэлэн мөнгө, зээл, эрхийг үнэгүйдлээс хамгаалах гэрээний үндсэн дээр итгэмжлэн авч зөвхөн өөрийн үйл ажиллагааны хүрээнд удирдах, тодорхой хугацааны дараа итгэмжлэн авсан хөрөнгийг харилцан тохирсон үр шимийн хамт буцаан төлөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь хэсэгт[40] банк бус санхүүгийн үйл ажиллагаанд итгэлцэл орно гэж заасан байна. Тус журамд итгэлцлийн үйлчилгээ 6 сар болон түүнээс дээш хугацаатай байх ба валютын төрлийг тохиролцож болохоор байна. Мөн итгэлцлийн үр шимийг тодорхой давтамжтай олгох, хөрөнгө итгэмжлүүлсэн этгээдийн хүсэлтээр гуравдагч этгээдэд олгох зэрэг зохицуулалтыг тусгасан байна. Журмын 6 дугаар зүйлд заасанаар БИД итгэлцлийн хүрээнд хүлээн авсан хөрөнгийг зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооноос авсан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны хүрээнд зарцуулах үүрэг хүлээсэн байх ба талуудын хооронд заасанаас өөр байдлаар зарцуулахыг хориглосон байна. Мөн итгэмжлэгчийг татах зорилгоор олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилгаа явуулах, үр шимийн талаар олон нийтэд урьдчилан амлах зэргийг хориглосон байна. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 03 сарын 11-ний өдрийн №71 тоот тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 2 дугаар зүйлийн 2.15 дахь хэсгийг хангасан байна.

БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №09/17/01 тоот тогтоолоор "Үнэт цаасны бүтээгдэхүүний журам"-ыг баталсан байна. Өөрөөр хэлбэл нь өөрийн бэлэн мөнгө, активыг үнэгүйдлээс хамгаалах хүсэлтэй иргэн, хуулийн этгээд нь ББСБ-аас гаргасан хөөлттэй болон нээлттэй үнэт цаасыг худалдан авч хөрөнгөө шилжүүлэх, ББСБ нь төвлөрсөн хөрөнгийг өөрийн үйл ажиллагаанд зарцуулж тохирсон хугацаанд хүү төлж үнэт цаасаа анх тохирсон үнээр буцаан худалдан авахтай холбоотой үүсэх харилцаанд баримтлах зарчмыг уг журмаар зохицуулсан байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь хэсэгт[41] заасанаар ББСБ нь төлбөр тооцооны хэрэгсэл гаргаж болохыг заасан байна. Тус

[40] Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002)
7 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа
7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараах үйл ажиллагааг хэлнэ:
7.1.8. итгэлцлийн үйлчилгээ;
[41] Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002)
7 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа
7.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж дараах үйл ажиллагааг хэлнэ:

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023.05.12 БҮРТГЭВ Нууц баримт

Үнэт цаасны танилцуулга 2023-05-28 БҮРТГЭВ-02

журамд үнэт цаас нь 12 сар ба түүнээс дээш хугацаатай, зөвхөн төгрөгөөр гарахаар заасан ба хаалттай өрийн хэрэгслийн хувьд нийтэд сурталчилгаа хүргүүлэхыг хориглосон байна. Мөн хүү төлөлтийн давтамжийг жил, хагас жил, улирлаар байж болохоор оруулжээ. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 04 сарын 28-ны өдрийн №165 тоот тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3 болон 2.4 дэх заалтыг хангаж байна. Энэхүү журмын 5 дугаар зүйлд өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээнд тавих шаардлагыг тусгасан байх ба БИД ББСБ ХХК-ийн баталсан "Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ" нь хангаж байна.

БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 сарын 21-ний өдрийн №11/21 тоот тогтоолоор "Зээлийн бодлого"-ыг шинэчлэн баталсан байна. Уг Зээлийн бодлогод ББСБ-аас олгох зээлийг хэмжээний хувьд бичил зээл (15 сая төгрөг хүртэл), жижиг дунд зээл (15 сая төгрөгөөс дээш), хэрэглээний зээл гэж ангилсан байна. Зориулалтаар нь хэрэглээний болон бизнесийн гэж хуваасан байна. Нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ нь 300.00,000 (гурван зуун сая) төгрөг, хугацаа нь дээд тал нь 36 (гучин зургаан) сар байхаар зааж хязгаарлалт оруулж өгсөн байна. Энэхүү журамд зээлийн судалгаа, барьцаа хөрөнгөд тавигдах шаардлага, түүнийг хэрхэн үнэлэх, зээл олгох шийдвэр гаргалт, харилцагчийн эрх ашгийг хамгаалах тухай, зээлийг эргэн төлүүлэх, төлөлт хийх дараалал, зээлтэй холбоотой дүн шинжилгээ, мэдээллийн нууцлал зэрэг зохицуулалтыг нарийвчлан тусгасан байна.

БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 23-ны өдрийн №01/23 тоот тогтоолоор "Зээлийн хороодын ажиллах журам"-ыг шинэчлэн баталсан байна. Уг журмаар зээлийн ББСБ нь зээлийн хороо, дэд зээлийн хороо, салбар зээлийн хороотой байхаар заасан байна. Эдгээр хороодын ажиллах зарчим, хурлын ирц, шийдвэр хүчин төгөлдөр болох, эрх үүрэг зэргийг журамд нарийвчлан тусгасан байхаас гадна зээлийн хороод тус бүрийн зээл олгох хэмжээг дараах байдлаар тогтоож өгсөн байна. Үүнд салбар зээлийн хороод 30,000,000 (гучин сая) төгрөг хүртэл, дэд зээлийн хороо 50,000,000 (тавин сая) төгрөг хүртэл, зээлийн хороо 70,000,000 (далан сая) төгрөг хүртэл зээл олгох шийдвэр гаргах эрхтэй байна. Харин ТУЗ-ийн даргын бүрэлдэхүүнтэй зээлийн хороо нь 70,000,000 (далан сая) төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зээлийн шийдвэр гаргах эрхтэй байдаг байна.

Зээлийн бодлого, зээлийн хороодын ажиллах журамд нийцүүлэн БИД ББСБ ХХК-аас санал болгож буй зээлийн бүтээгдэхүүн тус бүр дээр зээлийн журмуудыг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр тус тус батлуулсан байна. Эдгээр зээлийн журмууд нь тухайн зээлийн бүтээгдэхүүний онцлог, зээлийн судалгаа, зээлийн хугацаа, зээлийн хэмжээ, барьцааны шаардлага мөн холбогдох зээлийн гэрээ зэргийг агуулсан байна. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн дээр дурдсан зээлийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмууд Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор баталсан "Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам"-д нийцсэн байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл ББСБ-ын тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны буюу итгэлцэл, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, гадаад валютын арилжаа, зээл болон санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмууд нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Банк бус санхүүгийн байгууллагын хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журамд тус тус нийцсэн байна.

(iv) <u>Санхүү, нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журам</u>

7.1.5. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах;

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК



273

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12 сар өдөр
БҮРТГЭВ
Нууц баримт

Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

БИД ББСБ ХХК-аас хуулийн фирмд ирүүлсэн санхүү нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журмууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт болон холбогдох бусад дүрэм журамд тус тус нийцсэн байна.

(v) <u>Мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журам</u>

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн эрсдэлийн удирдлага болон мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журмаас онцгойлон дурдвал БИД ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 10 сарын 14-ний өдрийн №10/14 тоот тушаалаар "Компьютер, техник хэрэгсэл, цахим аюулгүй ажиллагааны журам"-ыг баталсан. Энэхүү журмын хүрээнд компани нь өөрийн ажилтнууд болон харилцагчийн хувийн мэдээллийг нууцлан хамгаалах, хууль бусаар ашиглах, ашиглуулахгүй байх зохицуулалтыг тусгасан байна. Мөн ажилтнуудын харилцагчийн хувийн мэдээлэлд хандах эрх, хориглосон үйлдлийн жагсаалтыг оруулсан байна. Энэхүү журам нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуультай нийцсэн байна.

(vi) <u>Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд хамаарах дүрэм, журам</u>

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд БИД ББСБ ХХК-аас Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11 сарын 29-ний өдрийн №11/29 тоот тогтоолоор "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод журам"-ыг баталсан байна. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад[12] зааснаар 20,000,000 (хорин сая) төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг мэдээлэх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлэх үг журамд БИД нь 20,000,000 (хорин сая) төгрөг, түүнээс дээш үнийн дүн бүхий бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш 5 хоногийн дотор батлагдсан маягтын дагуу санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх тухай заасан байна. Мөн харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх, мэдээллийг хадгалах, хамгаалах талаар журамд тусгасан байна.

**Хуулийн фирмийн зүгээс БИД ББСБ ХХК-аас ирүүлсэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод журам нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуультай нийцсэн байна гэж үзлээ.**

(vii) <u>Бусад дүрэм, журам</u>

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн бусад дүрэм, журмаас "Шүгэл үлээлтийн бодлого"-ыг онцгойлон авч үзлээ. БИД ББСБ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 30-ны өдрийн №01/30 тоот тогтоолоор "Шүгэл үлээх бодлого"-ыг баталсан байна. Энэхүү Бодлогоор зохисгүй үйлдэлтэй холбоотой шүгэл үлээгчийн мэдээлсэн мэдээллийг хүлээн авах, шалгах, тогтоох, дахин давтагдахаас сэргийлэх, шүгэл үлээгчийг хамгаалах зэрэг харилцааг зохицуулахаар байна. Шүгэл үлээгчийн мэдээллийг 7 хоногийн 7 өдөр 24 цагаар авахаар зохицуулалт хийж тусгай дугаар, и-мэйл хаяг гаргасан байна. Зөвхөн харилцааг зохицуулсан уг журам нь компанийн ажилтан ямар нэг болгоомжлол, айх эмээх зүйлгүйгээр шүгэл үлээж мэдээлэл өгөх, цаг хугацаанд нь асуудлыг шийдвэрлэх зэрэг хүний нөөцийн бодлогын ач холбогдолтой байх тул нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.

**Нэгтгэн дүгнэвэл БИД ББСБ ХХК-ийн дотоод үйл ажиллагаандаа мөрдөж байгаа 53 (тавин гурав) дүрэм, журам нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл**

[12] Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013)
4 дүгээр зүйл. Мэдээлэх үүрэгтэй этгээд
4.1. Дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 15.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй:
4.1.2. банк бус санхүүгийн байгууллага

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023 он 05 сар 12 өдөр БҮРТГЭВ № 1 Нууц баримт

Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02

ажиллагааны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хуультай тус тус нийцсэн, эрх бүхий этгээдээс баталж мөрдүүлсэн байна гэж Хуулийн фирмийн зүгээс үзлээ.

Дөрөв. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд буюу 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 сарын 01-ний өдөр (цаашид "Гэрээг тасалбар болгосон өдөр" гэх)-өөр тасалбар болгон БИД ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээний жагсаалтыг гаргуулан авч жагсаалтаас өөрсдийн тогтоосон загварчлалын дагуу санамсаргүй түүврийн аргаар сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

БИД ББСБ ХХК-аас ирүүлсэн баримт материалаас үзвэл Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 24,730 (хорин дөрвөн мянга долоон зуун гучин) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Түүнчлэн 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 50 (тавин) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Иймд Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 24,780 (хорин дөрвөн мянга долоон зуун наян) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

*Хүснэгт №08: Сүүлийн 3 (гурван) жилийн дотор бусадтай бичгээр байгуулсан нийт хүчин төгөлдөр гэрээний тоон үзүүлэлт*

| № | Гэрээний нэр, төрөл | 2020.01.01-ний өдрөөс өмнө | 2020.01.01 – 2021.01.01 | 2021.01.01 – 2022.01.01 | 2022.01.01 – 2023.01.01 | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Өрийн гэрээ, худалдах, худалдан авах гэрээ болон Итгэлцлийн гэрээ | - | 6 | 69 | 403 | 478 |
| 2. | Санхүүжилт татах зээлийн гэрээ | | 2 | 2 | 1 | 5 |
| 3. | Зээлийн гэрээ | 50 | 175 | 3,528 | 20,471 | 24,224 |
| 4. | Санхүүгийн зөвлөхтэй хамтрал | - | 4 | 11 | 27 | 42 |
| 5. | Бусад гэрээ | - | 6 | 1 | 24 | 31 |
| | НИЙТ | 50 | 193 | 3,611 | 20,926 | 24,780 |

Хуулийн фирм нь БИД ББСБ ХХК-аас Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэж ирүүлсэн зээлийн гэрээний жагсаалтаас санамсаргүй түүврийн аргаар гэрээг сонгон авч гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээ байгуулах журам, гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

(i) БИД ББСБ ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардагдах итгэлцлийн гэрээ нь Иргэний хууль (цаашид "ИХ" гэх)-ийн 406 дугаар зүйлд[4] заасан хөрөнгө болон итгэлцлийн гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан

[4] Иргэний хууль (2002)
406 дугаар зүйл. Хөрөнгө итгэмжлэх гэрээ
[illegible]



БИД БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

275

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ ... Ирсэн бичиг

Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

(ii) Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээний хувьд Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 165 дугаар тогтоолоор баталсан "БИД ББСБ ХХК-аас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-д заасан нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын оны даргын 2021 оны 1

(iii) Зээлийн гэрээний хувьд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 19-27 дугаар зүйл[16], ИХ-ийн 281-283 дугаар зүйл[17], 451-453 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан зээлийн гэрээ болон зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан барьцааны гэрээний гол нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, барьцааг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, зээл олгох шийдвэр БИД ББСБ ХХК-ийн дотоод дүрэм, журамд заасны дагуу гарсан эсэх, холбогдох хууль тогтоомжид заасан хэлбэрийн шаардлага хангасан эсэх;

(iv) Гадаад улсын хууль тогтоомжийг удирдлага болгохоор заасан гэрээний хүчин төгөлдөр байдалд дүгнэлт өгөөгүй бөгөөд БИД ББСБ ХХК нь үнэт цаас гаргахын өмнө гэрээний нөгөө талд заавал мэдэгдэх эсэх, зөвшөөрөл авах эсэх;

(v) Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээний хувьд ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.1 дэх хэсэгт[18] заасан түрээсийн гэрээний гол нөхцөл болон Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн эсэх (үл хөдлөх эд хөрөнгийг хэсэгчлэн түрээслэх гэрээнд энэхүү шаардлага хамаарахгүй);

(vi) Худалдах, худалдан авах гэрээний хувьд ИХ-ийн 243-261 дугаар зүйлд заасан нөхцөл болон худалдах, худалдан авах гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх,

[16] Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021).
19 дүгээр зүйл.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн үйл ажиллагаа
20 дугаар зүйл.Зээлийн гэрээ
21 дүгээр зүйл.Зээлийн хүү
22 дугаар зүйл.Зээлийн хүүгийн хэрэг
23 дугаар зүйл.Зээлийн батлан даалт
24 дүгээр зүйл.Зээлийн барьцаа
25 дугаар зүйл.Зээлийг хугацаанаас нь өмнө буцаан төлөх
26 дугаар зүйл.Зээл төлүүлэх
27 дугаар зүйл.Зээлийг ангилах
[17] Иргэний хууль (2002).
281 дүгээр зүйл.Зээлийн гэрээ
281.1.Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.
282 дугаар зүйл.Зээлийн гэрээний хүү
282.1.Зээлийн гэрээгээр талууд тохиролцон хүү тогтоож болно.
282.2.Хуулийн этгээд нь зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн [illegible] зээлийн хүүг багасгаж болно.
282.3.Хуульд өөрөөр заагаагүй бол хүү тогтоосон бол зээлийн гэрээг бичгээр хийнэ. Энэ шаардлагыг хангаагүй бол хүү авах эрхээ алдана.
282.4.Мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлсэн өдрөөс зээлийн гэрээг байгуулсанд тооцно.
283 дугаар зүйл.Зээлийн гэрээний хугацаа
283.1.Зээлийн гэрээгээр зээлийг буцаан төлөх хугацааг тогтоогоогүй бол зээлдүүлэгчийн шаардсанаар зээлийг буцаан төлөх бөгөөд энэ тухай шаардсанаас хойш нэг сарын дотор зээлдэгч үүргээ биелүүлнэ.
283.2.Зээлийн гэрээгээр хүү тогтоогоогүй бол зээлдэгч хугацаанаас нь өмнө зээлийг буцаан өгч болно.
283.3.Зээлийн гэрээгээр хүү тогтоосон бол гагцхүү талууд урьдчилан тохирсон буюу зээлдүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд зээлийг хүүгийн хамт хугацаанаас өмнө буцаан өгч болно.
283.4.Гэрээнд өөрөөр заагаагүй бол зээлийн хүүг сар тутам төлнө.
[18] Иргэний хууль (2002).
318 дугаар зүйл.Түрээсийн гэрээ
318.1.Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон гэрээнд заасан зориулалтаар ашиглуулахад [illegible] эд хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээнд тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.



BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
6015948 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
2071031195 СТС2420

276

СЗХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ

Үнэт цаасны танилцуулга
2023 . 05 . 2 8
БҮРТГЭВ-02

агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;

(vii) Ажил гүйцэтгэх гэрээний хувьд ИХ-ийн хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх хэсэгт[17] заасан ажил гүйцэтгэх гэрээний гол нөхцөл болон ажил гүйцэтгэх гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;

(viii) Даатгалын гэрээний хувьд ИХ-ийн 431 дүгээр зүйлийн 431.4 дэх хэсэгт[18] заасан нөхцөл болон холбогдох даатгалын хуулиудад заасан нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, батлагдсан загварын дагуу бичгээр байгуулсан эсэх (батлагдсан загвараар байгуулах даатгалын гэрээний хувьд), талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

**Нэг. Хөрөнгө итгэмжлэх буюу итгэлцлийн гэрээ болон өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ**

БИД ББСБ ХХК-аас бусадтай байгуулсан хөрөнгө итгэмжлэх буюу итгэлцлийн гэрээ, өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээнд дүн шинжилгээ хийхдээ Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг баримталлаа. Мөн БИД ББСБ ХХК-ийн зүгээс итгэлцэл болон үнэт цаасны үйл ажиллагаатай холбоотой баталсан дараах дүрэм, журмыг удирдлага болголоо. Үүнд:

(i) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №09/17/01 тоот тушаалаар баталсан Итгэлцлийн үйлчилгээний журам;
(ii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №09/17/01 тоот тушаалаар баталсан Үнэт цаасны бүтээгдэхүүний журам;
(iii) Бусад холбогдох дүрэм, журам.

БИД ББСБ ХХК-ийн иргэн болон хуулийн этгээдтэй байгуулсан (i) хөрөнгө итгэмжлэх буюу итгэлцлийн гэрээ; (ii) өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ нь холбогдох хууль тогтоомж, БИД ББСБ ХХК-ийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

**(i) Итгэлцлийн гэрээ**

БИД ББСБ ХХК нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтад[19] заасанаар иргэд болон аж ахуйн нэгжээс хадгаламж татан төвлөрүүлэх хориотой. Харин хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, эрхийг түүний нэрийн өмнөөс өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн итгэмжлэн удирдаж ашиг олж өгөх итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой юм. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь хэсэгт итгэлцлийн үйлчилгээг "*итгэл хүлээлгэгчийн актив /бэлэн мөнгө, эзэл, бусад актив/-ыг*

[17] Иргэний хууль (2002).
343 дугаар зүйл. Ажил гүйцэтгэх гэрээ
343.1. Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар [illegible] ажил гүйцэтгэж, захиалагч нь үр дүнг хүлээн авч, тохиролцсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.
[18] Иргэний хууль (2002)
431 дүгээр зүйл. Даатгалын гэрээ
431.4. Даатгалын гэрээнд дараах нөхцөлийг тусгана:
431.4.1. даатгалын зүйл;
431.4.2. даатгалын эрсдэлийн төрөл;
431.4.3. даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ;
431.4.4. даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл;
431.4.5. даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа;
431.4.5. даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;
431.4.7. гэрээг дуусгавар болгох, цуцлах, түүний үр дагаврыг зохицуулах нөхцөл.
[19] Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002).
12 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хориглох зүйл
12.1. Банк бус санхүүгийн байгууллага дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:
12.1.3. иргэн, хуулийн этгээдээс хадгаламж авах, хадгаламжийн данс нээх;

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9021031195 СТС2420

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023 05 12 БҮРТГЭВ

Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02

*үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг тур хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг"* хэлнэ гэж тодорхойлсон байна. БИД ББСБ ХХК-ийн хувь хүн, хуулийн этгээдтэй байгуулсан нийт итгэлцлийн гэрээнээс гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар 441 (дөрвөн зуун дөчин нэг) ширхэг гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Хуулийн фирмийн зүгээс хувь хүн, хуулийн этгээдтэй байгуулсан итгэлцлийн гэрээ болон түүний хувийн хэрэг нэг бүрийг үзэж хувь хүн, хуулийн этгээдтэй байгуулсан БИД ББСБ ХХК-ээс баталсан гэрээний загварын дагуу ижил нөхцөл журмаар байгуулдаг тул Итгэлцлийн гэрээний батлагдсан загвартай танилцсан болно. Итгэлцлийн гэрээний загварыг БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №09/17/01 дугаартай тогтоолын "Итгэлцлийн үйлчилгээний журам"-ын 1 дүгээр хавсралтаар баталсан байна.

ИХ-ийн 406 дугаар зүйлд[41] хөрөнгө итгэмжлэх гэрээний зохицуулалтыг тусгасан байдаг. БИД ББСБ ХХК нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулах итгэлцлийн гэрээнд хугацаа, итгэмжлэлээр шилжүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ, валютын төрөл, итгэмжилсэн мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах зориулалт, үр шимийн хэмжээ, үр шимээс хувь хүртэх гуравдагч этгээд байгаа бол түүний нэр, хүртэх үр шимийн хэмжээ, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах нөхцөл зэргийг тодорхойлж зохицуулсан байна. Мөн итгэмжлэл гаргасан этгээд болон үр шимийг хүртэгч гуравдагч этгээд нь хүртсэн үр шимээсээ хуульд заасан татварыг төлөх үүрэгтэй болохыг зааж оруулжээ. БИД ББСБ ХХК нь итгэлцлийн дагуу шилжүүлэн авсан хөрөнгийг зөвхөн өөрийн үйл ажиллагаандаа ингэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрлийн хүрээнд захиран зарцуулахаа гэрээнд тусгасан байна. Итгэмжлэгдэгч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөс итгэмжлэгчийг хохиролгүй болгож өгөх заалтыг мөн тусгасан байна. Итгэлцлийн гэрээг талууд бичгээр байгуулан гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болдог нь ИХ-ийн холбогдох шаардлагыг хангаж байна.

**(ii) Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ**

Мөнгөний болон зохицуулалттай зах зээлд арилжихыг зөвшөөрсөн санхүүгийн хэрэгслийн нэг нь үнэт цаас юм. Тэгээд өрийн хэрэгсэл нь үнэт цаасны нэг ба Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад өрийн хэрэгслийг *"үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаа дуусмагц үндсэн төлбөр болон хүү мөнгөн хэлбэрээр, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр тухайн үнэт цаасыг эзэмшигчид эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн болон түүнтэй адилтгах бусад үнэт цаасыг"* хэлнэ гэж заасан байна. Өөрөөр хэлбэл БИД ББСБ ХХК нь нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг (хэрэгсэл)-ийг хөрөнгө оруулагчид санал болгож худалдах ба заасан хугацааны дараа хүү, үндсэн төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ. БИД ББСБ ХХК нь өрийн бичгийг худалдаж олсон орлогыг өөрийн үндсэн үйл ажиллагаанд зарцуулах үүрэгтэй байна. Харин өрийн бичиг худалдан авагч нь тухайн өрийн бичгийн бусдад шилжүүлэх, худалдах эрх эдлэх эрхтэй байдгаараа онцлогтой.

Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 37 (гучин долоо) ширхэг өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ байгааг БИД нь Хуулийн фирмд

---

[41] Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002).
406 дугаар зүйл. Хөрөнгө итгэмжлэх гэрээ
406.1 [illegible]
406.2 [illegible]
406.3 [illegible]
406.4 [illegible]
406.5 [illegible]
406.6 [illegible]

БИД БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК



УЛААНБААТАР ХОТ 5183855 9021031195 СТС2420

278

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12 өдөр
ГЭВ
Нууц баримт
Эх хувь

Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

мэдэгдсэн. Хуулийн фирмийн зүгээс БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №19/1 7/01 дугаартай тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Хаалттай эрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ"-ний төсөлтэй танилцсан болно. Учир нь Хаалттай эрийн бичиг худалдах, худалдан авах гэрээг БИД ББСБ ХХК-аас баталсан загварын дагуу ижил нөхцөл журмаар байгуулдаг байна.

Хаалттай эрийн бичиг худалдах, худалдан авах гэрээнд зорилгыг "БИД ББСБ ХХК буюу худалдагч нь өөрийн хөрөнгөөр баршуулсан худалдан авагчид хаалттай эрийн бичиг худалдан борлуулна. Уг эрийн бичгийг гаргахдаа түүний төрөл, хэмжээ, үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн авах үнэ зэргийг тогтоох ба гэрээнд талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагыг тогтооно" гэж заасан байна. Гэрээнд эрийн бичгийн нийт үнэ, жилийн хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эрийн бичгийн нийт үнийг төлж буцаан авах хугацаа зэргийг заасан байхаас гадна эрийн бичгээр төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг зөвхөн БИД ББСБ ХХК-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулах тухай нарийвчлан заасан байна. Мөн хаалттай эрийн бичиг өөр аж ахуйн нэгжээс тусгайлан гаргасан баталгаа байхгүй болохыг гэрээнд дурдсан байна. Эрийн хэрэгслийн онцлог нь түүнийг худалдан авсан этгээд өөр гуравдагч этгээдэд шилжүүлэх, худалдан борлуулах боломжтой байдаг. Гэсэн хаалттай эрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээнд худалдан авагч тал нь эрийн бичгийг бусдад шилжүүлэх, худалдан борлуулах эрхтэй байхаар заасан байна. Ингэхдээ анх байгуулсан гэрээний нөхцөл, зохицуулалтыг өөрчлөхгүй байх үүрэг оноосон нь холбогдох хуулийн шаардлагатай нийцэж байна. Худалдан авагч тал гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд мөрдөх хүүгийн хэмжээг тогтоосон байна. Үүнээс гадна БИД ББСБ ХХК нь хүү болон үндсэн төлбөрөө хугацаанд нь төлж чадаагүй бол алданги төлөх зохицуулалтыг тусгасан ба хэрэв худалдагч талд хохирол учруулсан бол өөрийн хөрөнгөөр хариуцан төлөх заалтыг мөн оруулсан байна.

Хаалттай эрийн бичиг худалдах, худалдан авах гэрээнд талууд гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

**Дүгнэж үзвэл БИД ББСБ ХХК-ийн итгэлцлийн гэрээ, эрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ нь холбогдох хууль тогтоомж болон БИД ББСБ ХХК-ийн дотоод дүрэм, журамд нийцсэн гэж үзлээ. Итгэлцэл болон эрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээнд БИД ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсан байх тул Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3 дахь хэсэг[41], Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэгт[42] тус тус заасны дагуу тухайн гэрээ, хэлцлийг хүчин төгөлдөр гэж дүгнэлээ.**

**Хоёр. Зээлийн гэрээ**

БИД ББСБ ХХК-аас ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээнээс үзвэл нийт 5 (тавaн) зээлийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Өөрөөр хэлбэл БИД ББСБ нь өөрийн үйл ажиллагаанд зориулж бусад хуулийн этгээдээс авсан зээл, зээлийн гэрээ юм. Энэхүү зээлийн гэрээний мэдээллэлтэй **Хавсралт №02. "Хавсралт №01. "Бизнес Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн бусдаас санхүүжилт татсан зээлийн гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

---

[41] **Иргэний хууль (2002).**
62 дугаар зүйл. **Хамтад төлөөлөл**
62.3. Төлөөлөгчийн бүрэн эрх хуулийн дагуу буюу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ.
[42] **Компанийн тухай хууль (2011).**
83 дугаар зүйл. **Гүйцэтгэх удирдлага**
83.8. Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэрэг эд компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

БИД БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО ХУУЛЬ ХХК
5183855 9021031195 СТС2420

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
он сар өдөр
2023 05 13

Эх хувь

Үнэт цаасны танилцуулга 2023-03-28
БҮРТГЭВ-02

Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн 2023 оны 02 сарын 08-ны өдрийн дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл БИД ББСБ ХХК нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс авсан нийт 2 (хоёр) зээл төлөгдөж дуусаагүй өр төлбөрөөр бүртгэлтэй бөгөөд хэвийн ангилалтай байна.

Компаниас ирүүлсэн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа зээлийн гэрээнээс 2 (хоёр) зээлийн гэрээ нь Худалдаа, Хөгжлийн банктай байгуулсан Зээлийн эрх нээх гэрээ, нөгөө 3 (гурав) гэрээ нь гадны санхүүгийн байгууллагаас авсан зээлийн гэрээ байна. Үүнд:

(i) Худалдаа, Хөгжлийн банк, Зээлийн эрх нээх гэрээ, 2020 он;
(ii) Худалдаа, Хөгжлийн банк, Зээлийн эрх нээх гэрээ, 2020 он;
(iii) Arbor FS Ltd, Зээлийн гэрээ, 2020 он;
(iv) EMF Microfinance Fund, AGmvK, Зээлийн гэрээ, 2021 он,
(v) Microfinance Enhanvement Facility SA, SICAV-SIF, Зээлийн гэрээ, 2022 он.

Хуулийн фирмийн зүгээс БИД ББСБ ХХК-ийн гадны санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээнд үнэлэлт, дүгнэлт өгөхгүй болно. Учир нь эдгээр гэрээнд өөр улсын хуулийг хэрэглэхээр заасан ба маргаан гарсан тохиолдолд гадаад улсын шүүхээр шийдвэрлүүлэхээр заасан байна.

БИД ББСБ ХХК-ийн Худалдаа, Хөгжлийн банктай байгуулсан Зээлийн шугамын гэрээний хувьд тухайн банкнаас боловсруулсан зээлийн гэрээний загварыг ашигласан байна. Зээлийн шугамын гэрээгээр зээлдэгчид тодорхой хугацаанд зээлийн эрхийн дээд хэмжээг зааж өгөх байдлаар зээл авах эрхийг олгодог. Энэ хугацаанд зээлдэгч нь зээлийн эрхийн хэмжээнд багтаан зээл авах буцаан төлөх харилцааг хэдэн ч удаа үүсгэж болдог онцлогтой. Мөн энгийн зээлийн гэрээнээс ялгаатай нь зээлийн шугамын данснаас зарлагын гүйлгээ хийснээр зээлийг олгосонд тооцдог ба ашиглаагүй зээлийн эрхийн үлдэгдэлд жилийн буюу 365 (гурван зуун жаран таван) хоногт тогтмол хувиар шимтгэл төлдөг. Зээлийн шугамын гэрээний бусад зохицуулалт нь зээлийн гэрээтэй ижил байна. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт зээлийг зээлийн шугам хэлбэрээр олгож болохоор зохицуулсан байна. Дээрх 2 зээлийн шугамын гэрээнд зээлийн гэрээнд тавигдах бүхий л шаардлагыг хангасан байх ба үүргийн гүйцэтгэлийг хангуулахын тулд үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ болон батлан даалтын гэрээг мөн байгуулсан байна.

**Дүгнэж үзвэл БИД ББСБ ХХК-ийн Худалдаа, Хөгжлийн банкнаас авсан Зээлийн шугамын 2 (хоёр) гэрээ нь холбогдох хуульд нийцсэн бөгөөд хэвийн ангилалтай зээл байна гэж үзлээ.**

**Гурав. Үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээ**

БИД ББСБ ХХК-аас бусадтай байгуулсан бүх төрлийн (i) зээлийн гэрээ, барьцаат зээлийн гэрээ; (ii) барьцааны гэрээ; (iii) ипотекийн гэрээ; (iv) фидуцийн гэрээнд дүн шинжилгээ хийхдээ Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, дагалдан гарсан бусад дүрэм, журмуудыг баримталлаа. Мөн БИД ББСБ ХХК-ийн зүгээс зээлийн үйл ажиллагаатай холбоотой баталсан дараах дүрэм журмуудыг удирдлага болголоо. Үүнд:

(i) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны №11/21 тоот тогтоолоор батлагдсан Зээлийн бодлого;
(ii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны №01/23 тоот тогтоолоор батлагдсан Зээлийн хорооны ажиллах журам;
(iii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №04/04 тоот тогтоолоор батлагдсан Санхүүгийн түргэн тусламжийн зээлийн журам,

БИД БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК
280
5183855
9021031195 СТС2420

(iv) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №04/04 тоот тогтоолоор батлагдсан Бизнес эхлэлтийн зээлийн журам,

(v) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №04/04 тоот тогтоолоор батлагдсан Автомашины барьцаат зээлийн журам,

(vi) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №04/04 тоот тогтоолоор батлагдсан Сайн харилцагч, гишүүнчлэлийн зээлийн журам,

(vii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №04/04 тоот тогтоолоор батлагдсан Бизнес хөгжлийн зээлийн журам,

(viii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №04/04 тоот тогтоолоор батлагдсан Итгэлцэл барьцаалсан зээлийн журам,

(ix) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №04/04 тоот тогтоолоор батлагдсан Цалингийн зээлийн журам,

(x) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №04/04 тоот тогтоолоор батлагдсан дугаартай Ажилтны лизингийн зээлийн журам,

(xi) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №04/04 тоот тогтоолоор батлагдсан Аялалын зээлийн журам,

(xii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №05/28 тоот тогтоолоор батлагдсан Ногоон зээлийн журам,

(xiii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №05/28 тоот тогтоолоор батлагдсан Шуурхай зээлийн журам,

(xiv) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №05/28 тоот тогтоолоор батлагдсан Боловсролын дэмжих зээлийн журам,

(xv) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны №05/06 тоот тогтоолоор батлагдсан Автомашины хэрэглээний зээлийн журам,

(xvi) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны №05/06 тоот тогтоолоор батлагдсан Автомашины лизингийн зээлийн журам,

(xvii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны №11/02 тоот тогтоолоор батлагдсан Улсын дугаартай автомашины лизингийн болон хэрэглээний зээлийн журам,

(xviii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны №02/16 тоот тогтоолоор батлагдсан Эко зээлийн журам,

(xix) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны №12/01 тоот тогтоолоор батлагдсан Онлайн зээлийн журам,

(xx) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны №12/01 тоот тогтоолоор батлагдсан Үл хөдлөх хөрөнгийн санхүүжилтийн зээлийн журам

Энэхүү бүлэгт БИД ББСБ ХХК-ийн эрхэн болон хуулийн этгээдтэй байгуулсан бүх төрлийн зээлийн гэрээг хууль тогтоомж, БИД ББСБ ХХК-ийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх болно.

БИД ББСБ ХХК-аас ирүүлсэн жагсаалтаас үзвэл тасалбар болгосон өдрийн байдлаар 24,224 (хорин дөрвөн мянга хоёр зуун хорин дөрвөн) зээлийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Зээлийн гэрээг зээлийн бүтээгдэхүүний төрлөөр ангилан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт №09. Сүүлийн 3 (гурван) жил бүтээгдэхүүнээр байгуулсан хүчин төгөлдөр зээлийн гэрээний дүн, тоон үзүүлэлт*

| № | Төрөл | 2020.01.01-ний өдрөөс өмнөх | 2020.01.01 - 2021.01.01 | 2021.01.01 - 2022.01.01 | 2022.01.01 - 2023.01.01 | НИЙТ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Санхүүгийн түргэн тусламжийн зээл | 19 | 26 | 408 | 1,770 | 2,223 |
| 2. | Бизнес хөгжлийн зээл | 2 | 7 | 47 | 252 | 308 |
| 3. | Бизнес хөрөнгө оруулалтын зээл | 0 | 0 | 13 | 46 | 59 |
| 4. | Бизнес эхлэлтийн зээл | 1 | 4 | 60 | 124 | 189 |
| 5. | Сайн харилцагчийн гишүүнчлэлийн зээл | 2 | 12 | 139 | 568 | 721 |
| 6. | Автомашины [illegible] | [illegible] | 124 | 357 | 397 | 904 |

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12
Нууц баримт
Эх хувь

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | Автомашины хэрэглээний зээл | | | 1 | 39 | 40 |
| 8 | Ажилтны лизингийн зээл | | | | 2 | 2 |
| 9 | Аялалын зээл | | | | 1 | 1 |
| 10 | Боловсролын дэмжих зээл | | | | 5 | 5 |
| 11 | Итгэлцэл барьцаалсан зээл | | | | 8 | 8 |
| 12 | Лизингийн зээл | | | | 897 | 897 |
| 13 | Ногоон зээл | | 1 | 2 | 20 | 23 |
| 14 | Эко зээл | | | 19 | 334 | 353 |
| 15 | Цалингийн зээл | | 1 | 2 | 20 | 23 |
| 16 | Онлайн зээл | | | 2480 | 15968 | 18,468 |
| 17 | Гэр хорлох хөрөнгийн санхүүжилтийн зээл | | | | | |
| 18 | Шугамын зээл | | | | | |
| | НИЙТ | 50 | 175 | 3528 | 20,471 | 24,224 |

БИД ББСБ ХХК-аас ирүүлсэн гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар байгуулсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй зээлийн гэрээний жагсаалтаас санамсаргүй түүврийн аргаар 54 (тавин дөрвөн) гэрээг сонгон авч үзэж танилцлаа. Энэхүү гэрээний мэдээлэлтэй Хавсралт №03. **"Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан зээлийн гэрээний мэдээлэл"** хэсэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

БИД ББСБ ХХК нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бичил, жижиг дунд бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн эрэлт хэрэгцээг хангасан, ялгарахуйц зээлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх тухай "Зээлийн бодлого"-доо тодорхой тусгасан байна. Зээлийн үйл ажиллагааг зориулалтаар нь бизнесийн болон хэрэглээний гэж ангилан ангилал бүрээр зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлсэн байна. БИД ББСБ ХХК нь Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар 18 (арван найман) төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож гэрээ байгуулсан ба гэрээ байгуулахдаа "Зээлийн бодлого"-д заасны дагуу хот суурин газрын бичил, жижиг дунд бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдэд санал болгосон байна.

БИД ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн 2023 оны №01/02-01 тоот тогтоолоор БИД-ийн хэмжээнд хийгдэж буй зээлийн гэрээнүүд болон, фидуцийн гэрээнүүдийн загварыг тус тус шинэчлэн баталсан байна.

**(I) Зээлийн гэрээ**

ИХ-ийн 281-285 дугаар зүйлд зээлийн гэрээний зохицуулалтыг заасан ба 451-453 дугаар зүйлд БИД ББСБ ХХК-аас зээл олгох гэрээний зохицуулалтыг нэмж тусгасан байдаг. Мөн Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19-26 дугаар зүйлд БИД ББСБ ХХК-ийн зээлийн үйл ажиллагаа, зээлийн гэрээ, зээлийн хүүгийн хэргийн талаарх зохицуулалтыг илүү нарийвчлан заасан байна.

БИД ББСБ ХХК нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулах зээлийн гэрээгээр тодорхой хугацаа, хүү, үүргийн гүйцэтгэлийг хангах арга, зориулалттайгаар мөнгөн хөрөнгө зээлдүүлэх, зээлдэгч зээлийг хүү, тооцогдсон бол нэмэгдүүлсэн хүүгийн хамт эргэн төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж зохицуулсан байна. Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь зээлийн бүтээгдэхүүнээс хамааран харилцан адилгүй байж болохоор БИД өөрөө тогтоосон байна. Нэмэгдүүлсэн хүүний хувьд үндсэн хүүгийн 20% иар тооцож авахаар зээлийн гэрээнд тусгажээ. Дээрх заалтууд нь ИХ-ийн 282 дугаар зүйлийн 282.1, 452 дугаар зүйлийн 452.1-2 дахь хэсэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 20 дугаар зүйлийн 20.2.3-7 дахь хэсэгтэй нийцэж байна.

Зээлийн гэрээнд зээлийн дүн, валютын төрөл, гэрээний хугацаа, зээлийн зориулалт, тухайн зээлийг хүлээн авах банк, данс, талуудын оршин байгаа, оршин суугаа газрын хаягийн мэдээлэл зэргийг оруулахаар заасан нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж,



БИД БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
CTC2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1-12 дугаар заалтыг хангаж байна. ИХ-ийн 283 дугаар зүйлийн 283.3 дахь хэсгийг 2022 оны 11 сарын 04-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон ба 2023 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх тул Зээлийн гэрээнд зээлдэгч нь авсан зээлээ хугацаанаас нь өмнө төлөх эрхгүй байх заалтыг оруулж өгөхийг Хуулийн фирмийн зүгээс зөвлөж байна.

ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.5-д хүүгээс анз тооцохгүй байх тухай заасан. Өөрөөр хэлбэл зээлдэгч нь үүргээ гүйцэтгэх хугацаа хэтрүүлсэн тохиолдолд нэмэгдүүлсэн хүү төлөх ба нэмж анз төлөхгүй. Зээлийн гэрээнд зөвхөн нэмэгдүүлсэн хүүгийн талаар заасан ба ямар нэгэн анзын талаар дурдаагүй нь хуулийн дээрх зохицуулалттай нийцэж байна. БИД нь зээлийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хангах арга болгож барьцааны гэрээ, ипотекийн гэрээ, фидуцийн гэрээ, батлан даалтын гэрээнээс аль нэгийг байгуулах эсхүл дурдсан бүх гэрээг байгуулж болохоор заасан байна. Эдгээр гэрээ нь тусдаа бие даасан зохицуулалттай бөгөөд зээлийн гэрээний салшгүй нэг хэсэг юм. Мөн зээлдэгч хүсвэл зээлийн гэрээг нотариатаар гэрчлүүлж болох ба дээрх дагалдах гэрээг төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, холбогдох хураамж болон гарах зардлыг зээлдэгч хариуцахаар зохицуулсан байна.

БИД ББСБ ХХК-ийн барьцаат зээлийн гэрээ нь зээлийн гэрээтэй ижил зохицуулалттай боловч зээлийн зориулалтын дагуу худалдан авсан хөрөнгөө барьцаалуулдаг онцлогтой. Мөн барьцаа хөрөнгийг даатгуулж даатгалын хураамжийг зээлдэгч тал хариуцахаар барьцаат зээлийн гэрээнд заасан байна. Хэрэв гэрээний хугацаанд даатгалын тохиолдол үүсвэл даатгагчаас олгох нөхөн төлбөрөөс тэргүүн ээлжид зээлдэгчээс БИД ББСБ ХХК-ийн өмнө гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнг үл маргах журмаар суутган төлүүлэхээр зохицуулсан байна. Барьцаат зээлийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцааны гэрээ, фидуцийн гэрээ, батлан даалтын гэрээг байгуулж болохоор заасан. БИД ББСБ ХХК-ийн зүгээс мөн итгэлцэл барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож гэрээ байгуулдаг ба уг гэрээ нь зохицуулалтын хувьд барьцаат зээлийн гэрээтэй ижил байна.

**(ii) Батлан даалтын гэрээ**

Батлан даалтын гэрээгээр зээлийн гэрээний дагуу төлбөрийн үүрэг хүлээсэн зээлдэгч үүргээ зөрчсөн буюу үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй эсхүл үүргээ гүйцэтгэж чадахгүй нь илт болсон тохиолдолд батлан даагч нь БИД ББСБ ХХК-ийн шаардлагын дагуу төлбөрийн үүргийг хамтран хариуцахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

ИХ-ийн 459 дүгээр зүйлийн 459.3 дахь хэсэгт батлан даалтын гэрээнд батлан даагчийн хүлээх хариуцлагын дээд хэмжээг заана гэсэн байна. Мөн хуулийн 460 дугаар зүйлийн 460.4 дэх хэсэгт батлан даагч нь батлан даалтын гэрээнд заасан хэмжээгээр хариуцлага хүлээнэ гэсэн байна. Батлан даалтын гэрээнд зээлийн гэрээний үүргийг бүхэлд нь батлан даагч талаас шаардаж болохоор БИД-ийн зүгээс оруулсан байна. Батлан даалтын гэрээнд батлан даагчийн хамтран хариуцах үүргийн хэмжээ нь зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөр, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр, барьцаа хөрөнгийг хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх, худалдан борлуулахтай холбоотой БИД ББСБ ХХК-ийн гарсан зардал, зээлийн гэрээтэй холбоотой үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбоотойгоор БИД ББСБ ХХК-д учирсан хохирол, зардал, БИД ББСБ ХХК-аас гарсан бусад зардлуудын нийлбэр дүнтэй тэнцүү байхаар заасан байна. Гэрээний энэхүү заалт нь ИХ-ийн 460 дугаар зүйлийн 460.5 дахь хэсэгт заасан зохицуулалттай зөрчилдөхгүй байна. Хэрэв зээлдэгч зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас батлан даагч нь батлан даалтын гэрээний дагуу зээлдэгчийн хүлээсэн үүргийг бүрэн биелүүлсэн бол зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг зээлдэгчээс шаардах бүх эрх батлан даагчид шилжихээр байна.

Батлан даалтын гэрээнд зээлдэгч үндсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд батлан даагчид энэ тухай мэдэгдэх үүргийг БИД ББСБ ХХК хүлээхээр байна. Мөн батлан даагч нь ямар ч тохиолдолд зээлдэгчийн зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн биелэлтийн талаарх



BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5183855
CTC2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

мэдээллийг БИД ББСБ ХХК-аас авах эрхтэй БИД ББСБ ХХК нь зээлдэгчийн хүлээсэн үүрэг болон үүргийн биелэлтийн талаарх үнэн зөв мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээсэн байна. Энэ нь ИХ-ийн 462 дугаар зүйлийн 462.1.2 дахь заалтын дагуу байна. Уг гэрээнд зээлдэгч нь зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй тухай мэдэгдлийг батлан даагчид өөрт нь бичгээр гардуулсан, утсаар мэдэгдсэн, гэрийн хаягаар эсхүл түүний цахим шуудангаар илгээснийг БИД ББСБ ХХК мэдэгдэл хүргүүлсэн, батлан даагч мэдэгдэл хүлээн авсанд тооцохоор заасан байна. Мөн зээлийн гэрээнд орсон өөрчлөлтийг тухай бүр батлан даагчид мэдээлэх үүргийг БИД ББСБ ХХК хүлээсэн ба зээлийн гэрээнд өөрчлөлт орсон нь батлан даагч батлан даалтын гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй юм.

Батлан даалтын гэрээгээр зохицуулагдаагүй, орхигдсон бусад асуудлыг Иргэний хуульд заасны дагуу зохицуулахаар гэрээнд тусгасан байна.

(iii) Барьцааны гэрээ (хөдлөх эд хөрөнгө болон эрх)

Барьцааны гэрээгээр БИД ББСБ ХХК болон зээлдэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээний төлбөрийн үүргээ зээлдэгч тал нь гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол барьцаалуулагч нь барьцааны хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хууль болон гэрээнд заасны дагуу хангахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Барьцааны гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг дарж баталгаажуулах ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг бичгээр байгуулна гэж заасан бол Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг болон 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны барьцааны гэрээг бичгээр байгуулах ба талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэн барьцааны эрх үүснэ гэж зүйлчилсэн байна. Барьцааны гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

ИХ-ийн 154 дүгээр зүйлийн 154.1 дэх хэсэг болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт барьцааны зүйлийг иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа эсхүл ирээдүйд бий болох эд хөрөнгө болон бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх байж болно гэж заасан. Тэгвэл БИД ББСБ ХХК-ийн зүгээс боловсруулсан барьцааны гэрээнд барьцааны зүйлийг барьцаалуулагчийн хууль ёсны өмчлөлийн эрхийн болон биет байдлын доголдолгүй хөдлөх эд хөрөнгө болон эрх, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйлийг хамтад нь ойлгохоор тусгасан байна. Барьцааны гэрээг байгуулах үед барьцаа хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байгаа бол хамгийн өмчлөгч тус бүрээс холбогдох зөвшөөрлийг авч баталгаажуулан барьцааны гэрээнд хавсаргахаар зохицуулсан байна.

ИХ-ийн 156 дугаар зүйл болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлд[43] барьцааны гэрээнд заавал тусгах агуулгыг заасан ба БИД ББСБ ХХК-ийн байгуулж буй барьцааны гэрээнд дээрх бүх агуулга багтсан байна.

[43] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).
10 дугаар зүйл. Барьцааны гэрээний агуулга
10.1 Барьцааны гэрээг Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуульд заасны дагуу бичгээр байгуулах бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:
10.1.1 барьцаалагч болон барьцаалуулагч нь иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газрын хаяг;
10.1.2 барьцаагаар хангах үүрэг, гэрээ байгуулах үед мэдэгдэж байгаа бол барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээ;
10.1.3 барьцаалагч, барьцаалуулагч талууд гэрээнд барьцаагаар хангах үүргийн хэмжээг тусгах, эсхүл өөрчлөгдөж болохоор тохиролцсон бол түүнийг тодорхойлох журам, бусад нөхцөл;
10.1.4 барьцааны зүйлийн тодорхойлолт, түүний нэр төрөл, эсхүл төрлийн шинжээр тодорхойлогдох байдал;
10.1.5 барьцааны гэрээний үйлчлэх хугацаанд барьцааны зүйлийг эзэмшилдээ байлгах тал;
10.1.6 барьцааны гэрээ байгуулсан он, сар, өдөр.
10.2 Дараах этгээдийн талаар энэ хуулийн 10.1.1-д заасан мэдээллийг барьцааны гэрээнд тусгана:
10.2.1 үүрэг гүйцэтгэгч нь барьцаалуулагч биш бол үүрэг гүйцэтгэгчийн;
10.2.2 барьцааны зүйл нь дундын хөрөнгө бол дундаа өмчлөгчдийн;
10.2.3 үүрэг гүйцэтгүүлэгч буюу барьцаалагч нь хэд хэдэн этгээд бол үүрэг гүйцэтгүүлэгчдийн.

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
СТС2420
284

BiD BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-05-28
БҮРТГЭВ-02



Барьцаа хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үндсэн зээлийн хэмжээ, хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх, шүүхийн зардал, барьцаа хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой төлсөн татвар, хураамж болон БИД ББСБ ХХК-иас гарсан зардал, хохирлын хэмжээ зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр барьцааны гэрээнд оруулсан байна. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтад барьцааны гэрээнд барьцаагаар хангагдах шаардах үүргийн хэмжээг тусгана гэж заасныг гэрээний дээрх заалт хангаж байна.

Барьцааны гэрээнд барьцаа хөрөнгийг барьцаалуулагч нь өөрийн эзэмшилд байлган бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах ба барьцаа хөрөнгийг барьцааны гэрээний хугацаанд даатгуулах үүргийг хүлээлгэсэн байна. Харин БИД ББСБ ХХК нь барьцаа хөрөнгийн барьцааны мэдэгдэл, тэмдэглэлийг цахим мэдээллийн санд бүртгүүлж барьцааг баталгаажуулах үүрэг хүлээсэн. Энэ тухай Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт зүйлчилсэн байна.

Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд БИД ББСБ ХХК нь барьцаа хөрөнгөөс үүргийг хангуулах эрхтэй болох ба ингэхдээ зээлдэгчид зээлийн гэрээний үүргийг гүйцэтгэх хугацаа зааж, барьцаанаас үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай мэдэгдлийг барьцаалуулагч талд мэдэгдэхээр барьцааны гэрээнд заасан байна. Энэ нь ИХ-ийн 158 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 47-49 дүгээр зүйлтэй нийцэж байна. БИД ББСБ ХХК нь барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангуулахдаа ийнхүү ажиллагаа эхлүүлсэн тухай тэмдэглэлийг цахим мэдээллийн санд оруулж, бүртгэлээр баталгаажсан бусад барьцаалагчид мэдэгдэхээр гэрээнд зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл барьцааны зүйлийг цаашид худалдан борлуулах тухай бусад барьцаалагчид мэдэгдэнэ гэсэн үг юм. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 50 дугаар зүйлд мэдэгдэлтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан заасан ба гэрээний дээрх заалт нь нийцэж байгааг тэмдэглэж байна. Барьцааны зүйлийг хэд хэдэн этгээд барьцаалсан байж болох ч хамгийн түрүүнд барьцаалсан этгээд барьцааны зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй байдаг. Энэ тухай ИХ-ийн 158 дугаар зүйлийн 158.1 дэх хэсэгт *"Барьцааны зүйл нь хэд хэдэн этгээдэд барьцаалагдсан бол хамгийн түрүүнд түүнийг барьцаалсан этгээд уг зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй"* гэж тодорхойлсон байна.

БИД ББСБ ХХК нь барьцааны зүйлийг худалдан борлуулах зохицуулалтыг ИХ-ийн 159 дүгээр зүйл[44], Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 54 дүгээр зүйлд[45] заасантай нийцүүлэн барьцааны тухай гэрээнд заасан байна. ИХ-ийн 156 дугаар зүйлийн

10.3 Барьцааны гэрээнд барьцаалагч, барьцаалуулагч, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.
10.4 Бичгээр байгуулаагүй барьцааны гэрээ хүчин төгөлдөр бус байна.
[44] Иргэний хууль (2002).
159 дүгээр зүйл. Барьцааны зүйлийг худалдах
159.1. Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцааны зүйлийг энэ хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаагаар худалдана.
159.2. Барьцаалуулагч шаардсан бол барьцааны зүйлийг худалдсаны дараа түүний үнэлгээг шинжээчээр тогтоосон болон бусад холбогдох зардлыг барьцаалуулагч хариуцна.
159.3. Барьцааны зүйлийг худалдах ажиллагаанд барьцааны зүйлийн өмчлөгч оролцож, уг зүйлээ худалдан авах санал гаргаж болно.
159.4. Барьцааны зүйлийн үнийг төлөөгүй тохиолдолд худалдан авах эрхээ алдаж, дуудлага худалдаанд оролцогчдод тайлбарласан байвал зохино.
159.5. Барьцааны зүйлийг хууль зөрчиж, шударга бус аргаар олж авсан этгээдэд барьцааны зүйл эрхийн хамгаалалтгүйгээр шилжинэ.
[45] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).
54 дүгээр зүйл. Барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг хуваарилах
54.1. Барьцааны зүйлийг энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу худалдан борлуулахтай холбогдон гарсан зардлыг төлсний дараа барьцаалагч нь барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг өөрийн болон бусад барьцаалагчийн барьцааны шаардлагыг энэ хуульд заасан дарааллын дагуу хангаж, үлдэгдлийг нь барьцаалуулагчид олгоно.
54.2. Энэ хуулийн 54.1-д зүйлд заасны дагуу барьцааны зүйлийг худалдан борлуулснаас олсон орлогыг хуваарилахаас 10-аас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 50.1-т заасан этгээдэд орлого хуваарилах он, сар, өдөр, газар, орлого хуваарилахад гаргах шаардлага, нотлох баримтыг хүргүүлэх болон хамгийн талаарх мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд уг мэдэгдлийг энэ хуулийн 50.1-т заасан мэдэгдэлтэй хамт, эсхүл тусад нь хүргүүлж болно.
54.3. Барьцаалагч энэ хуулийн 54.1-д заасны дагуу барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг хуваарилахдаа дараах дарааллыг баримтална.

BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
СТС2420

2023.05.12
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж болно гэж заасны дагуу нотариатаар гэрчлүүлж холбогдон гарах зардлыг барьцаалуулагч тал хариуцахаар зохицуулжээ.

**(iv) Ипотекийн гэрээ (үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа)**

Ипотекийн гэрээгээр БИД ББСБ ХХК болон зээлдэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээний төлбөрийн үүргээ зээлдэгч тал нь гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол барьцаалуулагч нь барьцааны үл хөдлөх хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хууль болон гэрээнд заасны дагуу хангахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Ипотекийн гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг дарж баталгаажуулж улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1-2 болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан гэрээг заавал бичгээр байгуулж бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байхыг шаардсан ба талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэн барьцааны эрх үүснэ гэж тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан байна. Ипотекийн гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргааныг шүүхээс шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

ИХ-ийн 154 дүгээр зүйлийн 154.1 дэх хэсэг болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт барьцааны зүйлийг барьцаалуулагчийн өмчлөлд байгаа ИХ-ийн 84.3 дахь хэсэгт заасан үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрх байна гэж заажээ. Тэгвэл БИД-ийн зүгээс боловсруулсан ипотекийн гэрээнд барьцааны зүйлийг барьцаалуулагчийн хууль ёсны өмчлөлийн эрхийн болон биет байдлын доголдолгүй үл хөдлөх эд хөрөнгө, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйл, засан сайжруулалтыг хамтад нь ойлгохоор тусгасан байна. Ипотекийн гэрээг байгуулах үед барьцаа хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байгаа бол хамтран өмчлөгч тус бүрээс холбогдох зөвшөөрлийг авч баталгаажуулан ипотекийн гэрээнд хавсаргахаар зохицуулсан байна.

ИХ-ийн 156 дугаар зүйл болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлд[46] ипотекийн гэрээнд заавал тусгах агуулгыг заасан ба БИД-ийн байгуулж буй ипотекийн гэрээнд дээрх бүх агуулга багтсан байна.

---

54.3.1.Барьцааны зүйлийг эзэмшилдээ авах, хадгалах, худалдан борлуулахтай холбогдон гарсан бодит зардал;
54.3.2.энэ хуульд заасан хүүгээс өмнөх дараалын шаардлага;
54.3.3.барьцааны эрхийг хэрэгжүүлэх байгаа барьцаалагчийн хэрийн шаардлага;
54.3.4.барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг хуваарилахаас өмнө энэ хуулийн 54.2-т заасан мэдэгдэл, нотлох баримт ирүүлсэн дараалын хувьд дараах бусад барьцаалагчийн шаардлага.

[46] Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай (2009)
11 дүгээр зүйл.Барьцааны гэрээний агуулга
11.1.Барьцааны гэрээ /цаашид "гэрээ" гэх/-г Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуулийг баримтлан бичгээр байгуулах бөгөөд түүнд Иргэний хуулийн 156.2-т заасныг хадгаа дараах зүйлийг тусгана:
11.1.1.барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, хэрэв уг бүтэн төлбөрийн хэмжээг урьдчилан тогтоогоогүй бол түүнийг тодорхойлох журам;
11.1.2.барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх хугацаа, үүрэг нь өөр гэрээнд үндэслэсэн бол уг гэрээний талууд, гэрээ байгуулсан он, сар, өдөр, түүнтэй холбоотой бусад нөхцөл;
11.1.3.барьцааны зүйлийн байршил, тухайн зүйл нь барьцаалуулагчийн өмч мөн болохыг нотлох баримт, эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгэсэн байгууллагын нэр, өмчлөх эрхийн гэрчилгээний дугаар;
11.1.4.барьцааны зүйлийг өөр этгээдэд барьцаалуулсан эсэх тухай мэдээлэл;
11.1.5.барьцаагаас хангагдах үүргийг хэсэгчлэн гүйцэтгэх бол төлбөр гүйцэтгэх хугацаа, давтамж, хэмжээ, эсхүл тэдгээрийг тодорхойлох журам;
11.1.6.барьцааны шаардлагыг хангах журам;
11.1.7.барьцаалагчийн эрх нь барьцааны баримт гэрчлэгдэх эсэх тухай заалт;
11.1.8.барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх бол тухайн эрхийг олж авсан гэрээний үндсэн нөхцөл, хугацаа;
11.1.9.барьцааны зүйлтэй холбоотой гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх;
11.1.10.бусад.
11.2.Хуульд заасан бөгөөд талууд гэрээгээр тохиролцсон бол барьцааны зүйлээс шаардлагыг шүүхээс гадуур хангаж болно.
11.3.Энэ хуулийн [illegible] барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдах эсэх талаар нарийвчлан заана.



BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР
5013346

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
9021031195 СТС2420

286

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.03.12
БҮРТГЭВ

Үнэт цаасны танилцуулга 2023 03 28
БҮРТГЭВ-02

Барьцаа хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үндсэн зээлийн хэмжээ, хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх, шүүхийн зардал, барьцаа хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой төлсөн татвар, хураамж болон БИД ББСБ ХХК-аас гарсан зардал, хохирлын хэмжээ зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр ипотекийн гэрээнд оруулсан байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтад барьцааны гэрээнд барьцаагаар хангагдах шаардах үүргийн хэмжээг тусгана гэж заасны гэрээний дээрх заалт хангаж байна.

Ипотекийн гэрээнд барьцаа үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулагч нь өөрийн эзэмшилд байлгаж бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах ба барьцаа үл хөдлөх хөрөнгийг барьцааны гэрээний хугацаанд даатгуулах үүргийг хүлээлгэсэн байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 22 дугаар зүйлд даатгалд даатгуулах эсэхийг талууд гэрээгээр тохиролцохоор нээлттэй үлдээсэн байна. Мөн ипотекийн гэрээ, барьцаалбар зэргийг бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцааг баталгаажуулах үүргийг барьцаалуулагч хүлээсэн. Энэ тухай ИХ-ийн 166 дугаар зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 12-т зүйлчилсэн байна.

Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг худалдах, арилжих, бэлэглэх зэргээр бусдын өмчлөлд шилжүүлэх мөн барьцааны зүйлийг бусдад давхар барьцаалах эрхтэй байх ба энэ тохиолдолд барьцаалагч талд заавал мэдэгдэх үүрэгтэй байхаар ипотекийн гэрээнд заажээ. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар *"Барьцаалуулагч барьцааны зүйлийг зориулалтынх нь дагуу ашиглах эрхтэй"* байна. Харин 30 дугаар зүйлд барьцааны зүйлийг гуравдагч этгээдэд түрээслэх, хөлслөх, үнэ төлбөргүйгээр түр ашиглуулах зорилгоор бусдын эзэмшилд шилжүүлэх эрхтэй байхаар заажээ. Хэрэв энэ эрхийг хязгаарласан гэрээний нөхцөл байгаа бол тухайн нөхцөл хүчин төгөлдөр бус байхаар зүйлчилсэн байна. Мөн хуулийн 28 дугаар зүйлд барьцааны зүйлийг өмчлөлдөө шилжүүлэн авсан этгээд өмнөх барьцаалуулагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхээр зүйлчилсэн байна.

Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд БИД нь барьцаа хөрөнгөөс үүргийг хангуулах эрхтэй болох ба ингэхдээ зээлдэгчид зээлийн гэрээний үүргийг гүйцэтгэх хугацаа заан, барьцаанаас үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай мэдэгдлийг барьцаалуулагч талд мэдэгдэхээр ипотекийн гэрээнд заасан байна. Энэ нь ИХ-ийн 174 дүгээр зүйл[47], Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 41-42 дугаар зүйлтэй[48] нийцэж байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3-т *"Барьцаалагч нь тухайн*

---

[47] Иргэний хууль (2002).
174 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах
174.1 Ипотекийн шаардлагыг хангах хугацаа үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах эрхтэй.
174.4 Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмыг хуулиар тогтооно.
[48] Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль (2009).
41 дүгээр зүйл. Үүргийн гүйцэтгэлийг шаардах
41.1 Үүрэг гүйцэтгэгч болон барьцаалуулагч нь үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол барьцаалагч нь үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй.
41.2 Энэ хуулийн 41.1-д заасан барьцаалагчийн шаардлагыг биелүүлээгүй бол үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулахаар барьцааны зүйлийг худалдахыг шаардах эрхтэй.
41.3. Барьцааны зүйлийг давхар барьцаалсан бол барьцаалагч нь энэ хуулийн 41.2-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ бусад барьцаалагч болон барьцаалуулагчид, барьцаалуулагч нь гуравдагч этгээд бол үүрэг гүйцэтгэгчид, барьцааны зүйл нь түрээсийн зүйл бол түрээслүүлэгчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.
42 дугаар зүйл. Барьцаалуулагчид мэдэгдэл хүргүүлэх
42.1 Барьцаалагч нь энэ хуулийн 41.1-д заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг шаардах тухай мэдэгдлийг барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ.
42.2 Барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгч нь мэдэгдэлд заасан хугацаанд хаяг өөрчлөгдсөн бол барьцаалагч нь энэ тухай улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцаалуулагч болон тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн этгээдэд [illegible] үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тухайгаа бичгээр мэдэгдэнэ.
42.3 Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдэлд 30 хоногийн дотор барьцаалуулагч хариу мэдэгдээгүй буюу үүргээ биелүүлээгүй бол барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдах ажиллагааг эхлүүлнэ.
42.4 Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдлийн маяг болон мэдэгдлийг хүргүүлэх журмыг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
21031195 СТС2430



287

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12
БҮРТГЭВ
Эх хувь

Үнэт цаасны танилцуулга
2023-03-26
БҮРТГЭВ-02

*эд хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шаардахын өмнө бусад барьцаалагчид энэ тухай бичгээр мэдэгдэх үүрэгтэй"* байхаар зүйлчилсэн байна. Хуулийн энэ зохицуулалтыг ипотекийн гэрээнд тусгаагүй ч БИД-ийн зүгээс хуулийн хүрээнд ийнхүү мэдэгдэх үүрэг хүлээх юм. Ипотекийн гэрээнд барьцааны зүйлээс үүргийг хангах дараах аргуудыг зааж талууд чөлөөтэй сонгож болохоор заажээ. Үүнд шүүхийн журмаар, шүүхээс гадуур шууд худалдах, шүүхээс гадуур дуудлага худалдаагаар худалдах зэрэг юм. Ипотекийн гэрээнд барьцааны зүйлийг худалдах дээрх аргуудыг задлан арга тус бүрээр зохицуулалтыг тусгасан ба энэ нь ИХ-ийн 175-181 дүгээр зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 45-52 дугаар зүйлтэй нийцэж байгааг тэмдэглэж байна.

ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1-д барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж болно гэж заасан бол ипотекийн гэрээнд нотариатаар гэрчлүүлж холбогдон гарах зардлыг барьцаалуулагч тал хариуцахаар зохицуулжээ.

**(v) Фидуцийн гэрээ**

Үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргуудын нэг нь фидуцийн гэрээ юм. Фидуцийн гэрээгээр үүрэг гүйцэтгэгч нь мөнгөн хөрөнгө төлөх үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлдэг онцлогтой. БИД-ийн хувьд фидуцийн зөвхөн автомашины өмчлөх эрхийг шилжүүлэн авдаг онцлогтой байна.

БИД ББСБ ХХК-ийн фидуцийн гэрээнд *"үүрэг хүлээгч нь автомашиныг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, зээл, зээлийн хүү төлөх үүргээ зээлийн гэрээнд заасан хугацаанд бүрэн гүйцэд биелүүлсэн тохиолдолд уг автомашиныг үүрэг хүлээгчид буцаан өгөхөөр үүрэг хүлээнэ"* гэсэн байна. Энэ нь ИХ-ийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт[49] заасантай нийцэж байна.

Фидуцийн гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг дарж баталгаажуулах ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. ИХ-ийн 235 дугаар зүйлийн 235.5 дахь хэсэгт фидуцийн гэрээг хуульд өөрөөр заагаагүй бол бичгээр байгуулна гэж зүйлчилсэн байна. Фидуцийн гэрээнд холбогдох тохиролцоо нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

Фидуцийн гэрээнд фидуцийн хөрөнгө гэж үүрэг хүлээгчийн хууль ёсны өмчлөлийн эрхийн болон биет байдлын доголдолгүй хөдлөх эд хөрөнгө /автомашин/ бөгөөд бусдад барьцаалуулаагүй, шилжүүлээгүй, гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байхгүй байна гэж тодорхойлжээ. Фидуцийн хөрөнгийг дундаа хамтран өмчлөгч байгаа бол фидуцийн гэрээнд мөн гарын үсэг зуруулахаар заасан байна. Фидуцийн хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн нийт дүн, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, фидуцийн хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, болон зээлдүүлэгчээс гарсан зардал зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр фидуцийн гэрээнд оруулсан байна. Фидуцийн гэрээнд үүрэг хүлээгч нь зээлийн гэрээний дагуу зээл олгогдохоос өмнө фидуцийн хөрөнгийг зээлдүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, эрх бүхий байгууллагад бүртгүүлж гэрчилгээ авах, даатгуулах зэрэг арга хэмжээг авч холбогдон гарах зардлыг хариуцахаар заасан байна. Фидуцийн гэрээний хугацаанд фидуцийн хөрөнгийг үүрэг хүлээгч тал нь эзэмших ашиглах эрхтэй байхаар заасан ба бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах үүрэг хүлээнэ. ИХ-ийн 235 дугаар зүйлийн 235.2 дахь хэсэгт фидуцийн хөрөнгийг гэрээнд заасан бол үүрэг хүлээгч ашиглах эрхтэй байж болохоор заасан байна.

[49] Иргэний хууль (2002).
235 дугаар зүйл.Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ /фидуци/
235.1 Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр /цаашид "фидуци" гэх/ үүрэг гүйцэтгэгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.



BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855
9071031195

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй эсхүл гэрээний үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд зээлдүүлэгчийн фидуцийн хөрөнгийг үл маргах журмаар захиран зарцуулж үүргийн хангуулахаар заасан байна.

Дүгнэж үзвэл БИД ББСБ ХХК-ийн зээлийн гэрээ болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад гэрээ нь Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна. Эдгээр гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг БИД ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 сарын 02-ны өдрийн №01/02/08 тоот Эрх олгох тухай тушаалаар баталгаажуулсан байна.

**Дөрөв. БИД ББСБ-ын үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ**

Үнэт цаас гаргагчийн зүгээс гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагатай байгуулсан хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад 31 (гучин нэг) гэрээний мэдээллийг ирүүлсэн ба Хуулийн фирмийн зүгээс эдгээр гэрээг үзэж танилцлаа. Эдгээр гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

БИД ББСБ ХХК-ийн зүгээс бусадтай байгуулсан үйл ажиллагаанд ач холбогдол бүхий бусад гэрээ гэдэгт (i) худалдах, худалдан авах гэрээ; (ii) үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ; (iii) ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ; болон (iv) бусад гэрээнүүд багтах ба Хуулийн фирмийн зүгээс эдгээр гэрээнүүдийг хууль тогтоомж, БИД-ийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх болно.

**(i) Худалдах, худалдан авах гэрээ**

БИД ББСБ ХХК-ийн бусадтай байгуулсан худалдах, худалдан авах гэрээний хувьд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар 1 (нэг) гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэхүү гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

БИД ББСБ ХХК нь худалдах, худалдан авах гэрээнд дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

(i) Эрхийн болон биет байдлын доголдолгүй барааг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх төлбөрийг гэрээнд заасны дагуу шилжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах;

(ii) Барааны шинж чанар, загвар, тоо ширхэг, үзүүлэлт, иж бүрдэл, бүрэн бүтэн байдал, баталгаа, үйлдвэрлэгчийн мэдээлэл, ашиглалтын байдал, зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг оруулж хавсаргах;

(iii) Барааг нийлүүлэх хугацаа, хүргэх газар, барааны сав баглаа боодол, тээвэрлэх нөхцөл, барааг хүлээн авах, хүлээлгэн өгөх журам;

(iv) Талуудын эрх, үүрэг;

(v) Барааг нийлүүлэх үед болон хүлээн засны дараа доголдолтой эсхүл гэрээнд заасан шаардлагыг хангаагүй болох нь илэрхий болсон үед талуудын авах арга хэмжээний талаар;

(vi) Баталгаат хугацааны явцад гарсан эвдрэл, гэмтлийг засах шийдвэрлэх талаар;

(vii) Гэрээний үнэ, төлбөр төлөх журам;

(viii) Талуудын хүлээх хариуцлага, хариуцлагын хэмжээ, зэх;

(ix) Гэрээг цуцлах нөхцөл, болон бусад

Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болохоор худалдах худалдан авах гэрээнд заасан ба ИХ-ийн 243-257 дугаар зүйлд худалдах худалдан авах гэрээний зохицуулалттай нийцэж байна.

**(ii) Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ**



289

БИД ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээнээс үзвэл нийт 7 (долоон) түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр түрээсийн гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу

Хуулийн фирмээс үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг хуульд нийцсэн эсэхийг шалгахдаа БИД ББСБ ХХК-ийн түрээсэлж буй байр, талбайн хэмжээгээр үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гарсан тохиолдолд түрээсийн гэрээг ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэгт заасны дагуу улсын бүртгэлийн газрын бүртгүүлэх хуулийн зохицуулалтыг үндэслэл болгон авч үзлээ.

БИД ББСБ ХХК-ийн байгуулж буй үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээнд дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

(i) Түрээслүүлэгчийн өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн нийт талбайгаас тодорхой талбайг албан тасалгаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж, ашиглуулахаар түрээслэгчид шилжүүлэх гэрээгээр тохирсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах,
(ii) Түрээслүүлэх үл хөдлөх эд хөрөнгийн байрлал, хэмжээ, ашиглалтын нөхцөл;
(iii) Гэрээний үргэлжлэх хугацааг тодорхой заах гэрээний хугацаа дуусахад хэрхэн сунгах нөхцөл,
(iv) Түрээсийн төлбөрийг тодорхой заах, хэрхэн төлөх, үнэ өөрчлөгдөх тохиолдолд хэрхэн шийдвэрлэх;
(v) Түрээсийн хөрөнгөтэй холбогдон гарах урсгал зардлыг хэрхэн хуваарилах, түрээсийн хөрөнгийн засан сайжруулсан тохиолдолд тухайн зардлыг хэрхэх;
(vi) Талуудын эрх, үүрэг;
(vii) Түрээсийн хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах журам;
(viii) Талуудын хүлээх хариуцлага, хариуцлагын хязгаарлалт, анз;
(ix) Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах нөхцөл болон бусад.

Гэрээнд заасанаар Түрээслүүлэгч тал нь гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх холбогдон гарах зардлыг хариуцах ба хэрэв энэ үүргээ хэрэгжүүлээгүй бол холбогдон гарах үр дагаврыг дангаар хариуцахаар заасан байна. Хэдийгээр түрээсийн гэрээг түрээслүүлэгч тал холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээж байгаа боловч ийнхүү бүртгүүлээгүй бол гэрээ хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй. Иймд БИД ББСБ ХХК-ийн зүгээс тухайн гэрээ бүртгэгдсэн эсэхийг лавлаж хэрэв үгүй бол бүртгүүлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай. Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болохоор уг гэрээнд заасан ба ИХ-ийн 318-320 дугаар зүйлд заасан зохицуулалттай нийцэж байна.

**(iii) Ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ**

Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар БИД-ийн бусадтай байгуулсан хүчин төгөлдөр үйлчилж байгаа ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

БИД ББСБ ХХК нь тухайн байгуулсан гэрээг Ажил гүйцэтгэх гэрээ, Үйлчилгээ үзүүлэх гэрээ, Хамтран ажиллах гэрээ гэж нэрлэсэн байх боловч гэрээний шинж чанар болон үүргээс хамаарч ИХ-ийн 359 дүгээр зүйлд[30] заасан Хөлсөөр ажиллах гэрээний онцлогийг агуулсан байх тул түүгээр зохицуулагдах тохиолдол бий. Мөн зарим нэг төрлийн Хамтын ажиллагааны гэрээ, Хамтран ажиллах гэрээ нь ИХ-ийн 343 дугаар зүйлд[31] заасан Ажил гүйцэтгэх гэрээний хүрээнд

[30] Иргэний хууль (2002).
359 дүгээр зүйл Хөлсөөр ажиллах гэрээ
359.1. Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажиллуулагч хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ
359.2. Энэ гэрээний зүйл нь бүх төрлийн ажил, үйлчилгээ байж болно
[31] Иргэний хууль (2002).
343 дугаар зүйл Ажил гүйцэтгэх гэрээ

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01
Эх хувь

Үнэт цаасны танилцуулга
2023-05-28
БҮРТГЭВ-02

зохицуулагдахаар байна. Өөрөөр хэлбэл холимог гэрээний хувьд тухайн гэрээний оновчтой нөхцөл илүүтэй гэрээний гүйцэтгэлд илүү тохиромжтой тухайн төрлийн гэрээг зохицуулсан хуулийн зүйл хэмжээг анхаарах шаардлагатай. Энэ тухай ИХ-ийн 198 дугаар зүйлийн 198.3-д тодорхой заасан байна.

Эдгээр ажил гүйцэтгэх гэрээ нь ИХ-ийн 343 дугаар зүйл болон 359 дүгээр зүйлд заасан агуулгын шаардлагыг хангасан, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан байх тул гэрээнд тавигдах агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

(iv) Бусад гэрээ

БИД ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бусад гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хэсгээс дэлгэрүүлэн танилцана уу.

Бусад төрлийн гэрээнд нууц хадгалах гэрээ, хамтран ажиллах, төрийн байгууллагатай байгуулдаг тодорхой төрлийн гэрээ, санамж бичиг зэрэг гэрээнүүд багтаж байна.

**Дүгнэж үзвэл БИД ББСБ ХХК-ийн иргэн, хуулийн этгээдтэй байгуулдаг худалдах, худалдан авах гэрээ, зээлийн гэрээ, үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ болон бусад гэрээ нь Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна. Эдгээр гэрээнд БИД ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал гарын үсэг зурж баталгаажуулсан байна.**

**БИД ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, тэдгээрийн хэрэгжилтийн тухай.**

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэлх БИД ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээг гэрүүлэн авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээг сонгон авч дүн шинжилгээ хийлээ. Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт *"Тухайн компанийн хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу зарсан нийт бүх төрлийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан хувьцааны хувьцаа хамаарахгүй"* гэж заасан байна.

Сүүлийн 3 (гурван) жилийн байдлаар БИД ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) хувь нь дараах дүнтэй байна. Үүнд:

*Хүснэгт №10. БИД ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) хувь (төгрөгөөр).*

| № | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр) | 2020.01.01 - 2022.01.01 | 2020.01.22 - 2021.01.01 | 2021.01.01 - 2022.01.01 | 2022.01.01 - 2023.01.01 |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хувь нийлүүлсэн хөрөнгө | 3,571,429,000 | 5,000,001,000 | 5,000,001,000 | 5,000,001,000 |
| 2. | Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувь | 178,571,450 | 250,000,050 | 250,000,050 | 250,000,050 |

Үнэт цаас гаргагч нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 29 (хорин есөн) гэрээний мэдээллийг Хуулийн фирмд жагсаалтаар гаргаж өгсөн. Эдгээр гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №05. "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

343.1. Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь үр дүнг нь хүлээн авч хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.



BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ХХК

291

БИД ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнүүд нь өөр улсын санхүүгийн байгууллагаас авсан зээлийн гэрээ, ажил үйлчилгээ байгууллага болон иргэдтэй байгуулсан итгэлцлийн гэрээ, хэлэлцээрт өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ, өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ, зээлийн гэрээ байна. Өөр улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээг БИД ББСБ ХХК-аас баталсан зээлийн гэрээний төслөөр бус зээл олгогч талаас боловсруулсан гэрээний төслөөр байгуулсан байна.

*Хүснэгт №11. БИД ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний төрлийн тоон үзүүлэлт*

| № | Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ | 2020.01.01 – 2021.01.01 | 2021.01.01 – 2022.01.01 | 2022.01.01 – 2023.01.01 | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хүчин төгөлдөр гэрээний тоо | 2 | 7 | 20 | 29 |
| | **НИЙТ** | | | | 29 |

Гадаад улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээнд бусад улсын хууль тогтоомжийг удирдлага болгохоор заасан бөгөөд талуудын хооронд маргаан гарсан тохиолдолд гадаадын хууль тогтоомжийг мөрдлөг болгон өөр улс оронд маргааныг шийдвэрлүүлэхээр заасан байна. Иймд Хуулийн фирмийн зүгээс гадаадын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээний хүчин төгөлдөр байдал, зохицуулалтын талаар үнэлэлт, дүгнэлт өгөхгүй бөгөөд БИД ББСБ ХХК нь үнэт цаас гаргахдаа гэрээний дагуу нөгөө талдаа мэдэгдэх, зөвшөөрөл авах шаардлагатай эсэхийг нягталж үзэхэд дараах 3 (гурван) гэрээний хувьд үнэт цаас гаргахын өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдсэн байхыг шаардаж байна. Үүнд:

(i) Arbor FS Ltd, Зээлийн гэрээ, 2020 он;
(ii) EMF Microfinance Fund, AGmvK, Зээлийн гэрээ, 2021 он;
(iii) Microfinance Enhancement Facility SA, SICAV-SIF, Зээлийн гэрээ, 2022 он.

Эдгээр мэдээлэлтэй **Хавсралт №05. "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

БИД ББСБ-ын бусадтай байгуулсан бусад гэрээ, хэлцэл буюу итгэлцлийн гэрээ, өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гэрээ, зээлийн гэрээнд БИД ББСБ ХХК нь өрийн бичиг гаргах тохиолдолд гэрээний нөгөө талд мэдэгдэх, зөвшөөрөл авах, ийнхүү өрийн бичиг гаргахыг хязгаарласан зохицуулалт байхгүй тул гэрээний нөгөө талд мэдэгдэлгүй өрийн бичиг гаргаснаас үүдэн дээрх гэрээнд заасан үүргээ зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй гэж үзлээ.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК нь өрийн бичиг гаргах талаар дээрх 3 (гурван) зээлдүүлэгчид и-мэйлээр мэдэгдсэн байна. Иймд Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК нь гэрээний үүргээ хэрэгжүүлэн өрийн бичиг гаргах талаар албан ёсны мэдэгдлийг албан бичгээр дээрх 3 (гурван) зээлдүүлэгчид хүргүүлж хариу авахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.**

**Тав. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх:**

Хуулийн фирм нь энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд БИД ББСБ ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл дотор их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч 2023 оны 01 сарын 01-ний өдрийн байдлаар дуусгавар болоогүй хэрэгжиж байгаа их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх, байгаа нөхцөлд Компанийн тухай хуулийн дагуу хийгдсэн эсэх асуудлыг судалж үзлээ.

(i) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:



292

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 оны 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Компанийн дүрмийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)" болон 16.2.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт актив[32] болон балансын активын 25 хувийн дүнг тооцож үзвэл дараах хэмжээтэй байна. Үүнд:

*Хүснэгт №12. Балансын активын 25%-ийн тооцоолол*

| № | Гаргасан жил, төрөл | Тухайн улирлын балансын нийт актив (төгрөгөөр) | Тухайн улирлын балансын активын 25% (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| 1. | 2020 оны 1 улирал | 45,883,929,700.0 | 11,470,982,425.00 |
| 2. | 2020 оны 2 улирал | 47,585,512,470.8 | 11,896,378,117.69 |
| 3. | 2020 оны 3 улирал | 47,447,703,159.4 | 11,861,925,789.86 |
| 4. | 2020 оны 4 улирал | 43,819,940,045.1 | 10,954,985,011.32 |
| 5. | 2021 оны 1 улирал | 73,373,264,259.4 | 18,343,316,064.84 |
| 6. | 2021 оны 2 улирал | 48,283,719,961.9 | 12,070,929,990.48 |
| 7. | 2021 оны 3 улирал | 52,168,378,881.4 | 13,042,094,720.35 |
| 8. | 2021 оны 4 улирал | 59,023,473,965.8 | 14,755,618,491.44 |
| 9. | 2022 оны 1 улирал | 61,840,179,979.8 | 15,460,044,994.96 |
| 10. | 2022 оны 2 улирал | 65,849,591,038.6 | 16,462,397,759.86 |
| 11. | 2022 оны 3 улирал | 64,677,182,048.7 | 16,169,295,512.16 |
| 12. | 2022 оны 4 улирал | 69,716,206,148.6 | 17,429,051,537.15 |

Дээрх хүснэгтэд тусгагдсан Үнэт цаас гаргагчийн хэлцэл хийхийн өмнөх балансын сүүлийн балансын активын 25 хувийн дүн болон Компаниас ирүүлсэн гэрээ, хэлцэл, мэдээлэлд үндэслэж үзвэл БИД ББСБ ХХК нь дурдсан хугацааны дотор их хэмжээний их хэмжээний хэлцэл байгуулаагүй байна.

БИД ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 сарын 27-ны өдрийн №03/23/05 тоот Хуулийн фирмд ирүүлсэн Баталгаа гаргах тухай албан бичгээс үзвэл БИД ББСБ ХХК нь сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд тодорхойлсон их хэмжээний хэлцэл байгуулаагүй (Компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон гэрээ, хэлцэл хамаараагүй) болохыг тодорхойлсон байна.

[32] "Балансын нийт актив" гэдэг Санхүүгийн байдлын тайлангийн 1.4 дах мөр [illegible] буюу "Эд хөрөнгийн нийт" гэсэн [illegible] байдлаар [illegible] тодорхойлсон болно. Хуулийн фирм.

БИД
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

Иймд Хуулийн фирмийн зүгээс БИД ББСБ ХХК-ийн батламж гаргах тухай албан бичигт үндэслэн гэрээ, хэлцлийг гасалбар болгосон өдрийн байдлаар их хэмжээний хэлцэл байгуулаагүй байна гэж дүгнэлээ.

(ii) **Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-аас 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд бусадтай бичгээр байгуулсан чийт гэрээ, хэлцлийн дотор сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, байгуулагдсан нөхцөлд Компанийн тухай хуулийн дагуу хийгдсэн эсэхийг судлан үзлээ.

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт "Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай Компанийн тухай хуульд тодорхойлсон харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно" гэж тодорхой заасан байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан журмын дагуу байгуулдаг бөгөөд тус хэсэгт "сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-ын гишүүдийн олонхын саналаар гаргана", 92 дугаар зүйлийн 92.2 дахь хэсэгт "Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно" гэж тодорхойлсон байна. Мөн сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж ямар хэлцэл болох, түүний оролцогч нь хэн болох, хэлцлийг хэрхэн байгуулах талаар БИД ББСБ ХХК нь компанийн дүрэмдээ тодорхой зааж өгсөн байна.

Компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэгт[33] заасны дагуу компани нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлийг тухай бүр хөтлөх үүрэгтэй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн хувийн байдлын талаар мэдээлэл өгөх хуулиар ногдуулсан үүрэгтэй байна. Хуулийн фирм нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлохдоо БИД ББСБ ХХК-аас гаргаж өгсөн баримт материалд үндэслэсэн бөгөөд эдгээр баримт материал нь Компанийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт[34] заасан шаардлагыг бүрэн хамарсан эсэх болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд хэлцэл хийхдээ сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд компанид тухай бүр мэдээлэх үүргээ биелүүлсэн эсэх асуудлаар бие даан дүн шинжилгээ хийх, баталгаа гаргах боломжгүй байгааг анхаарна уу.

---

[33] **Компанийн тухай хууль (2011)**
91 дүгээр зүйл. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавих шаардлага
91.3.компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг нэгтгэн, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх боломжтой эсэхийг хянах үүрэгтэй.

[34] 89 дүгээр зүйл. Сонирхлын зөрчил бүхий этгээд
89.1.Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай доор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:
89.1.1.хэлцлийн нэгэн тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
89.1.2.хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /нэгдэж хувийн/ 20 оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
89.1.3.хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /нэгдэж хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
89.1.4.хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үнэт цаас олж авах эрх хүртэж байгаа.



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 сар 03 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01
Нууц баримт
Эх хувь

Үнэт цаасны танилцуулга
2023
БҮРТГЭВ-02

БИД ББСБ ХХК-ийн зүгээс 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд байгуулагдсан гэрээ, хэлцлийн жагсаалт болон БИД ББСБ ХХК-аас исгүүлсэн мэдээлэлд үндэслэж үзвэл тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт 42 (дөчин хоёр) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байна. БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 сарын 30-ны өдрийн №01/30-06 тоот тогтоолоор нийт 42 (дөчин хоёр) сонирхлын зөрчилтэй хэлцэл хийснийг баталгаажуулсан байна. Эдгээр хүчин төгөлдөр хэрэгжиж буй сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн жагсаалт, гэрээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт №06. "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн үзэж танилцана уу.

Дүгнэж үзвэл БИД ББСБ ХХК-аас нэгдмэл сонирхолтой этгээдтэй байгуулсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй 42 (хорин хоёр) сонирхлын зөрчилтэй хэлцлийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталгаажуулсан бөгөөд тул эдгээр гэрээ, хэлцлийг хэрэгжүүлэх боломжтой байна гэж Хуулийн фирмээс үзэв.

Компанийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэгт "Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй", 89 дүгээр зүйлийн 89.5 дахь хэсэгт "Компани тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусгаж нийтэд мэдээлэх үүрэгтэй", Компанийн засаглалын кодексийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт "Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг эрх ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байна" гэж заасан. Иймд БИД ББСБ ХХК нь цаашид сонирхлын зөрчлийг зохицуулах бодлого журмыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журамд үндэслэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

Зургаа. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх асуудлаар:

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн зүгээс үйл ажиллагаа эрхлэхдээ хууль тогтоомжид заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авахыг шаардсан буюу тодорхой төрлийн эх ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз гэсэн шалгуурын хүрээнд ойлгож дүн шинжилгээ хийлээ.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 09 сарын 28-ны өдрийн №130 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл[14] эсэны үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Хуулийн дүгнэлт гарах өдрийн байдлаар БИД ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон дараах 5 (таван) тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Үүнд:

*Хүснэгт №13. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн мэдээлэл*

| № | Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа | Тусгай зөвшөөрөл олгосон огноо, шийдвэрийн дугаар | Хүчинтэй эсэх Тийм/ Үгүй Лавлагааны огноо, дугаар |
|---|---|---|---|

[14] Санхүүгийн зохицуулах хороо
https://www.frc.mn/
Банк бус санхүүгийн байгууллага, Бизнес инвест девелопмент ББСБ ХХК байгууллага болон тусгай зөвшөөрлийн талаарх холбоотой мэдээлэл



BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183856
21031195 СТС2430

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 05 17
БҮРТГЭВ

Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх | Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол 2007.09.28 №130 | Тийм Санхүүгийн зохицуулах хороо 2023.02.15 №9/711 |
| 2 | Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх | Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол 2008.10.22 №233 | |
| 3 | Банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх[56] | Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол 2014.12.10 №445 | |
| 4 | Банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх[57] | Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол 2018.04.04 №147 | |
| 5 | Банк бус санхүүгийн богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх[58] | Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол 2021.03.10 №83 | |

БИД ББСБ ХХК нь хуулийн этгээд болохын хувьд эрх зүйн бүрэн чадамжтай, татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага[59] хангаж байгаа бөгөөд эрхлэх үйл ажиллагаа нь 2022 оны 06 сарын 27-ны өдөр батлагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг[60] буюу зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд хамаарч байна.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр байх дээрх тусгай зөвшөөрөл нь хүчинтэй эсэх, тэдгээрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүссэн эсэх талаар Санхүүгийн зохицуулах хорооноос лавлагаа гаргуулан авч үзлээ.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 02 сарын 15-ны өдөр ирүүлсэн №9/711 тоот албан бичгээс үзвэл БИД ББСБ ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны №130 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2008 оны №233

---

[56] Санхүүгийн зохицуулах хороо
[illegible] 14_445.pdf
Бизнес инвест девелопмент ББСБ ХХК-д олгосон "Банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх" тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

[57] Санхүүгийн зохицуулах хороо
[illegible]
Бизнес инвест девелопмент ББСБ ХХК-д олгосон "Банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

[58] Санхүүгийн зохицуулах хороо
[illegible]
Бизнес инвест девелопмент ББСБ ХХК-д олгосон "Банк бус санхүүгийн богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх" тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

[59] Зөвшөөрлийн тухай хууль (2022).
Дөрөвдүгээр бүлэг Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага, зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг
4 дүгээр зүйл. Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага
1 Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд дараах нийтлэг нөхцөл, шаардлагыг хангасан байна:
1.1 иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх;
1.2 хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, эсхүл дүгнэлт гаргуулсан байх;
1.3 татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх.

[60] Зөвшөөрлийн тухай хууль (2022).
Наймдугаар бүлэг Зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа
8 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн жагсаалт
2 Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд [illegible]:
2.7 банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх;
2.8 банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх;
2.9 банк бус санхүүгийн зээл олгох үйл ажиллагаа эрхлэх;
2.10 банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх;
2.11 банк бус санхүүгийн богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх

BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК



УЛААНБААТАР ХОТ
5183855

дугаар тогтоолоор Иттгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, 2014 оны №147 дугаар тогтоолоор цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, 2021 оны №83 дугаар тогтоолоор богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон бөгөөд лавлагаа гаргах өдрийн байдлаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал бүрдээгүй болохыг тодорхойлсон байна. Мөн тус тодорхойлолтод БИД ББСБ ХХК нь 2022 оны жилийн эцсийн байдлаар хангаж ажиллавал зохих зохистой харьцааг бүрэн хангаж ажиллаж байгаа бөгөөд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулгыг тогтмол ирүүлдэг бөгөөд 2022 оны жилийн эцсийн эрсдэлийн үнэлгээ "Бага" буюу 2.73 болохыг дурдсан байна.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны №160 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг хийсэн бөгөөд шалгалтаар илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгөгдсөн ба биелэлтийг хугацаанд нь бүрэн ирүүлж, зөрчлийг арилгаж ажилласан байгаа тул үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлд учирсан эрсдэл бүрэн арилсан байна.

Иймд Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа Санхүүгийн зохицуулах хорооноос олгогдсон 5 (таван) тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, түдгэлзүүлэх, хүчингүй болох аливаа нөхцөл үүсээгүй байна гэж Хуулийн фирмийн зүгээс үзлээ.

Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагч нь аливаа зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмшдэг эсэх, тэдгээр нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн асуудлаар Оюуны өмчийн газраас ирүүлсэн лавлагаа болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн БИД ББСБ ХХК-ийн нэр дээр олгогдсон зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх талаар дэлгэрүүлэн авч үзлээ.

Оюуны өмчийн газрын 2023 оны 03 сарын 01-ний өдрийн №3/153 тоот тодорхойлолтоос үзвэл БИД ББСБ ХХК-ийн нэр дээр 3 (гурван) барааны тэмдэг бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн болохыг тодорхойлсон байна. Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдэж эрхийн хамгаалалт хийгдсэн зохиогчийн эрх болон барааны тэмдгийн мэдээллийг **Хавсралт №07. "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн нийт хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй зохиогчийн эрх болон барааны тэмдэг нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлын хувьд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг[41] заасны дагуу хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн[42] 2023 оны 03 сарын 02-ны өдрийн байдлаар бүртгэлээс хайлт хийж үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдгийн барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна. Иймд БИД ББСБ ХХК-ийн нэр дээр бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн 3 (гурван) барааны тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлд үндэслэн үзэхэд Үнэт цаас

---

[41] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).
7 дугаар зүйл. Барьцааны зүйл
7.1 [illegible] хөдлөх эд хөрөнгө, [illegible] бүх төрлийн [illegible], үнэт цаас, [illegible] барааны тэмдэг, [illegible] бусад хөдлөх эд хөрөнгө, эдийн бүс хөрөнгө нь барьцааны зүйл байж болно.
[42] [illegible]
[illegible] хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн [illegible] барьцааны [illegible] мэдэгдэх болон барьцааны [illegible] Цахим мэдээллийн сан [illegible] Улсын бүртгэлийн [illegible] газар (УБЕГ) [illegible]



BID Business Invest Development 2023 05 12 БҮРТГЭВ №11
Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ
УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6183855 9021031195 СТС2420

BID BUSINESS INVEST DEVELOPMENT 2023 .03. 12 өдөр БҮРТГЭВ № 01

Үнэт цаасны танилцуулга БҮРТГЭВ-02

гаргагчийн нэр дээр бүртгэлтэй зохиогчийн эрх, барааны тэмдэг нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл БИД ББСБ ХХК-ийн нэр дээр олгогдсон үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, барааны тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд гадгаарийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгүй байна гэж дүгнэлээ.

Долоо. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар:

БИД ББСБ ХХК нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалтын хүрээнд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх буюу хөрөнгө оруулалтын үнэт цаас болон үнэтэй адилтгах санхүүгийн хэрэгсэлд хөрвүүлэх банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг. Үнэт цаас гаргагч нь Хуулийн дүгнэлт үйлдэх өдрийн байдлаар (i) 6 (зургаан) төрлийн хувьцаа, болон (ii) 1 (нэг) бонд буюу нийт 7 (долоон) санхүүгийн хэрэгсэл эзэмшиж байна. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй үнэт цаасны дэлгэрэнгүй мэдээллийг "Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн нийт хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээлэл"-ээс дэлгэрүүлэн танилцана уу.

*Хүснэгт №14. Үнэт цаас гаргагчийн эзэмшдэг үнэт цаасны дэлгэрэнгүй мэдээлэл*

| № | Хувьцаа/Бондын нэр | Төрөл | Тоо ширхэг | Хувь | Нийт үнийн дүн, үнэлгээ (төгрөгөөр болон ам.доллараар) | Үүрэг хангуулсан холбоотой байгуулсан эсэх, баталгаа, батлан даалт болон барьцаанд тавьсан эсэх /Тийм/Үгүй/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | АПУ | Хувьцаа | 44,490 | 0,00% | 64,065,600.00 | Үгүй |
| 2. | Мандал даатгал | Хувьцаа | 509,552 | 0,08% | 44,519,558.24 | Үгүй |
| 3. | Ард даатгал | Хувьцаа | 38,308 | 0,15% | 30,393,485.30 | Үгүй |
| 4. | Түмэн шувуут | Хувьцаа | 48,149 | 0,02% | 17,574,385.00 | Үгүй |
| 5. | Голомт банк | Хувьцаа | 155,643 | 0,02% | 198,134,539.00 | Үгүй |
| 6. | Мандал иргэдүйн эссэт | Хувьцаа | 88,7734 | 0,18% | 77,198,580.00 | Үгүй |
| 7. | MONMIN үнэт цаас | Бонд | 2,190 | | 219.0000 | Үгүй |

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2023 оны 02 сарын 13-ны өдрийн №4 тоот Үнэт цаас эзэмшлийн тодорхойлолтоос үзвэл БИД ББСБ ХХК-ийн нэр дээр 6 (зургаан) төрлийн үнэт цаас эзэмшиж байгааг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК нь 2021 оны 11 сарын 11-ны өдөр гадаад арилжааны захиалгын гэрээгээр үнэт цаасны MONMIN 9.25% 04/15/24 нэртэй бондыг худалдаж авсан байна.

Иймд төрийн эрх бүхий байгууллагын тодорхойлолт болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэвэл, БИД ББСБ ХХК-ийн нэр дээрх 7 (долоон) үнэт цаас эзэмших эрх нь хүчин төгөлдөр бөгөөд үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн холбогдол хийгдээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Үнэт цаас гаргагчаас БИД ББСБ ХХК-ийн өмчлөх болон эзэмших эрх бүхий 3 (гурван) тээврийн хэрэгслийг өөрийн үйл ажиллагаанд ашигладаг, үндсэн хөрөнгө мөн бөгөөд хөрөнгийн үнэлгээнд орсон гэсэн мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн. Мөн Үнэт цаас гаргагч нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх буюу фидуци[51] гэрээний дагуу тээврийн хэрэгслийг БИД ББСБ ХХК-ийн өмчлөлд шилжүүлж, Автотээврийн үндэсний төвд бүртгэл хийлгэдэг байна.

[51] Иргэний хууль (2002).
| 45 | №15001[illegible]0015 | Зээлийн гэрээ / Барьцааны гэрээ | 2020.11.05 | 2023.11.05 | [illegible] СЗ Ж.Төртүвшин | ХХК, газар | 2020.11.05 УБ 343 | 2020/11/04 СЗХ шийдвэр | №511 | [illegible] / [illegible] |
| 46 | №15000[illegible]0047 | Зээлийн гэрээ / Барьцааны гэрээ | 2021.09.06 | 2023.09.06 | [illegible] СЗ [illegible] | ХХК | 2021.09.07 УБ 199 | 2021/09/06 СЗХ шийдвэр | №[illegible] | [illegible] / [illegible] |
| 47 | №[illegible] | Зээлийн гэрээ / Барьцааны гэрээ | 2022.07.06 | 2023.07.06 | [illegible] СЗ Ж.Төртүвшин | ХХК, газар | 2022.07.06 УБ [illegible]/1 46 | 2022/07/06 СЗХ шийдвэр | №[illegible] | [illegible] / [illegible] |
| 48 | №12000[illegible]0076 | Зээлийн гэрээ / Барьцааны гэрээ | 2021.07.02 | 2024.07.02 | [illegible] СЗ [illegible] Мөнх-Оргил | ХХК | 2021.07.02 УБ 571 | 2021/07/02 СЗХ шийдвэр | №[illegible] | [illegible] / [illegible] |
| 49 | №12000[illegible]00123 | Зээлийн гэрээ / Барьцааны гэрээ | 2021.10.29 | 2024.10.29 | Баянгүрэн СЗ Н.Түвшинбаяр | ХХК, газар | 2021.10.29 УБ 11/169 | 2021/10/29 СЗХ шийдвэр | №[illegible] | [illegible] / [illegible] |
| 50 | №12001[illegible]00483 | Зээлийн гэрээ / Барьцааны гэрээ | 2022.10.27 | 2025.10.27 | [illegible] СЗ Ж.Төртүвшин | ХХК, газар | 2022.10.28 УБ 35/1 46 | 2022/10/27 СЗХ шийдвэр | №[illegible] | [illegible] / [illegible] |
| 51 | №13001[illegible]00080 | Зээлийн гэрээ / Барьцааны гэрээ | 2022.10.[illegible] | 2024.10.[illegible] | СЗ А.Ачтай | [illegible] | N/A | 2022/10/22 СЗХ шийдвэр | N/A | [illegible] / [illegible] |
| 52 | N/A | Онлайн зээлийн гэрээ | 2023.02.16 | 2023.02.16 | N/A | N/A | N/A | N/A | N/A | [illegible] |
| 53 | N/A | Онлайн зээлийн гэрээ | 2021.10.13 | 2023.10.12 | N/A | N/A | N/A | N/A | N/A | [illegible] |
| 54 | N/A | Онлайн зээлийн гэрээ | 2021.10.20 | 2023.10.20 | N/A | N/A | N/A | N/A | N/A | [illegible] |

BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855
[illegible]21031195 CTC2420

314

BID BUSINESS INVEST DEVELOPMENT СЭХ он 2023 сар 05 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02

Хавсралт №04. Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл

| № | Гэрээний дугаар | Гэрээний нэр | Харилцагчийн нэр | Эхлэх | Дуусах | Гэрээг баталгаажуулсан албан тушаалтан | Утга |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | №22/13-05 | Түрээсийн гэрээ | Чатбот ХХК | 2022.02.07 | 2023.04.07 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | Автомат хариулагч чатбот түрээслэн авах |
| 2 | №22/2-11 | [illegible] ашиглах гэрээ | Үндэсний дата төв УТҮГ | 2022.02.18 | 2023.02.18 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | [illegible] |
| 3 | №2022/2/30 | [illegible] систем ашиглах гэрээ | Үндэсний дата төв УТҮГ | 2022.02.18 | 2023.02.18 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | [illegible] |
| 4 | №5/30/2022 | Худалдах, худалдан авах гэрээ | Метафорс ХХК | 2022.05.30 | | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | [illegible] газар худалдан авах |
| 5 | | [illegible] гэрээ | Хаан Банк ХХК | 2022.06.02 | 2024.06.07 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | [illegible] |
| 6 | №2022115 | Түрээсийн гэрээ | Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК | 2022.06.16 | 2025.06.16 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | Сүхбаатар дүүргийн [illegible] 747.14м2 талбай түрээслэн ашиглах |
| 7 | | Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ | [illegible] ХХК | 2022.09.08 | 2023.09.08 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | [illegible] |
| 8 | №БХЭ/106-22 | Зээлийн мэдээлэл өгөх, авах гэрээ | Бүрэн скор ЗМС ХХК | 2022.09.23 | 2025.09.23 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | Зээлийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийг боловсруулах, хадгалах, хамгаалах, мэдээллийн үйлчилгээ авах |
| 9 | №БХЭ/106-22 | Нууц хадгалах гэрээ | Бүрэн скор ЗМС ХХК | 2022.09.23 | 2025.09.23 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | Нууц хадгалах |
| 10 | №1 | Хамтран ажиллах гэрээ | Шинэ эрин сургууль | 2022.09.12 | 2023.06.12 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | [illegible] |
| 11 | №2022/69 | Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ | [illegible] глобал монголиа аудит ХХК | 2022.09.26 | 2023.02.10 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | 2022 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгүүлэх |
| 12 | №ХАГ-22/01/35 | Хамтран ажиллах гэрээ | [illegible] ХХК | 2022.10.14 | 2023.10.13 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | ББСБ-ны [illegible] хамтран ажиллах |
| 13 | №10/25/02 | Нууц хадгалах гэрээ | Э.Сар-Од | 2022.10.25 | 2023.10.25 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | Нууц хадгалах |
| 14 | №10/17/02 | Нууц хадгалах гэрээ | А.Одбаясгалан | 2022.10.17 | 2023.10.17 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | Нууц хадгалах |
| 15 | №11/18 | Түрээсийн гэрээ | Бид моторс ХХК | 2022.11.18 | 2023.11.18 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | 31м2 талбай эзэмшүүлэх |
| 16 | №221125/02 | Хамтран ажиллах гэрээ | Дижитал мерчант сервисэс ХХК | 2022.11.25 | | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | ББСБ-ны [illegible] үйлчилгээ авах |
| 17 | | Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ | Өмгөөллийн [illegible] ХХН | 2022.11.09 | | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | [illegible] хууль зүйн туслалцаа авах |
| 18 | №22/11 | Оффисын байрны [illegible] гэрээ | [illegible] ХХК | 2022.11.01 | 2023.11.01 | ГЭ Ц.Бат-Эрдэнэ | Оффисын 4 дугаар давхарт [illegible] авах |

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9025010137

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга 28
БҮРТГЭВ-02

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
СЗХ
он сар өдөр 2023 05 12
БҮРТГЭВ
№ 01

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | №22/11 | Оффисийн байрны ашиглалт, үйлчилгээний гэрээ | Морьт тунга ХХК | 2022.11.01 | 2023.11.01 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Оффисийн 6 дугаар давхарын ашиглалтын үйлчилгээ авах |
| 20 | №0015/22 | Үйлчилгээ үзүүлэх гэрээ | БибиСиЭм ХХК | 2022.12.08 | 2023.04.01 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг боловсруулах үйлчилгээ авах |
| 21 | №12/И-КУБ/972 | Интернэт худалдааны төлбөр тооцоог картаар гүйцэтгэх гэрээ | Голомт банк ХХК | 2022.12.30 | 2024.12.30 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | BiD [illegible] худалдаанд карт [illegible] төлбөр тооцоо гүйцэтгэх тал [illegible] |
| 22 | №01/23 | Түрээсийн гэрээ | Эндлесс энерги ХХК | 2023.01.04 | 2023.12.31 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Баянгол дүүрэгт 47м2 талбай түрээслэн ашиглах |
| 23 | №01/06 | Түрээсийн гэрээ | Нью сүмбэр констракшн ХХК | 2023.01.02 | 2024.01.02 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Хан-Уул дүүрэгт 40м2 талбай түрээслэн ашиглах |
| 24 | №ІА 20/13 | Програм хангамж түрээслэж ашиглах гэрээ | Грэйпсити монгол ХХК | 2020.01.28 | | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Поларис суурь системийг ашиглах гэрээ |
| 25 | №ГМ 2010901-506-0 | Түрээсийн гэрээ | Инноэн рийл эстейт ХХК | 2021.09.01 | 2023.12.31 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Баянгол дүүрэгт 47м2 талбай түрээслэн ашиглах |
| 26 | №09/01/01 | Оффисийн түрээсийн гэрээ | Визард констракшн ХХК | 2022.09.01 | 2023.09.01 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Баянзүрх дүүрэгт 31м2 талбай түрээслэн ашиглах |
| 27 | №Ш-40745966 | Интернэтийн байнгын холболтын үйлчилгээ үзүүлэх гэрээ | Мобинет ХХК | 2020.09.15 | | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Интернэтийн байнгын холболтоор хангуулах |
| 28 | №20167467 | Үүрэн холбооны дараа төлбөрт үйлчилгээний гэрээ | Мобиком корпораци ХХК | 2020.09.09 | | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Дараа төлбөрт дугаарын үйлчилгээ авах |
| 29 | | Дараа төлбөрт үйлчилгээний гэрээ | Юнител ХХК | 2020.09.15 | | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Дараа төлбөрт дугаарын үйлчилгээ авах |
| 30 | №402476 | Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ | УБЦТС ТӨХК | 2020.08.25 | 2025.08.25 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Цахилгаан эрчим хүчээр хангуулах |
| 31 | | Шатахууны картын үйлчилгээ үзүүлэх гэрээ | Петростар ХХК | 2020.05.10 | | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Шатахууны картын үйлчилгээ авах |

BID
БИЗНЕС ИНВЕСТ [illegible]
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
[illegible] ХХК
5183855
9021031195 СТС2420

316

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК

СЗХ 2023 он 05 сар 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE Үнэт цаасны танилцуулга 2023-03-28 БҮРТГЭВ-02

Хавсралт №05. Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл

| № | Гэрээний дугаар | Гэрээний нэр | Харилцагчийн нэр | Эхлэх | Дуусах | Гэрээ баталгаажуулсан албан тушаалтан | Барьцаа | Төлөгдөх хугацаа хэтэрсэн огноо | Утга |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | №10502101030000207 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | "Практикал даатгал" ХХК | 2022.10.14 | 2023.10.14 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 2 | №1050210200000123 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | Г.Энхтуя | 2022.06.09 | 2023.06.09 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 3 | №1050210100000583 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | Д.Удвал | 2022.05.23 | 2023.05.23 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 4 | №1050210101000120 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | Э.Тэргэл | 2022.06.27 | 2024.06.27 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | 2022.06.27 6/27 | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 5 | №1050210101000150 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | Б.Отгондорж | 2022.10.24 | 2023.10.24 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 6 | №1050210100000647 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | Б.Отгонбаяр | 2022.10.21 | 2023.10.21 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 7 | №1050210101000014 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | С.Отгонбат | 2020.12.04 | 2023.12.04 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 8 | №1050210100000633 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | "Өнөр Үндэс ОМЗ" ББСБ | 2022.09.29 | 2023.03.29 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 9 | №1050240106000006 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | "Найдвартай даатгал" ХХК | 2022.08.25 | 2023.08.25 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 10 | №1050210102000009 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | "Мандал Даатгал" ХК | 2022.11.11 | 2023.11.11 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Байгаа | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| | №11/11/01 | Барьцааны гэрээ | | | | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | N/A | | Автомашин барьцаалсан 1.4 тэрбум төгрөгийн хэмжээний барьц |
| | №11/11/02 | Баталгаа даатгалын гэрээ | А.Алтанцуя | | | А.Алтанцуя | N/A | | Өөрийн 1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөөр баталгаа гаргасан |
| 11 | №105021010900000А | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | "Мандал Даатгал" ХК | 2022.11.01 | 2023.11.01 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Байгаа | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| | №10/31/01 | Барьцааны гэрээ | | | | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | N/A | | Автомашин барьцаалсан 1.4 тэрбум төгрөгийн хэмжээний барьц |
| | №10/31/02 | Баталгаа даатгалын гэрээ | А.Алтанцуя | | | А.Алтанцуя | N/A | | Өөрийн 1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөөр баталгаа гаргасан |
| 12 | №1020210101000018 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | А.Алтанцуя | 2021.02.02 | 2024.02.02 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 13 | №1050210101000096 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | А.Алтанцуя | 2022.03.01 | 2025.03.01 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 14 | №1050210100000256 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | А.Алтанцуя | 2022.03.09 | 2025.03.09 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | 2022.03.10 03/10 | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |
| 15 | №1050210103000007 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ | "Практикал даатгал" ХХК | 2022.10.14 | 2023.10.14 | ГЗ Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Мөнгөн хөрөнгийг итгэмжлэн удирдах |

УЛААНБААТАР ХОТ

BID BUSINESS INVEST DEVELOPMENT

2023 05 12 өдөр ГЭВ

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | | Харилцагчийн үнэт цаасны гадаад арилжааны зааварчилгын гэрээ | "ТиДиБи Капитал ҮЦК" ХХК | 2021.11.11 | 2024.04.15 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | MONMIN нэрийн үнэтэй үнэт цаасыг ҮЦК аар дамжуулан худалдан авах |
| 17 | №10502401010000017 | Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ | Г.Оркон | 2022.10.31 | 2024.04.30 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Хаалттай өрийн бичиг худалдах |
| 18 | №10502401010000019 | Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ | А.Алтансүх | 2022.11.01 | 2024.05.01 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Хаалттай өрийн бичиг худалдах |
| 19 | №10502401010000020 | Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ | А.Алтансүх | 2022.11.02 | 2024.05.02 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Хаалттай өрийн бичиг худалдах |
| 20 | №10502401030000008 | Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ | С.Отгонбат | 2021.09.25 | 2023.09.25 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Хаалттай өрийн бичиг худалдах |
| 21 | №10502401030000010 | Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ | С.Отгонбат | 2021.09.27 | 2023.09.27 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Хаалттай өрийн бичиг худалдах |
| 22 | №10502401030000011 | Хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ | С.Отгонбат | 2021.09.28 | 2023.09.28 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | Хаалттай өрийн бичиг худалдах |
| 23 | №BID-22/01 | Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гурвалсан гэрээ | Х.Гантөмөр "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК | 2022.10.13 | 2023.10.13 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Байгаа | N/A | Бонд худалдах |
| | №БГ-22/03 | Барьцааны гэрээ | "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК | | | | N/A | | ҮЛ хөдлөх хөрөнгө барьцаалсан 1.4 гэрээр төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн барьц |
| 24 | №BID-22/12 | Өрийн хэрэгсэл худалдах, худалдан авах гурвалсан гэрээ | Ж.Болдбаатар Б.Оюунжаргал "Өлзий энд Ко капитал ҮЦК" | 2022.11.10 | 2023.11.10 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Байгаа | N/A | Бонд худалдах |
| | №БГ-22/14 | Барьцааны гэрээ | "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК | | | | N/A | | ҮЛ хөдлөх хөрөнгө барьцаалсан 560 сая төгрөгийн үнийн дүн бүхий зээлийн барьц |
| 25 | №4653 | Зээлийн гэрээ | Microfinance Enhancement Facility SA, SICAV-SIF | 2022.03.17 | 2024.03.30 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | ББСБ нь зээл авсан |
| 26 | №BIDMON001 | Зээлийн гэрээ | EMF Microfinance Fund AGmvK | 2021.10.27 | 2024.12.10 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | ББСБ нь зээл авсан |
| 27 | №202008-0177 | Зээлийн гэрээ | Arbor FS Ltd | 2020.08.01 | 2023.08.31 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Үгүй | N/A | ББСБ нь зээл авсан |
| 28 | №ЗЗНГ/СС200424001 1 | Зээлийн шугамын эрх нээх гэрээ | Худалдаа хөгжлийн банк ХХК | 2020.04.28 | 2022.04.28 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Байгаа | 2020.09.11 09/13 | ББСБ нь зээлийн шугамын эрх нээлгүүлэв |
| | №ЗЗНГ/СС200424001 1 | Нэмэлт гэрээ | | 2022.04.15 | 2024.04.15 | | Байгаа | | Гэрээний хугацааг сунгаж зээлийн эрхийн хэмжээг 400 сая болгон бууруулав |
| 29 | №ЗЗНГ/СС210903016-2 | Зээлийн шугамын эрх нээх гэрээ | Худалдаа хөгжлийн банк ХХК | 2021.09.14 | 2024.09.14 | Г3 Ц.Бат-Эрдэнэ | Байгаа | 2021.08.27 08/27 | ББСБ нь зээлийн шугамын эрх нээлгүүлэв |

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО ХХК

318

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
ИБСХ
он 2023 сар 05 өдер 12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-03-28
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02



## БИЗНЕС-ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК-ИЙН НИЙТ ХӨРӨНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

1. Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдсэн оюуны өмчийн мэдээлэл.

| № | Улсын бүртгэлийн дугаар | Мэдүүлгийн бүртгэлийн дугаар | Барааны тэмдэг | Олон улсын ангилал | Анхдагч огноо | Хүчинтэй байх хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | 40-0025615 | 40-2021-0029534 | BID | 9,35,36,37,42,43,44 | 2021.11.08 | 2031.11.08 |
| 2. | 40-0025610 | 40-2021-0029519 | | 35,36,42 | 2021.09.17 | 2031.09.17 |
| 3. | 40-0025609 | 40-2021-0029518 | БИД | 35,36,42 | 2021.09.17 | 2031.09.17 |

2. Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдсэн үнэт цаасны мэдээлэл.

| № | Хувьцааны нэр | Төрөл | Тоо ширхэг | Хувь | Нийт үнийн дүн, үнэлгээ (төгрөгөөр болон ам.доллароор) | Үүрэг ногдуулсан хэлцэл байгуулсан эсэх, баталгаа, батлан даалт болон барьцаанд тавьсан эсэх /Тийм/Үгүй/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | АПУ | Хувьцаа | 44,490 | 0.00 | 64,065,600.00 ₮ | Үгүй |
| 2. | Мандал даатгал | Хувьцаа | 509,552 | 0.08 | 44,519,558.34 ₮ | Үгүй |
| 3. | Ард даатгал | Хувьцаа | 38,308 | 0.15 | 30,393,485.30 ₮ | Үгүй |
| 4. | Тумэн шувуут | Хувьцаа | 45,149 | 0.02 | 17,574,385.00 ₮ | Үгүй |
| 5. | Голомт Банк | Хувьцаа | 155,543 | 0.02 | 198,123,539.00 ₮ | Үгүй |
| 6. | Мандал ирээдүйн өсөлт | Хувьцаа | 88,7734 | 0.15 | 77,198,580.00 ₮ | Үгүй |
| 7. | MONMIN ҮНЭТ ЦААС | Бонд | Эхлэх 2021.11.15 Дуусах 2024.04.15 | | 219,000 $ | Үгүй |

3. Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн мэдээлэл.

| № | Улсын дугаар | Марк модель | Модель | Үйлдвэрлэсэн он | Үүрэг ногдуулсан хэлцэл бүртгэгдсэн эсэх лавлагаа, тодорхойлолтын дугаар, огноо | Үүрэг ногдуулсан хэлцэл бүртгэгдсэн эсэх /Тийм, Үгүй/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | 6724 УАК | Lexus | RX350-a20 | 2019 | 2023.01.23 | Үгүй |
| 2. | 0009 УНЗ | Lexus | LX570 | 2018 | 2023.01.23 | Үгүй |
| 3. | 6802 УНД | Toyota | Noah | 2009 | 2023.01.23 | Үгүй |

4. Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдсэн үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл

| № | Улсын бүртгэлийн дугаар | Байршил | Зориулалт | Эд хөрөнгийн талбайн хэмжээ | Үүрэг ногдуулсан хэлцэл бүртгэгдсэн эсэх лавлагааны огноо, дугаар | Үүрэг ногдуулсан хэлцэл бүртгэгдсэн эсэх /Тийм, Үгүй/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Ү-2201029202 | Улаанбаатар, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Сөүл гудамж, 11/1 байрлгын 4-р давхар 401 тоот | Оффис | 155.62 м2 | 2021.09.14 №36/СС2100003016-2-4 | Тийм |

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО АУДИТ ХХК

BIZ BUSINESS INVEST DEVELOPMENT

2023.05.12

Үнэт цаасны танилцуулга

БҮРТГЭВ-02

Хавсралт №07. Бизнес Инвест Девелопмент ББСБ ХХК-ийн нийт хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээлэл

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Ү-2202005264 | Улаанбаатар, Чингэлтэй дүүргийн 4-р хороо, Бага тойруу 13 байр, 4 тоот | Орон сууц | 55 м2 | 2021.09.14 №36/СС210903016-2-6 | Тийм |
| 3 | Ү-2204108148 | Улаанбаатар, Баянзүрх дүүргийн 15-р хороо, 13-р хороолол Энхтайвны өргөн чөлөө 47/9 байр 2 давхар 203 204 тоот | Үйлчилгээ | 58.17 м2 | 2021.09.14 №36/СС210903016-2-6 | Тийм |
| 4 | Ү-2203023914 | Улаанбаатар, Сүхбаатар дүүргийн 3-р хороо, 5 хороолол Сөүлийн гудамж 47 байр 1006 тоот | Орон сууц | 55.5 м2 | 2021.09.14 №36/СС210903016-2-6 | Тийм |
| 5 | Ү-2203029180 | Улаанбаатар, Сүхбаатар дүүргийн 2-р хороо, 5 хороолол Сөүл гудамж 11/1 дугаартай барилгын 6-р давхар тоот | Оффис | 221.63 м2 | 2021.09.14 №36/СС210903016-2-6 | Тийм |
| 6 | Ү-2203029103 | Улаанбаатар, Сүхбаатар дүүргийн 2-р хороо, 5 хороолол Сөүл гудамж 11/1 дугаартай барилгын 4-р давхар 402 тоот | Оффис | 67.35 м2 | 2021.09.14 №36/СС210903016-2-6 | Тийм |
| 7 | Ү-2101004199 | Орхон, Баян-Өндөр сум 3-р баг, Уурхайчин 3-р хороолол 17 байр 32 тоот | Орон сууц | 51 м2 | 2021.09.14 №36/СС210903016- | Тийм |
| 8 | Ү-2204077919 | Улаанбаатар, Баянзүрх дүүргийн 2-р хороо, Хорооллын хотхон, Их тойруу гудамж 60-р байр 3 давхар 6 хэсэг | Үйлчилгээ | 130 м2 | 2021.09.14 №36/СС210903016- | Тийм |
| 9 | Ү-2206085283 | Улаанбаатар, Хан Уул дүүргийн 14-р хороо Зуун мод 586/1 тоот | Амины орон сууц | 174.11 м2 | - | Үгүй |
| 10 | Ү-2203007998 | Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг 9-р хороо Алтайн 1 гудамж 10 тоот | Дэлгүүр | 151 м2 | - | Үгүй |

5. Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдсэн газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн мэдээлэл

| № | Гэрчилгээний төрөл | Гэрчилгээний дугаар № | Нэгж талбарын дугаар, байршил | Зориулалт, эзэмших хугацаа | Талбайн хэмжээ (м.кв) | Түрээс йогдуулсан хэлцэл бүртгэгдсэн эсэх, лавлагааны огноо, дугаар | Түрээс йогдуулсан хэлцэл бүртгэгдсэн эсэх /Тийм, Үгүй/ | Газрын төлбөрийн өртэй эсэх /Тийм, Үгүй/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эзэмших эрх | 1-000012421 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 9-р хороо Алтайн гудамж 1, 10 тоот | Худалдаа, үйлчилгээ 15 жил 2034.09.09 | 565 | №01-08/689 | Үгүй | Үгүй |

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК



УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК

BID BUSINESS INVEST DEVELOPMENT

2023 он 05 сар 12 өдөр БҮРТГЭВ № 01

Үнэт цаасны танилцуулга БҮРТГЭВ-02

Хавсралт №08. Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас авсан лавлагаа, тодорхойлолт

## БИЗНЕС-ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК-ТАЙ ХОЛБОГДУУЛАН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС АВСАН ЛАВЛАГАА, ТОДОРХОЙЛОЛТ

| № | Лавлагаа, тодорхойлолт гаргасан эрх бүхий байгууллагын нэр | Огноо, дугаар | Хуудасны тоо |
|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн зохицуулах хороо | 2023.02.15 №9/711 | 1 |
| 2 | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв | 2023.02.13 | 1 |
| 3 | Улсын бүртгэлийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн нэгдсэн архив | 2023.03.07 | 5 |
| 4 | Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн төвлөрсөн архив | 2023.02.08 №1/398 | 1 |
| 5 | Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар | 2023.02.14 №219 | 1 |
| 6 | Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар | 2023.02.09 №103 | 1 |
| 7 | Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар | 2023.02.09 №107 | 1 |
| 8 | Орхон аймаг дахь шүүхийн Тамгын газар | 2023.02.24 №18 | 1 |
| 9 | Орхон аймаг дахь шүүхийн Тамгын газар | 2023.02.24 №19 | 1 |
| 10 | Дархан-Уул аймаг дахь сум дундын шүүхийн Тамгын газар | 2023.02.24 №91 | 1 |
| 11 | Хөвсгөл аймаг дахь шүүхийн Тамгын газар | 2023.02.27 №1/194 | 1 |
| 12 | Цагдаагийн ерөнхий газар | 2023.02.06 №9BE5-5J3I-5RKQ-KPWQ | 1 |
| 13 | Цагдаагийн ерөнхий газар | 2023.02.06 №WGB3-WRCV-VW7N-TVP9 | 1 |
| 14 | Цагдаагийн Ерөнхий газар Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба | 2023.02.13 №136/420 | 1 |
| 15 | Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар | 2023.02.08 №192 | 1 |
| 16 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар | 2023.02.07 №4TVE-KDEZ-LWTR-BFXI | 1 |
| 17 | Оюуны өмчийн газар | 2023.03.01 №3/153 | 1 |
| 18 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Эд хөрөнгийн эрхийн баримтатай эсэх | 2023.02.08 | 16 |
| 19 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн цахим сан | 2023.02.06 | 3 |
| 20 | Нийслэлийн газар зохион байгуулалтын алба | 2023.02.15 №01-09/590 | 2 |
| 21 | Нийслэлийн газар зохион байгуулалтын алба | 2023.02.27 №01-08/680 | 1 |
| 22 | Авто тээврийн үндэсний төв | 2023.02.07 | 61 |
| 23 | Стандарт, хэмжил зүйн газар | 2023.02.14 №07/120 | 1 |
| 24 | МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр | 2023.02.07 №4/225 | 1 |
| 25 | Улаанбаатар хотын Худалдааны Танхим (УБХТ)-ын дэргэдэх Арбитр | 2023.02.08 №А-23/13 | 1 |

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ ... ХХК 6180858 2021031165 СТО2420

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

СЗХ 2023.03.13 өдөр БҮРТГЭВ № 01

Хавсралт №08. Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас авсан лавлагаа, тодорхойлолт

| | | | |
|---|---|---|---|
| 26. | Гаалийн ерөнхий газар | 2023.02.06<br>№BOLS-C25W-FKB2-AVT2 | 1 |
| 27. | Гаалийн ерөнхий газар | 2023.02.06<br>№S2JF-BTTL-7PGF-LROC | 1 |
| 28. | Зээлийн мэдээллийн сан | 2023.02.08 | 2 |
| 29. | Татварын тодорхойлолт | 2023.03.02<br>№23.1003.68f71c82-0f99-4389-9372-9e8716b35551 | 2 |
| 30. | Харьяа дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс | 2023.02.02 | 1 |
| НИЙТ | | | 114 |

БИД БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013568 9023010137

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК 6103855 9021031195 СТС2420

BiD BUSINESS INVEST DEVELOPMENT
СЗХ 2023.05.12 өдөр БҮРТГЭВ Нууц баримт

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-03-28
БҮРТГЭВ-02

## (Хуулийн нэмэлт дүгнэлт)

ӨМГӨӨЛЛИЙН БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХН

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 15, Монгол ТВ цамхаг, 10-р давхар, 1001-1003 тоот, Утас/Факс: (+976) 7711 9008, Цахим шуудан: contact@bnp.mn, Веб: www.bnp.mn

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.БАТ-ЭРДЭНЭ
ТАНАА

Огноо: 2023 03 23
Дугаар: BNP-20/23
Утга: Хуулийн нэмэлт дүгнэлт

**Хуулийн нэмэлт дүгнэлт хүргүүлэх тухай**

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН (цаашид "**Хуулийн фирм**" гэх) нь танай компанитай 2023 оны 02 сарын 06-ны өдөр байгуулсан №02/06/01 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК (цаашид "**БИД ББСБ ХХК**", "**Үнэт цаас гаргагч**" эсхүл "**ББСБ**" гэх)-ийн нийтэд санал болгон гаргаж буй өрийн бичиг (цаашид "**Өрийн бичиг**" эсхүл "**Бонд**" гэх)-ийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах хөндлөнгийн дүн шинжилгээг хийж, 2023 оны 03 сарын 09-ний өдөр №BNP-05/23 тоот Хуулийн дүгнэлт (цаашид "**Хуулийн дүгнэлт**" гэх)-ийг хүргүүлсэн.

БИД ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй өрийн бичгийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэх гэж байгаатай холбогдуулан Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн өрийн бичиг гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол болон төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд өөрчлөлт оруулсантай холбогдуулан Үнэт цаас гаргагчаас тавьсан хүсэлтэд үндэслэн Хуулийн фирм нь энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлтийг бэлтгэн хүргүүлж байна. Хуулийн фирмийн бэлтгэсэн энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлт нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний салшгүй хэсэг болно.

Хуулийн фирм нь энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлтийг Үнэт цаас гаргагчаас хүлээлгэн өгсөн баримт бичиг, материал, тэдгээрт агуулагдсан баримтат мэдээлэлд үндэслэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд энд дурдагдсан зорилгоор хийж гүйцэтгэсэн бөгөөд хийж гүйцэтгэсэн бөгөөд Хуулийн нэмэлт дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд Хуулийн нэмэлт дүгнэлт гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон бол Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

**Дүн шинжилгээ, дүгнэлт**

**Нэг. Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах шийдвэр нь хуульд нийцсэн хүчин төгөлдөр эсэх асуудлаар:**

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-аас өрийн бичгийн нөхцөлд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор холбогдох тогтоол, шийдвэрт өөрчлөлт оруулан дараах тогтоол, шийдвэрийг гаргасан байна. Үүнд:

(i) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 22-ны өдрийн №03/22 тоот Тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоол;
(ii) Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 22-ны өдрийн №03/22-01 тоот Тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоол;



БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ

СЗХ
BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 оны ... сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01
Эх хувь

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

(iii) Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 03 сарын 22-ны өдрийн №03/22 тоот Тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоол.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 22-ны өдрийн №03/22 тоот Тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолоор Үнэт цаас гаргагчийн гаргаж буй өрийн бичгийн хэмжээ, хүүгийн хэмжээнд өөрчлөлт оруулж нийт 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн бичгийг 18 (арван найман) сарын хугацаатай гаргахаар өөрчилж, өрийн бичгийг хэд хэдэн удаа хэсэгчлэн санал болгох нөхцөлийг хасаж, өрийн бичиг гаргах нөхцөлийг шинэчлэн батлаж шийдвэрлэсэн байна. Тус тогтоолын Хавсралт №1-д тусгасан өрийн бичиг гаргах нөхцөлөөс үзвэл нэг бүр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 80,000 (наян мянган) ширхэг нийт 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий, тогтмол хүүтэй, 18 (арван найман) сарын хугацаатай, жилийн 18.5 (арван найм аравны таван) хувийн хүүтэй, хагас жил тутамд хүү төлөгдөх давтамжтай өрийн бичиг гарган Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон нээлттэй арилжих, хөрөнгө татан төвлөрүүлэх, өрийн бичгийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн хувийн батлан даалт гаргасан нөхцөлийг тусгаж шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 сарын 22-ны өдрийн №03/22-01 тоот Тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолоор өрийн бичгийн дүн өөрчлөгдсөн холбоотойгоор их хэмжээний хэлцлийн дүнд өөрчлөлт оруулж, зөвшөөрөл олгож шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын үндэслэлийг дүгнэж үзвэл Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалтад "төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах бүрэн эрхтэй". Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэгт "Компанийн өрийн хэрэгсэл нь тус хуулийн зохицуулалтад хамрагдах үнэт цаасанд хамаарна, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Үнэт цаасыг нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргаж болно" гэж тусгасан нь өрийн бичиг гаргах эрх нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бүрэн эрхэд хамаарч байна. Түүнчлэн Компанийн нийтэд санал болгох өрийн бичгийг Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд бүртгэх харилцааг зохицуулж буй Санхүүгийн зохицуулах хорооны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын холбогдох заалт болон Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн дүрмийн холбогдох заалтыг тус тогтоолын үндэслэл хэсэгт тусгасан байна. БИД ББСБ ХХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.5 дахь заалтад "Компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах" асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэрлэхээр тусгасан байх тул өрийн бичиг гаргах эрх нь төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бүрэн эрхэд хамаарна гэж үзлээ.

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын дарга гарын үсэг зурна", 80.5 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно", 80.6 дахь хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй, эсхүл компанийн дүрмээр тусгайлан өндөр хувь тогтоогоогүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно", Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.11 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гарах бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна", 10.12 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал саналын эрхтэй ишүүдийнх нь дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож байгаа саналын эрхтэй гишүүдийн олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно" гэж тус тус заасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн тус тогтоолд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан бөгөөд хурлын тэмдэглэлд Төлөөлөн удирдах зөвлөлийн 6 (зургаан) гишүүн 100.00% ирцтэйгээр оролцож, эсрэг санал тэмдэглэгдээгүй бөгөөд хурлын тэмдэглэлд тус асуудлыг дэмжиж төлөөлөн удирдах зөвлөлийн 6 (зургаан) гишүүн гарын үсэг зурж



БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023. 05. 12
Нууц баримт

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023 -03- 28
БҮРТГЭВ-02

баталгаажуулсан байх тул Төлөөлөн удирдах зөвлөлийн тус тогтоол нь компанийн эрх барих байгууллагаас бүрэн эрхийн хүрээнд гаргасан хүчин төгөлдөр тогтоол байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Үнэт цаас гаргагчийн гаргаж буй өрийн бичгийн тоо, нөхцөлд өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн тус тогтоол нь Компанийн тухай хуульд заасан өрийн бичиг гаргах шийдвэрт тусгавал зохих зүйлийг тусгасан, Компанийн эрх барих байгууллага төлөөлөн удирдах зөвлөл бүрэн эрхийн хүрээнд гаргасан бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан шийдвэр байх тул Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд нийцсэн байна гэж дүгнэлээ.

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 03 сарын 22-ны өдрийн №03/22 тоот Тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолоор Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 02 сарын 24-ний өдрийн №02/24-01 тоот Батлан даалт гаргах тухай тогтоол болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 сарын 24-ний өдрийн Өөрийн хөрөнгө барьцаалах тухай №02/24 тоот тогтоолд (i) Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 сарын 24-ний өдрийн "Батлан даалт гаргах тухай" №02/24-01 дугаартай тогтоолын 1 дэх хэсэгт "... нэзлттэй санал болгох 10,000,000,000.00 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичиг ..." гэснийг "... нийт 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн бичиг ..." хэмээн өөрчлөх; (ii) Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 сарын 24-ний өдрийн "Батлан даалт гаргах тухай" №02/24-01 дугаартай тогтоолын 3 дахь хэсэгт "... андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК"ХХК – тай Баталгааны гэрээ байгуулахаар..." гэснийг "... андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК"ХХК – тай Батлан даалтын гэрээ байгуулахаар ..." хэмээн өөрчлөх; (iii) Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 сарын 24-ний өдрийн "Өөрийн хөрөнгө барьцаалах тухай" №02/24 дугаартай тогтоолын 1 дэх хэсэгт "... нээлттэй санал болгох 10,000,000,000.00 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичиг ..." гэснийг "... нийт 8,000,000,000.00 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн бичиг ..." хэмээн өөрчлөх; (iv) Өрийн бичгийн үнийн дүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан "Батлан даалтын гэрээ"-ний нэмэлт өөрчлөлтийн гэрээ байгуулах; болон (v)Өрийн бичгийн үнийн дүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан "Барьцааны гэрээ"-нд нэмэлт өөрчлөлт оруулах, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц. Бат-Эрдэнэ)-д үүрэг болгож шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын үндэслэлийг дүгнэж үзвэл Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт "Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна", Компанийн дүрмийн холбогдох хэсэг болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 03 сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн шийдвэрлэсэн байх тул Компанийн эрх барих дээд байгууллага өөрийн бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр байна гэж үзлээ.

Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт "энэ хууль болон компанийн дүрэмд зааснаас дээгүүр хувь тогтоогоогүй, эсхүл хуульд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөл/байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт "Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно" гэж заасан. БИД ББСБ ХХК-ийн дүрмийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох хуульд заасан хэмжээ, шалгуурыг нэмэгдүүлсэн нөхцөл, журам тусгаагүй болно. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоос үзвэл БИД ББСБ ХХК-ийн саналын эрхтэй 5,000,001 (таван сая нэг) ширхэг энгийн хувьцааг 100.00% эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч гарын үсэг зурж баталгаажуулсан байх тул тус тогтоол нь компанийн эрх барих дээд байгууллагаас бүрэн эрхийн хүрээнд гаргасан хүчин төгөлдөр тогтоол байна гэж үзэх үндэслэлтэй байна.

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК

BiD BUSINESS INVEST DEVELOPMENT
он сар өдөр
2023 он 05 сар 13 өдөр
Нууц баримт
Эх хувь

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

Нэгтгэн дүгнэж үзвэл БИД ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал болон төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан эдгээр тогтоол, шийдвэр нь Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд нийцсэн хүчин төгөлдөр байна гэж үзлээ. Цаашид Үнэт цаас гаргагч нь Компанийн эрх барих байгууллагаас гаргаж буй тогтоол, шийдвэрийн үндэслэл хэсэгт холбогдох дүрэм, журмын заалтыг заалт бүрээр тодорхой тусгаж оруулж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

**Хоёр. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан өөрчлөлт нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь андеррайтер компани Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-ийн бэлтгэсэн Үнэт цаасны танилцуулгад оруулсан өөрчлөлттэй танилцаж дүн шинжилгээ хийсэн бөгөөд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий өөрчлөлт болох Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгож байгаа өрийн бичгийн нөхцөл нь Хуулийн фирмд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн өрийн бичгийн нөхцөлд өөрчлөлт оруулсан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрт тусгагдсан нөхцөл, баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирм дүгнэж байна.

**Гурав. Барьцааны гэрээ, Бондын гэрээ, Батлан даалтын гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь БИД ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон нээлттэй өрийн бичиг гаргахтай холбогдуулан байгуулсан барьцааны гэрээ, Бондын гэрээ, Батлан даалтын гэрээ нь хуульд нийцсэн хүчин төгөлдөр эсэхэд дүгнэлт өглөө.

(i) **Барьцааны гэрээ:**

БИД ББСБ ХХК нь нийтэд санал болгон гаргаж буй нээлттэй өрийн бичгийн төлбөрийн баталгаа болгож 2023 оны 03 сарын 03-ны өдөр андеррайтер Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК- №БГ-23/06 дугаартай Барьцааны гэрээ байгуулсан бөгөөд өрийн бичгийн нөхцөлд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор 2023 оны 03 сарын 22-ны өдөр №БГН-23/06 тоот Барьцааны гэрээний нэмэлт өөрчлөлтийг байгуулсан байна. Тус Барьцааны гэрээний дагуу БИД ББСБ ХХК нь өөрийн хөрөнгийг барьцаалсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №226 тоот тогтоолоор батлагдсан Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.8 дахь хэсэгт "..... эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг барьцаалах бол барьцааны гэрээг нэг талаас бонд гаргагч, нөгөө талаас хөрөнгө оруулагчдыг төлөөлөн андеррайтер байгуулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна" гэж заасан. Энэхүү зохицуулалтын дагуу Үнэт цаас гаргагч нь Барьцааны гэрээг зохих этгээдтэй байгуулсан бөгөөд талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж тамга, тэмдгээр баталгаажуулсан байна. Мөн БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2023 оны 02 сарын 09-ний өдрийн №02/09 дугаартай тогтоол болон 2023 оны 03 сарын 22-ны өдрийн №03/22 тоот тогтоолоор компанийн өөрийн хөрөнгийг барьцаалан Барьцааны гэрээ байгуулах зөвшөөрлийг олгосон байна.

Иргэний хуулийн 154 дүгээр зүйлд барьцааны зүйл нь хөдлөх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, ирээдүйд бий болох хөрөнгө байж болохоор тусгасан. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт "Иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа, эсхүл ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, бүх төрлийн хувьцаа, үнэт цаас, шаардах эрх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загвар болон бусад хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө нь барьцааны зүйл байж болно" гэж тус тус заасан байна. Мөн Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэгт "..... барьцаа хөрөнгө нь ...... бусад төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хэлбэртэй байна" гэж

BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК

зохицуулсан байна. Иймд БИД ББСБ ХХК-аас нийтэд санал болгон нээлттэй гаргах өрийн бичгийн барьцааны зүйл нь Компанийн эзэмшлийн хөрөнгө байж болохоор байна гэж үзлээ.

Барьцааны гэрээний нэмэлт, өөрчлөлтийг талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулан, тамга тэмдэг дарсан байх тул гэрээний агуулга, хэлбэр нь Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлтэй нийцсэн байна гэж үзсэн бөгөөд тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг болон 5 дугаар бүлэгт заасны дагуу барьцааны мэдэгдлийг холбогдох бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Хуулийн фирмээс зөвлөж байна.

(ii) **Бондын гэрээ**

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №226 тоот тогтоолоор баталсан Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэгт Бондын гэрээг бичгээр байгуулах бөгөөд нэг талаас бонд гаргагч нөгөө талаас хөрөнгө оруулагчдыг төлөөлж андеррайтер байгуулж баталгаажуулахаар зохицуулсан. Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК нь андеррайтер Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-тай 2023 оны 03 сарын 03-ны өдөр №БОГ-23/02 тоот Бондын гэрээ байгуулсан бөгөөд өрийн бичгийн нөхцөл өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тус гэрээнд 2023 оны 03 сарын 22-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэгт бондын гэрээнд тусгавал зохих мэдээллийг нарийвчлан заасан бөгөөд талуудын хооронд байгуулсан Бондын гэрээнд дээрх мэдээллийг бүрэн тусгасан байна. Иймд Хуулийн фирмийн зүгээс Бондын гэрээ нь гэрээний хэлбэр болоод агуулгын шаардлага хангасан Иргэний хууль болоод холбогдох бусад хууль, журамд нийцсэн хүчин төгөлдөр гэрээ гэж дүгнэлээ.

(iii) **Батлан даалтын гэрээ**

Нийтэд санал болгон нээлттэй өрийн бичиг гаргахтай холбоотойгоор өрийн бичгийн төлбөрийн баталгаа болгож БИД ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчид болох иргэн А.Алтансүх, Х.Одонтуяа нар 2023 оны 02 сарын 24-ний өдөр №БД-23/02 дугаартай Батлан даалтын гэрээг Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-тай байгуулсан байна. Өөрөөр хэлбэл Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нь өрийн бичгийн төлбөрийн баталгаа болгож өрийн бичиг гаргагч буюу үүрэг гүйцэтгэгч өөрийн үүргийг гүйцэтгэж чадна гэж үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө батлаж, гүйцэтгэхгүй бол өөрийн хөрөнгөөр хариуцаж үүрэг хүлээхээр хувийн батлан даалт гаргасан байна. Тус Батлан даалтын гэрээнд иргэн А.Алтансүх, Х.Одонтуяа нар гарын үсэг зурж баталгаажуулсан байх бөгөөд хэрэв талууд хүсвэл гэрээг нотариатаар баталгаажуулж болохыг Хуулийн фирмээс уламжилж байна. Тус Батлан даалтын гэрээ Иргэний хуулийн 234 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байх тул холбогдох хуульд нийцсэн байна гэж үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлөөс өрийн бичиг гаргахтай холбогдуулан гаргасан тогтоол, шийдвэр нь Иргэний хууль, Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд нийцсэн, хуульд заасан шаардлагыг хангасан, Компанийн эрх барих дээд байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр байх бөгөөд андеррайтертай байгуулсан Батлан даалтын гэрээ, Барьцааны гэрээ нь хэлбэр болон агуулгын хувьд холбогдох хууль, журам, дүрэмд нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна гэж Хуулийн фирмийн зүгээс үзлээ.

-----ooOoo-----

BID BUSINESS INVEST DEVELOPMENT

СЭХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
Нууц баримт
Эх хувь

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ-02

**Хариуцлага хязгаарлах тухай**

Энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлтийг зөвхөн Үнэт цаас гаргагчийн тавьсан тухайлсан асуултын хүрээнд хийгдсэн бөгөөд хуулийн дүгнэлтийг хийхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг ашигласан

Энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлтийг БИД ББСБ ХХК-ийн нэр дээр бэлтгэсэн бөгөөд Хуулийн нэмэлт дүгнэлтийг харилцан тохиролцсоноос бусад зорилгоор ашигласан, түгээсэн, бусдад танилцуулсан, тайлбарласан, хэсэгчлэн задруулсан, нийтэд ил болгосноос үүсэх асуудлаар Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй бөгөөд энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа болон нийтэд санал гаргаж буй өрийн бичиг гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй

Хуулийн фирм нь хараат бус байх, гаргаж өгсөн баримт материалын хүрээнд дүн шинжилгээ хийх зарчмыг баримтлан хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн тул дүн шинжилгээнд хамруулах шаардлагатай чухал үйл баримт, БИД ББСБ ХХК-аас орхигдуулсан аливаа бусад гол баримт, материал, буруу дутуу, худал мэдээлэл гаргаж өгсөн, дүн шинжилгээ хийхэд ашигласан лавлагаа, тодорхойлолт бусад баримт материалд дурдагдсан хууль зүйн ач холбогдолтой аливаа нөхцөл, байдал дүн шинжилгээ хийснээс хойш Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн гарах аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй бөлно

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ХУЛАН

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК

Үнэт цаасны танилцуулга

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-11
БҮРТГЭВ-02

BiD BUSINESS INVEST DEVELOPMENT
СЭХ 2023.05.12 өдөр БҮРТГЭВ
Нууц баримт № 01

ӨМГӨӨЛЛИЙН БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХН

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 15, Монгол ТВ цамхаг, 10-р давхар, 1001-1003 тоот, Утас/Факс: (+976) 7711 9008, Цахим шуудан: contact@bnp.mn. Веб: www.bnp.mn

БИЗНЕС-ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.БАТ-ЭРДЭНЭ
ТАНАА

Огноо: 2023.04.26
Дугаар: BNP-27/23
Утга: Хуулийн нэмэлт дүгнэлт

**Хуулийн нэмэлт дүгнэлт хүргүүлэх тухай**

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН (цаашид **"Хуулийн фирм"** гэх) нь танай компанитай 2023 оны 02 сарын 06-ны өдөр байгуулсан №02/06/01 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу Бизнес-Инвест Девелопмент ББСБ ХХК (цаашид **"БИД ББСБ ХХК"** эсхүл **"Үнэт цаас гаргагч"** гэх)-ийн нийтэд санал болгон гаргаж буй өрийн бичиг (цаашид **"Өрийн бичиг"** эсхүл **"Бонд"** гэх)-ийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах хөндлөнгийн дүн шинжилгээг хийж 2023 оны 03 сарын 09-ний өдөр №BNP-05/23 тоот Хуулийн дүгнэлт болон 2023 оны 03 сарын 23-ны өдөр №BNP-20/23 тоот Хуулийн нэмэлт дүгнэлт (хамтад нь **"Хуулийн дүгнэлт"** гэх)-ийг хийж гүйцэтгэсэн.

БИД ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй Өрийн бичгийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдуулан Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК-ийн Өрийн бичгийн үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Барьцааны гэрээ, Батлан даалтын гэрээг шинэчлэн байгуулсан болон Хуулийн дүгнэлтийг хийж гүйцэтгэсэн өдрөөс хойш Голомт банктай Зээлийн шугамын гэрээ байгуулсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаас гаргагчаас тавьсан хүсэлтэд үндэслэн Хуулийн фирм нь энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлтийг бэлтгэн хүргүүлж байна. Хуулийн фирмийн бэлтгэсэн энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлт нь Хуулийн дүгнэлтийн салшгүй хэсэг болно.

Хуулийн фирм нь энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлтийг Үнэт цаас гаргагчаас хүлээлгэн өгсөн баримт бичиг, материал, тэдгээрт агуулагдсан баримтат мэдээлэлд үндэслэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд энд дурдагдсан зорилгоор хийж гүйцэтгэсэн бөгөөд хийж гүйцэтгэсэн бөгөөд Хуулийн нэмэлт дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд Хуулийн нэмэлт дүгнэлт гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон бол Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

**Дүн шинжилгээ, дүгнэлт**

**Нэг. Бусадтай байгуулсан зээлийн гэрээ болон Барьцааны гэрээ, Батлан даалтын гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх асуудлаар:**

Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК нь Хуулийн дүгнэлтийг хийж гүйцэтгэсэн өдрөөс хойш буюу 2023 оны 03 сарын 30-ны өдөр Голомт банктай №3ГС110039141-1/LNFL тоот Зээлийн шугамын гэрээг байгуулсан байна. Тус гэрээгээр зээлдэгч буюу БИД ББСБ ХХК-д 1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) төгрөг хүртэлх зээлжих эрхийг 12 (арван хоёр) сарын хугацаатайгаар нээсэн байна. Өөрөөр хэлбэл зээлдэгч нь уг зээлийн шугамын гэрээний хүрээнд шаардлагагүй бол зээл авахгүй байж болох бөгөөд зээл авах тохиолдолд зээлжих эрхийн хэмжээнд багтаан зээл авах эрхтэй байх хэлбэрээр зохицуулсан гэрээ байна. Зээлийн мэдээллийн сангийн 2023 оны 04 сарын

BiD БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ

26-ны өдрийн лавлагаанаас үзвэл БИД ББСБ ХХК нь зээлийн төлбөрийн үлдэгдэлгүй бөгөөд зээлийн ангилал нь хэвийн байна. Иймд энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК нь Голомт банкнаас ямар нэгэн зээл аваагүй болохыг дурдаж байна.

Голомт банктай байгуулсан Зээлийн шугамын гэрээ нь БИД ББСБ ХХК-ийн хувьд их хэмжээний хэлцэлд тооцогдохгүй болохыг дурдаж байна. Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна. (*БИД ББСБ ХХК-ийн их хэмжээний хэлцэлтэй холбоотой мэдээллийг Хуулийн дүгнэлтийн Дөрөвдүгээр хэсгийн "Сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх" гэсэн хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү*). Энэхүү Зээлийн шугамын гэрээ нь холбогдох хууль, тогтоомжид нийцсэн, хүчин төгөлдөр гэрээ байна гэж Хуулийн фирмийн зүгээс үзлээ.

Зээлийн шугамын гэрээтэй холбогдуулан Голомт банк нь үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа болгох үүднээс 6 (зургаан) ипотекийн гэрээ буюу үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг БИД ББСБ ХХК-тай байгуулсан байна. Эдгээр гэрээнээс үзвэл 9 (есөн) үл хөдлөх эд хөрөнгө барьцаалснаас 3 (гурав) нь БИД ББСБ ХХК-ийн өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгө байна. Зээлийн шугамын гэрээний нэмэлт нөхцөлийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу БИД ББСБ ХХК нь 1 (нэг) тэрбум төгрөгөөс дээш үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн хэлцэл хийх тохиолдолд Голомт банкинд мэдэгдэх үүрэг хүлээсэн байна. Зээлийн шугамын гэрээний хүрээнд хүлээсэн үүргийн дагуу БИД ББСБ ХХК нь 2023 оны 04 сарын 18-ны өдрийн №04/18-03 тоот албан бичгээр 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй өрийн бичиг гаргахаа Голомт банкинд мэдэгдсэн. Улмаар Голомт банкны 2023 оны 04 сарын 20-ны өдрийн №02/1981 тоот Мэдэгдэл хүлээн авсан тухай албан бичгийг ирүүлсэн бөгөөд тус албан бичигт БИД ББСБ ХХК нь 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн нээлттэй өрийн бичиг гаргах тухай мэдэгдлийг хүлээн авсан болохоо илэрхийлсэн байна. Иймд БИД ББСБ ХХК нь тус гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлж мэдэгдлийг хүргүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

Худалдаа, Хөгжлийн банкнаас ирүүлсэн албан тоотын тухайд БИД ББСБ ХХК нь тус банктай 2020 оны 04 сарын 28-ны өдөр болон 2021 оны 09 сарын 14-ний өдөр тус тус Зээлийн эрх нээх гэрээг байгуулсан. (*Энэхүү гэрээтэй холбоотой мэдээллийг Хуулийн дүгнэлтийн Дөрөвдүгээр хэсгийн "Зээлийн гэрээ" гэсэн хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү*). Тус гэрээнд заасны дагуу зээлдэгч буюу БИД ББСБ ХХК нь аливаа хөрөнгө оруулалт хийх, бусад банк, санхүүгийн байгууллагаас зээлийн санхүүжилт авах тохиолдолд банкинд урьдчилан бичгээр мэдэгдэж, зөвшилцөх үүрэг хүлээсэн. Энэ үүргийн дагуу БИД ББСБ ХХК нь 2023 оны 04 сарын 20-ны өдрийн №040/20/03 тоот албан бичгээр Худалдаа, Хөгжлийн банкинд 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй өрийн бичиг гаргах тухай мэдэгдсэн. Үүний хариуд Худалдаа, Хөгжлийн банк нь 2023 оны 04 сарын 20-ны өдөр №6/3956 тоот Мэдэгдэлд хариу хүргүүлэх тухай албан бичгийг ирүүлсэн бөгөөд тус албан бичигт төгрөгийн өрийн бичгийг дотоодын биржийн зах зээлд гаргахад татгалзах зүйлгүй болохоо илэрхийлсэн байна. Иймд БИД ББСБ ХХК нь Зээлийн эрх нээх гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлж мэдэгдлийг Худалдаа, Хөгжлийн банкинд хүргүүлсэн гэж үзэх үндэслэлтэй байна. Зээлийн мэдээллийн сангийн 2023 оны 04 сарын 26-ны өдрийн лавлагаанаас үзвэл БИД ББСБ нь Худалдаа, Хөгжлийн банкинд зээлийн төлбөрийн үлдэгдэлгүй бөгөөд зээлийн ангилал нь хэвийн байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-11
БҮРТГЭВ-02

Үнэт цаасны танилцуулга

Барьцааны гэрээний тухайд авч үзвэл Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК нь нийтэд санал болгон гаргаж байгаа өрийн бичгийн үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлтийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор, төлбөрийн баталгаа болгож 2023 оны 04 сарын 15-ны өдөр №БГ-23/03 тоот Барьцааны гэрээг андеррайтер Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-тай шинэчлэн байгуулсан байна. Энэхүү Барьцааны гэрээний дагуу БИД ББСБ ХХК нь өөрийн хөрөнгө, ирээдүйд олох орлого, үндсэн үйл ажиллагаа болон борлуулалтаас олох мөнгөн хөрөнгийг барьцаалсан байна. БИД ББСБ ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 сарын 24-ний өдрийн №02/24 тоот тогтоолоор Барьцааны гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосон. Талуудын хооронд 2023 оны 03 сарын 03-ны өдөр байгуулсан №БГ-23/06 тоот Барьцааны гэрээ болон 2023 оны 03 сарын 22-ны өдөр байгуулсан №БГН-23/06 тоот Барьцааны гэрээний нэмэлт, өөрчлөлтийг 2023 оны 04 сарын 15-ны өдөр талууд харилцан тохиролцож хүчингүй болгосон Гэрээ дүгнэсэн актыг Хуулийн фирмд ирүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн №226 дугаар тогтоолоор батлагдсан Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.8 дахь хэсэгт *"..... эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг барьцаалах бол барьцааны гэрээг нэг талаас бонд гаргагч, нөгөө талаас хөрөнгө оруулагчдыг төлөөлөн андеррайтер байгуулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна"* гэж заасан. Энэхүү журмын зохицуулалтын дагуу барьцааны гэрээг зохих этгээдтэй байгуулж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Мөн БИД ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2023 оны 02 сарын 09-ний өдрийн №02/09 тоот тогтоолоор өөрийн хөрөнгийг барьцаалан Барьцааны гэрээ байгуулах зөвшөөрлийг олгож шийдвэрлэсэн байгааг дурдаж байна.

Иргэний хуулийн 154 дүгээр зүйлд барьцааны зүйл нь хөдлөх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, ирээдүйд бий болох хөрөнгө байж болохоор тусгасан. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт *"Иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа, эсхүл ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, бүх төрлийн хувьцаа, үнэт цаас, шаардах эрх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загвар болон бусад хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө нь барьцааны зүйл байж болно"* гэж тус тус заасан. Мөн Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэгт *"..... барьцаа хөрөнгө нь ....... бусад төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хэлбэртэй байна"* гэж зохицуулсан. Эдгээр зохицуулалтаас үзвэл БИД ББСБ ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй өрийн бичгийн барьцааны зүйл нь компанийн өөрийн хөрөнгө байж болохоор байна гэж Хуулийн фирмээс үзэж байна. Барьцааны гэрээг талуудыг төлөөлөх эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байх тул гэрээний агуулга, хэлбэр нь Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлтэй нийцэж байгаа бөгөөд тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг болон 5 дугаар бүлэгт заасны дагуу барьцааны мэдэгдлийг холбогдох бүртгэлийн байгууллагад бүртгүүлж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

Батлан даалтын гэрээний тухайд авч үзвэл Үнэт цаас гаргагч БИД ББСБ ХХК нь нийтэд санал болгон өрийн бичиг гаргахтай холбоотойгоор үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож хувьцаа эзэмшигч Монгол Улсын иргэн А.Алтансүх болон Монгол Улсын иргэн Х.Одонтуяа нар 2023 оны 04 сарын 15-ны өдөр №БД-23/03 тоот Батлан даалтын гэрээг андеррайтер Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-тай шинэчлэн байгуулсан байна. Тус Батлан даалтын гэрээнд Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр болон Монгол Улсын иргэн А.Алтансүх болон Монгол Улсын иргэн Х.Одонтуяа нар гарын үсэг зурж нотариатаар гэрчлүүлсэн байна. Өөрөөр хэлбэл нэлээттэй өрийн бичиг гаргагч компанийн хувьцаа эзэмшигчид үүргийн гүйцэтгэлийг хангах нэмэлт баталгаа болгож хувийн батлан даалт гаргасан байна. Тус Батлан даалтын гэрээнд баталгаа гаргагч талууд хамт гарын үсэг зурсан нь хэлбэр болон агуулгын хувьд Иргэний хуулийн 45 дугаар бүлэгт заасан шаардлагыг хангасан, бичгээр байгуулж, талуудыг

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12 өдөр
Нууц баримт
Эх хувь 1
ЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-11
БҮРТГЭВ-02

төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байх тул холбогдох хуульд нийцсэн, хүчин төгөлдөр гэрээ байна гэж Хуулийн фирм үзлээ.

**Хоёр. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан өөрчлөлт нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь андеррайтер компани Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-ийн бэлтгэсэн Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан өөрчлөлттэй танилцаж дүн шинжилгээ хийсэн бөгөөд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын шийдвэрт материаллаг нөлөө үзүүлэхүйц өөрчлөлт болох Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгож байгаа өрийн бичгийн нөхцөлд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор байгуулсан Бондын гэрээ болон шинэчлэн байгуулсан Барьцааны гэрээ, Батлан даалтын гэрээ нь Хуулийн фирмд Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн өрийн бичгийн нөхцөлд өөрчлөлт оруулсан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэр болон холбогдох баримт материалд тусгагдсан нөхцөл, баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад оруулсан хууль зүйн ач холбогдол бүхий өөрчлөлт нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирм үзлээ.

**Хариуцлага хязгаарлах тухай**

Энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлтийг зөвхөн Үнэт цаас гаргагчийн тавьсан тухайлсан асуултын хүрээнд хийгдсэн бөгөөд хуулийн дүгнэлтийг хийхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг ашигласан.

Энэхүү Хуулийн нэмэлт дүгнэлтийг **БИД ББСБ** ХХК-ийн нэр дээр бэлтгэсэн бөгөөд Хуулийн нэмэлт дүгнэлтийг харилцан тохиролцсоноос бусад зорилгоор ашигласан, түгээсэн, бусдад танилцуулсан, тайлбарласан, хэсэгчлэн задруулсан, нийтэд ил болгосноос үүсэх асуудлаар Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй бөгөөд энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа болон нийтэд санал гаргаж буй өрийн бичигт гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй.

Хуулийн фирм нь хараат бус байх, гаргаж өгсөн баримт материалын хүрээнд дүн шинжилгээ хийх зарчмыг баримтлан хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн тул дүн шинжилгээнд хамруулах шаардлагатай чухал үйл баримт, БИД ББСБ ХХК-аас орхигдуулсан аливаа бусад гол баримт, материал, буруу дутуу, худал мэдээлэл гаргаж өгсөн, дүн шинжилгээ хийхэд ашигласан лавлагаа, тодорхойлолт бусад баримт материалд дурдагдсан хууль зүйн ач холбогдолтой аливаа нөхцөл, байдал дүн шинжилгээ хийснээс хойш Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн гарах аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй болно.

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ХУЛАН

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-11
БҮРТГЭВ-02

2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2013.06.18 — / Бүртгэсэн он сар өдөр /

№ 00007 5992

9022001074 — / Улсын бүртгэлийн дугаар /

5722292 — / Регистрийн дугаар /

Өмгөөллийн батбаяр энд партнерс ХХН — Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Гэрээ

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Тогтоол | 01/14 | 2014.02.21 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он сар өдөр / |

| 6910 | Хууль зүйн зөвлөгөө өгөх |
|---|---|
| / код / | / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |

/ код / — / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 2 | 100.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Монгол тэ цамхаг оффисийн 10давхар 1001-1003 , Утас1: 88119007, Утас2: 99109007, Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2014 он 3 сар 10 өдөр

БИД БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ 5013348 Д.Б. 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5103055 9021031135

BUSINESS INVEST DEVELOPMENT

2023.05.12

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-05-11
БҮРТГЭВ-02

## Харилцах дансны бүртгэл

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн ажилтан тэмдэг |
|---|---|---|---|
| *Худалдаа хөгжлийн банк* | *Төгрөгийн* | *470006252* | *Э.Эрдэнэбилэг* |
| *Худалдаа хөгжлийн банк* | *Валютын* | *470006253* | *Э.Эрдэнэбилэг* |

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Ганбаяр овогтой Батбаяр-г Захирал-р томилсныг бүртгэв* | *2013.06.18* | *Э.Эрдэнэбилэг* |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | *2014.03.10* | *У.Дэвээсүрэн* |
| 2 | *Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.* | ***2016.08.26*** | *М.Монголжин* |
| 3 | *Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.* | ***2017.06.06*** | *Б.Гэрэлзул* |
| 4 | *Баяраа овогтой Баасандорж-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв* | *2019.11.20* | *Б.Алтанхуяг* |
| 5 | *Хувьцаа эзэмшигч 2 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.* | *2021.11.27* | *Г.Болормаа* |
| 6 | [illegible] | *2022.02.22* | *Э.Эрдэнэбилэг* |
| 7 | *Даваа овогтой Хулан-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* | *2022.02.22* | *Э.Эрдэнэбилэг* |
| 8 | *Хувьцаа эзэмшигч 2 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.* | *2022.02.22* | *Э.Эрдэнэбилэг* |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдэж ашигласан Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5133855
9021031135

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 11
БҮРТГЭВ-02

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

# МОНГОЛ УЛС
# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
# ТОГТООЛ

2014 оны 03 сарын 12 өдөр Дугаар 72 Улаанбаатар хот

**Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. "Өмгөөллийн батбаяр энд партнэрс" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг "Өмгөөллийн батбаяр энд партнэрс" ХХН /Г.Батбаяр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

BID
УЛААНБААТАР ХОТ
5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

## ХАВСРАЛТ 4- БАРЬЦАА, БАТЛАН ДААЛТ ГАРГАГЧИЙН ТОГТООЛ

BUSINESS INVEST DEVELOPMENT

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
5-р хороолол, 2-р хороо, /14251/
Сөүлийн гудамжны 11/1-р байрны 8-р давхарт
Утас: 70002028, 99117724
Факс: 976-11-312028
Имэйл: info@bid.mn
Вэб сайт: www.bid.mn

2023.02.24 № 02/24

танай ________ -ны № ________ -т

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Өөрийн хөрөнгө барьцаалах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, "Бизнес Инвест Девелопмент ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх) -ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан "Бизнес Инвест Девелопмент ББСБ" ХХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгох 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичиг ("Бонд")-ийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани өөрийн хөрөнгийг "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-д өрийн бичгийн хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлт төлөгдөж дуусах хүртэлх хугацаатайгаар барьцаалуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Компанийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хөндлөнгийн хараат бус үнэлгээний компаниар хийлгүүлэх, тус үнэлгээ болон Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэг, Компанийн 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг тус тус үндэслэн Компанийн өөрийн хөрөнгийн үнэлгээг тогтоосугай.
3. Өрийн бичгийг нийтэд санал болгож хөрөнгө татан төвлөрүүлэхтэй холбоотойгоор шаардагдах ажлыг зохион байгуулах, шаардлагатай гэрээ, хэлцэл байгуулах болон холбогдох бусад баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах, андеррайтер "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК-тай Барьцааны гэрээ байгуулах, гарын үсэг зурах болон шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүрт авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц. Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ: А.АЛТАНСҮХ

Х.ОДОНТУЯА

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
он сар 2 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 11
БҮРТГЭВ-02

BiD BUSINESS INVEST DEVELOPMENT

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
5-р хороолол, 2-р хороо, /14251/
Сөүлийн гудамжны 11/1-р байрны 8-р давхарт
Утас: 70002028, 99117724
Факс: 976-11-312028
Имэйл: info@bid.mn
Веб сайт: www.bid.mn

2023.02.24 № 01/24
танай ____________ -ны № ______________ -т

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Их хэмжээний хэлцэлд
зөвшөөрөл өгөх тухай

Компанийн тухай хуулийн 75 дугээр зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, "Бизнес Инвест Девелопмент ББСБ" ХХК (цаашид "ББСБ" гэх)-ийн Дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 10.4.16 дахь хэсэг, 16 дугаар зүйл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан "Бизнес Инвест Девелопмент ББСБ" ХХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгох 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичиг ("Бонд")-ийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани өөрийн хөрөнгийг "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-д өрийн бичгийн хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлт төлөгдөж дуусах хүртэлх хугацаатайгаар барьцаалуулахаар шийдвэрлэсүгэй.

2. Дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 10.4.16 дахь хэсэг, 16 дугаар зүйлд заасны дагуу их хэмжээний хэлцэл хийхийг Гүйцэтгэх захирал /Ц.Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй

BiD БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 ★ 9033010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

BUSINESS INVEST DEVELOPMENT

2023.05.12

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-11
БҮРТГЭВ-02

3. Өрийн бичгийг нийтэд санал болгож хөрөнгө татан төвлөрүүлэхтэй холбоотойгоор шаардагдах ажлыг зохион байгуулах, шаардлагатай гэрээ, хэлцэл байгуулах болон холбогдох бусад баримт бичигт Компанийг төлөөлж гарын үсэг зурах, андеррайтер "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК-тай Барьцааны гэрээ байгуулах, гарын үсэг зурах болон шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүрт авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц. Бат-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

Дарга А.АЛТАНСҮХ

Гишүүд Х.ОДОНТУЯА

С.ОТГОНБАТ

Б.АНХИЛУУН

Ц.БАТ-ЭРДЭНЭ

Б.ОТГОНДОРЖ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-11
БҮРТГЭВ-02

BUSINESS INVEST DEVELOPMENT
2023.05.12
БҮРТГЭВ
№001

BUSINESS INVEST DEVELOPMENT

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
5-р хороолол, 2-р хороо, /14251/
Сөүлийн гудамжны 11/1-р байрны 8-р давхарт
Утас: 70002028, 99117724
Факс: 976-11-312028
Имэйл: info@bid.mn
Вэб сайт: www.bid.mn

2023.02.24 № 02/24-01

танай ____________-ны №____________-т

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Батлан даалт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, "Бизнес Инвест Девелопмент ББСБ" ХХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн №02/24 тоот хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан "Бизнес Инвест Девелопмент ББСБ" ХХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгох 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичиг ("Бонд")-ийн үндсэн болон хүүгийн төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор батлан даалт гаргасугай.

2. Өрийн бичгийг нийтэд санал болгож хөрөнгө татан төвлөрүүлэхтэй холбоотойгоор хувьцаа эзэмшигч А.Алтансүх болон хувьцаа эзэмшигч Х.Отгонтуяа нь үндсэн болон хүүгийн төлбөрт хувийн батлан даалт гаргаж байгааг дурдсугай.

3. Өрийн бичгийг нийтэд санал болгож хөрөнгө татан төвлөрүүлэхтэй холбоотойгоор андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК" ХХК-тай Баталгааны гэрээ байгуулахаар шийдвэрлэсүгэй.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ: А.АЛТАНСҮХ

Х.ОДОНТУЯА

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9033010137

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

(Тогтоолын нэмэлт өөрчлөлт)

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК 2023.05.12 БҮРТГЭВ №01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-11 БҮРТГЭВ-02

BiD BUSINESS INVEST DEVELOPMENT

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
5-р хороолол, 2-р хороо, /14251/
Сөүлийн гудамжны 11/1-р байрны 8-р давхарт
Утас: 70002028, 99117724
Факс: 976-11-312028
Имэйл: info@bid.mn
Вэб сайт: www.bid.mn

2023.03.22 № 03/22

танай ________-ны №________-т

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, "Бизнес Инвест Девелопмент ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх) -ийн Дүрмийн холбогдох хэсэг болон Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн №03/22 хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн "Батлан даалт гаргах тухай" №02/24-01 дугаартай тогтоолын 1 дэх заалтад дараах өөрчлөлтийг оруулсугай.
   *"... нэрлэсэн санал болгох 10,000,000,000.00 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичиг ..."* гэснийг *"... нийт 8,000,000,000.00 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн бичиг ..."* хэмээн өөрчлөх;
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн "Батлан даалт гаргах тухай" №02/24-01 дугаартай тогтоолын 3 дах заалтад дараах өөрчлөлтийг оруулсугай.
   *"... андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК"ХХК –тай Баталгааны гэрээ байгуулахаар..."* гэснийг *"... андеррайтер "Өлзий энд Ко капитал ҮЦК"ХХК –тай Батлан даалтын гэрээ байгуулахаар ..."* хэмээн өөрчлөх;
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн "Өөрийн хөрөнгө барьцаалах тухай" №02/24 дугаартай тогтоолын 1 дэх заалтад дараах өөрчлөлтийг оруулсугай.
   *"... нэрлэсэн санал болгох 10,000,000,000.00 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичиг ..."* гэснийг *"... нийт 8,000,000,000.00 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн бичиг ..."* хэмээн өөрчлөх;
4. Өрийн бичгийн үнийн дүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан "Батлан даалтын гэрээ"-ний нэмэлт өөрчлөлтийн гэрээ байгуулахаар шийдвэрлэсүгэй.

BiD БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

5. Өрийн бичгийн үнийн дүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан "Барьцааны гэрээ"-нд нэмэлт өөрчлөлт оруулах, холбогдох үйл ажиллагааг зохион байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ: А.АЛТАНСҮХ

Х.ОДОНТУЯА

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
СЭХ
2023 оны 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-05-11
БҮРТГЭВ-02

BID BUSINESS INVEST DEVELOPMENT

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
5-р хороолол, 2-р хороо, /14251/
Сөүлийн гудамжны 11/1-р байрны 8-р давхарт
Утас: 70002028, 99117724
Факс: 976-11-312028
Имэйл: info@bid.mn
Вэб сайт: www.bid.mn

2023.05.22 № 05/02-01
танай ____________-ны № ____________-т

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 75 дугээр зүйлийн 75.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, Бизнес Инвест Девелопмент ББСБ ХХК (цаашид "Компани" гэх) -ийн Дүрмийн холбогдох заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн "Их хэмжээний хэлцэлд зөвшөөрөл олгох тухай" №02/24 дугаартай тогтоолын 1 дэх заалтад дараах өөрчлөлтийг оруулсугай.
   *"... нэлттэй санал болгох 10,000,000,000.00 (арван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичиг ..."* гэснийг *"... нийт 8,000,000,000.00 (найман тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн бичиг ..."* хэмээн өөрчлөх;
2. Бондын нөхцөл өөрчлөгдсөнтэй холбогдуулан "Их хэмжээний хэлцэл"-д нэмэлт өөрчлөлт оруулах, холбогдох үйл ажиллагаа зохион байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц. Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

Дарга А.АЛТАНСҮХ

Гишүүд Х.ОДОНТУЯА
С.ОТГОНБАТ
Б.АНХИЛУУН
Ц.БАТ-ЭРДЭНЭ
Б.ОТГОНДОРЖ

BID БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХЦК

ХАВСРАЛТ 5- УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

СЗХ он сар 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -05- 11 БҮРТГЭВ-02

Хууль зүйн сайдын 2016 оны А/204 дугаар тушаалаар батлав.

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000211565

2005.08.19
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9015001006
/ Хувийн хэргийн дугаар /

5013348
/ Регистрийн дугаар /

Бизнес-Инвест девелопмент ББСБ — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |
|---|---|---|
| Шийдвэр | 01 | 2005.05.15 |

| / Код / | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 6499 | Итгэлцлийн үйлчилгээ |
| 6619 | Гадаад валютын арилжаа |
| 6492 | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга |
| 64190 | Зээлийн үйл ажиллагаа /2005.07.25-/ |

| / хугацаа / | / эзэмшигчийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мөнгөн төгрөгөөр / |
|---|---|---|
| Хугацаагүй | 2 | 5,000,000.00 |

Улаанбаатар, Сүхбаатар, 2-р хороо, 5 хороолол, сеул, 11/1-р барилга 6 давхарт, Утас1: 99119926, Утас2: 70002026, Факс: 312026
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

Улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2020 он 09 сар 24 өдөр

ББСБ ХХК УЛААНБААТАР ХОТ 5013348 № 9023010137

BID BUSINESS INVEST DEVELOPMENT

СЗХ
2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2023-05-11
БҮРТГЭВ-02

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Цэвээн овогтой Батэрдэнэ-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2013.12.26 | П.Энхбаяр |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2020.09.24 | Г.Санжаа |
| 3 | Улаанбаатар, Сонгинохайрхан, 37-р хороо, Хэнын материал, УЗГ, Содон хороолол, 101 байр-д байрлах салбар нэгжийг бүртгэв. | 2020.09.28 | С.Мөнхсанчир |
| 5 | 66300 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа шинээр бүртгэв | 2021.03.31 | Г.Санжаа |
| 6 | Улаанбаатар Сүхбаатар 2-р хороо 5 хороолол өвүл 11/Г-р байр, 4-р давхар, 402 тоот-д байрлах салбар нэгжийг бүртгэв. | 2021-12-13 | Г.Батмөнх |
| 7 | Улаанбаатар Чингэлтэй 4-р хороо 4 тоот-д байрлах салбар нэгжийг бүртгэв. | 2021-12-13 | Г.Батмөнх |
| 8 | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1428572 мян.төг-р нэмэгдэж нийт 5000001 мян төг болсон өөрчлөлтийг бүртгэв | 2020.01.22 | Э.Эрдэнэбилэг |

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ нь хууль ёсоор хүчин төгөлдөр байна. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

*00021196*

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ
ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 РД 9023010137

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 11
БҮРТГЭВ-02

2023 оны 05 сар 12 өдөр
№ 01

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 101/18

2007 оны 09 сарын 28 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 09 сарын 28 өдрийн 130 дугаар тогтоолоор

**"БИЗНЕС-ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ" ХХК**-д

**Банк бус санхүүгийн**

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА С.ДАВААСҮРЭН

"тамга"

*Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй*

ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 ₮ 9023010137

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 101/18 ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"БИЗНЕС-ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл, хэлбэрийн тэмдэглэл:

| Д/д | Үйл ажиллагааны төрөл, хэлбэр | Олгосон огноо | Олгосон шийдвэрийн дугаар | Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|
| 1. | Зээл | 2007.09.28 | №130 тогтоол | |
| 2. | Гадаад валютын арилжаа | 2007.09.28 | №130 тогтоол | |
| 1. | Гадаад валютын арилжаа | 2007.10.30 | №145 тогтоол | ХҮЧИНГҮЙ |
| 2. | Итгэлцлийн үйлчилгээ | 2008.10.22 | №233 тогтоол | |
| 3. | Гадаад валютын арилжаа | 2014.12.10 | №445 тогтоол | |
| 4. | Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ | 2018.04.04 | №147 тогтоол | |
| 5. | Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх | 2021.03.10 | №83 тогтоол | |
| 6. | Хадгаламжийн эрхийн бичгийг бүртгэх | 2021.06.11 | №232 тогтоол | |

"БИД финанс ББСБ" ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож "Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК-тай нэгтгэхийг зөвшөөрөв. 2019.12.27 №415 тогтоол

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хаяг | Утас | Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг |
|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Багатойруу 13-01 тоот. | | |
| 2. | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Сөүлийн гудамж, 11-1 байр, 6 давхар. | 70002028 99117724 | 2014.02.25 албан тоот |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

| Д/д | Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1. | | 2007.06.12 | №53 | 220,000,000 |
| 2. | 200,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2007.11.19 | №97 | 420,000,000 |
| 3. | 125,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2008.03.17 | №24 | 545,000,000 |
| 4. | 270,800,000 /нэмэгдүүлсэн/ | 2009.04.13 | №36 | 815,800,000 |
| 5. | 184,200,000 /нэмэгдүүлсэн/ | 2010.03.03 | №19 | 1,000,000,000 |
| 6. | 1,000,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2012.03.19 | №36 | 2,000,000,000 |
| 7. | 1,500,000,000 /нэмэгдүүлсэн/ | 2014.10.02 | №275 | 3,500,000,000 |
| 8. | 71,429,000 /нэмэгдүүлсэн/ | 2019.10.30 | №521 | 3,571,429,000 |
| 9. | 1,428,572,000 /нэмэгдүүлсэн/ | 2020.01.10 | №06 | 5,000,001,000 |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

BUSINESS INVEST DEVELOPMENT
он . сар . өдөр 2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-11
БҮРТГЭВ-02

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар:

| Д/д | Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Регистрийн дугаар | Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн | Хувь | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | А.Алтансүх | ХА72121475 | 110,000,000 | 50% | 2007.06.12 | №53 тушаал |
| 2. | Х.Одонтуяа | ХН73030266 | 110,000,000 | 50% | 2007.06.12 | №53 тушаал |
| 1. | А.Алтансүх | ХА72121475 | 210,000,000 | 50% | 2007.11.19 | №97 тушаал |
| 2. | Х.Одонтуяа | ХН73030266 | 210,000,000 | 50% | 2007.11.19 | №97 тушаал |
| 1. | А.Алтансүх | ХА72121475 | 272,500,000 | 50% | 2008.03.17 | №24 тушаал |
| 2. | Х.Одонтуяа | ХН73030266 | 272,500,000 | 50% | 2008.03.17 | №24 тушаал |
| 1. | А.Алтансүх | ХА72121475 | 407,900,000 | 50% | 2009.04.13 | №36 тушаал |
| 2. | Х.Одонтуяа | ХН73030266 | 407,900,000 | 50% | 2009.04.13 | №36 тушаал |
| 1. | А.Алтансүх | ХА72121475 | 500,000,000 | 50% | 2010.03.03 | №19 тушаал |
| 2. | Х.Одонтуяа | ХН73030266 | 500,000,000 | 50% | 2010.03.03 | №19 тушаал |
| 1. | А.Алтансүх | ХА72121475 | 1,000,000,000 | 50% | 2012.03.19 | №46 тушаал |
| 2. | Х.Одонтуяа | ХН73030266 | 1,000,000,000 | 50% | 2012.03.19 | №46 тушаал |
| 1. | А.Алтансүх | ХА72121475 | 1,750,000,000 | 50% | 2014.10.02 | №275 тушаал |
| 2. | Х.Одонтуяа | ХН73030266 | 1,750,000,000 | 50% | 2014.10.02 | №275 тушаал |
| 1. | А.Алтансүх | ХА72121475 | 1,821,429,000 | 51% | 2019.10.30 | №521 тушаал |
| 2. | Х.Одонтуяа | ХН73030266 | 1,750,000,000 | 49% | 2019.10.30 | №521 тушаал |
| 1. | А.Алтансүх | ХА72121475 | 2,550,001,000 | 51% | 2020.01.10 | №06 тушаал |
| 2. | Х.Одонтуяа | ХН73030266 | 2,450,000,000 | 49% | 2020.01.10 | №06 тушаал |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

BID
БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5013348 dt. 9023010157

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО ХНН
КАПИТАЛ ҮЦК ХХК

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

| Д/д | Нэр, дугаар | Хаяг, хаягийн өөрчлөлт | Зөвшөөрөл олгосон огноо | Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар | Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар |
|---|---|---|---|---|---|
| 1. | Салбар-01 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг. | 2010.01.28 | №08 | |
| 2. | Салбар-02 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг. | 2010.12.06 | №175 | |
| 3. | Салбар-03 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг. | 2012.12.19 | №249 | |
| 4. | Салбар-04 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. | 2013.10.25 | №256 | |
| 5. | Салбар-05 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг. | 2014.03.12 | №59 | |
| 6. | Салбар-06 | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг. | 2018.06.29 | №340 | |
| 7. | Салбар-07 | Хөвсгөл аймаг, Мөрөн сум. | 2018.09.28 | №539 | |
| 8. | Салбар-08 | Дорнод аймаг, Хэрлэн сум. | 2018.10.26 | №571 | |
| 9. | Салбар-09 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг. | 2019.06.10 | №401 | |
| 10. | Салбар-10 | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг | 2019.06.20 | №426 | |
| 11. | Салбар-11 | Орхон аймаг, Баян-Өндөр сум. | 2017.11.13 | №480 | |
| 12. | Салбар-12 | Дархан-Уул аймаг, Дархан сум. | 2017.11.13 | №480 | |
| 13. | Салбар-13 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. | 2017.12.27 | №535 | |
| 14. | Салбар-14 | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг. | 2020.09.11 | №293 | |
| 15. | Салбар-15 | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг. | 2020.09.22 | №314 | |
| 16. | Салбар-16 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг. | 2021.12.03 | №318 | |
| 17. | Салбар-17 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг. | 2021.12.03 | №319 | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-11 БҮРТГЭВ-02

СЗХ 2023.05.12 БҮРТГЭВ № 01

BID УЛААНБААТАР ХОТ 5013348 9023010137

УЛААНБААТАР ХОТ

BID BUSINESS INVEST DEVELOPMENT
он 2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-11 32
БҮРТГЭВ-02



**МОНГОЛ БАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2005 оны 07 сарын 25 өдөр Дугаар 340 Улаанбаатар хот

**Зөвшөөрөл олгох тухай**

"Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль"-ийн 9.1 дэх заалт, "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам"-ын 2.7 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Бизнес инвест девелопмент" ХХК-ийн үүсгэн байгуулагч нарт банк бус санхүүгийн байгууллага байгуулж, зээл, гадаад валютын арилжаа, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Бизнес инвест девелопмент" банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Л.Чимгээ), тус байгууллага байгуулагдсан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхийг Тамгын газар (Л.Мандал)-т даалгасугай.

ТЭРГҮҮН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ А.БАТСҮХ

252

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

Tushaal 5.dec 7 12
2023.02.13

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-11
он 2023 сар 05 өдөр 12

# МОНГОЛ УЛС

МОНГОЛБАНК

# БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2005 оны 07 сарын 25 өдөр Дугаар 184 Улаанбаатар хот

Монгол улсын "Банкны тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль", Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 136. тоот тушаалаар батлагдсан "Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам", банк бус санхүүгийн байгууллага байгуулах тухай Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005. оны 07. сарын 25. өдрийн 340 тоот тушаалыг үндэслэн Бизнес инвест девелопмент оноосон нэр бүхий ХХК -д банк бус санхүүгийн зээл, гадаад валютын арилжаа, санхүүгийн түрээс үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.

ЕРӨНХИЙЛӨГЧ "Тамга"

О. ЧУЛУУНБАТ

253. Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй.

БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ ХХК
УЛААНБААТАР ХОТ

Бирж болон Хороонд хүргүүлж байгаа танилцуулга нь адил бөгөөд, ямар нэг зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл санал болгох үйл ажиллагаанд оролцогч мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь хоорондоо болон Үнэт цаас гаргагчтай аливаа сонирхлын зөрчилгүй болно.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв болохыг батлав.

Овог, нэр: **А. АЛТАНСҮХ**

Албан тушаал: Үнэт цаас гаргагч "БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн дарга

Гарын үсэг:..........................

(Тамга/тэмдэг)

Овог, нэр: **Б.ӨЛЗИЙБАЯР**

Албан тушаал: Андеррайтерийн "ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:..........................

(Тамга/тэмдэг)

Овог, нэр: **Ц. БАТ-ЭРДЭНЭ**

Албан тушаал: Үнэт цаас гаргагч "БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:..........................

(Тамга/тэмдэг)

Овог, нэр: **А. БАЯРЖАРГАЛ**

Албан тушаал: Үнэт цаас гаргагч "БИЗНЕС ИНВЕСТ ДЕВЕЛОПМЕНТ ББСБ" ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:..........................

(Тамга/тэмдэг)